

ЖЕК ЛОНДОН

Өгүүллэгүүд



АНИРГҮЙ ЦАГААН ДАЙД

Жек Лондон

Аниргүй цагаан дайд

(Өгүүллэгийн түүвэр)

Үнэндээ амьдрал гэдэг хэзээ ч ялж
болдоггүй тоглоом шүү дээ.

Амьдарна гэдэг өтөл нас чам руу
сэмээрхэн гэтэн гэтсээр тулж иртэл
шургаж унатлаа зүтгэж, зовж
тарчилна гэсэн үг. Гэтэл бид
амьдралд хязгааргүй хайртай,
үхлийг туйлгүй үзэн яддаг.

Джек Лондон

Аниргүй цагаан дайд

-Кармен ч хоёр хоногийн насгүй болж дээ.

Мэйсон амандаа орсон бөөн мөсийг нулимж орхиод, өмнөө байгаа золгүй амьтан руу гунигтайхан харснаа, түүний хөлийг татан ам руугаа аваачиж, хуруудын нь завсраар товууцаж хөлдсөн мөсийг шүдээ хага ташуулан байж дахиад сугачиж хаяв.

-Чамин хачин нэртэй ноходтой би зөндөөн л таарч явсан, цөмөөрөө олхиогүй юмнууд байдаг юм гэснээ, хийж байсан ажлаа дуусгаж, нохойг

түлхэн цаашлуулах зуураа,

-Тэд чинь тамир нь харьж доройтсоор сүүлдээ үхчихдэг амьтад. Чи өөрөө мэднэ шүү дээ, зүгээр Касьяр, Сиваш, Хаски нэртэй нохдод тэр бүр муу юм тохиолдоод байдаг билүү? Жишээ нь энэ Шукумыг хар л даа, тэр...

Гэхийн сацуу цаад гуринхалсан эр нохой нь яах ийхийн завдалгүй цовх үсрэн, хурц цагаан соёогоороо Мэйсоны багалзуурыг арай л тас татаад хаячихсангүй.

-Энэ чинь одоо юу болж байна вэ?

Шилбүүрийн мод тархин дундуур нь тасхийн буухад нохой цасан дээр тарайж унаснаа, ухаан ороод, нүд ирмэхийн зуур огло харайн босоход араа шүднээс нь шар шүлс савирч байлаа.

-Шукумаас хараа бүү салгаарай гэж би хэлээд байсан шүү дээ. Энэ Шукум амар заяа үзүүлэхгүй нээ! Цаадах чинь Карменийг долоо хонохгүй л тасар татаад хаячих бий вий. Мөрийцсөн ч болно.

-Харин би бол... гэснээ Мэйлмют Кид, түүдэг галын дэргэд гэсгээхээр тавьсан талхыг эргүүлэх зуураа,

-Зорьсон газраа хүрэхээсээ наана бид өөрсдөө Шукумыг алж иднэ гэж мөрийцөхөд ч бэлэн байна. Чи юу гэж бодож байна даа, Руфь?

Улаан арьст бүсгүй идээг нь тунгаах гэж кофе руугаа жаахан мөс чулуудчихаад, Мэйлмют Кидээс харцаа салган нөхөр рүүгээ, дараа нь ноход руугаа харснаа, хар цагаан юу ч дуугарсангүй. Ийм хараажийн үнэнийг давхар нотлох барих гэж оролдохын хэрэг юу байх билээ. Тэдэнд өөр арга байхгүй юм чинь. Хүний хөл хүрээгүй хоёр зуун бээр газар өмнө нь тосч байгаа. Өөрсдөө бол зургаа хоногт хүрэхтэй, үгүйтэй хүнстэй үлдсэн байдаг, Нохдод нь

бол одоо гол зогоох юм юу ч
байхгүй болсон.

Хоёр анчин, хүүхэн гурав
өглөөнийхөө тарчигхан ундааг
уухаар түүдэг гал тойрон суулаа.
Бага үд хийж байсан болохоор
ноход нь хөллөгөөтэйгөө цагариглан
хэвтээд, эздийнхээ ам хөдлөх бүрийг
өлөн нүдээ салгахгүй ширтэцгээн
байна.

-Маргаашнаас эхлээд өглөө ам
хөдөлгөх юмгүй болно гээд
Мэйлмют Кид,

-Нохдоос нүд салгаж болохгүй
боллоо. Гай болоод гараас алдуурч

орхих юм бол эв нь таарсан цагт биднийг ч хүү татаад идэж орхиход бэлэн л байгаа шүү гэв.

-Цагтаа би методист мөргөлтний чуулганы тэргүүн, хишиг өдрийн сургуулийн багш явсан хүн дээ. Юуны учир ийм үг дуугарсныг бүү мэд. Мэйсон ингэж хэлчихээд, уур савсуулж байгаа бугын арьсан бойтог руугаа их бодол болчихсон гөлрөн ширтэж сууна. Руфийг аяганд нь кофе хийж өгөхөд сая тэр гүн бодлоосоо салж,

-Тэнгэрийн ивээлээр бид харин цайнаас их юмгүй хоцорлоо доо. Би Теннесид, гэртээ байхдаа цай яаж

ургадгийг харсан юм. Одоо бол би эрдэнэ шишийн ганц халуун гамбирын төлөө юугаа ч өгөхөөс буцахгүй болчихсон сууж байдаг. Гэхдээ, Руфь минь битгий гунихар. Гэдэс өлсөх, бугын арьсан бойтог өмсөх хоногийн чинь тоо дуусах цаг хаяанд ирсэн шүү. Энэ үгсийг сонсоод хүүхний магнайн үрчлээ тэнийж, анх удаа учирсан цагаан арьст хүн, бүсгүй туунийг адгуус амьтан, ачааны малаас өөрөөр харсан анхны хүн, тэр л цагаан арьст ноёныг хайрлах сэтгэлээр нүд нь гэрэлтээд ирэв.

-Тийм ээ, Руфь минь гээд эр нөхөр нь, зөвхөн хоёр биетэйгээ

ойлголцдог нөгөө л болзмол
хэлээрээ,

-Бид удахгүй эндээс хөдөлнө. Цагаан
хүний завинд суугаад Давст усаар
хөвж одно доо. Тэр оргилж
бургилсан муу ус уул мэт дээш
сүндэрлэн босч ирээд л доошоо
бууж байдаг юм. Хязгаар хярхаггүй
тэр усаар мөн ч их удаан явна шүү
дээ! Арав, хорь, бүр дөчин хоног
хөвлөө ч... гээд Мэйсон яриагаа улам
үнэмшилтэй болгохын тулд хоног
өдрийг хуруу даран тоолж байгаад,

-Өнөөх л усандаа, муу усандаа л явж
байна. Тэгж явсаар, зун цагийн ялаа
шумуул шиг язганасан олон хүнтэй

нэг их том гацаа тосгонд хүрч очно
доо. Урц овоохойн нь өндрийг яана.
Арав, хорин нарс залгасны дайтай
гээч! Ээ, мөн ч өндөр шүү!

Ийн өгүүлээд тэр цааш нь хэлэх үгээ
олж ядан таг болж, Мэйлмют
Кидийн зүг дэмий л ая зассан харц
чулуудсанаа, хорин нарс дээр дээр
нь залган босговол хэр зэрэг өндөр
болохыг хуруу гараараа жишин,
мэрийж мэхийн тайлбарлаж гарав.
Мэйлмют Кид дотроо доогтойхон
инээмсэглэж, гайхаж баяссан Руфь
нүдээ дүрлийлгэн ширтэж байна.
Нөхрийгөө наргиж зүггүйтэж байна
гэж мэдсэн хэдий ч тэр өхөөрдөл
хайр нь хөөрхий бүсгүйн сэтгэлийг

хөөргөж баясгаж байлаа.

-За тэгээд л хайрцаг дотор орж суугаад... ганц пифф! гээд л хөдөлчихнө дөө гэснээ, эл үгээ улам ойлгомжтой болгох гэсэн бололтой хоосон сэнжтэй аягаа дээш нь шидээд сурамгай нь аргагүй барьж авах зуураа,

-Бас ингээд л пафф! гээд хүрээд ирчихнэ! Ээ, их заарингууд минь ивгээлдээ багтааж хайрла! Чи минь Форт Юкон руу явна, харин би хорин тав хоноод Арктик Ситид байж байна. Тэндээс чам руу хөвөрч одсон олсны үзүүр дээрээс бэрьж аваад "Байна уу, Руфь минь!

Ямаршуухан аж төрж байна даа?" гэнэ. Тэгэхэд чи "Өө, өвгөн минь, чи юу?" гэж, би "Тийм байнаа" гэнэ. Чамайг "Соодгүй болоод талх барьж чадахаа болиод байна" гэхэд би "Пиндээ ороод гурил доогуур үз. За, баяртай" гээд, чи пин рүүгээ орж хичнээн л хэрэгтэй бол төчнөөн соод авна. Иймэрхүү маягаар, чи Форт Юконд, би Арктик Ситид суурьшин аж төрцгөөнө дөө. Бөөнэр гэдэг чинь ийм л хүмүүс байдаг юм!

Эл шидэт үлгэрийг сонсоод Руфийг гэнэхэн инээмсэглэж суухад хоёр эр тачигнатал хөхрөлдөж байлаа. Гэтэл, хэрэлдэн хэмхэлдэж буй ноход алс холын гайхамшигт орны тухай яриаг

нь таслаад, тэднийг салгаж аялуулж
байх зуур бүсгүй чарганыхаа ачаа
тээшийг боож баглаж, татлагаар
даруулан, замд гарахад бэлэн зэлэн
болчихсон байлаа.

-Урагшаа, Халзан минь, алив,
давхиарай!

Мэйсон шилбүүрээ дадамгай нь
аргагүй тас няс хийлгээд, нохдыг
аяархан гаслаж гийнан
хөллөгөөнийхөө сурыг сунган зүтгэж
эхлэхийн сацуу залуур модоороо
газар тулан түлхэхэд хөлдүү чарга
урагш хөдлөв. Руфь хоёр дахь
чарганд суужээ. Чаргаа хөдөлгөхөд
нь бүсгүйд тусалсан Мэйлмют Кид

сүүлчийн чаргыг залах боллоо.
Нүцгэн гараараа бухыг ганц цохиод
унагаж чадах эр хар бярттай,
шийдмэг догшин зантай энэ булиа
эр золгүй хөөрхий хөллөгөөний
нохдод гар хүрдэггүйгээр үл барам
боломжийнхоо хэрээр тордож
тэтгэж явдаг нэгэн ажээ. Ингэдэг
аянчин их ховор байдаг бөлгөө.
Зарим үед Мэйлмют Кид тэр нохдыг
хараад өрөвдөхдөө нулимс унагах
шахдаг аж.

Хүнд чаргануудаа замд гаргах гэж
хэдэнтээ хүчлэн оролдсоныхоо
дараа манай хүн:

-За, давхиад байгаарай, майга

хөлтнүүд минь! гэж аман дотроо дуугарав.

Ашгүй, тэвчээр зүтгэл нь талаар болсонгүй, ноход нь өвдсөндөө гаслаж гийналдан, өмнөө яваа ах дүүсээ гүйцэх гэж хурдлан одох нь тэр.

Яриа хөөрөө ч тасрав. Ийм зүдэргээтэй аяны замд тийм илүү дутуу юмны хэрэг юун. Умар зүг өөд аялана гэдэг хүнд бэрх бөгөөд амиа ч алдаж болох ажил билээ.

Таг дуугүй явж чадсанахаа хүчинд бүтэн өдрийг, тэгээд ч ийм улбаа төдий жимээр туулж чадсан хүнийг

аз жаргалтай хүн гэхээс өөр аргагүй.

Зам мөр гаргахаас илүү зовлонтой хэцүү ажил байхгүй дээ. Цанын гөрмөл өргөн бэхэлгээ алхам бүрт шахам алдуурч, өвдөгцөө цасанд зоогдоно. Хөлөө цаснаас аажуухан, болгоомжтой гэгч сугалах хэрэгтэй. Цанын цасыг гүйцэд цэвэрлээгүй цагт, босоо хүн ганц ямхын төдий хазайлаа л бол ямар ч гай гамшигтай юм болж мэднэ, Тийм үед урагшаа ганц алхаад нөгөө хөлөө зөөн, наад зах нь л гэхэд бас хагас ярд алхах ёстой. Анх удаа тийм юмыг туулж буй хэн боловч сайн л бол нэг зуун ярд газар яваад, тамир нь тасран, цанаа холбох нь бүү хэл

ганц сайн сүниаж ч амжилгүй нөгөө
л гай уддаг цасан дээрээ унаад өгнө
гээч. Өдрийн туршид нохойн хөл
доор ганц ч унаагүй хүн уутан
хөнжилдае санаа амар, сэтгэл
бардам шургаж болно. Умардын
аугаа бэрх жимийг хорь хоног дотор
туулж чадсан хүнд тэнгэр ч атаархах
буй заа.

Наран баруунаа гудайж байхад
Аниргүй Цагаан Дайдын сүр хүчинд
автан баргар царайлсан аянчид дуу
шуу ч үгүй, зам гарган урагшилсаар л
байлаа. Мөнх бусын заяанд төрснийг
нь хүнд өөрийн эрхгүй сануулан
эрхшээдэг, далай тэнгисийн
тасралтгүй ээлжлэн орчигч таталт,

түлхэлт, догшин шуурга, газар
дэнслэх, тэнгэрийн их буу болсон
аянгын нижигнээн гээд өдий төдий
зүйл байгальд байдаг билээ.

Тэдгээрээс хамгийн хүчтэй, хамгийн
аймшигтай нь эл Аниргүй цагаан
дайд хийгээд түүний нэгэн хэвийн
дүнсгэр байдал мөн дөө. Ёстой л
анир чимээгүй. Тэнгэр зүлгэж
өнгөлсөн зэс мэт гялалзаад, өчүүхэн
чимээ ч ариун бүхнийг бузарлаж
орхим санагдан, хүн өөрийнхөө
дуунаас ч хүртэл хирдхийн цочмоор
ажээ. Эл хуль ертөнцийн мэнэрсэн
их цөл дундуур урагшаа тэмүүлж
яваа, амьд төрөлтний өчүүхэн
ширхэгтөдий тэр хүн одоо

өөрийнхөө сөс ихтэй хар сөөрөг
зангаас баахан айн ширвээдэж, биеэ
яльгүй муу өт хорхой мэт бодном
бөлгөө. Орчлон ертөнцийн далд
нууц өөрийнхөө илрэн тодрох аргыг
хайж байна уу гэлтэй хачин бодол
бас төрөх аж. Үхлийн өмнө,
тэнгэрийн өмнө бүх л ертөнцийн
өмнө хүнийг ийм л үед айдас
эзэмдэн авдаг бөгөөд түүн сацуу
сайн төрөл олох, амьд явах найдвар,
мөнхрөхийн мөрөөдөл тэргүүтэн,
орчлонгийн хүлээсэнд баригдсан
хоосон хүсэл эрмэлзэл ч бас оргилж
ирнэ. Яг тэр үедээ л хүн Тэнгэртэй
орь гагцаар нүүр тулан учирдаг
байна.

Үдшийн наран бүр тонгойжээ. Голын гульдрал тэрүүхэндээ гэнэт огцом тохойрч, Мэйсон газар дөтлөн шууд огтлон гарахаар нохдоо цаад хошуу өөд залав. Гэтэл тэд яаж ч зүтгээд эрэг өөд гарч чадсангүй.

Руфь, Мэйлмют Кид хоёр араас нь түлхээд байсан хэр нь чарга ухран гулссаар байлаа. Өлсөж гуриатсан золгүй хэдэн ноход сүүлчийнхээ хүчийг шавхаж, улайран зүтгэж эхэлсэнд чарга овоо дээш ахи ахисаар арай чүү цаад эрэг дээр гарах нь л гарчээ. Гэтэл түүчээ нохой гэнэт баруун тийш зүтгэн, чарга Мэйсоны цана дээгүүр гарах яг тэр агшнаас хачин золгүй явдал эхлэх нь

тэр. Мэйсон газар харуулдан ойчиж,
бас нэг нохой хөллөгөөнийхөө
суранд орооцолдон унаад, чарга
газрын хэвгий рүү, бусад ноход,
хөллөгөө сэлтээ чирсээр гулсан буув.

Шилбүүрийн дуу тас! няс! хийн нөгөө
унасан нохой суранд нь өртөж
эхлэхийн сацуу:

-Мэйсон болиоч! гэж хашгираад
Мэйлмют Кид, -Наад хөөрхий амьтан
чинь амьсгал хураах гэж байна шүү
дээ. Би өөрийнхөө хэдийг
хөллөгөөнд оруулаадахъя гэлээ.

Мэйсон, түүний үгээ хэлж дуусахыг
хүлээж байгаад, урт шилбүүрээрээ

дахиад шавхуурдан, гэмтэй нохдыг
ороолгож гарчээ. Нөгөө, бидний
танил Кармен өрөвдөлтэйеэ гаслан
гангинаж, цас руу шургах гэж хүртэл
оролдож үзсэнээ тэрий хадан сунаад
ойчив.

Тэрхэн үе бол аянчдын хувьд тун
хэцүү, шаналгаатай хором байлаа,
Нэг нохой амьсгал хураан алдаж,
хоёр найз ам мурийн, яах учраа
олохоо больсон Руфь тэр хоёрын
нүүр өөд царайчилсан байдалтай
дэмий л ээлжлэн харсаар байж,
Мэйлмют Кидийн нүдэнд тун ч
зэмлэнгүй харц тодроод ирсэн
хэдий ч биеэ барин, нохой руу очиж
хөмөлдрөгийг нь тасар огтчин

салгав. Хэн нь ч дуугарсангүй.
Дүйзлэж хөллөсөн ноход эрэг өөд
мацсаар дээр нь гараад алсынхаа
замд шуудрав. Кармен эцсийнхээ
хүчийг шавхан араас нь бараадан
дагалаа. Нохойг явж чадаж
байгаа цагт нь буудах ёс байхгүй.
Амьд үлдэх эцсийн ганц арга гэвэл,
дараагийн буудалд яаж ийгээд
хүрэх, тэнд нь хүмүүс хандгай
алчихсан байж байх л явдал юм.

Өөрийнхөө буруу явдалд дотроо
гэмшиж байсан хэдий ч Мэйсон
угаас баахан зөрүүд зантай хүн тул
юу ч дуугарсангүй, манлайн чарганы
нохдыг залан зүтгүүлсээр явлаа. Тэр,
тосч байгаа аюул зовлон, гай

түйтгэрийн талаар сэжиг ажиг ч үгүй,
цагаан газар өтгөн ургасан цагдуул
дундуур туучуулж явна. Тавиад
тохой газрын зайтай нэгэн хөгшин
нарс сүглийн байна. Зуу зуун жилийн
турш тэнд гав гагцаар хөглийн
бараалсаар байгаад дуусах хувь
тавилан түүнд ногдсон ажээ,
хөөрхий. Манай Мэйсон ч бас ямар
хувь тавилантай юм билээ, бүү мэд
дээ.

Түүнийг бугын арьсан гутлынхаа
үдээсийг чангалах гэж тонгойхын
сацуу чарганууд ч зогсч, ноход цасан
дээр хэвтээд өглөө. Эргэн тойронд
нь нэг л хачин нам гүм, хөл
хөдөлгөөн ч алга, тэр жихүүн жавар,

нам жим байдал хоёр байгаль
ертөнцийн зүрхийг царцааж, амыг
нь бээрүүлж орхио юу даа гэлтэй
цаанаа л нэг ёозгүй.

Агаарт огцом шүүрс алдах мэт чимээ
гарахад, түүнийг хэн ч сонсоогүй авч,
тэр хөшин царцаж орхисон мэт
хөлдүү бөглүү ээрэм цөлд нэг л юм
болох нь дээ гэдэг ёр дохиог
төдөлгүй цөм мэдэрчээ. Он удаан
жилийн насанд дарагдаж, тэр
жилийн унасан цасны хүндэд
дийлдэн бөхийсөн аварга том нарс
мод хүний аминд хүрсэн эмгэнэлт
явдлаар насныхаа нарыг жаргаах нь
тэр. Тар няр хийх чимээг
сонсонгуутаа Мэйсон хурдан холдох

гэж ухасхийсэн боловч түүнийг
гүйцэд босч ч амжаагүй байхад нь
мод дал мөрөн дээрээс нь дараад
унаж орхив.

Гэнэтийн аюул, нүд ирмэх зуурын
үхэлтэй Мэйлмют Кид бишгүй л нэг
нүүр тулан учирч явсан даа! Нарсны
шилмүүс чичигнэхээ зогсоогүй
байхад тэр, бүсгүйд нэг юм зандран
тушаагаад өөрөө нөхөртөө туслахаар
дайран орлоо. Улаан арьст бүсгүй,
цагаан арьст эгч дүү нарынхаа
олонхийн адил ухаан алдаж унасан
ч үгүй, дэмий нулимсаа асгаруулан
цаг алдсан ч үгүй. Мэйлмют Кидийг
хашгирахын сацуу ухасхийн,
дамналдан унасан модны нөгөө

үзүүр дээр бүх биеэрээ тэгнэн хэвтээд, модны хүндийг чадах ядахаараа хөнгөлөн, нөхрийнхөө ёолж гаслахыг чих тавин чагнаж байх тэр агшинд Мэйлмют Кид модыг сүхээр цавчиж гарав. Тэс хөлдүү модонд хальт үсрэх сүхний төмөр ян ян хийх агаад цохилт бүрийн араас Мэйлмют Кидийн хэт хүчилсэндээ өөрийн эрхгүй гаргаж буй урт бөгөөд бөглүүхэн дуу залгаж байлаа.

Тэг тэгсээр байгаад, сав саяхан амьд саруул гялалзаж явсан нөхрийнхөө сэг болсон биеийг модон доороос арай гэж сугалан гаргаад цасан дээр тавив. Харин, бүсгүйн битүү уй

гунигт царай, итгэл цөхрөл сүлэлдсэн
нүднийх нь харц тэргүүтэн эр
нөхрийнх нь шаналгаа зовлонгоос ч
илүү аймшигтай харагдаж байлаа.
Умарт нутгийнхан үгийн дэмий
хоосон, үйл ажлын үнэ цэнэтэйг эрт
ухаардаг болохоор үг цөөтэй байдаг
билээ. Хасах жаран таван тэмийн
хүйтэнд хүн цасан дээр удаан хэвтэж
чадахгүй тул, золгүй Мэйсоныг
ангийн арьсаар тунтуйлан ороож,
чарганаас огтчиж авсан татлага
сураар боогоод, мөчир зулж зассан
хэвтэр дээр хэвтүүлэн, хажууд нь гал
өрдөж гарав. Нөгөө гай удсан модны
гал дүрэлзэн байна. Галын илчийг
хорьж тогтоон, орчин тойрныг

нь дулаацуулахад нэмэр гэж дээгүүр
нь хуучин даавуу татжээ. Энэ бол хэн
хүний үл андах, байгалиас олж авсан
физик арга билээ.

Үхэлтэй нэг биш удаа нүүр тулан
учирч явсан хүн түүний ёр зөнг
анддаггүй. Мэйсоныг даанч нүд
хальтирмаар айхавтар
зэрэмдэглэчихжээ. Зэрвэсхэн
харахад л илт. Баруун гар, дунд
чөмөг, ууц нуруу нь хугарч бэртээд,
хоёр хөл нь мэдээ алдаж, дотор
эрхтнүүд нь ч бас авах юмгүй болсон
байж магадгүй байдалтай
харагдана. Хааяа нэг гиншин
ёолохоор нь л хөөрхий минь, амьд
шүү л байгаа юм байна гэж

бодохоос өөр арга алга.

Яах ч арга байхгүй, ямар ч горьдлогогүй болж дээ. Энэрэлгүй хар шөнийн дуусахгүй уртыг бас яана. Руфь цөхөрч гүйцсэн ч овог аймгийнхныхаа онцлог шинж болсон гүргэрхэн байдлаар гай зовлонтой нүүр тулж, харин Мэйлмют Кидийн хүрэл адил хүрэн царайд хэдэн үрчлээ нэмэгджээ. Тэнд хамгаас бага зовлон эдэлж байгаа нь Мэйсон байж. Тэр аль хэдийнээ Дорнод Теннесид Манант Их Уулсын дунд дуудчих. Би түүнтэйгээ үүрд салахын ёс хийе... Хүүгээ бодоод, миний амьсгал хураахыг бүү хүлээ гэж хэлье. Эс

тэгвэл цаадахь чинь чамтай цуг
явахгүй ч байж мэднэ. За, анд минь,
хагацъя даа! Алив, байзаарай, Кид...
Дээхнүүр ухах хэрэгтэй шүү. Би тэнд
алттай элс угаах тоолондоо дөчин
цент унагадаг байсан юм. Аа, Кид
минь, өөр нэг зүйл...

Амьсгалын нь тоо хэзээ мөдгүй
дуусах гэж буй хүний өөрийгөө ялан
байж хэлсэн чин сэтгэлийн үг, чихэнд
дуулдахтай үгүйтэй байгаа сүүлчийн
үгийг сонсохын тулд Кид бөхийн,
дахиад л чихээ аманд нь бараг наав.

-Өршөөгөөрэй намайг... Юуны төлөө
гэдгийг чи мэдэж байгаа... Кармены
төлөө...

Усан нүдэлж гүйцсэн бүсгүйг эр
нөхрийн нь хажууд орхиод Мэйлмют
Кид, ангийн арьсан том дээлээ өмсч,
цанаа хөлдөө углан, буугаа шүүрч
аваад ой руу орж одлоо. Догшин
ширүүн Умард нутгийн байгальтай
халз тулан үзэлцэж явахдаа
балчирдаж барьц алдаж яваагүй ч
гэлээ, ийм бэрх хэцүү юмтай тулгарч
явсан удаагүй билээ, Кид. Өнгөцхөн
төдий бодоод үзлээ ч гэсэн, огт
найдлагагүй болсон нэг хүний төлөө
гурвын гурван хүний амь... гэдэг,
шийдэж цөхөөд байх юмгүй,
хамгийн энгийн ойлгомжтой зүйл
шүү дээ. Гэлээ ч Мэйлмют Кид
дотроо тээнэгэлзсээр байлаа.

Хээрийн буудал, алтны уурхай, гол мөрөн, зам жимд өнгөрүүлсэн хүчир амьдрал, ан гөрөө, өлсгөлөн, үер гээд амь дүйсэн адал явдлаар дүүрэн таван жилийн нөхөрлөл түүнийг Мэйсонтой холбож байгаа билээ. Улаан арьст бүсгүй, тэр хоёрын дундуур ороод ирсэн анхны өдрөөс түүнийг Рүфээс битүүхэндээ харамлах сэтгэл төрөхөөр тийм бат зузаан нөхөрлөсөн хоёр доо. Гэтэл одоо тэр сайхан нөхөрлөлөө өөрийн гараар тасар татан хаяхдаа тулж орхиод байж байдаг!

Хандгай, ердөө ганц хандгай хайрлаач гэж тэнгэрт залбирч гүйсаар явсан авч, ан амьтад нутаг

сэлгэн одсон аятай, юу ч таарч
өгсөнгүй, үдэш болсон хойно ядарч
гүйцсэн амьтан гар хоосон, сэтгэл
дундуур буцаад гэлдэрчээ. Гэтэл
нохдын чих дөжирөм чанга
хуцалдах, Руфийн бачимдан
хашгирах дууг сонсоод өөрийн
эрхгүй алхаагаа хурдасгалаа.

Буудалдаа дөхөж ирээд Мэйлмют
Кид, улаан арьст бүсгүй өөрийг нь
бүчээд хар хурхийн дайрч буй олон
ноходтой сүх барьчихсан үзэлцэж
байгааг харав. Ноход, эздийнхээ
тогтоосон төмөр мэт хатуу хуулийг
зөрчин, үлдсэн жаахан хүнсний зүйл
рүү дайрч байгаа нь тэр аж.
Кид бууныхаа аман талаас бариад

бүсгүйд туслахаар дайран орж,
байгалийн шалгарлын өнө эртний
эмгэнэлт явдал балар цагийн
хэрцгий догшин нанчилдаанаар
өрнөж эхлэх нь тэр. Буу сүх хоёр
зэрэг зэрэг бууж, байгаа нэг онон,
нэг хальт тусан байх агаад ноход
ийш тийш мурилзан бултаж, нүд нь
шуналын галаар цогшсон тэдний
соёо шүдээ арзайлгасан ам хамраас
өлөн шүлс савиран байлаа. Хүн
араатан хоёр бие биенээ эз
дийлэхийн төлөө тийнхүү тартагтаа
тулан тултлаа тэмцэлдвэй. Тэг
тэгсээр, нэвширтлээ жанчуулсан
ноход түүдэг галаас мөлхөн
холдоод, шарх савираа долоож, од

мичид өөд өлийн гомдолтой гэгчийн дуугаар улилдан байлаа.

Хатааж нөөсөн хамаг загас нохойн гэдсэнд орж, үлдсэн хоёр зуу гаруй бээр замд гол зогоох таван фунт хүрэхтэй үгүйтэй гурил л үлджээ. Руфь нөхөр рүүгээ очиж, Мэйлмют Кид сүхэнд гавлаа цөм цохиулж үхсэн нэг нохойн арьсыг хуулаад махыг нь эвдэж, найдвартай газар нуун, арьс, гэдэс дотрыг нь нохдод хаяж өгөв

Өглөө нь бас нэг санаанд ороогүй явдал гарах нь тэр. Ноход хоорондоо хэрэлдэж, хэмхэлдэж эхэлснээ, гэнэт амь нас нь ёстой л

хялгасанд торж яваа Карменыг
сүргээрээ дайран ноцжээ. Хичнээн
шилбүүрдэж жанчаад нэмэр
болсонгүй, гасалж гангинан, унан
босон байсаар Кармены биеэс үс
ясны өөдөс ч үзэгдэхээ болимогц сая
нэг юм тарж одохчаан аядлаа.

Мэйлмют Кид, аль хэдийнээ
Теннесид оччихоод, ах дүү нараа
юунд ч юм бэ итгүүлэхийг хичээн
утга авцалдаагүй нөгөө л сургаал
номлолоо айлдан дэмийрч буй
Мэйсоны яриаг чих тавин чагнах
зуураа, ажил төрлөө хийж эхлэв.

Нарс модод дэргэд нь байсан
болохоор Мэйлмют хурдан шалмаг

амжуулж байлаа. Анчид хүнснийхээ зүйлийг нохой зээх, хөллөгөөний нохдод идүүлчихгүйн тулд хийдэг нуувчин хоргыг мань хүн яажшуухан урлаж байгааг Руфь дуугайхан ажин байна. Тэгээд тэр, хоёр залуу нарсны үзүүрийг газар шүргэтэл махийлган татаж ирээд бугын ширний сураар модноос аргамжиж орхисноо, шилбүүрийнхээ сурыг нэгэнтээ шав хийлгэн Дуугаргаж, нохдоо номхотгож чарганд нь хөллөмөгцөө, Мэйсоныг тунтуйлсан арьснаас бусад бүх юмаа янзлан ачаалав. Найзыгаа олсоор баглаж боогоод, олсныхоо үзүүрийг нарсны оройгоос уялаа. Хутга ганц далайгаад л буулгахад

нарс модод эгцрэн, найз нөхрийг нь газраас тэртээ дээр өргөн тогтоох болно.

Руфь нөхрийнхөө сүүлчийн захиасыг үг дуугүй чагнаж байна. Хөөрхий тэр бүсгүйг дуулгавартай бай гэж сургамжлах ч хэрэггүй. Бүр жаахан охин байхдаа л, өөдөөс нь үг сөрвөл нүгэл болдог, амьтай бүхний оройн дээд эзэн-эр хүний өмнө омгийнхоо бүх бүсгүйчүүлтэй хамт толгой гудайлган зогсдог байжээ.

Нөхрийгөө эцсийн удаа үнсэхэд нь, түүний удам угсаа нэгтнүүд ийм ёс мэддэггүйг эс андах Кид, Руфийн сэтгэлийг засах, барих гэж оролдсон ч үгүй, эхний чарга руу шууд хөтөлж

аваачаад цанаа хөлдөө бэхлэхэд нь хамжилцав. Хүүхэн сохор хүн аятай хар зөнгөөрөө залуур модыг атган авч, шилбүүрээ нэг шавхийлгээд нохдоо шавдуулан замаа хөөж одлоо.

Кидийг, ухаангүй байгаа Мэйсон руу эргэж очиход Руфийн бараа аль хэдийн харагдахаа больсон байсан тул тэр түүдэг галын захад очиж суугаад нөхрийгөө хурдхан шиг амьсгалаа хураагаасай билээ хэмээн залбиран залбиран хүлээв.

Аниргүй цагаан дайд дунд гашуун гунигт бодолд автан орь ганцаараа ийн сууж байна гэдэг тийм амар

наанын юм биш ажээ. Аниргүй
бараан дайнд бол арай нигүүлсэхүй
чанартай, үл баригдам энэрэл
түшигээрээ хүний сэтгэлийг
бүлээцүүлж байдаг бол хүйтэн төмөр
мэт тэнгэрийн дор хязгаар хярхаггүй
цэлийсэн тув тунгалаг, цэв цэмцгэр
эл Аниргүй цагаан дайдад бол
өчүүхэн төдий ч тийм юм алга.

Нэг цаг, хоёр цаг өнгөрөв. Мэйсон
амьд л байна. Үд дундын алдад,
тэнгэрийн хаяанаа наран үл
үзэгдэвч, агаарт улаавтар туяа татаж
ирснээ төдөлгүй бүрийгээд явчлаа.
Мэйлмют Кид босч, өөрийгөө
албадан байж Мэйсонд дөхөж
очсоноо, гэнэт эргэн тойрноо

нэгжин харав. Аниргүй цагаан дайд
түүгээр тохуурхаад ч байгаа юм шиг.
Тэр аяараа айдаст автаад явчлаа.
Буун дуу огцомхон тасхийх нь тэр!
Тэр даруй Мэйсон тэнгэрийн орноо
халин, Мэйлмют Кид нохдоо
шавхуурдан шавхуурдсаар цасан
цагаан цөл дундуур хар эрчээрээ
алслан алслан одвой.

Алс тэртээх хязгаарт

Хүн алс холын хязгаарт одоходоо өөрийн хуучин дадлын олонхийг умартахаас буцахгүй, хувьсан буй амьжиргаандаа нийцсэн шинэ дадал олохноо ч бэлхэн байх ёстой билээ. Тэрбээр урьдын хүсэл тэмүүллээсээ хагацах ёстой төдийгүй сүсэлж байсан бурхнаасаа хүртэл буруулж, өнөөг хүртэл өөрийн үйл хэргийг бүтээж асан ёс суртахууныхаа хэм жудгаас ухрах нь олонтаа. Түүгээр ч үл барам дасан зохицох онцгой увидастай зарим нь шинэ сэргэг орчин ахуйгаасаа таашаал олох нь бий. Харин хүүхэд ахуйдаа олсон

дадалдаа яг баригдаж гүйцсэн
заримынх нь хувьд шинэ ахуйгаас
үүдсэн зовлон зүдгүүр тэсвэрлэшгүй
агаад тийм хүмүүс хувьсан
өөрчлөгдөж буй орчныхоо шаардаж
буй зүйлийг үл ухварлан, бие
сэтгэлээрээ тарчилж гүйцдэг жамтай.
Мөнөөх тарчлаан нь эсэн бусын
нүгэлт хэрэг өдөөхөд түлхэх төдийгүй
хүнийг элдэв зүйлийн зовлонд
унагана. Ийнхүү амьдралын шинэ
замаар замнаж эс чадсан нь тэр
даруй нутгаа тэмцэхээс сайн юмгүй
бөгөөд удаж төдөх нь түүний амь
насны үнэтэй цэнэтэй ч дүйж мэднэ.

Умардын ширүүн догшин балар
эртний эгэл болхи ахуйн төлөө

хуучны соёл иргэншлийн сайхнаас татгалзсан тэр хүний амжилтын хувь хэмжээ сэтгэлд нь балрахын аргагүй шингэсэн дадал зуршлынх нь тоо чанартай урвуу хамааралтай.гэдгийг ойлгох ёстой буй заа. Хэрэв тэр бүхнийг давж чадваас амьдрал ахуйн ая тух хамгаас чухал биш юм байна гэдгийг хүн аяндаа ухаардаг билээ. Тансаг чамин идээний оронд хээ шаагүй бүдүүн борог хоол идэх, арьсан гутлын оронд бугын арьсаар хийсэн эв хавгүй зөөлөн бойтог углах, өдөн зөөлөн дэвсгэрт бус хөрцасан дээр хажуулах мэтэд эцэс сүүлдээ дасчихдаг бүлгээ. Хамгийн бэрхтэй нь хамт байгаа, ялангуяа

ойр дотнын хүмүүстэйгээ хүний ёсоор харьцах тэр л хүслийг өөртөө төрүүлэх явдал юм. Тэр ч байтугай сэтгэлдээ оршсон эгэл хүндэтгэлээ хүлцэнгүй ивээл, эцэс мохоолгүй тэвчээр, амиа золиход ч бэлэн хязгааргүй хүслээр солих ёстой. Чухам тэгэж чадвал хариуд нь үнэлж баршгүй хишиг, нөхрийн үнэнч хайрыг хүртдэг билээ. Түүнээс талархлын үг хэн ч шаардахгүй, гагцхүү ачийг ачаар хариулж бүхнийг үйл хэргээрээ нотлох ёстой, товчхондоо худал хуурмагийг үнэн цагаанаар тэнсэх ёстой.

Умард туйлын алтны сураг ертөнцөд түгэж, хүмүүсийн зүрх сэтгэг Умар зүг

өөд тогтоохуйяа бэрх тэмүүлж эхлэх
яг тэр үед Картер Уэзерби албан
хаагчаар ажиллаж асан газрынхаа
халуун суудлаас ховхорч, нөөсөн
мөнгөнийхөө хагасыг эхнэрийнхээ
нэр дээр шилжүүлээд, үлдсэн
мөнгөөрөө аялан жуулчлахад
хэрэгтэй бүхнийг худалдан авчээ.
Оргилуун хүсэл гэхээр юм түүнд
байсангүй, тэр бүхнийг нь арилжаа
наймааны ажил аль хэдийн сорж
гүйцээд, мань хүн нэгэн хэвийн
уйтгарт албанаасаа залхаж, аз
сорьсон хэрэг хоосон хоцроохгүй
биз хэмээн, хувь заяандаа сохроор
найдан, зориглоод үзэхээр
шийджээ. Умардын анхдагчид олон

жилийн турш замнасан найдвартай
шалгагдсан хуучин замыг тэвчиж
чаддаггүй олон мунхаг улсын нэгэн
адил тэр хавар эрт гэгч Эдмонтонд
санд мэнд бууж, ёртой юм шиг
алтны хайгуулчидтай нийлжээ.

Хэтийн төлөвлөгөөг нь эс тооцвоос,
тэр хүмүүст ер бусын юм даанч
байсангүй. Бусад олон аянчдын
адилаар тэдний эцсийн хүсэл нь
Клондаик байлаа. Гэвч тэр хүслээ
гүйцэлдүүлэхийн тулд тэд зовлон
зүдгүүр, таамаглах аргагүй
санаандгүй явдлаар дүүрэн, Зүүн
хойд нутгийн хамгийн аймшиггүй
унаган хүмүүсийг ч мухардуулам
тийм зам сонгож авч. Жак Батист

хүртэл, бугын арьс бөгтөрсөн урцанд
жаран тавдугаар уртрагаас умар зүгт
уйлах дуугаа анх хадааж, ангалзсан
улаан аманд нь түүхий өөх чихэж
орхиход таг чиг болчихсон, Чиппева
овгийн индиан хүүхэн, Канадын
франц газарч хоёрын хүү агуу Жак
Батист хүртэл энд замын тухай
сонсоод мэл гайхжээ. Хэдий тэрбээр
энэ хүмүүст өөрийн тусыг худалдсан
ч, мөнхийн мөс цас хүртэл
газарчлахыг зөвшөөрсөн ч таны
зөвлөгөөг сонсьё п доо хэмээн
тэднийг хүсэхэд нь түйтгэр далласан
мэт тэр толгой сэгсэрсэн авай.

Аянчдын тэр нэг галтай нийлсэн үеэс
Перси Катфертын аз хийморь

харьжээ. Энэ хүн уг нь хамгийн эгэл нэгэн байсан агаад олсон боловсрол нь банкин дахь мөнгө шиг нь үлэмж арвин байж. Энэ ч бас бага юм биш. Гэнэн уяхан бодолдоо цаламдуулж орхисоныг эс тооцвол иймэрхүү үйл явдалд оролцох ямар ч шалтаг шалтгаан түүнд байгаагүй бипээ. Мань эр өөрийнхөө энэ байдлыг адал сонин явдалд дуртайнх, жинхэнэ урам зориг орж ирлээ хэмээн андуурчээ. Хүмүүс олонтаа ийнхүү эндүүрч алддаг бөгөөд үүнийхээ төпөө дэндүү өндөр төлөөс телдөг явдап ч бас байдаг. Аянчид хаврын эхээр Хандгайтын гол хүрч, цөн түрж дуусав уу, үгүй юу голоо

уруудан аяллаа. Хүүхнүүд, хүүхдээ дагуулсан эрлийз газарч нарын алаг эрээн жин хөвөрч, ачаа тээш нь арвин болохоор бүхэл бүтэн цуваа онгоц болчихов. Залхуутайяа жингэнэх ялаа шумуулыг үргээж дальдичсаар тэд өдөржин том жижиг завин дээрээ бөхөпзөн ажиллаж, завиа газраар чирэх хэрэг гарахаар хөлсөө цувуулан, хараалын муухайг дуудаж явцгаалаа. Хар бор ажил хүний сэтгэлийг дэндүү гүн гүнзгий нээдэг болохоор аянчид Атабаски нуурыг өнгөрөөгүй явахад цувааны хүн бүрийн үнэн дүр байдал, зан араншин аяндаа тодроод иржээ.

Картер Уэзерби, Перси Катферт хоёр адгийн залхуу, новшийн үглээ амьтас байж. Хоёулаа бусдынхыг цөмийг нь нийлүүлснээс хавьгүй илүүтэй өвчин зовлон тоочин гоншигноно. Хээр буудаллахад амжуулах ёстой үй түмэн ажлаас нэгийг нь ч тэд санаагаараа хийж байсан нь үгүй. Ганц хувин ус барьж ирэх, тэвэр түлээ хагалах, сав суулга угааж зүлгэх, новширсон олон юмнаас даруй хэрэг болсон юуханыг болтугай олох хэрэг гарахаар соёлт ертөнцийн сулбагар хоёр жаал шөрмөс сунах юм уу, цэврүү үсрэх мэтийн дав даруй эмчлэх өвчин өөрсдөөсөө хэдийнээ

олчихсон байдаг билээ. Оногдсон
ажлаа дуусгалгүй хамгийн түрүүн
орондоо шур-гана, өглөө
цайлахаасаа өмнө замд гарахад бүх
юмаа жин тан болгох естой атал
амьтны адагт босно. Хамгийн түрүүн
хоолны ард суух мөртөө хоол үйхэд
хамгийн сүүлд оролцон, шимүүстэйг
нь шүүрээд авах агаад хажуугийнхаа
хүний хоолыг цусалчихсанаа тээр
хожуу мэдсэн дүр эс-гэнэ. Сэлүүрдэх
болохоор гараа өргөх тоолондоо
сэлүүрээ усанд сул Унагаж орхиод,
завиа голын урсгалд хөвүүлж
алдана. Тэр бүхнийг хэн л аРав гэж
тэд дотроо бодох авч, нөхөд нь мань
хоёрыг дотроо битүүхэн Үзэн ядаж,

зүхэж эхэлснээр барахгүй Жак Батист тэднээр тохуурхан, өглөөнөөс үдшийн бүрийг хүртэл хараалын муугаар булсаар авай.

Их Боолын нуурын хөвөөнөө аянчид баахан нохой худалдан авч, хатаасан загас завиа дааж ядтал ачив. Түргэн урсгалт Маккензийн долгио тэднийг хөнгөхөн тосон, юман чинээ тоолгүй Их Хоосон Зайруу авч одлоо. Зам зууртаа бяцхан ч болтугай горьдлого хоргоосон горхи бүрийг нэгд нэгэнгүй судалж нэгжиж явсан ч алтны химэрлэг тэднээс алсарсаар, умар зүг өөд холдсоор авай. Үзэгдэж дуулдаагүй газрын сүрээс айж ширвээдсэн газарч нар

Их Баавгайн нуурын орчмоос алтны хайгуулчдыг орхин одож эхлэв.

Тэдний хамгийн сүүлчийнх нь, хамгийн зүрх цөстэй нь хүртэл Сайн Итгэлтийн хошууны дэргэдээс татлаганаасаа шүүрч, саяхан болтол мэдэж итгэж явсан голоо өгсөн завиа чирч тэднийг орхиж эхлэв ээ. Жак Батист ганцаараа үлдэв. Мөнхийн мөс цасыг хүрэн хүртэл аянчдыг дагалдана хэмээн тэр ам тангаргаа өгсөн билээ.

Төлөв дуулсан санасан төдийхнөөр бүтээсэн, үнэн худалд нь эргэлзмээр газрын зургаа тэд байн байн шагайж явсан агаад зуны наран хэдийнээ буцаж, Умард туйлын хүйтэн өвөл

айсуйг гадарлаж, яаравчлах
хэрэгтэйгээ эрхгүй мэдэрсээр
байлаа. Маккензи, Хойт мөсөн
далайд цутгадаг тэнгисийн буланг
тойрч гарсан аянчид Литтл-Пил
голын адаг руу орж ирлээ. Тэр үеэс
голын урсгал сөрсөн зовлонт зам
эхэлж, хэнд ч хэрэггүй хоёрын ажлыг
хийх нь хэзээ хэзээнээс илүү болов.
Завиа татлагаар чирэхдээ чирч,
заримдаа сэлүүр хатгуураар түлхэж,
харгиан дээгүүр чангаан газраар
үгтээх мэтийн зовлон зүдгүүр тэдний
нэгэнд амь золисон энэ мэт явдлаас
нэгмөсөн гутах сэтгэл төрүүлж,
нөгөөд нь адал явдалд хөтлөгдсөн
дэврүүн бодол юунд хүргэдгийг

барим тавим нотлоход хангалттай байлаа.

Тэр бүү хэл, мань эрс нэг удаа Жак Батистын адгийн муухай хараал зүхлийг үл тоон мөчөөрхөж, буудлаасаа хөдөлсөнгүй, Эрлийз эр тэдний цус нөжийг нь гоожтол нударгалаад, хүчээр ажиллуулав. Энэ бол тэдний амьдралдаа үзсэн анхны зодуур нь байлаа.

Литтл-Пил голын эхэнд завинуудаа орхисон аянчид Маккензи, Хулгана голын хөндийнүүдийг зүдэн ядан туулсаар зуны дийлэнхийг баржээ. Умардын агуу их усан зам Юкон мөрөн Хойд туйлыг огтлон гардаг

тэр газар түүнд нийлдэг Поркюпайн голын цутгал нь энэ Хулгана гол буй заа.

Гэвч өвөл тэднээс өрсөж, сал нь мөсөнд тулж орхингуут аянчид ачаа юугаа эрэг рүү яаран сандран зөөжээ. Шөнөдөө голын мөс хахалдан овоорч, аварга том мөснүүд хоорондоо тас няхсийн мөргөлдөцгөөж, дээр дээрээсээ овоорон байснаа, үүрээр үхлийн нойронд автах мэт бүх юм тас барьцалдан хөлджээ.

* * *

Слоупер эрхий хурууныхаа хумсаар

газрын зураг дээрх зайг хэмжсэнээ,

-Бид Юконоос дөрвөн зуун бээрээс холгүй байх ёстой доо хэмээн өгүүлвэй. "Хэнд ч хэрэггүй" хоёр ам хамхилгүй гомдоллож гоншигносон зевлөлдөөн өндөрлөх тийшээ хандаж байлаа.

-Хэзээ ч билээ дээ, энэ хавьд Гудзонын компанийн харуул байсан. Одоо юу ч үгүй болоодуджээ хэмээн Жак Батист өчив. Үнэт ангийн үсний компанид алба хааж асан Жак Батистын аав эрт цагт энэ хавийн газраар бядан хэрэн явсныхаа дараа хөлийнхөө хоёр хуруунаас хагацсан аж.

-Чи чинь өөрийн ухаантай байна уу!
Энд тэгээд цагаан арьстнууд байхгүй
юу хэмээн нэг нь дуу алдав.

-Ганц ч байхгүй - гэж Слоупер эрсхэн
өчөөд, -Гэхдээ бид нар Юкон
хүрчихвэл Доусон хүрэхэд таван зуун
бээр үлдэнэ. Тэгэхээр мянга орчим
бээр гэж бодож болно шүү. Уэзерби,
Катферт хоёр зэрэг сүүрс алдав.

-Үүнд хэдий хэрийн хугацаа хэрэгтэй
вэ, Батист?

Эрлийз эр түр зуурхан бодолхийлэв.

-Хэрэв бид бүгдээрээ чөтгөр шулмас
шиг ажиллах аваас арав, хорь, дөч,

тавь хоногийн дараа хүрнэ. Харин энэ нялхастай гэснээ, "Хэнд ч хэрэггүй" хоёр руу дохисноо, зууралдах юм бол хэзээ Доусон хүрэхийг мэдэхгүй. Аягүй бол тамын ёроол тас хөлдсөний дараа ч юм уу, магадгүй хэзээ ч очихгүй байж ч магад гэлээ. Цана, бугын арьсан бойтог хийх ажил нэг мэдэхийн зогсов. Аянчдын нэг нь байхгүй байгааг мэдсэн хэн нэгэн түүнийг дуудан хашгирахад мөнөөх эр түүдэг галаас холгүйхэн харагдах урцны босгон дээр гарч иржээ. Энэ урц Умардын нүд алдам дайдын олон нууцын нэг байлаа. Хэн, хэдийд барьсныг нь хэн ч үл мэднэ. Урцны

хаалганы дэргэд баахан чулуу
овоолон тэмдэглэсэн хоёр шарил
эрт цагийн харийн хүмүүсийн нууцыг
хадгалж байгаа ч юм уу. Гэтэл тэр
чулуун овоо хэний гараар боссон
байх вэ?

Шийдвэрлэх мөч ирлээ. Жак Батист
хөллөгөөний сур имрэхээ больж,
зөрүүдлэн зүтгэлэх нохдыг
саатуулна. Тогооч ийнхүү сунжирч
буйд зэвүү нь хүрснээ дуугайхан
илэрхийлж, шош бужигнан буцлах
тогоо руу хэдзк зүсэм гахайн утсан
мах чулуудаад, нэг юмны чимээ
авсан бололтой чих тавив. Слоупер
босч зогслоо. Түүний зүс царай эрүүл
саруул дүр төрхөө алдаагүй "хэнд ч

хэрэггүй" хоёрынхтой даанч харьцуулашгүй. Зовонгуй шарланги царайтай, сулбагар энэ хүн хумхаа өвчний бугшмал үнэр ханхалсан Өмнөд Америкийн хаа нэгтэйгээс дөнгөж ирчихээд байсан ч аялан жуулчлах хорхой нь дарагдаагүй, бусадтайгаа зэрэгцэн ажиллах чадалтайгаа байлаа. Түүний биеийн жин гөрөөчний хүнд хутгатайгаа нийлээд ерэн фунтээс илүүгүй агаад мөнгөн хяруу буусан үсийг нь харвал идэр залуу нас нь хэдийн улиран одсоныг илтгэх. Залуу зандан Уэзерби, Катферт хоёрын булчингийн тэнхээ түүний бяр хүчнээс арав дахин илүү ч, тэр хоёр

түүний хаа ч хүрэхгүй билээ. Тэрбээр өөрөөсөө хавьгүй бяртай улсыг, хүний сэтгэлд төсөөлөгдөж болох бүх л аймшиг, зүдгүүр тохиолдож мэдэх мянган бээрийн аянд өдөржин уриалан дуудсан юмсанж. Эртний тевтончуудийн шантаршгүй зориг, янкуудын шавхагдаш-гүй хүч, ов ухаан цогцолсон түүний биеийг оюун бодол нь хураан захирч, арьсугсаа нэгтнийхээ ухарч няцашгүй хүслийн биелэл болсон эр билээ.

-Гол хадаалангуут аян замаа хөөх хүсэлтэй байгаа нь "тэгье" гэж хэлэгтүн.

-Тэгье хэмээн хариулсан найман

хүний дуу хадаад явчихлаа. Тийн хэлэгсэд хожим олон зуун бээрийн зүдэргээт аяны туршид хувь заяагаа нэг бус удаа хараан зүхэх буй заа.

-Хэн эсрэг байгаа нь "үгүй" гэж хэлэгтүн.

-Үгүй!

Анх удаа "хэнд ч хэрэггүй" хоёр бие биеийнхээ хүсэл зоригий! хөндөлгүй ийнхүү санаа нэгсчээ.

-Одоо та нар яаж шийдэх юм? гэж Уэзерби түрэмгий гэгч нь дуугарав.

-Олонхийн саналаар, олонхийн

саналаар хэмээн аянчдын үлдсэн хэд түрхрэлдээд явчихлаа.

-Та нар бидэнтэй хамт яваагүй цагт аялал маань сүйрч магад гэдгийг би мэдэж л байна, гэхдээ хамаг чадлаараа зүтгэхэд бид та нартай, та наргүй яагаад ч гэсэн болгоно гэж бодож байна. Залуус аа, юу гэмээр байна?

Хариуд нь дэмжин орилолдох дуун чих дэлсэв.

-Сонсооч таминь, би яах болж байнаа гэж Катферт доройхон өгүүлэх нь тэр.

-Чи бидэнтэй явахгүй биз дээ?

-Үгүй... Тэгвэл юу дуртайгаа хийхгүй юу, чөтгөр аваасай билээ! Энэ одоо бидэнд падгүй!

-Чи өөрийнхөө найзтай зөвлө л дөө. Үдийн хоол пурхиилгэх ч юм уу пээ түлшинд явах болохоор тэр чамд сайхан сургаал хэлнэ гайгүй хэмээн Дакота нутгийн нэгэн залуу Уэзерби рүү заангаа хэлэх аж.

-Тэгэхээр бүх юм жин тан болох шив дээ. Маргааш бид замд гарна. Хамаг юмаа эцсийн удаа шалгаж, энд юу ч атугай мартаагүй гэдгээ мэдэхийн тулд таван бээр яваад түр амсхийнэ

хэмээн Слоупер эцэст нь өчив.

Болд төмрөөр бөгжилсөн чарганы царги чихран, амьдрах үхэхийн хувь оршсон хөллөгөөгөө чангаан ноход байрнаасаа алгуурхан хөдөллөө. Жак Батист Слоуперийн хажууд зуурхан азнахдаа, урцны зүг салах ёс гүйцэтгэсэн харц чулуудах ажээ.

Яндангаас нь цэнхэр утаа мэдэгдэхтэй үгүйтэй суунаглах агаад Юкон хийцийн пийшингээ галлачихаж. "Хэнд ч хэрэггүй" хоёр босгон дээрээ зогсоод, холдон одож буй чаргануудын араас ширтэн байлаа. Слоупер эрлийз эрийн мөрөн дээр гараа тавив.

-Жак Батист, чи Килкеннийн муурнуудын тухай дуулсан уу?

Нөгөөх нь дуулаагүй бололтой толгой сэгсрэв.

-За тэгвэл найз минь, Килкеннд хоёр муур уралцжээ. Уралцахдаа бүр зодооны дараа тэднээс юу ч үлдэхгүй болтлоо, үс ноосны өчүүхэн тасархай, яс арьсны өөдөс ч үлдэхгүй болтлоо үзэлцжээ. Ойлгов уу? Мөр ч үгүй гэж юуг хэлснийг ойлгов уу? Тэгэхээр байна шүү, энэ хоёр ажил хөдөлмөрт сэтгэлгүй, үүнийг бид мэднэ. Урт, харанхуй, бүх л өвлийн турш хоёулхнаа энэ муу урцанд үлдлээ, эд нар. Би Килкенний

муурнуудын тухай яагаад санасныг
одоо ойлгов уу?

Франц Батист хариуд нь мөрөө
хавчсан бол, индиан Батист харин
таг чиг болж орхилоо. Энэ бол муу
ёр зөгнөсний дохио билээ.

Эхний үед урцанд бүх юм сайхан
байлаа. Нөхдийнх нь гашуун
даажинтай үг Уэзерби, Катферт
хоёрыг өөрсдөдөө ноогдсон үүрэг,
хувь тохиолыг ойлгохоос аргагүйд
хүргэсэн бөгөөд эцсийн эцэст эрүүл
саруул хоер хүнд хийгээд байх ажил
ч ховорхон, Догшин эрлийз эр,
түүний хатуу гараас зайцсаны гайхам
үр шим ч гарав. Тэр үед Умардын их

замыг туулах зүдэргээт урт аянд
алжааж аяншиж явсан нөхөд нь, тэр
хоёр эхний үед нэг нэгнийхээ дээр
гарахаар яаж зүтгэж, жижиг сажиг
ажлыг хүртэц махран нухаж буйг нь
харсансан бол гайхан цочирдмоор
байлаа.

Тийнхүү айдас, түгшүүр аажимхан
замхарсаар авай. Урцыг гурван
талаас нь хүрээлсэн ой тайгад түлээ
түлш дуусахгүй арвин. Урцын
хаалганаас хэдхэн ярдын зайтай
Поркюпайн гол урсах бөгөөд шүд
хага ташим хүйтэн, цэв цэнгэг ус ууя
гэвэл түүний хучлагыг нүхэлсэн
цооног гаргахад л хангалттай. Гэвч
цооног байнга бин битүүрэн хөлдчих

учир тэр хоёрт үе үе сүх шүүрэх хэрэг
гарч, сүүлдээ бүр тэр зовлонгүй
ажлаасаа хүртэл төвөгшөөх боллоо.
Урц босгогч үл мэдэгдэх хүмүүс ард
нь идэш ууш хадгалдаг пин хүртэл
барьжээ. Тэнд аянчдын үлдээсэц
хүнсний ихэнхийг хадгалж буй
билээ. Аяганы хийц арвин, зургаан
хүнд элбэг хүрэлцэхээр ч амттан
гэхээр юм ховор, хүнсний дийлэнх
нь булчин шөрмөс чангаруулж, бяр
тэнхээ сэлбэхэд зориулагдсан идээ,
ууш. Бяр хүч жагссан хоёр эрд
даамай хүрэлцэх элсэн чихэр байсан
ч чихэртэй халуун ус ямар сайхан
амттайг тэр хоёр удаж төдөлгүй
балчир хүүхдээс дутуугүй ухаарч,

талхныхаа захыг түүндээ дүрж,
самнаа боовон дээрээ чихрийн
зунгаарсан цагаан шүүс нялж иддэг
болжээ.

Цай, кофе, ялангуяа хатаасан
жимсэндээ дэндүү их элсэн чихэр
хутгана. Тэгсээр сүүлдээ элсэн чихэр
тэдний эхний хэрүүл харгалдааны
шалтаг болов. Цагийн уртыг
хоёулхнаа өнгөрөөж буй хоёр хүн
хоорондоо хараал зүхэл урсгаж
эхлэхээр ямар олиг байхав.

Уэзерби улстөрийн бодлогын тухай
чалчих дуртай бол Катферт бичиг
цаастайгаа зууралдан төрийн хэрэгт
хошуу дүрэлгүй тайван байхыг илүүд

үзнэ. Энэ мэтийн яриаг тэрээр үл тэвчин, даажинтай хорон үг сонсохоороо өрвөсхийдэг нэгэн билээ. Катфертын оюун бодлоо халхалсан гял цал байдлыг үнэлж цэгнэхэд албан хаагчийн молхи толхи ухаан хүрэхгүй тээр болох агаад цаадах нь уран үгийн сайхнаар олныг мэлрүүлж орхидгоо эрхгүй үгүйлж, өөрийг нь сонсож, дуулах хүн үгүйд ихэд бачуурч сэтгэлдээ дүрэлзэх дарь хүхрээ дэмий хий гарздаж буйдаа байж ядна.

Урцанд хамт толгой хоргодож буйг эс тооцвол тэр хоёрт ээнэгшиж ижилсэх ганц юм, сэтгэл нийлэх

өчүүхэн зүйл ч үгүй. Уэзерби
насаараа албан хаагчийн ажил
хийсээр бичиг цаасны ажлаас өөр юу
ч мэдэхгүй, юу ч хийж сураагүй.
Катферт цагтаа урлаг судлалын
магистр байж, завандаа бийр будаг
ч нийлүүлж, утга зохиолд хүртэл
хүчээ сорьж явсан. Тэдний нэг нь
нийгмийн доод давхаргад
хамаардаг ч өөрийгөө соёлт хүмүүнд
тооцдог, тэгтэл нөгөөх нь үнэхээр
соёлт хүн, түүнийгээ ч гүнээ
ухамсарладаг авай. Үүнээс ургуулан
бодохуйяа соёлт хүн нөхрөө хүндлэх
бодь сэтгэлтэй байх албагүй ч мэт
санагдмой. Нэг нь эмзэг атлаа эрээ
цээргүй хар хүн атал нөгөөх нь гоо

сайхныг хоосон номлогч. и энх нь хуурамч зөгнөлийн биелэл байсан янаг амрагийн явдлын тухай өгүүлэх албан хаагчийн эцэс төгсгөлгүй яриа муу усны нүхний үнэр лугаа л соёл урлагийн эрхэмсэг магистрыг эвгүйцүүлнэ. Тэрбээр албан хаагчийг гахайтай хэвтэш хувааж амьдрах олиггүй адгуус гэж үзэх бөгөөд үүнийгээ өөрт нь палхийтэл хэлчихнэ. Хариуд нь Катферт үхээнц, хүний үнэргүй амьтан гэсэн үг дуулна.

Хорвоогийн алив бүхнийг амласан ч, хүний үнэргүй амьтан хэмээгч үгс яг тийм үед чухам ямар утга илэрхийлж байгааг Уэзерби

тайлбарлаж ч чадахгүй, гэвч доог тохуу, хорт үйлээ хийнэ, эцсийн эцэст үүнээс аймшигтай юм хаа байхав.

Арга ядсан хуурамч дүртэй Уэзерби "Бостоны дээрэмчин", "Хөөрхөн усан цэрэг" мэтийн олиггүй завхай дуу хэдэн цагаар орилох агаад Катферт уурласандаа нулимс унагахаас наахнуур юм болж сүүлдээ тэвчихээ болиод ухасхийн хаалга савж одно. Үүнээс илүү бухимдаж мухардана гэж юу байхав. Тасхийм жаварт удаан зогсох аргагүй, гэтэл хоёр ор, ширээ багтах арав, арванхоёрын умгар урц хоёр хүнд дэндүү давчуухан. Нэгнийхээ дэргэд байх нь

энэ хоёрын алинд нь ч доромжлол гутамшиг болж, цаг хугацаа хуучрах тусам хоёул дуугаа хураан дүнсийж, өдөр хоног өнгөрөхийн хэрээр улам ужиг, заналтайгаар амаа хамхин дүнсийсээр. Таг дуугүй байх үедээ тэр хоёр бие биенийхээ байгаа үгүйг мэдэхийг хүсдэггүй боловч заримдаа тэсч чадалгүй нүднийхээ булангаар биенээ хялайчихсан, үзэн ядсан байртай ярвайчихсан суудаг билээ. Басхүү дор бүрнээ сэтгэлийнхээ гүнд бурхан үүн шиг заваан ийм амьтныг яах гэж бүтээнэ вэ хэмээн өөрийн мэдэлгүй гайхна.

Гар хөсөр суусаар манай хоёр сүүл тийшээ цагаа яаж үрэхээ мэдэхгүй,

улам залхуу хөшингө болжээ.
Эцэстээ бүр бээрэнги нозооролд
автаад өөрсдийгөө сэргээх ч
тэнхэлгүй, өчүүхэн төдий ажил хийх
болохоор л өрвөсхийн уурлацгаадаг
болов. Нэг өглөө Уэзерби өнөөдөр
миний өглөөний унд зэхэх ээлж гэж
бодсоор хөнжлөөсөө сугарав.
пөхрийнхөө хурхирах дууг чагнангаа
дэнгээ асааж, пийшиндээ гал
өрдлөө. Тогоотой ус хөлдөөд гар
нүүр угаачих ч ус алга. Гэвч тэр бүхэн
түүнийг бүхимдуулсангүй. Тогоон
дахь мөс хайлахыг харзнах зуураа
тэр хаин утсан махнаас хэдэн
зүсмийг хэрчээд ам руугаа хийчихэв.
Дараа нь бингийн зуурмаг гурилаа

залхуутайяа хутгаж эхлэв. Гэтэл Катферт үүнийг нүднийхээ булангаар сэм харж байж. Энэ явдал хараал зүхэл, хэрүүлийн муугаар өндөрлөсөн бөгөөд түүнээс хойш өглөөнийхөө ундыг дор дороо бэлдэхээр шийдэцгээж, долоо хоногийн дараа Катферт хүртэл өглөөний угаал үйлдэхээ больсон ч өөрийн гараар бэлдсэн өглөөний ундааг их л амтархан зооглоход тэр нь өчүүхэн саад болсонгүй. Уэзерби бүр даажинтай инээмсэглэх боллоо. Түүнээс хойш өглөө босоод угаал үйлддэг мунхаг ёсыг тэр чигт нь халжээ. Элсэн чихэр бас бус амттаны нөөц хомсдох тийшээ хандсан тул

нэгнийгээ илүү идчих вий хэмээсэн
айдас түгшүүрээр тэд сэтгэлээ
хэмлэж, талуулж дээрэмдүүлчих вий
гэсэн шиг ам руугаа аль болох арвин
чихэж залгих боллоо. Шинэ ногоо
идэхгүй, түүний дээр хөшинги
нозооронги ахуйгаасаа тэд турж
эцэн, биеэр нь сэжиг хүрмээр нил
улаан юм туурчээ. Гэвч тэр хоёр
аюул заналын тухай бодохыг ч
хүсэхгүй байлаа. Төдөлгүй тэд
сэлхрэн хавагнаж, үе мөч нь
бамбайн, арьс нь харлаж, ам, буйл,
шүд нь өтгөн цөцгийнний өнгөтэй
болоод ирлээ. Хамгийн гайхмаар нь
өвчин зовлон тэднийг
дотносуулсангүй, харин эсрэг юм

болж, нэгийгээ чийг бамд идүүлж
буйг бах нь ханасан янзтай
тавлангуй харж байдаг болжээ.

Удалгүй тэд өөрсдийгөө бүр гаргуунд
нь хаяж, хүмүүний хамгийн эгэл
жудаг ёсыг ч умартав. Урц нь ёстой л
гахайн хэвтэш мэт новшроод хэн нь
ч ор дэвсгэрээ хураахаа больж,
дэвсгэрийнхээ шилмүүсийг сэлгэхээ
ч байж, болж өгвөл хөнжлөөсөө
сугаралгүй хэвтэхийг хүсэвч даанч
тэгэх аргагүй, тэсвэрлэшгүй
хүйтэрсэн болохоор пийшин нь
мундахгүй их түлш залгиж байлаа. Үс
нь туг тугаараа ширэлдэн унжиж,
нүүр царай нь үс хялгасандаа
баригдаад, хувцас хунар нь хуучин

хувцасны худалдаачин ч тоож
хяламхиймгүй навсархай юм болов.
Харамсалтай нь үүнийгээ тэд үл
тоомсорлох аж. Тэгээд ч энэ хүмүүс
өвчтэй, бас хэн ч тэднийг үзэж
харахгүй, нөгөөтэйгүүр босоод явна
гэхээр даанч шаналгаатай. Гэтэл ийм
олон зовлон зүдгүүр дээр шинэ
аймшиг нэмэгдэж, Умардын айдас
тэднийг нөмөрлөө.

Их хүйтэн, Их аниргүйн мөнхийн
дагуул нь тэрхүү айдас хүйдэс агаад
наран өмнө зүгт тэнгэрийн хаяанаа
нэгмөсөн шингэхүйеэ тэрбээр түнэр
харанхуй, арванхоёрдугаар сарын
тас хар шөнийг* (" Шөнө-Нар
тэнгэрийн хаяанаас дээш гарч, хойд

өргөрөгт (68 градуст) тусахгүй, 23-аас 176 хоног Умард туйлд харанхуй байх хугацааг туйлын шөнө гэдэг.) дагуулж ирдэг билээ. Айдас хүн бүрийн ааш авирт нийцүүлэн тэднийг өөр өөрөөр эзэмддэг ажээ. Уэзерби жолоогүй мухар сүсгийн түйтгэрт автлаа.

Орхигдсон булшинд хэвтэх хэн нэгний тухай хүйтэн бодол түүнийг сүүдэр мэт дагалдах агаад тэр хүмүүсийн сүнс босч ирж буй мэт санагдана. Энэ бол хий сүг. Тэд мөс шиг хүйтэн булшнаас зүүд нойронд нь хийсэн ирж хөнжил доогуур нь шурган хэвтээд өөрсдийн гаслант амьдрал, үхлийн өмнөх

тарчлааныхаа тухай өгүүлнэ.
Уэзерби тэдний зунгарсан тэврэлтээс
мултрахаар бүх биеэрээ агдчин
тэлчигнэх авч тэд түүнийг мөс шиг
хүйтэн өвөртөө тас тэвэрч улам улам
наалдах агаад ёрын зөнгөө чихэнд
нь шивнэхэд умгар урц аймшигт
бачуу хашгираанаар дүүрнэ. Катферт
юу ч үл ойлгоно. Уэзерби тэр хоёр
аль хэдийнээс үг солихоо болиод,
орилоон хашгираанаар нойрноосоо
цочин сэрэхдээ мань хүн давхийн
буугаа шүүрнэ. Дараа нь дагжин
чичирсээр орон дээрээ цомцойн
сууж, ухаан мэдрэлгүй хэвтэх хүн рүү
буугаа онилон тас атгаж суудаг
бүлгээ. Уэзерби солиорч байгаа байх

хэмээн түгшсэн Катферт өөрийнхөө
амь насны төлөө айж эхэллээ.

Гэтэл түүний өөрийнх нь өвчин арай
тодорхой шинж тэмдгээр илрээд
ирэх нь тэр. Урцны үл мэдэгдэх
барилгачин барилгаа дуусангуут
дээврийнх нь нэг үзүүрт салхины
чиглүүр босгож, чиглүүр байнга
өмнө зүгийг зааж буйг ажигласан
Катферт тэр хөдөлгөөнгүй байдалд
зэвүүцсэндээ нэг удаа өөрөө түүнийг
дорно зүгт эргүүлж орхижээ.

Тийнхүү мань эр шуналтай гэгч нь
өнөөхийгөө гөлөрсөөр байсан авч
салхины нэгээхэн ч исгэрээн
чиглүүрийг өчүүхэн хөдөлгөсөнгүй.
Тэгэхээр нь гараа дахиад хэзээ ч

түүнд хүргэхгүй, гагцхүү салхи хөдлөхийг хүлээнэ хэмээн өөртөө андгайлаад чиглүүрийг умар зүг рүү эргүүлж орхив. Агаар тэнгэр сэвхийх хөдөлгөөнгүйд ямарваа ер бусын, хүйт оргиулам учир зөн буй мэт санагдан Катферт чиглүүр хөдөлж үү, үгүй юү гэдгийг харахаар шөнө дунд хүртэл үе үе давхийн сэрдэг сэн. Хэрэвзээ үгүй ядахнаа арван градус ч гэсэн хөдөлсөн болов уу! Гэтэл үгүй шүү, хувь тавилан лугаа адил нөгөөх нь дээвэр дээр тэр чигээрээ эргэлт буцалтгүй Дүүжлээстэй. Катфертын хувьд тэр зүйл сүүлдээ сахиус шүтээн лугаа адил болжээ. Заримдаа өвчин зовлонд самуурсан ухаан бодол нь

атфертыг салхины чиглүүрийн заасан тэр зүгт авч одох мэт тийм гэхийн тэмдэггүй харанхуй бачуурал, айдас хүйдэс тас базаад авна.

Нэг мэдэхийн үл үзэгдэх, үл мэдэгдэх ертөнцөд оччихсон, мөнх оршихуйн эрхэн дор, зүрх сэтгэл нь тарчилж байх шиг санагдана. Энд Умардын бүх юм, амьдралгүй хөдөлгөөнгүй ахуй, түнэр харанхуй, эцэсгүй амгалан нойронд автсан газар дэлхий, зүрхний цохилт ч сандчааж орхимоор жигтэй нам гүм дайд, ухаан санаа хүрэмгүй, үгээр илэрхийлэх аргагүй, сэтгэл хирдхийм нууц агуулсан мэт ихэмсгээр сэрвийлдэх модод хүртэл түүнийг

зовиурлуулна.

Ард олон нь үймэн донсолж, агуу үйл хэрэг өрнөж байсан, дөнгөж саяхан түүний орхиод одсон тэр ертөнц яагаад ч юм тэртээ алсад байгаа мэт. Хэзээ билээ мэддэг байсан шуугиант худалдааны төв, хүн зон холхилдсон зам, гудам, хар фрак, язгууртны ёс жудаг. сайн нөхөд, сэтгэлд дотно бүсгүйчүүлийн тухай улиг болсон дурсамж нь үе үесхэн сэтгэлийг нь эзэмдэн авдаг ч бүүр түүрхэн тэр дурсамж ямар ч юм өөр гариг ертөнцөд, олон зууны өмнө амьдарч асан түүний тэс өмнөө амьдралд хамаатай мэт бодогдоно. Гэтэл бодит байдал гэхээр түүнийг

өдгөө хүрээлэн буй хачин жигтэй
явдлууд тодроод ирнэ. Салхины
чиглүүрийн дор зогсоод Умард
туйлын тэнгэр өөд ширтэхүйеэ, яг
энэ мөчид хаа нэгтээ амьдрал, хөл
хөдөлгөөн өрнөн буй Өмнөд гэж бас
байгаа гэдэгт яагаад ч итгэж
чаддаггүй билээ. Өмнөд гэж ч
байхгүй, төрж, амьдарч, хурим найр
хийдэг хүмүүс ч бас алга. Тэнгэр
газрын бүүдгэр савслагын тэртээд
хүнгүй холхи газар бий, түүний
цаана бүр ч уудам, хоосон орон зай
үргэлжилнэ. Нар мандан гийсэн,
цэцэг алагласан тийм орон энэ
ертөнцөд одоо лав байхгүй. Тэр
бүхэн диваажингийн тухай эртний

хоосон мөрөөдөл төдий зүйл мэт болжээ. Нарлаг Баруун, халуун ногооны үнэр анхилсан Дорно, инээд цалгисан орон-Аркадий гагц бурханы адис хүртсэн хувьтай хүмүүсийн арал буй заа.

-Ха, ха! Инээд хов хоосныг бусниулж, төсөөрч гүйцсэн энэ дуунаас Катферт хиртхийлээ. Нар дахиад үзэгдэхгүй. Харин үзэгдэж буй юм нь үхэл дуудсан цэв хүйтэн, хав харанхуй энэ орчлон, тэр ганц амьд амьтан нь, Уэзербиг яах вэ? Ийм цаг мөчид түүнийг хүн гэж тоох хэрэггүй. Энэ бол Катфертэд хэдэн зууны өмнөөс хадагдаж наалдсан калибан*, аймшигт сүг, мартагдсан

гэмт үйлийнх нь лай ланчиг билээ.

(* калибан-У.Шекспирийн "Щуурга"
(1612 он) жүжигт гардаг, адгуусыг
хүн болгож эрхшээлдээ оруулдаг
мангас)

Сэтгэлд нь оршсон аниргүй олон
зууны сохор хүчинд автаж, өөрийн
өчүүхнийг эрхгүй ухаарсан тэрбээр
үхэлтэй хамт, үхэгсдийн дунд
амьдарч байлаа. Хүрээлэн буй
бүхний сүр хүч айдсыг нь төрүүлнэ.
Гагц өөрөөс нь бусад бүх юманд
сэвхийх салхи, өчүүхэн хөдөлгөөн ч
үгүй хязгаар хярхаггүй цасан цөл,
тэнгэрийн өндөрт, анир чимээгүйн
тэртээд сүр хүчин оршин байлаа.

Энэ муу чиглүүр, үгүй ядахнаа
өчүүхэн ч атугай хөдөлсөн бол уу!
тэнгэрийн хамаг л аянга цахилгаан,
гал дөл ой тайгыг ниргээд, хуйхлаад
хаяхнаа ч яах вэ! Аймшигт шүүхийн
өдөр болж, хурмаст задарсан ч яах
вэ юу ч байсан яахав, ямар ч
хамаагүй нэг юм болоосой! Үгүй
шүү... Юу Ч алга, ямар ч хөл
хөдөлгөөн алга. Анир чимээгүй
ертөнцийг нөмрөөд, Умардын айдас
түүний зүрхийг мөсөн савраараа тас
базчих шиг болов. Гэтэл нэг өглөө
тэр, шинэ цагийн Робинзон Крузо
лугаа адил голын хөвөөнөөс шинэхэн
цаснаа дурайсан туулайн тавхайн
бүдэгхэн мөр оллоо. Түүний хувьд

мөр шинэ нээлтээс ялгаа юун.
Умардад амьдрал байна! Шуналтай
нь аргагүй харсаар, мань хүн мөр
мөшгиж, хавагнасан хөлөө ч
умартан, итгэл найдвараас улбаалах
түгшүүр юугаа тээсээр хунгар цас
туучин алхлаа. Сүүмэн цагаан гэгээ
бөхөж, тайга түүнийг залгиад авсан ч
тэр сүүлчийнхээ тэнхээг шавхан
зүтгэсээр, тамирдсандаа цас руу
шургачиж унатлаа урагшаа, гагцхүү
урагшаа алхсаар, тэмүүлсээр байсан
юм. Ёолох дуун цээжнийх нь гүнээс
өөрийн эрхгүй дуурсахад тэрбээр
туулайн мөр хий бодол санааных нь
үр байсныг гашуунаар ухаарч,
солиорч гүйцсэн биеэ зүхжээ.

Үдэш орой болсон хойно тэр дөрвөн хөллөн мөлхсөөр урцандаа ирсэн бөгөөд хацар нь хөлдөж, хөл нь нэг л жигтэй бадайрчихсан байжээ.

Уэзерби бах нь ханасан янзтай мушилзсан ч тусалъя хэмээсэнгүй. Катферт хөлийнхөө хурууны цэврүүг хагалан, зүүгээр сүлбэн, пийшиндээ ээн суусан агаад долоо хоногийн дараа хөл нь үхжиж эхэллээ.

Албан хаагч ч тамаа цайж байлаа. Үхдэлүүд оршил бунхнаасаа сүүмэлзэн босч ирэх нь улам олширч, өдгөө бараг түүнээс холдохыг болив. Тэдний ирэхийг мань эр зүрх шимшрүүлэн хүлээж, шарилын хоёр чулуун хөшөөний

дэргэдүүр өнгөрөх бүртээ дагжин
чичирнэ. Нэг шөнө унтаж байхад нь
үхдэлүүд түүн дээр ирж, араасаа
дагуулж одсон төдийгүй ямар ч юм
бэ ажил хийлгэв. Мань эр хэлж
боломгүй айдас хүйдэст автан,
овоолоотой чулуун дунд өөрийн
ухаангүй байгаад гэнэт сэрсэн
бөгөөд ум хумгүй урц руугаа
ухасхийжээ. Хацар, хөл нь
хөлдчихсөнийг бодоход тэр гадаа
бас ч удаан хэвтсэн бололтой.

Заримдаа үхдэлүүдийн зүрх халирам
нэхэл дагал түүнийг галзууруулж
орхих агаад далайн урцан дотуураа
холхиж, замдаа тааралдсан бүхнийг
хэмх хамх цохино. Хий сүгнүүдтэй

хийж буй тулааных нь үеэр Катферт хөнжилдөө шигдчихээд, хэрэв тэр ойртоод ирвээс гохоо дарахад бэлхэн буугаа тас атгаж солиотыг нүд салгалгүй ажсаар хэвтдэг авай. Тийм нэгэн самуурал галзуурлынхаа дараа ухаан орохдоо албан хаагч өөр рүү нь онгойж харласан бууны амыг харчихжээ. Сэжиг сэхээрэл төрөх шиг болж, тэр өдрөөс хойш мань эр бас амь насныхаа төлөө мөнхийн айдаст автах нь тэр. Тэр хоёр бие биеийнхээ араас сэм мөшгин, нэг нь араар нь өнгөрөхөд нөгөөх нь агдагасхийн түгшүүртэй гэгч эргэж хяламхийнэ, Түгшүүр нь сүүлдээ дэмийрэл болж хувираад

унтах нойронд нь хүртэл тайван байлгахаа болив. Айдас тэр хоёрыг цочроож, үгсэж хэлэлцээгүй ч үдэш хичээнгүй гэгч нь дэнгийнхээ тосыг сэлбэсээр, дэнлүүгээ хүртэл шөнөжин асаалттай орхино. Нэг нь өчүүхэн хөдлөхөд нөгөөх нь цочин сэрж, харц тулгарах төдийгүй бууныхаа гохон дээр хуруугаа чичрүүлсээр хөнжил дотроо айдаст автан дагжих нь энүүхэнд.

Умардын айдас, самуурал, өвчин зовлонгоосоо тэр хоёр хүн төрхөө алдаж, эцсийн бүлэгт улангассан зэрлэг араатан шиг болжээ. Хөлдсөн хамар хацар нь зэвхийрэн хөхөлбий даагаад, хөлийнх нь хуруунууд үе

үеэрээ өмөрч унах аж. Хөдлөх
бүрийд тэсэхүйеэ бэрх янгинавч
пийшин нь ханаж цадахыг үл мэдэн,
тарчилж гүйцсэн хоёрын бие
сэтгэлийг дуусашгүй зовлонд
унагана. Бас зүгээр ч үгүй жинхэнэ
Шейлок* шиг мөнөөх бие нь өдөр
бүр фунт мах шаардаж өлөн хомхой
сэтгэлээ амарлиулахын эрхээр тэр
хоёр шүд зуун ой руу салгална. Нэг
удаа унанги дархи олж ирэхээр ой
руу одсон хоёр нэг нэгийгээ
анзаарсангүй явсаар гэнэт
тааралдчих нь тэр. Үхдэл гэмээр
хоёр хүн нүүр нүүрээрээ улаан халз
тулчихжээ. Нажид зовлон тэгтэл нь
өөрчилсөн юм байлгүй, бие биенээ

таньсангүй, тэр хоёр. Айсандаа зүрх
зүсэм орлилдсоор ухасхийлдэж,
тулам болсон эрэмдэг хөл дээрээ
догонцсоор урцынхаа босгон дээр
ойчоод, эндүүрснээ ойлгон
ойлготлоо зэрлэг араатнууд мэт
биесээ хазалж, маажилцсан бүлгээ.

(* Шейлок-Еврей нарын домогг
гардаг, хүний шарилыг хөгцрүүлж
ялзруулдаг агуй. Тамтай адил
утгатай.)

Гэхдээ ухаан сэхээ ордог өдрүүд бас
бий. Тийм нэгэн ухаарал
сэхээрлийнхээ үеэр тэд хэрүүл
маргааны бай элсэн чихрээ эн
тэнцүүхэн хуваалаа. Идэш уушаа өөр

өөрийн уутанд хадгалах бөгөөд түүнийгээ их л сэрэмжтэй харж хямгадна. Ердөө хэдхэн аяга элсэн чихэр үлдсэн атал харин бие биедээ итгэх итгэлээс нь юу ч үлдсэнгүй. Тэгтэл Катферт нэг удаа эндүүрэв. Зовиур шаналалдаа тэнхэрсэн мань эр арайхийн өндийж гартаа аягаа тас зууран мөлхсөөр пин рүү очтол юу юугүй толгой нь эргэж, нүд нь харанхуйлаад өөрийнхөө уутны оронд андуураад Уэзербигийн ууттайг авчихжээ. Тэр явдал нэгдүгээр сарын эхээр, нар өвлийн замынхаа тэн хагасыг туулж, Умардын тэнгэрт үд дунд хуурамчхан шаргал гэгээт ташуухан

цацраг хаялан байсан тэр үед болсон юмсанж. Элсэн чихэртэй холбоотой эндүүрэл гарсны маргааш Катферт бие сэтгэл сэргэлэн, урьдахаасаа хавьгүй дээрдчихсэн босч иржээ. Үд дунд гэгээ татаад явчихад, түүний хувьд нар наашилж буйн дохио сүүмэн цагаан гэгээг харж баясахаар арайхийн гадагш гарчээ. Уэзерби ч хөнгөрч сэргэсэн янзтай түүний араас урцнаасаа мөлхөн гарч ирэв. Тэд өчүүхэн ч хөдөлгөөнгүй салхины чиглүүр дор цасан дээр суугаад хүлээж эхэллээ.

Эргэн тойрныг үхлийн анир чимээгүй нөмөрчээ. Өөр хязгаар

нутагт хаа нэгтээ байгаль ертөнц
ийнхүү ажин түжин болж орхивоос
ямар ч атугай үл мэдэг дуу гарч,
амьсгаа дарсан түгшүүрийг одоохон
сарниана даа хэмээсэн чив чимээгүй
хүлээлтийг хөдөлгөөнгүй ахуй нь
өөртөө агуулж байдаг буй заа. Гэтэл
Умардад огт тийм бус. Тэр хоёр хүн
ч дотор зарсхийм нам гүм дунд
мөнх амьдарч буй мэт. Тэр хүмүүс
улирч одсон цагийн ганц ч дууг үл
санах агаад айсуй цагийн нэг ч
чимээг үп төсөөлнө. Ер бусын тийм
анир чимээгүй хэзээд оршсоор
байсан бус уу. Тэр бол мөнхийн
амар амгалан билээ.

Тэд умар зүг нүд цавчилгүй ширтэнэ.

Өмнө этгээдэд дүнхийх уул
нуруудын цаана үл үзэгдэх наран
алгуурхан огторгуйн оргил өөд
мацсаар байлаа. Сүр жавхлант
үзэгдлийн цорын ганц гэрч болсон
хоёр хүн тэнгэрт хуурамчхан сүүмэн
гэгээ татуулсаар үүр манхайн цайж
буйг үзлээ. Сүүмгэр гэгээ улам улам
тодорсоор, өнгөө хувиргах агаад
улбар шар байснаа час улаарч,
сүүлдээ бүр ногоороод явчихав.
Тэнгэрийн өнгө эцэстээ жигтэйхэн
тодроод ирэнгүүт Катферт "Одоо ид
шид биелж, нар хойноос мандах нь"
хэмээн палхийгээд явчихлаа.

Тэгснээ хувьсан шилжрэх ч завдгүй
гэв гэнэт хурмаст хувирч, тэнгэрийн

өнгө будаг хувхайран гэгээ тасарлаа.
Хоёр эр цээжнийхээ гүнээс сүүрс
алдан гасалснаа арай л мэгшсэнгүй.
Энэ чинь юу гээч вэ? Цэв хүйтний
очис гялалзсан тоос агаарт дэгдэж,
чиглүүрийн там тум сүүдэр цасан
дээр умар зүгт сунан тусчээ. Сүүдэр!
Сүүдэр! Жин үд оолжээ. Тэр хоёр
цочсон мэт тэргүүнээ өмнө зүгт
эргүүлэв. Уулсын сэрэвгэр цаст оргил
дээгүүр алтан бөмбөлөгийн хүрээ
гялсхийж, ер бусын
инээмсэглэлээрээ тэднийг нүд
ирмэхийн төдийд ивээснээ дахиад
далд орчихлоо.

Тэд бие биеэ гайхан харахуйяа,
нүдэнд нь нулимс цийлэгнэчихсэн

байлаа. Тийм гэхийн тэмдэггүй
уярал харуусал зүрхэнд нь багтаж
ядна. Бие биенээ гэсэн цаглашгүй
хайр хүсэл оргилж буйг тэд
мэдэрчээ. Тийм ээ, нар айсуй!
Маргааш, нөгөөдөр, улиран одох бүх
л өдрүүдэд нар тэдэн дээр ирнэ.
Өдөр ч, шөнө ч наран гийх тэр цаг
ирэн иртэл, мандах бүртээ нар
тэнгэрт улам л удна, тэгсээр тэнгэр
газрын савслагаар алга болохоо ч
болих буй заа. Дахиад шөнө
болохгүй, мөсөнд баринтаглуулсан
өвөлч буцна. Салхи исгэрэнгүүт, ой
тайга өөрийн дуугаар хариу өгүүлнэ.
Газар дэлхий нарны туяагаар
адислуулан угаагдаж, амьдрал

сэргэнэ. Тэд ч энэ аймшигт зүүдээ сэтгэлээсээ таягдаж, хоёул өмнө этгээдэд, гэртээ харина. Өөрийн мэдэлгүй тэд өөд өөдөөсөө ухасхийн, гар барилцсан бүлгээ. Зэрэмдэг, тахир, хавдаж хүн харахын эцэсгүй болсон, зовлон үзсэн гар!

Гэвч тэр горь найдвар биелэх ёсгүй байж. Умард бол Умард. Тэнд хүний бяцхан зүрх, тэртээх холхи хязгаарт аялж үзээгүй хүмүүс хэзээч үл мэдэх тийм л хачин жигтэй цаазад захирагддаг бүлгээ.

Цагийн дараа Катферт бинтэй хайруулынхаа тавгийг пийшин дээрээ тавьж, гэртээ харьсных нь

дараа эмч нар хөлийг нь эмчилж чадах болов уу хэмээн эргэлзэн бодож эхэлжээ. Гэр орон нь өдгөө хүршгүй хол санагдахаа больжээ. Уэзерби энэ үед пин дотор юм хумаа ухаж төнхсөөр байлаа.

Гэв гэнэт тэсрэв үү яав гэмээр догшин хараал зүхэл тэндээс тачигнаснаа, гэнэт эхэлсэн шигээ таг чиг болчихов. Албан хаагч өөрийнх нь элсэн чихрийг хулгайлчихсаныг тийнхүү мэджээ. Хэрэв зээ үхдэлүүд чулуун доороосоо өндийн босч хэлсэн зүхлийг нь багалзуур руу нь эргүүлэн чихээгүйсэн бол бүх юм арай өөрөөр эргэх байж. Дараа нь тэд хаалгыг нь хаахаа мартаж

орхисон пингээс түүнийг сэмээрхэн гаргалаа. Эмгэнэлт төгсгөл дөтөлсөөр... Дуг нойрон дунд нь шивнээд шившээд байсан тэр зүйл одоохон биелнэ. Үхдэлүүд түүнийг сэмээрхэн, бүр чимээгүйхэн овоопоотой түлээ рүү аваачиж, гарт нь сүх бариулаад, дараз нь хаалгаа нээхэд нь хамжилцав. Тэр энэ бүхэнд нот итгэснээр барахгүй. түүний ард тэд хаалгыг нь яаж түгжиж, хаалга тар нярхийн яаж хаагдаж. түгжээний тээглүүр торхийхийг хүртэл тодхон сонссоноор барахгүй өөрт ноогдсон үйлийнхээ үрийг гүйцээхийг нь хүлээн, үхдэлүүд хаалганы цаанз

зогссоор байгааг мэдэж байлаа.

-Картер! Сонсооч, Картер!

Албан хаагчийн царайг харсан Перси Катферт хүйт даан ширвээтэж ширээний цаагуур ухасхийлээ.

Картер Уэзерби яаралгүй, тайван урагш алхах агаад царайд нь уур хилэн харамсал гунигийн аль нь ч үл үзэгдэнэ. Тов тодорхой үйл гүйцэлдүүлэх ёстой, түүнийгээ зайлбаргүй чанд биелүүлэгч нэгний жолоогүй мунхаг итгэл нүдэнд нь тодрох аж.

-Чи чинь яачихаа вэ, Картер?

Албан хаагч алхам ухарч, Катфертын хаалга руу одох замыг хаасан бөгөөд ганц үг ганхийсэнгүй.

-Сонсооч, Картер! Дуулж байна уу! Хоёул хэдэн үг сольё. Ухаараач дээ!

Соёл урлагийн магистр галзуурсан мэт тэчъядан байдлыг цэгнээд, шаламгай нь аргагүй тойрсоор "Смит-и-вессон" гар буугаа орхисон орондоо хүрэв. Ухаан нь зайлсан солиотоос нүд салгаагүй тэрбээр дэрэн доороосоо буугаа суга татан авав. -Картер!

Дарины гал, утаа Уэзербигийн нүд рүү манасхийнгүүт мань хүн зэвсгээ

далайн урагш ухасхийжээ. Сүхний ир ширхийн Катфертын нуруунд зоогдож, тэр дороо хөл нь алга болчих шиг болов. Тамиргүй хуруунуудаараа багалзуураас нь базаад авсан албан хаагч нэг л мэдэхийн хамаг хүндээрээ түүнийг дарж ойчсон байлаа. Сүхний битүү цохилт Катфертын гар бууг алдуулсан агаад биеэ чөлөөлөхөөр амь тэмцэхдээ бүүгаа эрэлхийлэн хөнжил дээгүүрээ салгалан тэмтэчжээ. Тэр гэнэт нэгийг санав. Ангийн хутга зүүлттэй байдаг албан хаагчийн бүснээс гараараа тас зуураад авч.

Тийнхүү тэд сүүлчийн удаа чанга

тэврэлдэн золгожээ. Хүч чадал нь түүнээс хэрхэн холдон одож буйг Перси Катферт гашуунаар мэдэрч байлаа. Бүсэлхийнээс нь доош юу ч үл мэдрэгдэнэ.

Уэзербигийн бие хамаг л хүндээрээ амь давчуулан дээрээс нь дарж, занганд орсон шармаахай шиг тэр унасан газраа хадагдаж хоцорчээ. хачин танил үнэр урцаар ханх тавиад явчихсан нь бин түлэгдсэн хэрэг байлаа. За энэ ч түүнд юуны хамаатай билээ. Өдгөө энэ бүхэн хэрэг олохоосоо нэгэнт өнгөрч. Пин дотор зургаан аяга дүүрэн элсэн чихэр үлдсэнсэн, ингэнэ гэж мэдсэн бол сүүлийн хэдэн өдөр юунд тэгж

хуруу хумсаа хуйхлан ариглав даа.
Хэзээ нэгэн цагт салхины чиглүүр
хөдлөх болов уу? Яг энэ мөчид
хөдөлж байгаа ч юм билүү. Магадгүй
шүү. Өнөөдөр нар үзэгдээ биз дээ.
Одоо тэр босч очоод харна. Үгүй ээ,
чадахгүй. Уэзерби ийм лагс хүнд гэж
тэр хэзээ ч бодоогүйсэн.

Урц ямар хурдан хүйт даадаг юм бэ.
Гал унтарчихсан бололтой, хүйт-ний
эрч чангарсаар авай. Одоо хэм
тэгээс доошлоо биз, хаалга аажуухан
мөсөөр бүрхэгдэн хөлджээ. Тэр
үүнийг хараагүй, гэхдээ мэднэ,
агаарын хэм доошилж байгааг
арьсаараа мэдэрч байгаа хойно.
Доод талын татуурга нь өдийд

хэзээний тас хөлдөө биз. Энд юу болсныг хүмүүс хэзээ нэгэн цагт мэдэх болов уу? Найз нар нь энэ явдлыг яаж хүлээж авах бол? Аяга кофе уух зуураа сониноос бяцхан мэдээ олж уншаад, дараа нь хаа нэгтээ клубт тэр тухай ярилцвал дээдийн заяа. Яриа хөөрөөг нь ч тэр тов тодорхой төсөөлж байна. "Өө зайлуул, Катферт уг нь гайгүй залуу байсан шүү" хэмээн шогшрох байлгүй. Зүйгуур хоосон үгэнд хөх инээд нь хүрсэн мань эр өөр зүйлийн тухай төсөөлж эхлэв. За тэр, мань хүн турк халуун усны газар хайж явна. Гудманд нөгөө л хүн зон холхино. Хамгийн гайхмаар нь

түүний хандгайн арьсан бойтог, цоорхой ноосон оймсыг нь хэн ч анзаарахгүй юм. За бараг хөлсний тэрэг авсан нь дээр биз. Ууранд сууж, усанд булхсэныхаа дараа сахлаа мөлчийтөл хусахаас сайхан юмгүй. Үгүй дээ, тэр юун түрүүн хоол иднэ. Бифштекс, төмс ногоо, ямар сайхан шинэ юм бэ! Энэ чинь юу вэ? Сархинаг дүүрэн бал, тув тунгалаг, нялуун сайхан үнэртэй... Ийм ихээр яах юм. Ха, ха! Ийм юм тэр хэзээч дахиэд амтлахгүй... Юу цэвэрлэх гэж?

Нээрээ тийм шүү. Тэр хайрцагдээр хөлөө тавив. Гутал тослогч түүнийг гайхан харах агаад хандгайн арьсан

бойтогтой яваагаа санан мань эр
бушуухан холдож одлоо.

Чиш! Аягүй бол салхины чиглүүр
эргэсэн дээ. Үгүй дээ, энэ зүгээр чих
шуугиж байна. Чих шуугиж байна,
тэгээд гүйцээ. Мөс өдийд хаалганы
оньс хүрчихээ биз. Дээд талынх нь
татуурга мөстчихсөн байж магад.
Таазны дүнзнүүдийн завсар
заальхайгаар, хөвд чихсэн
ангархайнуудаар бяцхан дугуй
толбонууд бурзайгаад эхэллээ. Эд
чинь яасан удаан гарч ирдэг юм бэ.
Үгүй ээ! Тийм удаан биш юм, тэр
дахиад нэг гараад ирлээ, тэнд ч бас
нэг. Хоёр... гурав... дөрөв... Одоо бүр
эд чинь тоолохын арга-гүй хурдан

гарч ирж байна. Тээр тэнд хоёр нүүгээд нийлчихлээ, гурав дахь нь бас хажуугаас нь нийллээ. Одоо олон тусдаа толбо үзэгдэхээ больж, бүгд сүлэлдээд тааз тэр чигтээ нил цанд бүрхэгдчихлээ.

За яахав, тэр орь ганцаар биш хойно. Хэзээ нэгэн цагт бүрээн дуун тасхийж Умард зүгийн анир чимээгүйг цочоох аваас тэд хамтдаа гар гараасаа барилцан эрлэгийн хааны цаазын өмнө зогсох болно. Тэнгэр бурхан тэднийг шүүнэ! Тэнгэр бурхан л тэднийг шүүнэ...

Перси Катферт нүдээ анин гүн нойронд автлаа.

Пассукийн агуу хайр

Битүү цан бурзайсан, зовиур дүүрэн нүдтэй чонын хоншоор майхны хаяаг хунируулснаа дотогш зүтгэллээ.

-Хөөе, Сиваш! Арил цаашаа, шулмасын зулбадас хэмээн майханд байсан улс нэгэн дуугаар бачимдан хашгиралдах нь тэр. Беттлз чонын хоншоор дундуур тугалган тавгаар дэлсээд орхитол толгой сая далдрав. Луй Савой үүд халхалсан өрмөг даавууг бэхэлж уяснаа, хөлөөрөө халуун хайруулын таваг хөмөрч, дээр нь бээрсэн гараа ээлээ.

Аймшигтай хүйтэрлээ. Хоёр
хоногийн өмнө спирттэй хэмжигч
тэгээс доош жаран найман хэмийг
зааснаа хага үсэрсэнээс хойш бүр
байж суухын аргагүй жаварлаж
тачигнасаар... Тасхийм жавар хэдий
болтол тийнхүү хүйт оргиулахыг
хэлэхэд бэрх. Тийм жавартайд
пийшингээс хол, мөс шиг хүйтэн
агаар залгиасай гэж дайснаа ч
хараамааргүй. Тийм хүйтэнд
гарахаар зориглодог зүрхтэй улс
бий. Гэхдээ тэд гол төлөв уушгины
хатгалга тусдаг. Дотор урсан хуурай
ханиалга ийм хүнийг багалзуурдан
давчдуулаад дэргэд нь өөх шараад
эхэлбэл хиншүүнд нь бүр яах ч учраа

олохоо болино. Хожим нь хавар зуны аль нэгэнд тэс хөлдүү газар тэсэлж, хаа нэгтээ шарилын нүх малтах хэрэг гарна. Шарилаа тийш нь хийгээд, дээгүүр нь хөвдөөр битүү хучин, хүйтэн жаварт тас тэврүүлсэн талийгаач аймшигт шүүхийн өдөр талийгаачдын ертөнцөөс бүтэн бүрэн, шалбархай ч үгүй босч ирнэ хэмээн нот итгэсээр, тэр чигт нь орхидог бүлгээ.

Тэр гайхамшигт өдөр хүн амь ордог гэдэгт итгэдэггүй улсад Клондайкаас илүү хойт төрлөө олоход таатай газар зааж өгөхөд хэцүү. Гэхдээ Клондаикт амьдрахад мөн тийм таатай гэсэн үг биш шүү дээ.

Майханд гадаах шиг хүйтэн
байгаагүй ч, дулаан гэмээргүй
жихүүн. Тавилга гэж хэлмээр ганц
юм нь пийшин бөгөөд хүмүүс
түүндээ бараг наалдах нь халаггүй.
Зарим газар нь нарсны шилмүүс
дэвсээстэй, дээр нь нэхий бүтээлэг
дэлгэж орхисон агаад дор нь цас
цайна. Майхны нөгөө талд
бойтогны уланд дагтаршсан цасан
дээр тогоо, хайруулын таваг гээд
Умардын хээрийн буудлын элдэв
агуурс хөглөрчээ. Бөөр нь улайссан
пийшинд хуурай мод тачигнан
дүрэлзэх аеч гуравхан алхмын зайд
дөнгөж сая голоос хагалж ирсэн
болов уу гэмээр хав хатуу том мөс

цайрах авай. Хүйтэн салхины аясаар
майхны хамаг дулаан дээш дэгдэж,
пийшингийн чанх дээхнэ яндан
гадагш гардаг дээврийн цоорхойн
гадуур хув хуурай өрмөг дугуйран
цайрч, уур савсуулах агаад
түүнийг тойрсон нойтон өрмөгнөөс
үс дусална. Майхны дээврийн үлдэх
хэсэг, хана тэр чигтээ хагас дүймын
зузаан, хуурай, цав цагаан цан
хүүрэгт битүү хучигджээ,

-О-о-о! О-ах! О-ах! хэмээн нэхий
хөнжил дороос нэгэн залуу нойрон
дундаа гэнэт орь дуу тавин ёоллоо.
Эцэнхий, зовлонт царай нь үс
сахалдаа баригджээ. Тэрбээр
өвчиндөө шаналан, нойрондоо улам

чанга, бүр ч зовиуртай ёолох аж,
Тэгтэл цээжин бие нь хөнжлөөсөө юу
юугүй дэвдчин сугарч, халгай дээр
унасан мэт дагжин чичирснээ
атийгаад хөшчихөв.

-Алив таминь, наад залуугаа
эргүүлээрэй. Дахиад татчихлаа
хэмээн Беттлзийт захирангуй
дуугаар хашгирахад зургаан нөхөр
нь өвчтөнийг тэр дор нь хайр
найргүй хөрвүүлэн өнхрүүлж, ухаан
орон ортол нь нухалан базалж, тал
талаас нь нударч цохилж гарлаа.

Мөнөөх залуу хөнжлөө хуу татаж
хаяад, орон дээр суух зуураа,

-Энэ цасан замыг чөтгөр аваасай хэмээн амандаа бувтнах аж.

-Би энэ нутаг орноор гурван өвөл тэнэлээ. Уг нь хатуужвал хатуужи-хаар. Хараал идсэн энэ хязгаарт ирснээсээ хойш хумсын төдий ч эр хүний шинжгүй. эмсийн явдалт грек шиг арчаагүй танхи амьтан болж хоцорлоо.

Тэр. галд ойртож суугаад тамхи ороож гарав.

-Намайг уйлагнах дуртай амьтан гэж бүү бодоорой. Үгүй дээ, би бүхнийг туулаад гарч чадна. Өөрийнхөө өмнөөс ичих ч шиг, тэгээд л тэр... Юу

ч гэмээр юм, тэр олиггүй гучхан бээр газрыг туулж ирчихээд, хотын хаяагаар таван бээрийн зугаалга хийгээд ирсэн сульдаатай хөхүүл хүүхэд шиг хамаг бие янгинаад өвчинд ээрэгдчихсэн хэвтэж байх ч гэж. Сэжиг хүрмээр юм! Чүдэнзтэй хүн байна уу?

-Битгий бүхимд, хүү минь -гээд Беттлз өвчтэй залууд чүдэнзний оронд галтай цучил авч өгсиөө эцгийн аргил дуугаар: -Хүн болгон үүнийг чинь дайрдаг юм. Чиний энийг өршөөж бололгүй дээ. Ядраа л биз, зүдрээ л биз. Би анхныхаа аяныг мартана гэж үү! Нуруугаа тэнийлгэж чадахгүй нь үү? Тэгдэг юмаа хөө,

хөлдүү цооногоос ус залгилчихаад дараа нь хөл дээрээ босох гэж арваад минут тамаа цайдаг явдал надад тохиолдож л байлаа. Яс янгинан, хамаг үе мөч тасармаар өвдөөд, галзуурахаа алддагсан. Татах уу? Бүх буудлынхан намайг хагас өдөр балбаж нүдээд ч тэнийлгэж чадахааргүй татаж тахийгаад хөшчихдөг байсан юм. Шинэ хүн боловч чи сайн хүү, чанга ч залуу! Жилийн дараа чи хөгшчүүл бидний цөмийнх нь бүснээс чангаах биз. Хамгийн гол нь, бие чинь яг хэвэндээ, олон чийрэг залуусыг элэнц хуланц руу нь цагаас нь өмнө илгээсэн тэр илүү дутуу өөх чамд

байхгүй юм.

- Өөх өө?

-Тийм ээ, тарган цатгалан мах шөл ихтэй хүн, тэр урт замд ягдчихдаг юм.

-Энийг чинь харин дуулаагүй юм байна.

-Дуулаагүй ээ? Энэ үнэн, эргэлзэх явдалгүй. Лухгар зузаан улс аливааг ухасхийгээд хийж чаддаг ч тэсвэр тэвчээр гэж тэдэнд үгүй. Хамгийн хэврэг улс. Туранхай, шөрмөслөг улс чинь л ёстой чанга, нэг зуураад авсан юмыг нь булааж авна гэдэг

нохойноос яс булаахаас долоон дор.
Үгүй, үгүй тарган цатгалан улсын
сачий нь санаагаа гүйцдэггүй гэлтэй.

-Үнэн юм хэлчихлээ, чи хэмээн Луй
Савой ярианд оролцож: -Би нэг одос
шиг хүдэр том залууг мэднэ. Умард
горхины тэнд газар хуваарилж шон
хатгаж эхлэнгүүт мань хүн Лон Мак-
Фейнтэй хамт тийшээ очсон юм.

Лоныг санаж байна уу? Үргэлж
жуумалзаж явдаг, жижигхэн, улаан
шар үстэй ирланд. Яахав тэд яваад л
байж, өдөржин алхаж, шөнө ч явж,
бүдүүн сүүлдээ тэнхээ тамираа
бараад, цасан дээр шургачиж унаад
эхэлжээ. Шөрмөслөг ирланд хархүү
түлхэж, татаж чангаахад цаадах нь

хүүхэд шиг орилчихно. Лон тэрнийг замын турш чирч гулдарч, түлхэж түрсээр миний буудалд хүргэж ирсэн. Тэгээд зүгээр ч үгүй нөгөөх нь манайд гурав хоног хөнжилдөө хэвтсэн. Эр хүн эмс шиг тийм арчаагүй байна гэж би ер бодож байгаагүй. Өөх хүнийг тэгэж л алдаг эд дээ.

-Аксель Гундерсон бас яалаа? гэж Принс асуув. Тэр зузаан том скандинав эр хийгээд түүний эмгэнэлт үхэл залуу инженерт дэндүү хүчтэй мартагдашгүй сэтгэгдэл үлдээсэн ажээ.

-Тэр тэнд хаа ч билээ, хэвтэж байгаа

-гээд Принс түмэн нууц агуулсан өмнө этгээд рүү гараараа хайнгадуухан зангав.

-Том хүн байсан шүү. Аль хэдүйнээс Давст усны хөвөөнөөс ийшээ цувсан бүх улс дотор хамгийн том нь тэр байсан. Бас хандгай агнадаг байсан - гэж Беттлз түүний амыг дагуулаад: - Гэхдээ ном ёсоороо нотлогдсоныг тэр тойроогүй. Түүний эхнэрийг санаж байна уу, Унча гээд. Дан булчин шөрмөс, унци ч өөхгүй, Тэрний зориг зүрх гэж, нөхрөөсөө хавьгүй илүү. Тэр хүүхэн бүхнийг туулан, ганцхан түүний төлөө л зүтгэсэн. Тэр бүсгүйн түүний төлөө хийгээгүй юм гэж энэ хорвоо дээр

байхгүй дээ, - Яах вэ, түүнд хайртай байсан биз. -Гол учир нь үүнд байгаа юм биш ээ! Тэр хүүхэн чинь... -Сонс л доо, ах дүү нар минь хэмээн идэш уушны юмтай хайрцаг дээр сууж байсан Ситка Чарли дэргэдээс нь ярианд оролцон: -Та нар сая хүдэр чийрэг, том эрсийг арчааг нь алдуулдаг илүү дутуу өөхний тухай, хүүхнүүдийн зориг цөс, энэрэл хайрын тухай ярилаа. Та нарын үг сайхан дуулдаж байна. Гэтэл би, энэ хязгаар нутаг идэр онгон, хүмүүсийн асаасан түүдэг өдрийн од шиг цөөхөн байсан тэр цагт надтай нүүр учирсан нэгэн эр, нэгэн хүүхнийг эрхгүй санах. Эр нь биерхүү зузаан,

чацтай ч чиний илүү өөх гэж
нэрлэсэн тэр юм түүнд гай болсон
байж магад. Харин хүүхэн нь биеэр
давжаа ч зүрх нь том бүр бухынх
мэт, эр хүний зүрхнээс ч том, зориг
тэвчээр ч гэж агуу. Биднийг Давст
Ус руу одоход зам гэж там, хунгар
цас, тасхийм хүйтэн, тарчлаант
өлсгөлөн бидний дагуул байсансан.

Тэр хүүхэн өөрийнхөө нөхрийг агуу
сайхан хайраар ивээж явсан, тийм
хайр бол жинхэнэ хайр.

Тийн хэлээд Ситка дуугаа хураан
дэргэдээ хэвтээ том цул мөсийг
сүхээр цохиж хэдэн мөс хэлтлээд
пийшин дээр байсан алт угаадаг

тогоо руу чулуудчихав.

Тэд ундныхаа усыг ийнхүү зэхнэ.
Эрчүүл түүнд дөхөн сууж, харин
өвчтэй залуу чичрүүдэс туссан биеэ
бүү янгинаасай гэсэндээ эвтэйхэн
суухаар дэмий л оролдох аж.

-Ах дүүс минь хэмээн Ситка цааш
өгүүлвэй.

-Миний судсаар сивашийн улаан
арьстаны цус гүйж байгаа ч зүрх
минь цагаан хүнийх билээ. Эхнийх
нь миний эцгийн лай ланчиг биз,
хөөрхий хоёр дахь нь харин нөхдийн
минь гавьяа. Намайг бүр балчир хүү
байхад л гашуун үнэн өмнө минь

нээгдсэн. Бүх хязгаар нутаг цагаан улс та нарын харъяаных, сивашууд цагаан арьстнуудтай үзэлцээд хүчин мөхөсдөнө, баавгай, буга үхэтхийн унадаг шиг бид цасан дээр төрөл арилжих юм байна гэдгийг би тэр үед мэдсэн билээ. Тэгээд би халуун дулаан газар руу ирж, та нарын дунд, танай голомтын захад сууж, та нарын нэг болсон. Амьдралынхаа туршид би ихийг үзлээ. Жигтэй хачин зүйл ч харлаа, олон овгийн улстай ертөнцийн түмэн замаар хэрэн тэнэлээ. Зон олны тухай, алив үйлийн тухай би та нар шиг тунгааж цэгнэдэг, та нар шиг бодож сэтгэдэг болсон. Тийм учраас хэрэв би ямар

нэгэн цагаан арьстаны тухай хатуу үг хэлвээс, та нар надад гомдохгүй гэдгийг чинь мэддэг. Бас эцгийнхээ овгийн хэн нэгнийг би магтвал та нар "Ситка Чарли-сиваш, түүний нүд буруу харж, хэл нь хальтирч байна" гэж дургүйцэхгүй байлгүй. Үгүй гэж үү?

Сонсож суусан улс түүний үгийг зөвшөөрч буйн тэмдэг болгон бөглүүхэн дуугарцгаах ажгуу.

-Хүүхний нэрийг Пассук гэдэгсэн. Давстай ус эргийг нь долоодог тэнгисийн булангуудын нэгний хөвөө орчмоор нутагладаг овгоос нь би түүнийг чамгүй их мөнгөөр худалдаж

авч билээ. Тэр хүүхэнд би зүрх сэтгэлээ зориулаагүй хойно түүнийг харахаас халирдаг байж. Урьд нь хэзээ ч харж яваагүй харийн хүний өвөрт хаягдсан хүний бүсгүй үрд ямар л олиг байхав. Харц нь үргэлж газар ширтээстэй, нэг л айдас хүйдэстэй, дорой нунж юм шиг санагддаг байлаа. Би хэлсэн шүү дээ, зүрх сэтгэлээ би түүнд зориулаагүй гэж. Гэтэл би алс замд гарахаар зэхэж, нохдыг минь тэжээж, голоор хөвөх эцэсгүй аяны үеэр сэлүүр барьж дэмнэх хэнбугай ч болтугай над хэрэгтэй байж билээ. Тэгээд ч ганц хөнжил хоёрыг дулаацуулж болдгоос хойш би Пассукийг

сонгосон юм. Би та нарт ярил уу, тэр үед Засгийн газарт алба хааж байсан гэж? Би чарга, тоног, ноход, хоол хүнсээ аваад цэргийн хөлөг онгоцонд сууж, Пассук надтай цуг явлаа. Би умар зүг Берингийн тэнгисийн мөсөн баринтаг хүртэл хөвөөд, тэнд Пассукуыг нохдыг минь буулгаж байхад, миний бие Засгийн газрын харъяат ёсоор мөнгө, урьд нь хүний мөр гарч байгаагүй тэр нутгийн газрын зураг, захидал сэлт гардан авч байж билээ. Захидал нь битүүмжилсэн лацтай, тэнгэрийн элдэв араншингаас найдвартай хамгаалагдсан байсан агаад би түүнийг агуу их Маккензи

голын ойролцоо мөсөнд тас хавчигдаад нам зогссон халим агнуурын хөлгүүдэд хүргэж өгөх ёстой байлаа. Бүх голын эх, бидний төрсөн нутаг Юкон мөрнийг эс тооцох юм бол орчлон дээр түүнээс том гол мөрөн гэж байхгүй билээ.

Гэхдээ энэ бүхэн тийм ч чухал бус, яагаад гэвэл миний өгүүлэх гэж буй бүхэн халим агнуурын хөлөгт ч, Маккензийн эрэгт өнгөрөөсөн догшин ширүүн өвөлд ч огтын хамаагүй юм шүү. Хавар нь өдөр урт болж, урь унангуут Пассук бид хоёр өмнө зүгийг барин, Юкон голын эрэг рүү хөдлөв өө. Хэдий хүчир бэрх, зүдэргээтэй аян байсан ч гэлээ наран

бидний замыг гийгүүлсээр байсан юм. Би түрүүн хэлсэн дээ, энэ хязгаар нутаг тэр үед хоосон зэлүүд байсан гэж. Бид Дөчдүгээр бээрт хүрэн хүртлээ эсвэл гох дэгээ чангааж, эсвэл сэлүүр савчуулан тувт урсгал сөрөн аялаж явсаар сая нэг цагаан царай харахад сэтгэл тэнийж, дорхноо эрэгт бууцгааж билээ.

Тэр өвлийн хахир хатууг ээ. Цэв хүйтэн, тас харанхуй ч боллоо. Араас нь өлсгөлөн нүүрлэв. Компанийг төлөөлөгч хүн бүрт ердөө л дөчин фунт гурил, хорин фунт гахайн утсан мах олгосныг яана. Шошны тухай бол ярих ч юмгүй. Ноход үргэлж улин, өлөн зөмөг ходоод гэдэс нь

хүмүүсийг тамлаж, улсын царайд гүн
гүн атираа үрчлээ суун, чийрэг нэг нь
сулбайж, сулбагар нь амьсгаа
хураасаар, бяцхан тосгонд үхжил,
чийг бам ноёллоо.

Нэг үдэш бид дэлгүүрт цуглаад, хов
хоосон лангуу тавиурын бараанаар
ходоод улам хонхолзон буйг бүр ч
гашуухан мэдэрсээр, хаврын бараа
харах хүмүүстээ зориулан лаагаа
далдын далд нуучихсан байсан
болохоор голомтын гапын сүүмэн
гэрэлд намуухан хүүрнэлдэж
суусансан. Тэгсээр сүүлдээ Давст Ус
руу хэн нэгнийгээ илгээж энд ийнхүү
аргаа барьж буйгаа хэлүүлэхээр
тогтсон даруй нэг харахнаа

хүмүүсийн тэргүүн миний зүг эргэж,
тэдний нүд надаас аврал хүсэн
дүрлийж байх нь тэр. Намайг хал
үзсэн аянчин гэж мэдэж байгаа
хэрэг. "Тэнгисийн эрэг дээрх
Хейнсийн төлөөлөгчийн газар хүртэл
долоон зуун бээр, тэр бүх замыг
цанаар туулах ёстой. Над хамгийн
чадалтай нохдоо, хамгийн шимтэй
хүнсээ өгөөд орхи. Би явъя. Пассук
надтай цуг явна" гэж би ам алдлаа.

Хүмүүс зөвшөөрцгөөв. Гэтэл тэндээс
өндөр Жефф гэдэг хүчирхэг. том янк
босоод ирпээ. Яриа нь баахан
онгиргон. Би ч гэсэн сайн аянчин.
цанаар явахын төлөөнөө хүн болсон,
зэрлэг үхрийн сүүгээр амласаи гээд,

надтай хамт явж, замд намайг
мажийчих юм бол өөрөө
төлөөлөгчийн газар хүрч, тэдний
захиас үгийг хүргэнэ гэвээ. Би ч тэр
үед залуу, янгуудыг муу мэддэг
байж. Онгиргон олон үг арчаагүйн
анхны шинж. их үйлийг гүйцэлдүүлэх
чадалтай улс хэлээ хазаж явдаг
гэдгийг хараахэн мэддэггүй байж. За
тэгээд бид хамгийн тэнхээтэй
нохдоо, аяганыхаа хийцтэй аваад
гурвуул замд гарлаа. Пассук, өндөр
Жефф бид гурав.

Та нар цөмөөрөө цасан талаар зам
гаргаж, тэс хөлдүү чарга түлхэн,
мөсөн овоолго дундуур зүтгэж үзсэн
болохоор тэр зүдэргээтэй аян замын

талаар би олон юм яриад яахав. Бид заримдаа өдөрт арван бээр зам туупдаг байлаа. Хааяа гуч хүргэнэ, гэхдээ гол төлөв арван бээр гэж хэлье та нарт. Хамгийн дөмөг хүнсээ бидэнд өгч явуулсан нь сайн ч хоол биш, тэгээд ч замд гарсан анхныхаа өдрөөс идэш уушаа ариглаж хямгадлаа. Хамгийн чадалтай ноход нь хүртэл арайхийн хөл дээрээ тогтох аядаж, өнөөдүүлийгээ чарганд зүтгүүлэх гэж бид тамаа цайж явлаа. Цагаан гол дээр ирэхэд бидний хөлпөгөөний гурван нохдоос хоёр нь үлдлээ. Гэтэл дөнгөж хоёр зуухан бээрийг туулжээ! Үнэндээ алдаж асгасан юмгүй, туйлдаж үхсэн

ноход амь мэнд байгаагийнхаа
ходоодонд орчихсон хэрэг.

Биднийг Пелли хүрэн хүртэл ган гэх
хүний дуу, ганц утааны суунаг ч
таарсангүй. Уг нь би дундарсан
хүнсээ тэндээс сэлбэж, замын ая
даалгүй цаг үргэлж гонгинож
гасалсан Жеффийг орхичихъё гэж
бодож явсан юм. Гэтэл Пеллид
байсан худалдааны суурингийн
агуулахууд хов хоосон, компанийн
төлөөний хүн уушгиа урагдтал
ханиаж, арай л багтарчихгүй, чичрэг
туссан бололтой нүд нь жигтэйхэн
гялапзаад байлаа. Тэр бидэнд
шашин номлоочийн эзгүй урц,
ноход ухаад зулгаачих вий хэмээн

чулуу овоолж дарсан түүний шарилыг үзүүлж билээ. Бид тэнд хэдэн улаан арьстантай тааралдсан. Тэдний дунд хүүхэд байсангүй, хөгшид үзэгдсэнгүй, үлдсэн тэр хэдээс цөөхөн нь хаврын бараа харах юм байна даа хэмээн эрхгүй бодож билээ.

Яахав, хоосон ходоодтой ч зориг мохоогүй бид цаашаа хөдөллөө дөө. Хейнсийн төлөөлөгчийн газар хүртэл мөнх цас, чих хулга дайр дундуур дахиад таван зуун бээр явах үлджээ. Жин үдэд ч тэнгэрийн умард савслагад нарны гэрэл огт хүрдэггүй, жилийн хамгийн харанхуй цаг... Гэхдээ мөсөн овоолго бас ч үгүй

сийрч, явахад арай хөнгөрлөө. Би нохдоо учиргүй шавдуулж, амьсгаа дарах завгүй довтолгов. Миний бодож байснаар болж, бид тувт цанаар явахаас өөр ямар ч аргагүй, нөгөө цана нь хөл янгинуулахыг яана, сүүлдээ эдгэж анидаг ч үгүй, нил шарх шалбархай болов. Өдөр өнгөрөх тусам тэр өвчин биднийг улам их тамлан тарчилгаж, нэг өглөө цанаа углаж байтал өндөр Жефф хүүхэд шиг мэгшээд явчих нь тэр. Би уг нь түүнийг жижиг чарганд зам гаргуулахаар явуулсан чинь мань хүн хөнгөнийг нь бодоод цанаа тайлчихаж, тэгэхээр ямар юмных нь зам гарах вэ.

Цааны арьсан гутал цасан дээр том том нүх гаргачихна. Ноход нөгөөх рүү нь өнхрөөд ойчно шүү дээ. Яс нь арьсаа нэвт сүлбэчихмээр тийм туранхай гуригхалсан амьтдын хөдөлж ядан явааг харах ямар хэцүү гаслантай вэ. Би Жеффийг үгийн муугаар харааж зүхээд эхэлтэл тэр дахиад цанаа тайлахгүй хэмээн амласан ч хэлсэндээ хүрсэнгүй шүү. Тэгэхлээр нь саваагаараа өгчилгөж орхилоо. Түүнээс хойш ноход маань цас үмхэж унахаа больсон. Жефф балчир хүүхэд шиг аяглана, аян замын бэрх зовлон, чиний тэр илүү өөх гэж нэрлэсэн юм түүнийг хүүхэд болгочихсон байсан юм.

Гэтэл Пассук! Эр хүн түүдгийн дэргэд сунаж унаад нулимсаа асгаруулж байхад, тэр хоол ундаа пурхийлгэж, өглөө нохдоо хооллоход минь хамжилцаж, үдэш хөллөгөөнөөс нь салгахад хүртэл дэм болно. Пассук л нохдыг минь үхлээс зайцуулж байлаа. Тэр хэзээний л нохдын урд цанатайгаа алхаж, тэдэнд зам гаргана. Пассук... та нарт юу гэж хэлэхэв дээ. Би тэр цагт түүнийг ингэх ёстой юм шиг санаж, тухайлж нэгийг бодоо ч үгүй явж, Толгойд маань өөр зүйл эргэлдэж, тэгээд ч би залуу, хүүхнүүдийг бага мэддэг байжээ.

Хаа хойно, тэр цагийг санан

дурсахдаа эвий эхнэр минь, миний эхнэр ямар хүн байсан билээ хэмээн сэтгэл шимшрэн боддог болсон юмсан.

Жефф сүүлдээ бүр гай болов. Тэртээ тэргүй нохдын маань тэнхэл тасарчихаад байхад мань хүн цувааны сүүлд гарахаараа чарган дээр сэмхэн хэвтээд өгнө. Пассук чаргыг нь өөрөө залахаар авснаас хойш Жефф бүр хийх юмгүй гар хөсөр боллоо. Өглөө бүхэн би ноогдох аяганы хийцийг нь түүнд үг дуугүй өгч, тэр ганцаар урагш түрүүлж бид хоёр юмаа бөөгнүүлэн чаргандаа ачаалж, нохдоо хөллөсөөр үлддэгсэн.

Бидний хорыг малтах мэт нар
үзэгдэхтэй үгүйтэй, үд дундын хэрд
нөгөөхийг чинь гүйцээд очиход бүр
дэмийрчихсэн, үйлж унжаад, хацар
дээр нь хамаг нулимс нь товууцаад
хөлдчихсөн,

арай гэж цаашаа сажлах аядаж явна.
Шөнө бид буудаллаж, Жеффийн
хоолыг цааш тавиад бугын арьсан
дэвсгэрийг нь дэлгэн, төөрөлгүй
олоод ирэг хэмээн ихээ түүдэг
ноцоож орхино. Хэдэн цагийн дараа
мань хүн дэгэн догон алхсаар ирж
гаслан зовлонгоо тоочсоор
өөрийнхөө ноогдлыг идчихээд унаад
өгнө дөө Өдөр бүхэн тийм юм
болно. Тэр хүн өвчинд дарлуулаагүй,

тэр аянд ядарч туйлдан, өлссөндөө
сулбайж гүйцээд, хийморь
лундаагүй болчихсон юм. Гэтэл
Пассук ч, би ч адилхан аяншиж
ядарч, ходоод хоосноосоо
тамирдаад, сөхрөхөөс наахнуур
байсан, гэхдээ бүх ажлаа жин тан
болгож явсан. Мань хүн болохоор
юун ажил. Бодоод байхнаа
Беттлзийн яриад буй илүү дутуу тэр
өөхөнд хамаг учир байсан бололтой,
аргагүй шүү дээ, бид нар тэрний
ноогдол хоолыг үг хэлгүй өгчихдөг
байсан юм чинь.

Гэтэл нэг үдэш Аниргүй цагаан
дайдаар тэнүүчилж яваа хоёр хий
үзэгдэлтэй зам дээр яг тааралдчихав

бид. Том хүн, хүүхэд хоёр. Цагаан арьстанууд. Ле-Барж нуурын цөн түрэхэд хамаг юмаа усанд алдчихаад, хүн болгон нөмөрсөн хөнжилтэйгээ үлдэж, тэр шөнөө түүдэг ноцоож, дэргэд нь хэвтэж хоног төөрүүлсэн гэнэ. Тэдэнд үлдсэн юм нь гэвэл жаахан гурил, түүнийгээ бүлээн усанд хутгаад, аажуухан оочлох. Тэр эрэгтэй хүн над уутны ёроол дахь найман аяга гурилаа үзүүлэв. Байгаа юм нь л тэр гэнэ. Гэтэл өлсгөлен нөмөрч эхэлсэн Пелли хүртэл дахиад хоёр зуун бээр шүү дээ. Бид хоёртой цуг нэг улаан арьстан зам нийлж явсан, аль байгаагаа түүнтэй хүн шиг хувааж

явсан боловч бидний аяыг
гүйцсэнгүй дээ хэмээн тэр аянчин
над хуучилж билээ. Тийм улс улаан
арьстантай идэх уухаа шударга
хуваалцсан гэдэгт нь харин би
итгэсэнгүй. Тэгвэл яахаараа эднээс
хоцорчихдог билээ?

Би тэр хүмүүст юу ч өгч чадаагүй.
Харин бидний хамгийн тарган
нохойг хулгайлах гэж оролдохоор нь
би гар буугаар чичин зүрхийг нь
үхүүлж, үтэр түргэн тонил гээд
хөөсөн юм. Яваад өгсөн дөө, нөгөө
хоёр (бас л танаггүй туранхай
амьтас) хий үзэгдэл чинь, яг л хөлчүү
улс шиг гуйвсаар Аниргүй цагаан
дайд дундуур Пеллийн чигт одсон.

Ингээд надад гуравхан нохой,
чарганууд маань үлдлээ. Ноход нь
гэж яс арьс. Түлээ бага байхад гал
яаж олигтой ноцох вэ, урцанд хүйт
хургана биз дээ. Бид тиймэрхүү л
янзтай байлаа. Ам хөдөлгөх төдий
юм идэж буй болохоор жавар голд
орчихно, нүүр царай маань хөлдөөд,
төрүүлсэн эх маань ч танимгүй тас
хар. Бас хөл янгинахыг нь яана.
Өглөө замаа хөөх болоход би арай л
хашгирчихалгүй шүд зууна. Цана л
тэгтэл тамладаг байсан юм. Гэтэл
Пассук уруулаа жимийх ч үгүй зам
гаргахаар түрүүлж одно. Янк нөгөө
янзаараа гасалж, гоншигносон
хэвээрээ.

Гуч дахь бээрт голын урсгал догшин,
зарим газар мөсөө хэмхлээд
харзалчихсан, бидний замд олон
ангархай хагархай таарч, заримдаа
бүр нил ус цэлэлзэж байлаа. Бид нэг
удаа хэзээний түрүүлж яваад амарч
хэвтээ Жеффийг гуйцдэгээрээ гүйцэж
билээ. Гэтэл хоорондуур маань ус
урсаж байлаа. Нөгөөх чинь мөсний
хөвөөгөөр тойроод ус гарчихсан. тэр
хөвөө хил нь чарганд дэндүү
давчуухан, бид нар хайсаар мөс нь
арай зузаан жаахан зурвас оллоо.
Цөмрөөд уначихвал хэрэг болно
хэмээн шилбүүрээ тас атгасаар
Пассук эхлээд гаталтал өөрөө хөнгөн
шингэн, цана нь өргөн болохоор

эсэн мэнд гарчихлаа. Дараа нь нохдоо дуудав. Гэтэл адгууст ямар юмных нь саваа, цана байхав, дороо цөмөрч урсгал тэр чигт нь залгиад авав. Би чарганыхаа араас тас зуурч, хөөрхий хэдийгээ тогтоогоод байтал хөллөгөө нь тас үсрэн, ноход яах ийхийн зуургүй мөсөн доогуур орчихож билээ. Ноход гуринхалж гүйцсэн хэдүй ч ямар боловч долоо хоног гол зогооно доо гэж бодож байсан маань тийнхүү талаар болов.

Маргааш өглөө нь би бүх хүнснийхээ өчүүхэн үлдэгдлийг гурав хуваагаад өндөр Жеффт хэллээ дээ, бидэнтэй хамт явна уу, үлдэнэ үү хүссэнээрээ бологтун, бид хоёр одоо хөнгөхөн

явна, хурдан явна гэлээ. Нөгөөх чинь
учиргүй орь дуу тавьж, өвчтэй хөл,
бэрх зовлон зүдгүүрээ дуудаж
гомдоллон, намайг адгийн хуншгүй
нөхөр гэж буруушаав. Гэтэл үнэн
хэрэгтээ Пассукийн хөл, миний хөл ч
бас янгинаж, нохдодоо зам гаргаж
явсан болохоор тэрнийхээс бүр
долоон дор зовиурлаж, бидэнд ч
тэсэхүйеэ бэрх байсан бус уу. Өндөр
Жефф цаашаа явснаас төрөл
арилжсан нь дээр хэмээн андгай
тавихаас наахнуур юм болов. Пассук
чив чимээгүй нэхий хөнжлөө авч,
би тогоо, буу хоёроо бариад
хөдлөхөөр завдтал хүүхэн Жеффид
үлдээсэн хүнсийг хяламхийн харснаа

"Энэ балчир амьтанд ийм их идэх юм үлдээх чинь мунхаг хэрэг биш үү. Нүд аньсан нь бараг шулуун даа" гэв. Би толгой сэгсрээд "Нөхөр хэзээд нөхөр байх ёстой" гэсэн чинь Дөчдүгээр бээрт үлдсэн хүмүүс ёстой жинхэнэ эрчүүл, тэд олуул, цөмөөрөө чиний тусыг хүлээж байгаа гэж Пассук над санууллаа. Намайг дахиад "үгүй" гэж хэлэв үү, үгүй юү тэр миний бүснээс бүүг минь суга татан булааж, түрүүн нөгөө Беттлзийн яриад байсан шиг өндөр Жефф нэг мэдэхийн өөрт нь ноогдсон хугацаанаас аль эрт элэнц хуланцынхаа араас явчихсан байж билээ. Би Пассукийг муухай хараасан

ч мань хүн гэмшиж харууссан янзгүй,
ер гутарсан ч шинж алга. Сэтгэл
зүрхнийнхээ гүнд түүний зөв гэдгийг
эрхгүй мэдэрч байсан л даа.

Ситка Чарли таг чиг болсноо пийшин
дээр тавиатай тогоо руу дахиад
хэдэн хэлтэрхий мөс чулуудлаа.
Эрчүүл дуугаа хурааж, тэсгим
хүйтэнд гомдоллосон мэт нохдын
урт урт улилдахад нуруугаар нь хүйт
даагаад явчихжээ.

-Нөгөө хоёр хий үзэгдлийн цасан
дээр хажуулсан тодхон мөртэй бид
өдөр бүр тааралдаж байсан агаад
Давст Усанд хурэн хуртлээ нэг бус
удаа шөнийг ийнхүү өнгөрөөнө

гэдгээ би битүүхэн гадарлаж байлаа. Яараа нь бид гурав дахь хий үзэгдэл, Пелли рүү яваа нөгөө улаан арьстантай нүүр учирлаа. Цагаан арьст том хүн, хүүхэд хоёр түүнд идэх юмны хувь хүртээлгүй хүний үнэргүй загнэсан тухай, гурил ч үгүй болоод гурав хонож байгээ зэргээ тэр ярьж билээ. Мань хүн бугын арьсан бойтогныхоо өөдөснөөс шөнөдөө нэг чанаж идэж явсээр, одоо бойтогноос нь ч бэраг юм үлдээгүй гэнэ. Тэр улаан арьстан эрэг хавиэр нутагтэй агаад түүний хэлийг ойлгодог Пассукээр хэлмэрчлүүлэн нэвтрэлцэж байсан билээ. Тэр Юконд хэзээ ч очиж

байгаагүй, тийшээ хүрэх зам ч
мэдэхгүй, гэсэн хэрнээ ямар ч гэсэн
тэр зүг рүү явж байсан юм. Хэр хол
вэ? Хоёр унтах уу? Арав уу? Зуу юу?
Энэ мэтийн юмыг тэр мэдэхгүй
боловч Пелли рүү зүтгэж байлаа.
Буцаад явнэ гэхээр дэндүү хол, түүнд
гагц урагш зүтгээд л байх үлдэж.

Тэр биднээс хоол хүнс гуйж
гувшсангүй, яагаад гэвэл бидэнд
өөрсдөд маэнь бэрх байгээг тэр
нүдээр үзсэн буй зээ. Дэгдээхэйнүүд
нь аюулд учирсан ятуу лугаа адил
Пассук нэг над руу, нэг мөнөөх улаан
арьстан руу бүлтэгнэн харж яахаз
шийдэж үл чадэн гайхширнэ. Би түүн
рүү эргэн "Энэ хүнтэй тэд даанч

олиггүй хэрьцаж. Өөрсдийнхөө жаахнаас илүүчлэх үү дээ" гэлээ.

Би түүний нүдэнд хязгааргүй баяр баясгэлан гялсхийхийг олж үзэв. Тэгснээ над руу, нөгөө улаэн арьстан руу цоргих мэт ширтэн, уруулаа гэнэт тас жимийн бодолхийлснээ "Үгүй ээ, Давст Ус хуртэл их хол, биднийг үхэл тосч байгаа. Тэр энэ харийн хүнийг аваг, миний нөхөр Чарлийг минь харин амьд үлдээг" хэмээн өчив.

Нөгөө улаан арьстан Пеллигийн зүгт, Аниргүй цагэан дайд дундуур алсарч одов.

Гэтэл шөнө нь Пассук шуг шуг уйлаад байлаа. Би урьд нь хэзээ ч түүний нулимсыг үзээгүйсэн. Тэгээд ч тэр нулимс түүдгийн утаанаас болоогүй, түлээ мод дан янхийсан хуурай юм чинь. Түүний уй гашуу намайг гайхуулж, тас харанхуй, өвчин зовлон хоёр хүүхний минь эр зоригийг нугалчихлаа даа гэж гашуудан бодож билээ.

Амьдрал гэж сонин эд шүү. Удаан эргэцүүлж, тэр тухай хичнээн тунгаан бодох тусам, өдөр өнгөрөх бүрт надад улам ойлгомжгүй санагдаад байдаг юм. Амьдралын төлөө эцэж цуцашгүй тэмүүлэл хаанаас бидэнд ирдэг юм бэ?

Үнэндээ амьдрал гэдэг хэзээ ч ялж болдоггүй тоглоом шүү дээ.

Амьдарна гэдэг өгөл нас чам руу сэмээрхэн гэгэн гэгсээр тулж иртэл шургаж унатлаа зүтгэн, зовж тарчилна гэсэн үг. Хөгширсөн хойно харин унтарсан түүдгийн хүйтэн нурман дээр сая гараа тайвуухан тавьж болно Амьдрах хэцүү. Зовж байж хүүхэд орчлонд ирнэ. өтөлж доройтсон хүн зовж зовж сүүлчийнхээ амьсгалыг хураана.

Бидний амьдралын едор хоногууд цөм уй гуниг. шаналал зовнилоор дүүрэн. Гэхдээ хүний үр өвөр задгай үхэл рүү очихдоо ямар дургүй, унаж тусан. эргэн хурган байдаг билээ.

Гэсэн хэдүй ч хэрэг дээрээ, үхэл ууч сэтгэлтэй. Гагцхүү амьдрал п хүнд зовпон авчирдаг. Гэтэл бид амьдралд хязгааргүй хайртай. үхлийг туйлгүй үзэн яддаг. Энэ үнэхээр хачин.

Бид хоёр цөөхөн үг сольдог байсан. Пассук бид хоёр. Шөнө нь бид цасан дээр үхсэн мэт хэвтээд өгнө, өглөө нь бас үхдэлүүд шиг чив чимээгүй өөрсдийнхөө замыг хөөж одно. Бидний эргэн тойронд бүх юм үхмэл. Ятуу ч үл үзэгдэнэ, туулай, хэрэм ч харагдахгүй. ер нь юу ч байхгүй. Гол мөрөн цагаан бэринтаг дороо таг чиг. Тайгад хамаг юм нам гүм. Жавар яг өнөөдрийнх шиг

тачигнана. Шөнө нь одод ойрхон,
улам ч том болчихсон юм шиг, үсэрч
харайж бүжиглэж буй мэт
санагдана. Өдөр нь цасан ширхэг
очир алмазны тоосонцор шиг
гялалзаж, агаар гэнгэрт очис хаялан
бужигнаад түмэн наран харж байна
хэмээн эндүүртэл наран ч бас
биднээр даажигнах бүлгээ Эргэн
тойрон дуу шуу ч үгүй, түүдэг ч үл
үзэгдэнэ. Гагц жавар салхи, Аниргүй
цагаан дайд цэлийнэ. Бид өдөр
гараг, цаг тооллоо бүр мартаж,
үхдэлүүд шиг гэлдэрцгээнэ. Зөвхөн
бидний хараа Давст Усны зүг
тэмүүлж, Давст Ус ухаан бодолд
маань хадагдаад. хөл маань өөрсдөө

биднийг Давст Ус руу чирч гулдран
явлаа. Бид хоёр Тахкиний хажууханд
амсхийхдээ тэр газрыг таньсангүй,
нүд маань Цагаан Адуутыг харж
байсан ч түүнийг гэж мэдсэнгүй, хөл
маань Каньоны газар дээгүүр
гишгэлж буй ч түүнийгээ мэдэрсэн ч
үгүй. Бид ерөөс юу ч мэдрэхээ
болив. Бид үе үе үхэдхийн унах
агаад тийн унахдаа хүртэл Давст
Усны зүг харна.

Үргэлж тэнцүүхэн хувааж асан бид
хоёрын аяганы хийцний сүүлчийн
үлдэгдэл дуусч, Пассук арай олонтаа
ойчоод эхэллээ. Тийнхүү явсаар
Бугатын давааны орчим түүний
тэнхэл бүр тасарлаа. Нэг өглөө бид

хоер ганц хөнжилдөө хэвтсээр замд гарсангүй. Би арай хэрсүүжиж, бүсгүй хүний хайр гэгч юу болохыг ухаарч эхэлсний учир Пассуктай гар гараасаа барилцан үхлийг тосч, тэндээ үүрд үлдмээр санагдаж билээ. Хейнсийн төлөөлөгчийн газар хүртэл дахиад наян бээр газар үлдсэн ч шуурга салхинд ноцуулсан агуу сүрлэг Чилкутын ихэмсэг тэргүүн тайгын дээгүүр тэртээ алсад цайвалзан байлаа. Тэгтэл Пассук гэнэтхэн надтай хөөрөлдөж эхэллээ. Намайг сайн гонсог гэсэндээ уруулаа чихэнд минь хүргэн хүргэн намуухан ярьж гарлаа. Өдгөө нэгэнт миний уур хилэнгээс айж ширвээтэхээ

больсон учир тэрбээр зүрх сэтгэлээ миний өмнө дэлгэж, миний урьд нь ойлгож ухаараагүй хайр сэтгэл хийгээд өөр олон зүйлийн тухай над хүүрнэж билээ. Тэр ингэж ярьсан юм.

"Чарли, чи миний нөхөр, би чиний сайн эхнэр чинь билээ. Би үргэлж чиний гал голомтыг асааж, чамд хоолыг чинь хийж өгч, чиний нохдыг тэжээж, сэлүүр барьж, зам гаргаж явсан, хэзээ ч гомдоллож байгаагүй. Эцгийн урц пүнхийсэн дулаахан, Чилкутад бидэнд идэш ууш элбэг дэлбэг байсан гэж би хэзээ ч хэлж байгаагүй. Харин чамайг ярихад чинь би сонсож суудаг. Чамайг

захирахад чинь би дуугүй дагадаг.
Тийм биз дээ, Чарли" ."Тийм ээ.
үнэхээр тийм" гэж би хариу өчив.

Тэр минь цааш өгүүлэв. "Чилкутад чи
анх бидэн дээр ирж, нохой авч
байгаа хүн шиг миний өөдөөс
хяламхийлгүй шахам худалдаж
аваад дагуулж одоход чинь зүрх
сэтгэл минь чиний өөдөөс
өрвөсхийж, айдас хүйдэс, уй
гашуугаар эрхгүй дүүрээд ирж
билээ. Тэр цагаас хойш их хугацаа
улирчээ. Чарли, чи намайг сайн хүн
нохойгоо хайрладаг шиг хайрлаж
явсан ч, зүрх сэтгэл чинь хүйтэн
хэвээрээ, тэнд миний багтах зай
байгаагүй, хүнтэй яаж л харьцах

ёстой тэр ёс жудгаар харьцаж, цаг
үргэлж надтай шударга шулуухан
байсан. Их үйл бүтээл, аймшигтай
аюул заналтай нүүр учрахаар явахад
чинь би чамтай хамт байж, чамайг
бусад эрчүүлтэй харьцуулж, тэдний
олонхиос хувь илүү байж, нэр төрөө
үнэнхүү хайрлаж хамгаалж
чаддагийг чинь, үг чинь ухаалаг,
хэлсэн чинь чигч шударга байдгийг
мэдсэн. Би чамаар бахархдаг
болсоон. Яв явсаар ни миний
сэтгэлийг эзэмдэж, миний бүх бодол
санаа зөвхөн гагц чиний төлөө зовох
тэр цаг ирлээ. Миний хувьд чи, мөнх
тэнгэрээс үл хагацан алтан жимээр
орчигч ид зуны наран билээ. Миний

нүд хаашаа ч харсан үргэлж
өөрийнхөө нарыг харж явсан. Гэтэл
Чарли минь, чиний зүрхэнд хүйт
хургаад, тэнд миний гэх зай алга
байсан даа".

Би ингэж хариулсан. "Тийм ээ,
үнэхээр тийм байсан. Миний зүрх
хүйтэн, тэнд чамайг багтаах зай
байгаагүй. Гэхдээ энэ чинь урьдын
явдал шүүдээ. Одоо мииний зүрх
нар буцдаг хавар цагийн цас шиг
болчихсон. Миний зүрхэн дэх бүх
юм хайлж, шувуу жиргэж, бүх юм
ногоорон цэцэглэж байна. Яагаад
гэвээс өвөл дийлдэж, ятууны дуу,
үүрч шувууны жиргээн, хөгжмийн
эгшиг дуулдаж байна. Пассук, би

бүсгүй хүний их хайрыг мэдлээ"

Мань хүн сэтгэл дүүрэн
инээмсэглэснээ надад улам чанга
наалдлаа. Харин дараа нь "Би
баяртай байна" хэмээн өгүүлээд
толгойгоо цээжинд минь наан, аяар
аяархан амьсгалсаар баахан
чимээгүй хэвтэж билээ. Тэгэж
байснаа тэр бүр шивнэж ярьсан.
"Миний зам энд дуусч байна. Тэнхэл
минь тасарчээ. Гэхдээ би дахиад
чамд хэдэн юм хэлмээр байна. Аль
эрт дээ, би бүр жаахан охин
байхдаа, эрчүүл гөрөөлөхөөр одож,
намнасан анг нь ойгоос авчрахаар
эрэгтэй хүүхэд, хүүхнүүдийг явчихсан
хойно Чилкутад аавынхаа урцанд

байн байн орь ганцаар үлддэгсэн.
Гэтэл хаврын нэг өдөр намайг
ганцаараа ангийн арьсан дээр
тоглож суутал, өвлийнхөө ичээнээс
дөнгөж сая сэрсэн өлөн зэлмүүн
гуринхалсан том хүрэн баавгай
зантагар толгойгоо овоохой руу
шургуулан, гэнэтхэн "Уух" гэж зүрх
зогстол хүрхрэх нь тэр. Миний ах яг
тэр үед ангийн олз ачсан эхний
чаргыг залаад ирж явж. Нөгөөх чинь
яах ийхийн завдгүй голомтноос
шатаж байгаа цучил шүүрч,
баавгайтай айж эмээсэн юмгүй ач
тач үзэлцэн, ноход чаргаа чирсээр
хөллөгөө юутайгаа баавгайны араас
зүүгдчихэв. Амь өрссөн тулаан болж,

их шуугиан дэгдэн, нөгөөдүүл чинь гал дээгүүр өнхрөн унацгааж, арьс үс ийш тийш чулуудан, төдөлгүй урц нураад ойчлоо. Сүүлдээ баавгайн зүрх үхсэн ч, миний ахын хуруу араатны аманд хоцорч, баавгайн саврын мөр түүний нүүрэнд сорви болон үлдсэн юм. Пелли рүү явж байсан тэр улаан арьстаны галд ээж суусан гарынх нь эрхий хуруу мухар байсныг чи ажигласан уу? Тэр бол миний ах... Би түүнд идэх юм өгөөгүй, тэр хоол хүнсгүй Аниргүй цагаан дайд дундуур одсон".

Ах дүү нар минь, Бугатын хавцалд цасан дунд амьсгаа хураасан Пассукийн хайр ямархан байж вэ?

Энэ бол агуу хайр! Дуусашгүй бэрх замаар тийм гашуун төгсгөл рүү өөрийг нь хөтөлж ирсэн эр хүний төлөө тэр төрсөн ахыгаа зольсон юм. Түүний хайр өөрийгөө золиход ч үл түвдэм тийм агуу байсан юм. Нүдээ сүүлчийн удаа анихаасаа өмнө Пассук миний гарыг чанга чанга атган хэрэмний арьсан дээлнийхээ хормой доогуур шургуулж билээ. Битүү юм чихээстэй жижигхэн уут бүсэнд нь уяатайг тэмтэрч үзээд, би бүхнийг ухаарав. Өдрөөс өдөрт бид өөрсдийнхөө аяганы хийцийг, сүүлчийнх нь ганц үмхийг хүртэл тэг дундуур нь талласаар байтал, тэр зөвхөн хагасалж идчихээд үлдсэнийг

нь надад өгөхөөр тэр уутандаа
нууцгай хийчихдэг байж.

Пассук хэлж байна. "За ингээд
Пассукийн зам төгслөө, харин Чарли
чиний зам дуусаагүй, агуу их
Чилкутыг даваы цаашаа тэнгисийн
эрэг дэх Хейнсийн телөөний газар
хүртэл зурайж байгаа. Тэр зам
цаашаа олон олон нарны зүг, харь
газар орон, үзэгдэж дуулдаагүй гол
мөрний зүг алсын алсад хөвөрч,
амьдралын урт урт он жилүүд,
гавьяа, агуу ялдар нэр зам дээр чинь
минь хүлээж байгаа. Тэр зам чамайг
олон хүүхнүүдийн, сайн ч
хүүхнүүдийн урцанд хөтөлж аваачна,
гэхдээ чи Пассукийн хайраас илүү

хайртай хэзээ ч учрахгүй"

Тэр чин үнэнийг өгүүлж буйг би мэдэж байлаа. Миний сэтгэл хирдхийгээд явчихлаа. Би нөгөө юм чихээстэй жижиг уутыг чулуудаж орхиод, андгай тавин учирлаваа. Пассукийн гал нь бөхөж буй нүдэнд нулимс мэлмэрээд ирсэн агаад арайхийн дуугарав. "Улсын дунд Ситка Чарли үргэлж чигч шударга хэмээн үнэлэгддэг. Түүний хэлсэн үг үнэн байдаг. Одоо болохоор нэр төрөө умартчихаад, Бугатын хавцалд хэрэггүй үг хэлэх нь үү. Хамгийн шимтэй хүнсээ, хамгийн тэнхээтэй нохдоо түүнд харамгүй өгсөн Дөчдүгээр бээрт үлдсэн улсыг

умартсан гэж үү? Пассук цаг үргэлж нөхрөөрөө бахархаж явсан. Одоохон босч цанаа углаад замдаа гараасай. Пассук хуучин шигээ түүгээр бахархмаар байна"

Миний тэвэрт түүний минь бие мөс шиг хөрчихсөн хойно сая би босч, нөгөө жижиг ууттайг олж аваад, цанаа углан, тэнтэр тунтар алхсаар замдаа гарч билээ. Өвдөг маань хариугүй сулраад байгааг би эрхгүй мэдрэн, толгой эргэж, чих жигтэйхэн шуугин, нүдний өмнүүр очис гялалзан жирэлзэх бүлгээ. Хүүхэд ахуй цагийн хэзээний мартагдсан зураг өмнө минь тодорно. Би бургилан буцлах тогоотой найрын

идээний дэргэд сууж дуу аялах юм. Идэр эрс хийгээд залуу бүсгүйчүүлийн сайхан дууны аянд, далайн морины арьсан бөмбөрийн дуунд би бүжиглэж, Пассук миний гараас хөтлөн, цаг үргэлж хамт явах ажээ. Намайг унтчихаар тэр аяархан сэрээнэ. Таварцаглаад унахаар дэмнэн босгоно, их цасан дунд төөрчихөөд бэдэрч явахад замд минь оруулж өгнө. Тийнхүү ухаан нь самуурч хачин хий юм үздэг хүн шиг, уусан дарснаасаа толгой нь хөнгөрч орхисон хүн шиг яван явсаар, би тэнгисийн эрэг дэх Хейнсийн төлөөний газарт хүрч билээ.

Ситка Чарли босч майхны үүдийг

сөхөн гарч одлоо. Жин үд болжээ.
Цэв хүйтэн наран бөмбөлөг өмнөд
этгээдэд Гендерсоны уулсын оройд
дүүжлээтэй мэт харагдана. Аалзны
тор мэт гялалзсан цан хүүрэг агаар
тэнгэрт хэрээстэй мэт үзэгдэх авай.
Өмнөхөн нь замын хажууханд
чонотой эндүүрэм адилхан, нил цан
хүүрэг болсон нэг нохой оцойн
суугаад дээш өлийн гаслантайяа
улих ажээ.

Сорвитой хүн

Шунал хомхойрол Жекоб Кентийг насан туршид нь хэмлэж буй билээ. Урхагт энэ өвчин үргэлждийн атгаг сэжгийг нь гааруулсаар, түүний ая занг үлэмж буртаглан, мань хүнтэй аливаа үйлийг бүтээхэд нэн бэрхтэй болгожээ. Тэрбээр эцэс төгсгөлгүй шаргуу, гэсэн атлаа ухаан мунхаг боольхойгоороо онцгой нэгэн агаад бас зүгээр ч үгүй зүүд нойрын өвчтэй.

Клондайкын хөл үймээн түүний цусыг хөөргөж, суурь машинаас нь ховх татах хүртэл Кент бараг өлгийтэйгөөсөө нэхмэлчин хийсэн

билээ. Жардугаар бээрт, Стюарт голын харуулуудын тэхий дунд, замын хагаст Кентийн урц байдаг бөгөөд Доусон орох замдаа түүгээр дайрдаг аянчид өөрийнхөө цайзад бүгчихээд харьяат нутгийнхаа зэлүүд замаар цувах жин хөсгөөс барьц, татвар хураагч дээрэмчин гүнтэй Жекоб Кентийг зүйрлүүлдэг авай. Уг нь иймэрхүү зүйрлэл бодож олохын тулд ямар ч атугай түүхийн мэдлэгтэй байх ёстой. Гэтэл Стюарт голын эргээс ирэгч боловсрол мэдлэгээр маруухан алтны хайгуулч нар төлөв доогтой гашуухан хоч гуншин давамгайлсан арай бүдүүн хадуун үгээр Кентийг авгайлдаг аж.

Нарийн яривал урц нь ерөөс түүнийх ч бус. Хэдэн жилийн өмнө энэ газар руу мод ачсан сал урсгаж ирсэн алтны хоёр хайгуулчин тэр урцыг барьсан аж. Алтны хайгуулч нар найрсаг зочломтгой улс байсан учир ийшээ ирэх замыг хэзээний мэддэг аянчид урц эзгүйрснээс хаа хойно ч хүй болохоос урьтан ийшээ яардаг байж. Буудал оромж барих цаг, хөдөлмөр хэмнэдэг хойно энэ нь ч тавтай, таатай. Урцанд хоноглосон хүн бүхэн дараагийнхаа хүнд өчнөөн тэвэр түлээ орхиод оддог бичигдээгүй хууль ёс хүртэл тогтжээ. Арэв гаруй хүн тэнд цугладаггүй шөнө ч гэж ховор.

Гэтэл үүнийг мэдсэн Жекоб Кент урц эзэнгүй гэдгээр гул барьж дураар суурьшжээ. Тэр цагаас хойш ядарсан аянчид шалан дээр хоног төөрүүлэх эрхийн төлөө эл луйварчинд хүн бүр нэг доллар төлөх ёстой болов.

Тэдний төлж буй алтан элсийг Жекоб Кент өөрөө жигнэнэ. Тэгэхдээ хүртэл ичихгүй луйвардахыг нь яана. Тэр бүү хэл түр толгой хоргодогсод түлээг нь хагалж, усыг нь барьж өгөхөөр ажил хэргээ зохицуулж чаджээ. Энэ нь хэдийгээр ичих нүүргүй дээрэм мөн ч гэлээ Кентийн золиос болсон улс түүнийг үзэн ядах атлаа хууль ёс эвдэн өөрсдийг нь шулан юмжиж буйд саад үл болох

тийм цайлган, хар хорын санаагүй
улс байлаа.

Дөрөвдүгээр сарын тэр нэгэн өдөр
Кент урцныхаа үүдэнд хавар эртийн
наранд жаргалтайяа тухлаад,
торондоо орох шинэ олзыг
шүлэнгэтэн хүлээх махчин аалз лугаа
адил зам руу харуулдан байлаа.
Эргийнхээ хооронд элбэг хоёр бээр
өргөн, хоёронтоо ихээ тохойрч,
өмнө умар зүгт тэртээ алс руу
цэлийсэн мөсөн далай Юкон тэр дор
цайрна. Түүний бартаат өөхий
дундуур чарганы зам өнгөрдөг
бөгөөд бүтэн хагас фут өргөн, хоёр
мянган бээр урт нарийхан жим цас
мөсөн дээгүүр эцэс төгсгөлгүй

зурайжээ. Тэр замын фут бүр нь бүх л Христийн ертөнц, түүний хилийн чанадад буй өөр ямар ч замаас хавьгүй илүү хараал зүхэл дуулсан билээ.

Жекоб Кент өнөөдөр сэтгэл өег гэж жигтэйхэн байлаа. Өнгөрсөн шөнө тэрбээр дээд амжилтаа эвдэж, их ч үгүй, бага ч үгүй хорин найман хүнд зочломхой зангаа худалджээ.

Мэдээж өөрөө тун тохьгүй хонож, тэдний дөрөв нь яг орных нь хажууд шалан дээр өглөө болтол тувт хурхирсан. эхдээ хүүдийтэй алтан элснийх нь жин хавьгүй хүндэрчээ. Гялалзсан шар эрдэнэ хадгалсан тэр уут Кентийн амьдралын хязгааргүй

баяр баясгалан төдийгүй бас
ёроолгүй зовлон тарчлаан нь юм.
Тэр өчүүхэн зайд там диваажин хоёр
тэрсэлдэнэ. Ганц өрөөтэй муу
урцанд хүний нүднээс далд юм
нууна гэж юу байхав. Цөлмүүлчих
вий хэмээсэн айдас цагийн мөнхөд
түүнийг тарчлаана. Үс сахалдаа
баригдсан ийм яргачингуудад тэр
муу хүүдийг хулгайлах даанч юу ч
биш. Эрдэнэсийг нь яаж хулгайлж
буйг тэр зүүд нойрондоо үргэлж
үзэж, хар дарсандаа агдагасхийн
сэрнэ. Тэр зүүд нь түүнийг салахгүй
дагасаар сүүлдээ бүр тонуулчдын зүс
царай жигтэй тодхон хоногшиж, тэр
дундаа тэдний толгойлогчийн

баруун хацар дээрээ сорвитой,
наранд түлэгдсэн хүрэл царай юу!
Тэр залуу бүхнээс олонтаа зүүдэнд
нь орно. Түүнээс айсандаа Кент
үүрээр огло харайн босч, урцны
гадна дотно хүүдийгээ нуух хэдэн
арван завсар заальхай бодож олох
бүлгээ.

Амин эрдэнээ нуучихаад мань эр
сэтгэлээ онгойтол санаа алдан,
хэдэн шөне амгалан нойрсоно.
Тэгснээ л гэнэт нэг шөнө зүүд
нойрондоо, нандин эрдэнийг нь сэм
хулуун одож буй сорвит эртэй эг
маггүй тулгарчихна. Хулгайчтай амь
наана тэмцэлдсээр давхийн
сэрэнгүүтээ Кент тэр дороо ухасхийн

гарч ууттайгаа арай өөр найдвартай,
далд газар дарна. Гэхдээ Кент
хоосон дэмийрлийнхээ сүрд
эргэлтгүй автчихсан гэж арай хэлж
боломгүй. Харин зөн совин, аюул
осол бодол, орон зайд шилжин
оддогт гүнээ итгэнэ. Яг тэр цагт хаа
нэгтээ өөр газраас сэтгэлээрээ
түүний алтанд халдаж буй амьтай
голтой, бодит хүмүүсийн хий биес нь
эл дээрэмчид мэт түүнд
төсөөлөгдөнө.

Тэгэх тусмаа Жекоб Кент толгой
хоргодох орон хайсан улсыг улам
улам цөлмөсөөр, хүүдийд нь орсон
унц алт бүхэн түүний зүдэг зовлонг
арвижуулсаар авай.

Урцныхаа үүдэнд нарлаж суусан
тэрбээр гэнэ сэнэгүй гялсхийсэн
бодолдоо хөтлөгдөн ухасхийн
босчээ. Хураасан алтан элсээ байн
байн жинлэх, дахин дахин дэнслэх
нь түүний хувьд жаргалын дээд.
Харамсалтай нь эдүгээг хүртэл
шийдэж чадаагүй нэгэн явдал баяр
жаргалыг нь багагүй гутаадаг бөгөөд
түүний дэнс дэндүү жижиг, нэг удаад
бүтэн хагас фунтээс (арван найман
унц гэсэн үг) илүүг жигнэж барахгүй.
Гэтэл мань хүнд багцаагаар бүтэн
гурав, гуравны нэг дахин их алт
хэдийнэ цуглачихаад буй билээ.

Бүх алтаа нэг доор дэнсэлж яагаад ч
болохгүй, эрдэнэс юугаан сэтгэл

бахдан урамтай сайхнаар харах
хүслийг нь энэ л хөсөрдүүлээд буй
мэт Кентэд санагдахыг яана.

Үүнгүйгээр олох долохын баяр тэн
хагасаар дундарна.

Тийм ээ, үл ялиг энэ мэт саад тотгор
ямарваа байдлаар зөвхөн утга учрыг
нь төдийгүй алттай болсныг нь
хүртэл үгүйсгэж буйг Кент мэдэрч
байсан аж. Энэ хүсэл зорилгоо
хэрхэн гүйцэлдүүлэх тухай бодол
гэнэт санаанд нь орсон учир сая
мань хүн огло харайн босчээ.

Зам руу хянамгайхан харснаа, хэн ч
үзэгдэхгүй байгаад сая итгэн
урцандаа орлоо. Ширээн дээрх

юмсаа нүд ирмэхийн зуурт хурааж, дэнсээ гаргаж тавиад, нэг тавган дээр нь арван таван унцын туухай орхиж, нөгөөх рүү нь алтан элс асгаж тэнцүүлэв. Дараа нь алтан нунтагаар туухайгаа солиод өчүүхний ч зөрүүгүй дэнсэлсэн гучин унцтай болов, тэгснээ тэр гучаа зяга руу савируулж, таваг алтан нунтагтай яг тааруулан жигнэв. Тийнхүү хамаг алт нь жинлүүр дээр багтах нь тэр. Хөөр бахдал, хязгааргүй цэнгэлдээ сайхь эр дагжин чичирч, хамаг биенийх нь хөлс асгарчээ.

Уутандаа байсан бүхнийг, сүүлчийн ганц ширхэгийг нь хүртэл хичээнгүй гэгч сэгсрэн унагахад энэ нь даанч

нэг саад болсонгүй. Мань эр дэнсний тэнцвэр алдагдан, аягануудын нэгийг ширээнд хүрэн хүртэл уутаа жингийн тавган дээр сэгсэрсээр байлаа. Дэнсээ дахин тэнцүүлэхийн тулд нөгөө аягандаа хорины нэг унцын ганц бяцхан туухай, алтны таван элсэн ширхэг аяархан унагалаа. Тэрбээр гайхаш нь тасарсан мэт, нэг мэдэхнээ тэргүүнээ гэдийлгэн жинлүүр рүү таг гөлөрчихжээ. Уут хоосорсон ч өдгөө тэрбээр хамгийн өчүүхэн элсэн ширхэгээс олон олон фунт хүртэл дуртай хэмжээнийхээ алтыг энэ дэнсэн дээр жинлэж болох юм байна гэдгийг нот мэдэж авчээ.

Мамона ийнхүү Кентийн зүрхэнд
хурц хумсаа шигтгэжээ.

Жаргаж байгаа нарны гэрэл
онгорхой үүдээр тусч, дэнс хийгээд
алтан шаргал ачааг нь нүд гялбам
хурцаар гийгүүлвэй. Хүрэл
Клеопатрагийн алтан хөх лугаа адил
эрдэнэсийн бумбагар овоолго
нарны туяанаа зөөлөн шаргал туяа
сацруулах ажээ. Цаг хугацаа, орон
зай зогсчих шиг.

-Хөөх! Таны наана чинь байгаа алт
хэдэн гиней хүрдэггүй юм бол
бурхан намайг залхааг! Жекоб Кент
овгосхийн эргэж харахын сацуу
бэлэн зэхээтэй хэвтээ хоёр амт буу

руугаа сарвайв. Гэвч заллагагүй
гийчний царайг хараад ухаан нь
зайлсан мэт өөрийн мэдэлгүй хойш
ухарчээ. Сорвитой хүн яг дүрээрээ!

Орж ирсэн хүн түүнийг сонжингүй
харах аж.

-За за, битгий ай. Танд, таны наад
хараал идсэн алтанд чинь би гар
хүрэхгүй хэмээн өчив.

Кентийн нүүрэн дээгүүр хөлс
дааварлан, өвдөг нь чичрэн буйг
ажигласан тэрбээр:

-Та чинь яасан жигтэйхэн хүн бэ! Тун
жигтэйхэн хүн юм гэж санаашрангүй

өгүүлэв.

-Ангархайдаа ус балгасан юм шиг яагаад таг болчихов. Хэлээ залгиж орхив уу? Эсвэл гай түйтгэр тохиолдоо юу гэж Кентийг арайхийн ухаан орж байх зуур мань эр дуржигнуулав.

-Таныг хаа ингэж орхио вэ хэмээн Кент гийчний хацрыг хага ярсан аймаар сорвийг салганасан хуруугаараа заасаар арайхийн дуугарахчаан аядлаа.

-Найз усан цэрэг маань миний нүүр рүү гротбом-брамселийн шонгоор дэлсчихсэн юм. Ер нь миний сорви

танд ямар хамаатайг мэдмээр байна. Та мэтийн хямсгар юмнуудад таалагддаггүй байж магад. Өөрийн чинь улаан нүүр янзандаа бол түүндээ баярлавал барав.

-Үгүй үгүй, надад зүгээр сонин... гэж Кент зовлонтой инээмээр аядсанаа явган сандалд лагхийтэл суулаа.

-Ер нь та хэзээ ч юм ийм сорви үзсэн үү гэж цаадах нь хилэнтэй гэгч нь тулган асуув.

-Үгүй ээ, үзээгүй.

-Сайхан байгаа биз, тийм ээ?

Гайхалтай гийчнийг тайтгаруулахыг хичээсэн Кент "Тийм, тийм" гэж, амыг нь дагуулан хэлж толгой дохилоо. Харамсалтай нь найрсаг эелдэг байх гэсэн түүний зүтгэл догшин шуурга даллахын чинээ санаагүй аж.

-Муу өмхий сагамхай загас, өгөр шалны арчуур мод! Бурхан тэнгэр хүний нүүрэн дээр хэзээ нэгэн цагт тавьсан им тамга шиг үзэшгүй муухай юм чамд сайхан харагдаа юу? Юу гэж ойлгох вэ энийг чинь, чи...

Дүрсхийн уурласан тэнгисийн хүү бурхан тэнгэр, ад шулмас, босоо

ороолон, хүн, түүний бүх л төрөл
нэгтнүүдийг дурссан, зүүд зөнд
оромгүй хараал зүхлээ тийнхүү аянга
цахилгаан мэт буулгаж гарав. Мань
эр ер бусын улангасч улайрсан дүр
эсгэж, үгээ нэг амиар
дуржигнуулсаар агаад Жекоб Кент
тэр чигтээ мэлэрчихэв. Тэр хамаг
биеэ хураан, хүнд нударганаас биеэ
хаацайлах гэсэн мэт гараа өргөн,
балбуулчихсан аятай сүр сүлд нь
зайлаад байтал сорвит эр сүржин
айлтгалынхаа төгсгөлд ч хүрэлгүй гэв
гэнэт цуурай хадтал инээж гарснаа:

- Нар гараад чарганы зам гэж там
хэмээн инээх зуураа арайхийн өчив.
- Над мэтийн ийм царай зүстэй

хүнтэй хоног төөрүүлэхдээ баярлана гэж найдахаас өөр арга алга, надад. Алив наад уурын зуухаа галлаач. би нохдоо хөллөгөөнөөс нь салгаж, хооллочихоод ирье. Арвихан түлээ авчраарай, ойгоос олдохгүйн зовлонгүй хойно бүү гутар анд минь, тэгээд ч чамаас өөр хэн сүх барихав, цаг заваас их юм алга чамд. Нээрээ. хувиндаа ус бариад ирээрэй. За за, шалавхан эргэж үз, тэгэхгүй бол чамайг үйрүүлээд үлээчихнэ шүү, тэнгэр минь!

Үзэгдэж дуулдаагүй юм болов. Жекоб Кент гал түлж, мод хагалж, ус барьж өөрийндөө толгой хоргодож буй хүнийг зүйл бүрээр бөөцийлж

эхлэв. Замын хажуугийн урцанд өөдгүй Шейлок гэгчийн үйлдэж буй хууль бус хэрэг явдлын тухай яриаг Жим Кардиджи Доусонд байхын дуулахаараа нэг болж. Тэр цагаас хойш Доусоноос наашлах замд Кентийн золиос болсон улстай бишгүй учирч, хүн бүхэн өөрийн гашуун гомдлыг тоочиж, түүний нүгэл хилэнцийн жагсаалтад юухан хээхэн ч болтугай нэмэрлэцгээсэн билээ.

Яахав, далайчин олныхоо адил Жим хатуу шоглоомд дуртай нэгэн хойно Кентийн урцанд хөл тавиад, эзнийг нь айлгаж номхруулахаар шийджээ. Бүх юм түүний санаснаас хувь илүү

сайхан бүтсэн нь хараажаар илхэн ч,
өөрийнх нь сорви энэ амьтанд
ямархан учир холбогдолтойг
даанч тааварласангүй. Гэхдээ чухам
юу Кентийн үнхэлцгийг хагартал
айлгасныг мэдсэн болохоор гартаа
орсон гүйлгээтэй бараанаас аль
болох ахиу ашиг унагахаар
улангасдаг өнөөгийн наймаачид
лугаа адил үүнийгээ сэтгэл төвдөх
юмгүй ашиглахаар шийдэв.

Бөгтгөнөн ажиллах гэрийн эзнийг
дагуулан харах зуураа:

-Чамайг шалмаг залуу гэж магтахгүй
юм бол миний нүд бүлтрэг хэмээн
тэр биширсэн байртай толгойгоо

гилжийлгэн өгүүлэв.

-Яах гэж чи алтны хайгуулч болсон юм бэ? Уушын газар эрхлээ гэж бурхан чамд зарлигдсан юм бишүү. Голоор нэг чиний тухай хэлэлцэхийг би бишгүйдээ дууллаа. Чамайг ийм овоо хүн гэж бодсонгүй.

Өөрийнхөө бууны цэнэгийг түүн дээр шалгахсан хэмээн Жекоб Кент тэчъядан шатаж байсан ч, сорвины нь ад мөрийн хүч арай дэндүү гэмээр байлаа. Зөн совин нь амин эрдэнийг нь булаан одож буй тонуулчийн Дүрээр дүрслээд байсан тэр хүнтэй амьдаар нь учирч, сорвитой нүүрийг нь харж байна.

Өөрийнх нь алтыг хулгайлахаар
өчнөөн удаа санаархан, зүүд
нойронд нь ороод байсан тэр этгээд
өдгөө мах цусанд төрсөн хүний биед
хувилчихаад байгаа нь энэ. Өөрөөр
санаж бодохын арга алга! Сорвит эр
Кентийг цөлмөхийн тулд хүн төрлийг
олоод өдгөө энд иржээ. Гэтэл энэ
сорви!

Зүрхнийхээ лугшилтыг зогсоож
дийлэхгүйтэй адил Кент түүнээс
өөрийн эрхгүй нүд эс салгана.
Соронзонт зүү туйлын зүг савлан
гозолздог шиг түүний харц, сэтгэл
зүрхнийхээ эцэсгүй чармайлтыг эс
хайхран, юм л бол усан цэргийн
царай руу эргээд мэлэрчихсэн байх.

Шалан дээр ороо засч байсан Жим Кардиджи санаандгүй өлийн харахдаа Кентийн түгшүүрт харцтай яг тулгарчихаад:

-Миний сорви яахаараа чамайг амар байлгадаггүй юм бэ? -хэмээн гэнэт уурсан хашгирснаа:

-Чамайг энэ тэгтлээ тарчлаагаад байгаа юм бол кливерээ (кливер-Дапайн хөлөг онгоцны гурвалжин дарвуул) хурааж, гэрлээ унтраагаад хэвтэхээс сайн юмгүй. Битгий наанаа бөртөгнөөд бай. Чамд хэлж байна шүү, дуулав уу, өгөр шүүр, тэгэхгүй бол чиний наад нармайг чинь чихчихнэ шүү, тэнгэр үзэг...

Кент дэнгээ унтраахаар гурвантаа үлээснийг бодоход ухаанаа гартал айчихаж. Бүр бугын арьсан бойтогоо ч тайлалгүй хам хум хөнжилдөө шургалаа.

Усан цэргийг шалан дээрх хатуу хэвтэртээ ороод төдөлгүй зэвүүн муухай хурхирч эхлэхэд Кент нэг гартаа үрлэн сумтаа тас атгаад харанхуй руу гөлрөн хэвтсээр байлаа. Далдхан газар нууж ч завдаагүй таван фунт алт дэрнийх нь хажуугийн сумны хайрцагт хэвтэж байгаа болохоор мань эр энэ шөнө нүд анилгүй хонохоор шулууджээ.

Хамаг байдгаараа хичээсэн ч тэр нэг

мэдэхэд дугхийж орхисон байх бөгөөд тэр тоопонд алт нь түүний зүрх сэтгэлийг хүнд ачаа аятай дарсаар байлаа. Хэрэв тэр зовлонт шүлэг нойрондоо тийнхүү автаагүйсэн бол, нойрон дунд нь түүнийг хий зөнгийн босоо ороолон ч зовоохгүй, маргааш өглөө нь Жим Кардиджи алт угаадаг түмпэнтэй тэгтлээ зууралдахгүй байж.

Голомтын гал сүүмэлзэж байгаад бөхөж, хүйтэн жавар дүнзний завсар заалхай, хөвдний сиймхийгээр сэнгэнэн, урц хүйт даагаад явчихлаа. Ноход цонхны дор гийналдахаа больж, цасан дээр байдгаараа цагираглан таг нойрсчээ. Хатаасан

загас хаа сайгүй өч төчнөөнөөрөө
хөглөрсөн, хөтөч нар ч байхгүй,
шилбүүр ч үл үзэгдэх диваажингийн
орон тэдний зүүдэнд эргэлдэнэ.

Гийчин урцанд хөзөр мэт
хөдөлгөөнгүй хэвтэж байсан атал
гэрийн эзэн хоосон зөндөө автан
зовиуртай эргэж хөрвөөсөөр авай.
Шөнө дундын хэрд тэр хөнжлөө
тийрчихээд орноосоо бослоо. Ганц
удаа чүдэнз шархийлгэлгүй түүний
хийсэн бүхэн нь нэн сонирхолтой.
Тас харанхуй байснаас ч тэр үү, усан
цэргийн хацар дээрх аймаар
сорвийг харахаасаа эмээсэн ч юм уу,
сайхь эр нүдээ нээсэн ч үгүй
тэмтэчсээр, сүмныхаа хайрцагны

тагийг нээж, гэнц ч ширхэг үйрмэг
унагалгүй үрлэн сумтынхаа ам руу
дарь цэнэг арвин гэгч чихэж аваад
дээрээс нь давхар чигжээсээр
бөглөн. басхүү хамаг юмаа байранд
нь эмхэлж тавьсны хойноо сая эргэж
хэвтлээ. Тостой цаас татчихсан
цонхоор үүрийн саарал гэгээ дөнгөж
тусгахад Жекоб Кент нүдээ нээсэн
бөгөөд тэр даруйхнаа тохой дээрээ
өндийн сумныхаа хайрцагны тагийг
нээж, доторхыг нь нэгжин харав.
Тэнд үзэж харсан юм нь, үнэндээ
түүний харахаасаа хэзээний
өнгөрсөн тэр юм нь, мань хүний хий
зөнгийн өвчнийг ч хөдөлгөсөнгүй,
үнэхээр гайхмаар нөлөө үзүүлжээ.

Тэгснээ унтаж буй усан цэрэг рүү
хялавхийгээд хайрцгаа чимээгүй
хаан цаашаа хараад хэвтчихэв.

Царайд нь ер бусын амар амгапан
байдал тодрон, нүүрнийх нь ганц ч
булчин татавхийсэнгүй, айж сандарч,
адгаж догдолсон шинж ч
үзэгдсэнгүй. Кент бодолд дарагдан
нэлээд хэвтсэнээ босч чимээгүй, яарч
бачимдсан юмгүй, тайван, ажиг
сэжиггүй ажилдаа орж эхэллээ.

Таазны дүнз рүү шааж орхисон
бахим дэгээтэй модон гадас
нойрсож буй Жим Кардиджийн
толгойн яг чанх дээр овойн харагдах
авай. Жекоб Кент хагас ямхын
бүдүүн олс тийш нь эвтэйхэн

чулуудаад, хоёр үзүүрийг нь доош
буулгаж, нэг үзүүрийг нь
бүсэлхийгээрээ ороон уяад,
нөгөөхөөр нь үхлийн гогцоо
зангидав. Дараа нь бууныхаа гохыг
татан баахан хандгайн арьсан сурны
хажууд гарын дор зэхэж тавив.

Өөрийгөө албадан, зоригоо
чангалсаар мөнөөх сорви руу харах
зуураа унтаа усан цэргийн хүзүүнд
гогцоогоо углаж хамаг биеэрээ хойш
ухасхийн чивчрүүлж орхилоо. Тэрхэн
хоромд ухасхийн буугаа шүүрч, Жим
рүү чиглүүлэв. Жим Кардиджи
амьсгаадан сэрсэнээ, өөдөөс нь
харлан онгойж буй бууны хоёр ган
ам руу хирдхийн гөлөрчихжээ.

-Хаа байна? хэмээн Кент олсоо арай
сулруулангаа асуув.

-Аа, чи муу...

Кент ахиад гэдэсхийн ухарч,
чивчирсэн олс Жимийн хоолойг
хяхтнуулав.

-Чи шулмын... муу... шүү... хр-р...

-Хаа байна? хэмээн Кент давтав.

-Юу? гэж Кардиджи сэхээ орж
амжив уу үгүй юү арайхийн
дуугарав.

-Алт,

-Ямар алт гэж учрыг нь олоогүй усан цэрэг бувтналаа.

-Ямар гэдгийг нь чи мэдэхийн цаагуур мэдэж байгаа, миний...

-Би тэрийг чинь нүднийхээ булангаар ч үзээгүй. Би чиний төмөр авдар уу!- Тэр чинь над падлий ч үгүй. Чиний алт хаана байгааг би мэдэх юм уу?

-Чи мэдэж байсан ч, мэдээгүй ч, хэлэхээс чинь нааш чамайг би боож алахгүй, хуруугаа хөдөлгөх гээд үзээрэй, тархийг чинь зад буудна шүү.

"Бурхан тэнгэр минь хараач гэж Кардиджи олс дахиад чангарангуут арайхийн хяхтнан дуугарав.

Кентийг олсоо сулрууласхийхэд усан цэрэг толгойгоо өөрийн мэдэлгүй хөдөлгөж буй аятай самбаачилж гогцоог жаахан сунгасаар бүр эрүүн дороо таарахаар болгочихов.

-За тэгээд хэмээн өчиг хүлээсэн янзтай Кент асуулаа.

Гэтэл Кардиджи доогтой нь аргагүй жуумалзана.

-Зүтгэ, зүтгэ, дүүжлээч, хараал идсэн новш.

Сүүлдээ Жимийн тооцоолж байсан зовиур зүдгүүр харин бүр инээдэм болж хувирав. Кардиджи Кентээс хүнд хойно. Кент арагш хичнээн зүтгээд ч, хичнээн уллаж гэдийгээд ч, усан цэргийг газраас хөндийрүүлж хүч хүрсэнгүй. Түүний бүх л чармайлт усан цэргийн хөлийг газраас хөндийрүүлээгүйгээр үл барам эрүүн доорхи олс нь нэмэлт тулгуур болж өглөө.

Гэлээ ч, Жимийг дүүжилж чадахгүйгээ мэдсэн Кент, эсвэл түүнийг ягуухан боомилж ална, эсвэл алтыг хаана нуусныг нь заавал хэлүүлнэ дээ гэсэн зуунги бодолдоо автан олсоо улам бүр чангаруулсаар

авай. Сорвит эр болохоор бас
боомилуулахгүйг байдгаараа хичээх
аж. Тав, арав, арвантаван минут
өнгөрсний эцэст Кент тэсвэр алдан
олзныхоо хүнийг шалан дээр нь
орхиж:

-За яахав -гээд хөлсөө шудран: -
Дүүжлүүлэх хүсэлгүй бол би чамайг
буудчихъя. Зарим улс дүүжлүүлэх ч
хувьгүй байдаг бололтой.

Кардиджи цаг хожих хэрэгтэй
байлаа.

-Чи энэ яршигтай явдлаараа
байшингийн шал л заваарууллаа.
Кент чи дуулж бай, би чамд хэлмээр

юм байна. Тархиндаа тунгааж үзье,
хоёулаа ярилцаад үзье. Чиний алтан
элс чинь алга болчихсон. Тэр
хаачсаныг намайг мэднэ гэж чи
ярьсан, би болохоор мэдэхгүй гэж
чамд хэллээ. Учрыг нь олоод хийх
юмаа тохиръё...

-Тэнгэр хараг! Үгүй шүү, энэ
байшинд би ганцаараа л хийх юмаа
хийнэ, харин чи ажиглаж, "учрыг нь
олж" болно шүү. Хөдлөх гээд
үзээрэй. Сэг болгож орхино шүү,
тэнгэрийн нэр барьж тангараглая.

-Ээжийг минь бодож...

-Тэр чамайг хайрладаг аваас тэнгэр

түүнийг өршөөг, Аа, чи яана гэнээ!..
гэснээ тэр өчүүхэн хөдөлснийг нь
далимдуулан усан цэргийн духанд
бууныхаа хүйтэн амыг тулгав.

-Хөдөлгөөнгүй хэвт! Хөдлөх л юм бол
чи дуусна...

Хэрэв Кент гохон дээр хуруугаа
байнга тавиатай байлгахаас өөр
аргагүй болсноо анхаарч үзэх юм
бол энэхүү ажил ер нь тийм ч
хялбаргүйг мэдэж цөхөх юмгүй.
Гэхдээ тэр юун төлөө
нэхмэлч байлаа, хэдхэн хором
өнгөрөөв үү, үгүй юү усан цэргийн
хөл гарыг дангинатал хүлэж орхив.
Дараа нь мань хүн Жимийг урцнаас

өргөн гаргаж, хана түшүүлэн,
гол хараа бэлчээж, нар чанх дээр
хөөрөхийг дураараа харж болох
тийм газар суулгалаа.

-Чамд үд хүртэл хугацаа олголоо
шүү, тэр үед...

-Юу?

-Тэр үед шууд тамд морилоорой.
Алт хаа байгааг хэлэх юм бол харин
үүгээр цагдаагийн анги дайрч
өнгөртөл би чамайг хүлээтэй
байлгана.

-Тэнгэр ивээг, бүр иймдээ тулсан уу!
Энэ чинь юу гэсэн үг вэ? Би ишиг шиг

гэмгүй, гэтэл чи бүр мангуурч
гүйцээд, юу хийхээ ч мэдэхээ больж,
юу юуны туханд хүрэлгүй намайг
тонилгох нь. Аа муу, зөнөг тонуулч!
Гайгүй ээ, чи...

Жим Кардиджи энэ удаа өөрөөс
ахдам хараал зүхлийн аянга буулган
сэтгэлээ онгойлгов.

Жекоб Кент тухтайхан суухаар
шийдэж урцнаасаа мухар сандал
гаргаж ирлээ. Зүсэм бүрийн хараал
зүхлийнхээ хамаг баялгийг бараад
усан цэрэг сая эрүүгээ хамхиж,
нэгийг тэчъядан бодсоор дорно
зүгээс үнэмшимгүй хурднаар хөөрч
буй нарыг нүд салгалгүй ажсаар.

Жимийн ийн удаан чарганд
хөллөхгүй байгаад үлэмж гайхсан
янзтай ноход нь эзэн дээрээ өөрсдөө
гүйж ирсэн бөгөөд эзнийх нь
арчаагүй нунж байдал тэднийг бүр ч
түгшүүлжээ. Ямар боловч түүнд
олиггүй юм тохиолдсоныг тэд
мэдэрсэн ч, чухам юу тохиолдсоныг
мэдэхгүй болохоор дэмий тойрон
гүйлдэж, гаслан гинших төдийхнөөр
эзнийхээ зовлонг хуваалцаж байлаа.

-Зайл цаашаа! гэж усан цэрэг ноход
руу хашгираад тэднийг хөөх
санаатай чийгийн улаан өт шиг
дэмий мурилзан байснаа ямар нэгэн
нүхний амсар дээр хэвтэж буйгаа гэв
гэнэт мэдрэв. Ноход тарж одонгуут,

Урьд нь надад үзэгдээгүй ямар нүх байдаг билээ, энэ чинь хэмээн тунгаан бодож эхэлжээ. Удсангүй гарцаагүй дүгнэлтэд хүрэв. Хүн гээч угаасаа залхуу, тэр зөвхөн зайлшгүй хэрэгтэй юмаа амжуулдаг, урц барихад дээврийг нь шороогоор хучих ёстой, шороогоо мэдээж хаанаас ч юм энүүхнээс авч таараа гэж Жим дотроо бодов. Нээрээ ч Кентийн эл урцыг барих үед шороо авч байсан тэр нүхний ирмэг дээр Жим хэвтэж байгаа бололтой. Хэрэв олигтойхон ашиглаж чадвал энэ нүх түүний амьд байх хугацааг уртасгаж чадах мэт санагдана. Тийнхүү Жим хамаг анхаарлаа өөрийг нь хүлж

багласан суранд чиглүүлвэй.

Гарыг нь нурууных нь ард зөрүүлээд
хүлчихсэн, дорхи цас нь хайлж эхэлж
байгаа агаад чийг авсан хандгайн
арьс амархан сунадгийг Жим юу эс
андах билээ. Гарынхаа хүлгийг улам
улам хүчтэй чангаасаар, үүнийгээ
аль болох мэдэгдэхгүйг хичээжээ.
Тэр зуураа мань эр харгуйч зүг нүд
тавин ширтсээр, алсад буй
Жардугаар бээрийн тэндээс мөсөн
овоолгын цав цагаан дэвсгэр дээр
хоромхоноо тодроод ирэх хар
цэгийг олж үзэнгүүтээ, нар өөд сэтгэл
нь түгшсэн янзтай, байн байн
хялалзаж эхэлжээ.

Хар цэг мөсөн овоон дээгүүр даван зам дээр нэг гарч ирснээ мөсний хоорондох ангал дундуур орон нэг далд оров. Юутай ч усан цэрэг Кентэд ажиг авахуулах вий хэмээн эмээсэндээ тэр зүг шуудхан хараачлаад байж зүрхэлсэнгүй. Кент гэнэт босч голын зүг хянамгай ширтэхэд Кардиджийн зүрх палхийн арай л зогсчихсонгүй.

Гэтэл яг тэр үед нохой хөллөсөн чарга замын мөсөн овоонд халхлагдсан хэсгээр давхиж өнгөрсөн болохоор үзэгдэх бараа нь алдарч, ашгүй аюул зайчжээ.

-Ийм олиггүй хэргийн чинь төлөө би

чамайг дүүжлүүрт өлгүүлнэ дээ гэж Кардиджи Кентийн анхаарлыг татах санаатай сүр бадруулан: -Чи тэгээд тамд шатаалгана, миний үгийг санаж явагтун! гэж байлаа. Тэгээд нэг хэсэг байзнаснаа:

-Сонсооч, чи... -гэж дахиад хашгиран: -Чи хий үзэгдэлд итгэдэг үү? гэжээ.

Кентийг агдагасхийн цочингуут, зөв юм хийж байгаагаа мэдэрсэн Жим цааш нь ийн өгүүлэв.

-Хий үзэгдэл хэлсэн үгэндээ хүрч чадаагүй хүн дээр ирдэг. Найман цаг хагасаас наана намайг нөгөө

ертөнцөд илгээнэ гэж бүү санаарай.
Өөрөөр хэлбэл, арван хоёр цагаас
өмнө гэж би хэлэхийг хүссэн юм.
Яагаад гэвэл хэрэв чи үүнийг
хийчихдэг юм бол би амьсгаа
тасарсныхаа дараа чам дээр заавал
эргэж ирнэ. Дуулав уу? Ганц
минутын өмнө, үгүй ядахнаа ганц
секундын өмнө намайг дүүжилчих
аваас би чам дээр заавал буцаж
ирнэ, бурхны нэрээр андгайлъя!

Жекоб Кент эргэлзэж буй нь
хараажаар илхэн ч, Жимтэй үгийн
солиогүй байлаа.

-Ингэхэд чи ямар цагтай вэ? Тэр
чинь зөв явж байгаа үгүйг чи яаж

мэдэх юм. Чи энд ямар уртраг дээр байна? гэж өөрийнхөө алуурчаас хэдхэн минут хожчихыг усан цэрэг дэмий л горьдон, түүнээс элдвийг шалгаана.

-Чи цагаа яаж тааруулсан бэ, хуарангийнхаар уу, эсвэл компанийн цагаар уу? Хэрвээ чи арван хоёр дуугарахаас өмнө юм хийх аваас би нөгөө ертөнцөд ч сэтгэл амрахгүй. Чамд хэлчихье. Би эргэж ирнэ! Ингэхэд цаг чинь япаг биш хойно яг арванхоёр боллоо гэдгийг чи яаж мэдэх юм бэ? Чи үүнийг яаж мэдэх юм, энэ над сонин байна!

-Зоволтгүй ээ, чамайг нөгөө ертөнц рүү яг цагт нь илгээнэ, гайгүй. Надад нарны цаг бий гэж Кент хариу өгүүлэв.

-Тэр дэндэнэ ээ. Зүү нь гучин хоёр хэмийн гажилттай байж болно шүү дээ.

-Яг тааруулчихсан.

-Чи яаж тааруулаа вэ? Луужингаар уу?

-Үгүй, Алтан гадасаар.

-Үнэн үү?

-Үнэн.

Кардиджи ёолсноо голын зүг хулгайгаар хяламхийв. Чарга урцнаас бээр хэрийн зайтай байдаг өгсүүр газарт хэдийн тулж, ноход нь хол хол сунан харайлдах аж.

-Сүүдэр зурааснаас хэр хол байна.

Кент болхи барагдуухан нарны цаг руугаа очиж анхааралтай харж байснаа:

-Гурван ямх хэмээн дуугарав.

-За чи буудахаасаа өмнө "Найман цаг хагас" гээд хашгираарай?

Кент зөвшөөрч тэр хоёр хэсэг зуур дуугай сууцгаажээ. Усан цэргийн гарыг хүлсэн сур алгуурхан сунасаар, мань эр хүлээсээ бугуйнаасаа мултлан бүр хуруунууд руугаа гулсуулж эхэлжээ.

-Зураас хүртэл хол байна уу?

-Ганц ямх үлдлээ.

Аминд тулсан цагт доош өнхөрч чадах нь уу гэдгээ үзэх санаатай усан цэрэг болгоомжтой хөдөлснөө, хүлээсний эхний гогцоог гараасаа мултлав.

-Одоо хэр зай үлдэж?...

-Хагас ямх.

Тэгтэл Кент чарганы ул чихрахыг сонсоод сэрдхийн ийш тийш харав. Хөтөч чарган дээрээ түрүүлгээ харж хэвтээд, ноход нь хар эрчээрээ сунасаар урц руу айсуй. Кент ухасхийн эргэж, буугаа мөрөндөө авлаа.

-Найман цаг хагас болоогүй хэмээн Кардиджи бачимдан орилов. -Ингэх юм бол би чам дээр заавал эргэж ирнэ.

Жекоб Кент хэдэн эгшин самгардчихав. Тэр нарныхаа цагны хажууд өөрийнхөө золиосноос

аравхан алхмын зайтай зогсч
байлаа. Чарган дээр яваа хүн урцны
дэргэд ямар нэгэн ер бусын юм
болж буйг ажиглаатахсан нь
гарцаагүй. Тэр өвдөг дээрээ босч,
шилбүүр нь нохдын нуруун дээгүүр
тас нясхийн хилэнтэйеэ исгэчлээ.

Сүүдэр зураас өөд улам дөхөхөд
Кент бугаа шагайлаа. -Бэлдээрэй
хэмээн тэр сүртэйеэ зандрав. -
Найман цаг ха... Түүнийг үгээ хэлж
дуусахын даваан дээр, нүд ирмэх
төдийд Кардиджи нүх рүү
өнхөрчихөв. Кент буудаж амжилгүй
нүхний амсар өөд ухасхийлээ. Усан
цэргийг газраас өндийв үү, үгүй юу
улаан нүүр өөд нь буу панхийжээ.

Гэтэл бууны амнаас утаа манасхийсэнгүй, харин хажуугаас нь бууны бөгс модны тэрүүхэнд хурц улаан гал цоровхийж, Жекоб Кент газар үхэдхийн унав.

Ноход эрэг өөд дүүлэн, түүний биен дээгүүр чаргаа чирч зүтгэлэх тэр агшинд Жим Кардиджи хүлээснээс гараа салган, нүхнээс мацан гарч, хөтөч ч чарганаасаа үсрэн буужээ.

-Жим хэмээн түүнийг таньсан аянчин хашгирав. -Юу болоо вэ? -Юу болоо вэ гэнэ шүү. Юу ч болоогүй. Би зүгээр л эрүүл мэндээ тэтгэх жаахан дасгал хийлээ. Юу болов гэнээ. Өө муу, хараал идсэн дүйнгэ. Одоохон

миний хүлгийгтайлаад орхиоч,
тэгэхгүй бол юу болсныг чамд
үзүүлээд өгөмз гайгүй. Олигтойхон
хөдлөөч, эсвэл наад бөндгөрөөр
чинь тавцан зүлгэнэ шүү.

Хөтөч халааснаасаа тонгорог гаргаж
хүлээсийг нь огтлох гэж ноцолдож
эхлэхийн сацуу усан цэрэг:

-Ёо-ох! хэмээн дотроо онгойтол
сүүрс алджээ. -Би өөрөө юу болсныг
мэдэхсэн. Чи харин надад
тайлбарлаад өгөх юм биш биз.

Тэд Кентийг өөд нь харуулахад аль
хэдийнээ амь тавьчихсан байлаа.
Аль дивангарын хийцтэй сүмбэтэй

буу нь хажууд нь хэвтэнэ. Гол төмөр нь хуй модноосоо салаад, баруун талынх нь гохны тэрүүхэнд хөвөө нь урагдаж арзайсан хэдэн ймхын урт хагарай онгойж харлах ажгуу. Усан цэрэг тэсгэлгүй сонирхсондоо бууг газраас авав. Гэтэл нөгөө хагархайнаас алтан элсний гялалзсан ширхгүүд годхийн асгарах нь тэр. Тэр үед л сая Жим Кардиджийн сэтгэлд бүдэг бадагхан сэжиг таавар гялсхийжээ.

-Яг энэ газар... тэнгэр ниргэг, намайг. Ийм юм байдгаа бас. Тэрний хараал идсэн алт хаа байсныг хараач! Хөөе Чарли, алив нааш нь түмпэн аваад ир, шалавла гэм, чөтгөр аваг чамайг

хэмээн тэрбээр байж ядан
хашгирчээ.

Зам салах хязгаарт

Уйтайхан байна, надад

*Үлэмжийн сайхан амраг минь
амьдардаг*

Энэ хотоос явна гэхээр

Уйтайхан байна, надад

Шваб ардын дуу

Дуу аялан байсан хүн шош пор пор
буцалж буй тогоо руу өнгийн
харснаа ус нэмлээ. Тэгээд саяхь эр
нуруугаа цэхлэн зогссоноо, идэш
ууштай хайрцаг хавиар эргэлдэж

байсан нохдыг утаа суунаглуулсан галтай цучилаар айлган хөөж гарав. Тэрбээр царай зүс сайтай, хөгжүүн цэнхэр нүдтэй, алтан шаргал үстэй агаад бүхий л дүр байдал нь цовоо Цолгин, эрүүл саруул ахуйг нь илтгэнэ.

Буудлыг нэвтэршгүй хана мэт хүрээлж, өөр бусад ертөнцөөс нэгмөсөн тусгаарласан цаст тайгын дээр шинийн хавирган сар гялтайна. Жаварт, цэлмэг тэнгэрт түмэн од бүжих мэт жирвэлзэнэ. Зүүн өмнө зүгт мэдэгдэхтэй үгүйтэй ногоон гэгээ сүүмийх нь умрын туяаны түрүүч авай.

Түүдгийн дэргэд хоёр хүн хэвтжээ. Цасан дээр зургаан ямх зузаан үелүүлж дэвссэн нарсны мөчир дээр хаясан баавгайн арьс тэдний хэвтэц аж. Хөнжлөө хажуу тийш нь тийрч орхиж. Хоёр модны хооронд газраас дөчин таван хэмийн өнцөг гарган татсан далбааны зотон салхины халхавч болохын сацуу түүдгийн илчийг тогтоон доош нь баавгайн арьс руу буулгах ажээ.

Түүдгийн хажууханд бас нэг хүн чарган дээр суугаад, бугын арьсан бойтгоо цойлдож байлаа. Баруун талд нь овоолоостой байгаа хөлдүү элс, болхи хөшүүрэг сэлт, эд нар өдөр өнжилгүй алтны судал тэмтчин

махран зүтгэж буйг илтгэнэ. Зүүнтэй нь цасанд зоосон дөрвөн хос цана, буудлаас чинагш одохдоо энэ улсын хэрэглэдэг унаа аж.

Эгэлхэн шваб дуу Умардын хүйтэн оддын дор нэг л жигтэй, сэтгэл догдлом дуулдах ажээ.

Тэр аялгуу зүдгүүрт ажлын өдрийн дараа түүдгийн хажууд ясаа амрааж буй улсын зүрхийг долгилуулан түгшээж, сэтгэл шимшрэм зовиур, алс холын нарлаг Өмнөдийн зүг тэмүүлэх дон лугаа адил гашуун гунигийг нь өөрийн эрхгүй сэдрээж байлаа.

-Бурханыг бодож амаа хамхиач дээ, Зигмунд хэмээн түүдгийн дэргэд хэвтэгсдийн нэг нь учирлаад, өвдтөл нь атгасан нударгаа баавгайн арьсны нугалаан доогуур сэмхэн шургуулжээ.

-Надад дуулмаар байхад би яагаад амаа хамхих ёстой юм, Дейв Верц - гэж Зигмунд хариу өчөөд: -Миний зүрх сэтгэл баяртай байгаа ч юм билүү гэв.

-Яагаад гэвэл баярлаж хөөрөх юм энд даанч алга. Эргэн тойрноо хараач. Бүтэн жил бид яаж амь зууж байгаагаа бодооч, зөвхөн идэж ууж, морь шиг зүтгэж байна, чөтгөр аваг.

Харин элтан шаргал үст Зигмунд цав цагаан цан хүүрэг болчихсон нохдыг, хүмүүсийн амнаас бургих цагаан мананг тайвуухан харж байлаа.

-Яахаараа би баярлаж болдоггүйнхээ учрыг олж харахгүй л байна гэснээ тэр инээд алдаад:

-Хамаг юм тийм муу муухай байгаа гэж үү. Над бол таалагдаж байна аа. Хоол хош адгийн гэж чи хэллээ. Яахав... -гээд тэр тохойгоо нугалан гарынхаа хүчирхэг булчинг илэх зуураа:

-Амь зуухын хувьд бид адгууснаас өөрцгүй ч, харин авах олохын хувьд

ёстой хаан шиг байна. Энэ судлаас
угаах бүртээ бид хорин доллар
олдог. Цаана нь энд ахиад элбэг
наймэн фунт алт бий, Энэ чинь хоёр
дахь Клондаик гэдгийг бид
цөмөөрөө мэднэ. Тэр, Жим Хоз
чиний дэргэд байна, мань хүн бол
юм ойлгодог, тиймдээ ч гомдол
гаргадаггүй. Хичкоkyг хар, бугын
арьсан бойтогоо чавганц шиг өөрөө
цойлдож сууна, тэглээ гээд хана
самардаагүй халамжлах хэрэгтэйгээ
мэднэ. Гэтэл хар, чиний тэсвэр
барагдаад, хавар болтол тайван ч
ажиллаж чадахгүй нь. Уг нь тэр цагт
бид хаан шиг баян болцгооно.
Америкт, гэртээ хурдхан очмоор

байна уу? Намайг тэгж боддоггүй гэж санаа юу? Би тэнд төрсөн. Гэхдээ би хүлээж чаднаа. Яагаад гэвэл өдөр болгон манай угаагчийн ёроолд тос цохигч доторхи цөцгий шиг алт шаргалтаж байдаг юм. Гэтэл чи хүүхэд шиг гоншигоноод, юу хүссэнийг минь одоохон өгөөч гээд. Тэгэх ч үгүй шүү, дуулж суусан минь дээр.

Жил жилийн дараа, усан үзэм дэлгэрэх цагаар

Унаган нутгаан зорино, би

Чи минь үнэнч байх аваас

Чамайгаа би эхнэрээ гэж нэрлэнэ

Жил жилийн дараа, цаг хугацаа
хуучрах цагаар

Чамайгаан би эхнэрээ гэж нэрлэнэ

Чи минь үнэнч байх аваас

Насан туршдаа би чинийх байх
болно.

Ноход сэрвээнийхээ үсийг босгон,
бүгтхэн гийналдсанаа, гэнэтхэн
түүдэгрүү дөхөцгөөв. Цанын жигдхэн
чихраан дуулдаж, хэн нэгэн элсэн
чихэр цацаж буй мэт цас
шийхтнуулан гулгасаар айсуй чимээ

сонсогдлоо. Зигмунд яриагаа таслаад, хараал зүхэл урсган нохдыг хөөлөө. Түүдгийн гэрэлд амьтны арьсан нөмрөг нөмөрсөн улаан арьст бүсгүй үзэгдэж, тэрбээр цанаа тайлж орхин, хэрмэн дээлнийхээ юүдэнг хойш нь унагаснаа, түүдгийн дэргэд буй хүмүүс рүү ойртож ирлээ.

-Сайн уу, Сипсу хэмээн Зигмунд, баавгайн арьсан дээр хэвтэж байсан хоёр зэрэг зэрэг түүнтэй мэндэлж, харин Хичкок чарган дээр хажуудаа зай гаргаж өгөх санаатай чимээгүйхэн цаашаа суув.

Тэр чихэнд чимэггүй чинуки аялгуутай муруй хазгай англи үгсээ

хольж хутган:

-За сонин хачин юутай байна даа,
Сипсу -хэмээн нэг л этгээд хачин
үгээр асуугаад:

-Тосгоныхон өлсгөлөн хэвээрээ л биз
дээ. Ан гөрөө, олз омог яагаад ингэж
хомсодсоныг, хандгай алс газар
одсоны учрыг танай бөө тайлж
чадаагүй байгаа биз дээ гэж асуув.

-Тийм ээ, чиний үг үнэн. Ан гөрөө
арвигүй, бид удахгүй нохдоо идэхээс
өөр аргагүй болно биз. Гэхдээ бөө
энэ гэй түйтгэрийн учрыг олсон,
маргааш тэр өргөл өргөж, овогт
нүүрлэсэн хараал зэтгэрийг

зайцуулна.

-Хэнийг золигт гаргах нь вэ? Дөнгөж мэндэлсэн балчир уу, эсвэл дараанаас цаашгүй, далд орсонд нь баярлахаар азгүй чавганц уу?

-Үгүй дээ, энэ удаа тэр өөрөөр болгоосон. Бурхад хилэгнэжээ. Тийм учраас золионд одох хүн нь овгийн тэргүүний охиноос өөр хүн байх ёсгүй гэнэ. Тэр нь би, Сипсу.

-Ай чөтгөр чамайг! хэмээн Хичкок өөрийн эрхгүй дуу алдав.

Тэрбээр үгээ таслан байж гайхшрал, санаашрал, уй шингэсэн дуугаар

жинтэйхэн дуугарсан билээ.

-Ингээд бидний зам салж байна даа
-гэж хүүхэн тайван өгүүлээд: -Бие
биеийнхээ зүсийг дахин нэг харахсан
гэсэндээ би хүрээд ирлээ, Сүүлчийн
удаа.

Бүсгүй балар эртний ертөнцөд
харьяалагдаж байгаа хойно түүний
амьдралын хэв жаяг ч бас балар
эртнийх. Ямар л байгаа тэр хэвээр
нь амьдралыг хүлцэж тэвчээд
сурчихсан болохоор бүсгүй амьд
хүнээр өргөл өргөхийг байдаг л юм
гэж үзнэ. Өдөр шөнө ээлжлэх, ус
бороо асгарах, хүйтэн жавар
тэргүүтнийг эрхшээж буй сүр хүчин,

цэцгийн дэлбээг хумиж, навчисыг шарлуулж байдаг тэр хүчин хилэгнэх удаа бий. Тэдний энэрэл нигүүсэлийг хүртэхийн тулд өргөл золиос ч хэрэгтэй. Тэдний хүсэл зориг янз янзаар илэрнэ. Шар усны үерээр хүн живж үхнэ, урвагч хуурамч мөсний ангал руу ойчно, баавгайн үхлийн саварт базагдана, эс бөгөөс төрөлх голомтынх нь дэргэд түүнийг ужиг өвчин нэрвэнэ. Бас сүүлчийн амьсгаатай нь цуг амьдрал түүнийг орхин одтол, уушигныхаа хэлтэрхийг нулиман ханиалгана. Заримдаа бурхад ч хүний амьдралыг өргөлд авахыг зөвшөөрнө. Харин бөө тэдний хүсэл зоригийг таамаглахдаа

гаргуун, сонгохдоо алдана гэж үгүй.
Хамаг юм эв энгийн. Үхэл түмэн
янзын замаар ирдэг ч, эцсийн эцэст
бүхнийг номхруулагч, ухаан хүршгүй
агуу хүчний зарлиг хэмээх ганц
төгсгөл рүү бүхнийг хөтөлдөг.

Гэтэл Хичкок огт өөр, хөгжингүй
ертөнцийн харъяат. Түүний
ертөнцийн хэв жаяг ийм энгүүн
болхи, ийм маргашгүй байдлаар үл
ялгарна. Тийм болохоор Хичкок:

-Хаанаас даа Сипсу. Энэ чинь мунхаг
явдал. Чи цэл залуухан. амьдралд ид
шатаж явна.

Танай бөө чинь мунхаг амьтан, тэр

буруу сонгож Ийм юм хаа байсан юм.

Бүсгүй ялдамхан инээснээ:

-Амьдрал хатуу. Хэзээ ч юм бэ тэр бидний нэгийг нь цагаан арьстай. нөгөөхийг нь улаан арьстай бүтээж. Дараа нь бидний замыг нийлүүлэх тэр үйлийг бүтээж, өдгөө дахиад биднийг салгах нь. Энэ бүхнийг өөрчлөх хүч бидэнд үгүй. Нэг удаа бас л бурхад догширох цагаар чиний ах дүүс бидэн дээр, тосгонд ирж билээ. Тэд гурвуулаа байсан, хүчирхэг цагаан хүмүүс Тэд яг чам шиг "Ийм юм хаа байсан юм" гэж хэлж байсан. Харамсалтай нь тэд

үхэцгээсэн, гурвуулаа. Юм
болдгоороо болсон.

Ойлгосны тэмдэг болгон Хичкок түүн
рүү толгой дохиод, дараа нь нөхөд
рүүгээ эргэснээ дуугаа чангаруулан:

-Дуулаа биз, залуус минь. Тэнд,
гацаанд бүгд солиорч орхисон
бололтой. Тэд Сипсуг алах гэж
байна. Та нар энэ тухай юу хэлмээр
байна? гэлээ.

Хоз Верц хоёр бие биеэ харснаа
дуугаа хураачихлаа. Зигмунд тэр-
гүүнээ гудайлган, хөлд нь наалдан
хэвтсэн хоньч нохойг илбэнэ. Мань
эр тэр нохойг алс холоос авчирсан

болохоор их л энхрийлж
халамжилдаг ажээ. Нууц нь юундаа
вэ гэхээр, цээжиндээ далд нуусан
бяцхан гуунд зураг нь буй.үргэлж
бодож санаж, дууг нь ямагт хөгжөөгч
тэр бүсгүй мань хүнийг Умардад
одоход үдэж өгөхдөө энэ нохойг
бэлэглэсэн юмсанж.

-За тэгээд та нар юу хэлмээр байна
даа? хэмээн Хичкок дахин хэлэв.

-Үнэхээр тийм биш ч байж мэднэ.
Сипсу хэтрүүлж байж магадгүй гэж
Хоз баахан азнаснаа сая ам нээв.

-Би та нараас энэ тухай асуугаагүй
гэж тэдний хариу дуугарах ч үгүй

байгааг харсан Хичкокийн уур хилэн дүрсхийж, царай нь улаа бутраад: - Хэрэв үнэхээр үнэн байвал бид ийм юмыг тэвчих хэрэг үү гэж би асууж байна. Бид юу хийх ёстой вэ?

-Миний бодлоор мань мэт оролцох хэрэг юун -хэмээн Верц өгүүлээд: - Үнэхээр тийм юм болсон байлаа ч, бид юу хийж чадах юм. Тэднийхэн ийм ёстой, шашин мергөл нь тэгж болгоодог биз, ер нь ч тэгээд бидний хэрэг биш. Бид ахиухан алт угааж аваад, түргэхэн хараал идсэн энэ нүхнээс зайлбал барав. Энд зэрлэг адгуус л амьдарч чадна, улаан арьстанууд адгууснаас ялгаа юун. Үгүй дээ, энэ бол бидний хувьд

дэндүү хөнгөн хуумгай явдал болно гэлээ.

-Би ч тэгж бодож байна. Бид энд дөрвүүлхнээ, гэтэл Юкон хүртэл гурван зуун бээр, ойр хавьд ганц ч цагаан арьстантай нүүр учрахгүй. тэгэхээр бид зуун тавиад улаан арьстаны өөдөөс юу хийж чадах юм? Хэрэв тэдэнтэй ам зөрвөл эндээс зайлахаас аргагүй болно, үзэлцээд яах юм, биднийг хүйс тэмтэрчихнэ. Тэгээд ч бид алтны судал дээр буучихсан шүү дээ, чөтгөр аваг, би энэ бүхнээ орхимооргүй байна гэж Хоз түүнтэй санаа нэгдэв.

-Зөв хэмээн Верц дуу алджээ

Жил жилийн дараа, усан үзэм
дэлгэрэх цагаар

Унаган нутгаан зорино, би.

Аяархан дуулж суусан Зигмунд руу
Хичкок тэсвэр алдан эргэж харлаа.

-За Хичкок минь, би бусадтай санал
нэг байна. Тэнд зуун тавиад улаан
арьстан бүсгүйг алахаар шийдсэн
бол бид юу хийж чадах юм.

Бүгдээрээ ганц ухасхийгээд биднийг
зүйл дуусгана. Ингэлээ гээд юу олж
долоох вэ. Жаал охин тэдний гарт
үлддэгээрээ үлдэнэ. Үгүй дээ. хамаг
хүч чиний талд байсан цагт
нутгийнхны дэг жаягийн өөдөөс сөрж

болно.

-Тэр хүч чинь бидний талд байна.
Дөрвөн цагаан дөрвөн зуун улаанаас
дутахгүй. Бүсгүйн тухай бодохгүй
байна уу, та нар хэмээн Хичкок
түүний үгийг таслав.

Зигмунд бодолд дарагдсан янзтай
нохойгоо илбэнэ.

-Би бүсгүйн тухай л бодож байна,
Түүний минь нүд зуны тэнгэр шиг
цэв цэнхэр, тэнгис долгилох шиг
инээдэгсэн. Үс нь минийх шиг алтан
шаргал, бүдүүн гэгч сүлжчихсэн. Тэр
намайг нар гялбасан тэртээх
нутагтаа хүлээж суугаа. Тэр аль

хэзээнээс хүлээж байгаа, санасан бүхэн минь бүтдэгийн даваан дээр би өдийд азаа үзмээр байна.

-Харин би чиний оронд байсан бол тэр цэнхэр нүд рүү тайван харж зүрхлэхгүй, миний хулчгараас үрэгдсэн гил хар нүдэн үргэлж сэтгэлийг минь цоргисоор байх биз гэж Хичкок хорсолтой нь аргагүй хэлэв.

Хэзээний уужим сэтгэлтэй, чин шударга энэ хүн хожим хойтохын тухай үл санан, аливааг тэгтлээ бодож тунгаалгүй, бүхэнд өглөгч харамгүй сэтгэлээр хандаад сурчихсан билээ. Зигмундыг толгой

сэгсрэн:

-Чи солиорч, Хичкок. Гэхдээ чамаас болж би тэнэг юм хийхгүй.

Саруулхан сэтгэж, учир начрыг нь тунгаах ёстой биз дээ. Би ийшээ зугаацах гэж ирээгүй. Хамгийн гол нь бидний оролцоо тэртээ тэргүй тус болохгүй. Бүсгүйн ярьсан бүхэн үнэн байлаа гээд яалтай. Түүнийг хөөрхийлөх л үлдэж. Овгийн ёс ийм хойно, бидний энд байгаа бол харин цэвэр тохиолдол. Эд мянган жилийн тэртээ ийм юм үйлдэж байсан, өнөө ч үйлдэнэ, хойшдоо зууны эцэс хүртэл үйлдсээр байх биз. Эд бидэнА харь ертөнцийн улс, бүсгүй ч гэсэн дээ. Үгүй шүү, би Верц, Хоз хоёрын

талд эцсээ хүртэл зогсоно, бас...
гэхийн сацуу:

-Ноход архиралдан овоорцгоолоо.
Зигмунд үгээ таслан чих тавих эгаад
харанхуйгаас олон цанын чихраан
дуулдана. Төдөлгүй, түүдгийн гэрэлд
нуруулаг, шийдмэг хүйтэн төрхтэй,
таг дуугүй, ангийн арьсан дээлтэй
хэдэн улаан арьстан үзэгдэв. Тэдний
сүүдэр муу ёр зөгнөх мэт цасан дээр
цоролзоно. Энэ хүмүүсийн нэг, бөө
Сипсуд хандан төвөнхийн авиагаар
юу ч юм хэлэв. Тэрбээр царайгаа
болхи гэгч шунхдаж, мөрөн дээрээ
чонын арьс тохсон агаад духан дээр
нь ангайсан араатны араа шүд
ярзайлдах аж. Бусад нь тагчиг, алтны

хайгуулчид ч чимээгүй. Сипсу босч,
цанаа углав.

-Хагацъя даа, анд минь хэмээн
бүсгүй Хичкокт хэлэв.

Гэтэл түүний хажууд чарган дээр
сууж байсан эр өчүүхэн ч
хөдөлсөнгүй, улаан арьстанууд нэг
нь нөгөөгийнхөө араас харанхуйд
алга болон одож байхад тэргүүнээ
өндийлгөсөн ч үгүй.

Энэ хязгаарт ирэгч олон олон
эрчүүлийг бодвол Хичкокт Умард
нутгийн хүүхнүүдтэй ойр дотно
харилцаа үүсгэх хүсэл хэзээ ч төрж
байгаагүй билээ. Тэр хаа ч гэртээ

байгаа юм шиг байж, бүх хүмүүст ав
адилхан ханддаг болохоор хэрэв
үнэхээр тийм хүсэл төрсөн бол үзэл
бодол нь өчүүхэн ч саад тотгор
болохгүй байсан биз. Гэтэл өдгөөг
хүртэл ер ийм хүсэл төрөөгүй. Харин
Сипсу. Мань хүн бүсгүйтэй түүдгийн
дэргэд хуучлах дуртай ч, эр хүн
эмэгтэй хүнтэй гэхээсээ илүүтэй том
хүн хүүхэдтэй харьцаж байгаа юм
шиг түүнд ханддаг, тэдний нөхөрлөл
баяр баясгалангүй амьдралынх нь
хэвийн ахуйг бага ч атугай
чимдэгийн учир энэ бүхэн түүн шиг
хүний хувьд эв энгийн зүйл байлаа.
Тэр байтугай мань эр Шинэ Англид
өсч уураг тархи, яс махандаа хүртэл

янк болчихсон ч, биеэр нь эрмэг халуун цус бургилж байгаа хойно морьтон эрсийн элдэв омголон явдал түүнд юундаа харшлах билээ. Басхүү амьдрал, амин зуулгын явдал үе үе түүнд огт утгагүй мэт санагдаж, сэтгэл зүрхнийх нь агуу хүсэл, тэмүүлэлтэй эрхгүй зөрчилддөг авай.

Тэрбээр тэргүүн гудайлган тийнхүү дуугүй суухдаа агуу төгөлдөр, ямар нэгэн ер бусын хүчин, эцэг өвгөдийнх нь сүр хүч сэтгэлд нь хуралдан сэргж буйг мэдэрчээ. Хоз, Верц хоёр өнгөц боловч ямар ч гэсэн мэдэгдэм зовиурт харцаар түүн рүү байн байн хялалзах аж. Зигмунд ч гэсэн тогтож ядна. Хичкок эгнэшгүй

зоримог нэгэн гэдгийг тэд мэднэ.
Үүнийг тэдэнд эргэлзээгүй
ойлгуулсан үйл явдал, аюулаар
дүүрэн хамтын амьдралынх нь уртад
нэг бус удаа тохиолдсон. Тийм
болохоор түүнийг одоо юу хийх нь
вэ хэмээн тэд баахан айдас,
сониучирхал бадраан хүлээж авай.

Гэтэл тэр таг дуугай, Цаг явсаар,
түүдэг бараг унтарчээ. Верц суниаж
басхүү эвшээснээ унтах цаг болсон
биш үү хэмээн өгүүлэв. Тэгтэл Хичкок
босч, хамаг биеэ цэхлэн зогсов.

-Та нарыг хараал идэг, муусайн
хулчгарууд! Би та нарыг ахиад
харахыг ч хүсэхгүй!

Тэрбээр үүнийг хэдий тайван хэлсэн ч, үг бүхэнд нь сүр хүч, мохошгүй хүсэл зориг оргилон байлаа.

-Ханалаа! Данс дугуйлцгаая! Яавал та нарт таатай байх вэ, түүгээрээ болцгоогтун. Энэ газрын анхны захиалгын дөрөвний нэг нь минийх. Энэ ч бидний гэрээнд орчихсон байгаа. Бид гучаад унц алт угаасан. Алив дэнсээ нааш нь, хуваая юмаа. Зигмунд бүх аяганыхаа хийцийн дөрөвний нэгийг над таслаад аль, Бас дөрвөн нохой минийх, гэхдээ над ахиад төдий тооны нохой хэрэгтэй. Оронд нь би багаж, тоног хэрэгслийнхээ хувийг үлдээе. Дээр нь бас долоон унц алт, сумтай

буугаа тавилаа. Тохирох уу?

Гурван эр тэрүүхэндээ хажуу тийш холдож, хоорондоо шивэр авир гэлцсэнээ эргэж ирэв.

Зигмунд бүгдийг төлөөлж:

-За, Хичкок бид чамтай бүхнийг шударга хуваана. Чи бүх юмнаасаа их ч биш, бага ч биш яг дөрөвний нэгийг нь авагтун, түүгээрээ юугаа хийх нь чиний дур. Харин ноход маань бидэнд хэрэгтэй, тэгэхээр өөрийнхөө дөрзийг л авна биз. Багаж хэрэгслийн чамд оногдох хувийн тухайд гэвэл өөрт чинь хэрэгтэй бол авна биз, хэрэггүй бол

үлдээчихээрэй. Энэ чиний хэрэг гэлээ.

-Бүх юм хуулийн үг үсгээр болох шив
-хэмээн Хичкок ёжтой жуумалзаж: -
Яая гэх вэ, би зөвшөөрч байна. За
шалавлая. Би энд ганц хором удахыг
хүсэхгүй. Харахаас нүд хорсож
байна, та нарыг гэв.

Дахиад хэн нь ч ганц үг ган гэсэнгүй,
юмаа хувааж дууссаны эцэст Хичкок
өөрийнхөө амин зуулгын жаахан
юмыг чарган дээрээ ачиж, дөрвөн
нохойгоо ялгаж хөллөв. Багаж сэлтэд
тэр гар хүрсэн ч үгүй, харин нохойн
зургаан хөллөгөө авч чарган дээрээ
чулуудчихаад, тэр хэдийн дургүйг

хүргэх гэсэн мэт өдөнгүй харжээ.
Гэтэл цаадуул нь гагцхүү мөрөө
хавчисхийлгээд ой руу далд орон
ортол нь түүний араас чимээгүйхэн
ширтсээр хоцорчээ.

* * *

Гүн цасан дундуур нэг хүн мөлхөж
явна. Түүний баруун, зүүн талаар
бугын арьс нөмөргөсөн улаан
арьстануудын овоохой харлах аж.
Өлсгөлөн ноход тэнд ч, энүүхэнд ч
байн байн гийналдах агаад бие бие
рүүгээ хорслонтойёо архиралдан
хуцалдана. Тэдний нэг нь мөлхөж
яваа хүн рүү ойртоод ирлээ. Тэр таг
чиг болчихов. Нохой бүр ойртож,

хий шиншилснээ харанхуй болохоос өмнө энд байгаагүй жигтэй сонин юманд хоншоороороо хүрэн хүртэл болгоомжтой нь аргагүй дахиад хэдэн алхам ойртов. Тэгтэл нөгөө хүн гэв гэнэт өндийж, (бээлийгээ ч урьд нь тайлчихсан байж) эгшин зуурт нохойн сагсгар хүзүүнээс гараараа тас зуураад авчээ. Тийнхүү ган шиг бахим гарт үхэл түүнийг гүйцэж ирэх нь тэр. Нөгөө хүн цаашаа мөлхөж одоход, хүзүүгээ хугалуулсан нохой оддын дор цасан дээр хөсөр хаягдан хоцорчээ. Энэ бол Хичкок байлаа.

Хичкок омгийн тэргүүний урц хүртэл мөлхөөд, Сипсу яг хаахна байгааг

мэдэх санаатай чимээ чагнан цасан дээр баахан хэвтжээ. Тэнд хүн зон олон байгаа нь илт, шуугиж байгаа байдлаас үзвэл сэтгэл нь ихэд зогдолсон янзтай ажээ.

Ашгүй, мань эр бүсгүйн дууг ялгаж таниад урцыг тойрон түүний ард нь очлоо. Тэднийг өдгөө зөвхөн бугын нимгэхэн арьс тусгаарлах болжээ. Хичкок цас нүхэлж малтсаар, толгой цээжээ нүх рүү оруулж цааш мөлхсөөр оронгийн халуун илчийг мэдрэнгүүтээ сая зогсон, хэсэг харзнав. Юу ч харахгүй байгаа болохоор хөдлөхөөсөө зүрхшээнэ. Баруун талд нь баахан арьс овоолоотой бололтой, мань эр

үнэрээр нь гадарласан ч лавтай
мэдэхийн тулд сэмхэн тэмтэрч үзэв.
Бас хэний ч юм нэхий хувцас
нүүрийг нь аяархан шүргэв. Энэ
гарцаагүй Сипсу хэмээн тэр итгэж
байсан ч, бүсгүйг дахиад ярьж
хөөрөөсэй гэж тэсгэлгүй хүсэн
хүлээжээ.

Омгийн тэргүүн, бөө хоёр юунаас ч
болсон юм халуухан маргаж, хаа
нэгтээ урцын мухарт өлсгөлөн хүүхэд
уйлж буй дуулдана. Хичкок
хажуугаараа эргэж, түрүүнийх шигээ
үстэй хувцсанд нүүрээ наан хэвтэж
байснаа болгоомжтой өлийсхийн
мөнөөх амьсгааг чих тавин чагнав.
Тэр яах аргагүй эмэгтэй хүний

амьсгаа. Үзээд алдахаар шийдлээ.

Болгоомжтой нь аргагүй нэлээн чангахан түүнд наалдаад орхитол цаадах нь бондогосхийн цочив. Тэр таг чиг хүлээлээ. Хэний ч юм гар толгойг нь илээд буржгар үсийг нь тэмтэрч, дараа нь нүүрийг нь өөр рүүгээ аяархан эргүүлэх тэрхэн эгшинд мань хүн Сипсутай харцаараа учрав.

Бүсгүй жигтэйхэн тайван байх ажээ. Тэрбээр юу ч болоогүй мэт суудлаа засаад, овоолоотой арьс тохойлдон, Хичкокийг баараггүй далдлахаар хормойгоо засав. Тэгснээ огт санаандгүй юм шиг түүний дээрээс

дахин тонгойж, сүүлдээ бүр
гилжийгээд, халуун чихээ уруулд нь
зөөпхөн наалдуулвай.

-Сиймхий гарангуут гацаанаас гарч,
салхи сөрөн, горхи тохойрдог тэр
газар руу шулуухан яваад очоорой.
Тэнд нарсны хажууд миний ноход,
чарга байгаа. Өнөө шөнөдөө бид
замд гарна. Юкон орно. Хоёулаа
түргэн явалгүй горыүй нь. Бас
замдаа тааралдсан нохдыг барьж
аваад горхи руу чирээд ирээрэй.

Сипсу анхандаа дургүйцэж толгой
сэгсэрсэн ч, нүд нь баяр хөөрөөр
гийгээд ирсэн бөгөөд энэ эр зөвхөн
өөрийн нь төлөө ийш ирсэнд учиргүй

бахаджээ. Өөрийнхөө угсааны бүх бүсгүйчүүдийн нэгэн адил эрчүүлийн сүр хүчинд захирагдах нь миний хувь тавилан хэмээн тэр итгэдэг буй заа. "Чи очих уу" гэж Хичкок захирангүй давтан тулгав. Бүсгүй хариу дуугараагүй ч, тэр хархүүгийн хүсэл өөрт нь хууль гэдгийг мэдэж байлаа, -Хөллөгөөнд санаа зоволтгүй. Шалавлаж үзээрэй. Өдөр нь шөнөө хөөгөөд цаг хугацаа хүлээхгүй нь хэмээн тэр нэмж хэлэв.

Хагас цагийн дараа Хичкок дулаацах санаатай гуяа алгадан хөлөө дэвсэчсээр чарганыхаа дэргэд зогсож байлаа. Тэгтэл ашгүй Сипсуг олж харав. Цаадах нь уллаж

чангаасан хоёр нохой араасаа
чирчихсэн, нөгөөдүүлийг нь үзсэн
Хичкодын ноход тэдэнтэй турсгаа
хуулалцмаар янзтай болоод
ирэнгүүт номхруулахын тулд мань
эр шилбүүрээ хэрэглэхээс аргагүй
боллоо. Гацаа салхин дор болохоор
өчүүхэн чимээ тэдний энд буйг
илчилчихмээр.

-Наадуулаа чарганд ойрхон хөллө.
Минийх урьд нь ороод яваг хэмээн
тэр захирав.

Хархүүгийн хэлснийг хийж байтал
Хичкодын хөллөгөөтэй ноход
өнөөдүүл рүү нь ухасхийн дайрч,
Хичкокийг бууныхаа бөгсөөр

номхруулахын завдгүй бөөн шуугиан дэгдэж, нойронд дарагдсан гацаагаар нэг цуурайтаад шөнийн амгаланг бусниулж орхив.

-Одоо санаснаас хавьгүй олон ноходтой болно доо -гэж тэр түгшүүртэй өгүүлээд чарганаас зүүлттэй сүхээ аван: -Чам руу чулуудсан бүхнийг хөллөөд байгаарай, жолоо цулбуураа харж байгтун.

Тэр урагш хэд алхаад, хоёр нарсны хооронд тосон зогсов. Гацаанаас ноход хуцалдах дуулдах агаад мань эр тэдний ойртож ирэхийг хүлээж байлаа. Удсан ч үгүй яах ийх завдгүй

айсуй хар толбо бүгээн цасан
цайдам дундаас тодроод ирлээ. Тэр
бол яах аргагүй нохой, жигдхэн хоя
хол сунан харайж, чоно шиг арагш
ангалзан, бүх сүргээ араасаз
дагуулжээ. Хичкок сүүдэрт
нуугдсанаа, нохойг өөртэй нь
зэрэгцээд ирэв үү үгүй юү, ганц
ухасхийгээд урд хоёр хөлнөөс нь
бариад авав. Нохой ч толгойгоороо
годройтон, цас руу шааж уналаа.
Дараа нь тэр чихнийх нь доохно
оновчтой нь аргагүй түсхийтэл
цохиод, Сипсу руу чулуудчихав.
Бүсгүй нохойд хөллөгөө углаж байх
зуурт сүх барьсан Хичкок бүх сүргийн
пайралтыг няцааж, нүд нь очтон,

шүд нь ярзайсан сагсгар үст
араатнууд хөлийнх нь тэрүүхэнд
албинтан овооролдож байлаа.
Сипсу шалмаг амжуулав. Эхний
нохойтой ноцолдоод дуусав уу үгүй
юү Хичкок урагш ухасхийж, дахин
нэгийг барьж дүйртэл нь цохиод,
бүсгүй рүү чудуудлаа. Энэ бүхэн
гурвантаа давтагдав. Архирч
урхирсан арван нохой хөллөгөөнд
орсны хойно тэр "Боллоо!" хэмээн
хашгирчээ.

Гацаанаас бөөн улс айсуй. Түрүүнд
нь идэрхэн улаан арьстан гүйж
явлаа. Тэр нохдын дундуур дайрч
орсноо, Хичколын зогсож буй тэр
газарт хүрэх санаатай тэднийг

баруун зүүнгүй цохилж гарав. Гэтэл цаадах нь бууныхаа бөгс модыг ганц буулгатал улаан арьст залуу салхийн өвдөг сөхөрч, төделгүй гэдрэг сунаад ойчив. Араас нь гүйж явсан бөө үүнийг харжээ.

Хичкок "Хөдлөөч" хэмээн Сипсуд тушаав. Тэр "Чук" гэж хашгирав уу үгүй юу улангассан араатнууд урагш ухасхийн давхихад Сипсу чарган дээрээ арэйхийн тогтжээ. Тэнгэр сахиулсан нь бөөд хилэгнэсэн бололтой. Тэрхэн агшинд гагцхүү тэр л зам хөндөлсжээ. Эхний нохой түүний цанан дээр гишгэж, хөллөгөөний ноход чаргатай юутай хүүтэйгээ түүний дээгүүр давхиад

өнгөрөв.

Гэвч юун хурдан хөл дээрээ босоод ирсэн юм, хэрэв Сипсу урт шилбүүрээр нүүрэн дундуур нь татаад аваагүйсэн бол энэ шөнө түүний хувьд арай өөрөөр дуусах байсан биз. Чарганыхаа араас гүйж явсан Хичкок түүнийг эрчээрээ дайран унагах хүртэл мань бөө толгой нь дүйрч гуйван замын голд зогссоор байсан аж. Тэрхүү мөргөлдөөний үр дүнд балар эртний шашин судлаачийн, цагаан арьст хүний нударганы хүчний тухай мэдлэг хавьгүй зузаарч, омгийн тэргүүний овоохойд буцаж ирснийхээ дараа тэрбээр бүх цагаан

хүмүүст учиргүй уурсан, зөвлөлд яруу тодоор илтгэж гарчээ.

* * *

-За залхуу минь бос! Арай хэтэрлээ!
Чамайг бугын арьсан бойтогоо
углаж амжаагүй байхад өглөөний
унд бэлэн болно...

Дейв Верц баавгайн арьсыг түлхэн
өндийснөө эвшээжээ. Хоз суниснаа
гар нь хөшиж орхисныг мэдээд
түүнийгээ нойрмогхон үрж гарав.

-Хичкок энэ шөнийг хаа өнгөрөөсөн
нь сонин байна гэж тэр өөрийнхөө
бойтогийг авах зуураа асуув. Өнөө

муу бойтог нь шөнөдөө хөлдөж
орхисон учир мань эр түүнийгээ
гэсгээхээр түүдгийн зүг арга буюу
оймстойгоо цасан дээгүүр сэвэгхэн
алхлав.

-Тэнгэрийн авралаар тэр явчихсан.
Гэхдээ сүрхий ажилсаг хүн байсныг
хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

-Тийм шүү. Гэхдээ тэр юм бүхнийг
өөрийнхөөрөө эргүүлэх даанч
дуртай. Энэ нь л түүнд өөрт нь
зовлон уддаг юм. Хөөрхий Сипсу,
өрөвдмөөр юм. Тэр бүсгүй түүнд
тэгтлээ таалагдсан юм байх даа.

-Би тэгж бодохгүй байна. Мань

эрийн хувьд хамаг юм зарчимдаа.
Энэ буруу гээд тэр бодчихсон,
мэдээж буруу л даа. Гэхдээ бид нар
оролцоод, бүгдээрээ цагаасаа урьд
нөгөө ертөнцөд очихын шалтгаан
гагц энэ болж болохгүй биз дээ.

-Зарчим уг нь муугүй эд. Гэхдээ
цагийн юм цагтаа сайхан, Аляск явах
гэж байгаа бол тэр зарчим
марчимаа гэртээ орхичихвол дээр.
Тийм үү? Би зөв ярьж байна уу?
Верц найз дээрээ очиж, бас түүдгийн
дэргэд суугаад цааны арьсан гутлаа
гэсгээж эхэллээ.

-Чи юу гэж бодож байна, бид нар
оролцох ёстой байсан уу? Зигмунд

үл ойшоосон маягтай толгой
сэгсэрчээ. Тэр ярих зав зай муутай
байж. Хүрэн бор хөөс данхны амсар
даван хариугүй дэврэх гээд, бас
хажуугаар нь хайруулын тавган дахь
өөхийг хэдийн эргүүлэх болчихож.
Түүнээс гадна мань хүн тэнгис далай
лугаа адил өнгөт, үргэлж мишээсэн
нүдтэй бүсгүйгээ мөрөөсөж, аяархан
дуу аяланхан байсан.

Нөхөд нь жумалзан нүд ирмэцгээж,
чимээгээ аядав. Хэдийгээр цаг долоо
дөхчихсөн ч үүр хаяартал элбэг
гурван цаг бий. Умарын туйлын туяа
бөхөж, шөнийн түнэр харанхуйд
тэдний буудал гэрэлт бяцхан арал
мэт үзэгдээд, гурван хүний дүрс

түүдгийн гэгээнд тодхон зураг шиг харагдана. Чимээ аниргүй болчихсонд олзуурхсан Зигмунд дуугаа өндөрсгөн, мөнөөх эрт цагийнхаа дууны сүүлчийн бадгийг аялав.

Жил жилийн дараа, усан үзэм дэлгэрэх...

Гэнэт чих дөжрүүлэм буун дуу шөнийн нам гүмийг эвдэн тачигнав. Хоз "Оох" хэмээн бөглүүхэн дуу алдсанаа нуруугаа тэнийлгэх аятай нэг цэхлэн зогсомдог болсноо газар лагхийтэл сууж орхилоо. Верцийг толгойгоо далжигасхийлгэн хажуугаараа сунаж ойчиход хоолой

нь хяхнан багалзуураас нь хар хүрэн
цус годхийлээ. Харин алтан шаргал
үст Зигмунд дуусгаж амжаагүй
дуугаа уруул дээрээ үлдээгээд, гараа
сарвагасхийн түүдэг дамнан ойчжээ.

* * *

Бөөгийн нүд уур хилэндээ
харанхуйлж, сэтгэл санаа нь хачин
муухай баргар бүрхэг байлаа, Тэр,
Верцийн буунаас болж омгийн
тэргүүнтэй муудалцаад, шуудайтай
шошноос өөрт оногдохоос хавьгүй
арвин авахыг санаархсан ажээ.
Түүгээр ч барахгүй баавгайн арьсанд
шунан өөртөө аваад, омгийн бусад
эрчүүлийн дургүйг хүргэж, сүүлдээ

Өмнөдийн бүсгүйн Зигмундад бэлэглэсэн нохойг тонилгох санаатай үзээд алдсан боловч нохой зугтан алга болж, харин өөрөө алтны хайгуулынхны ухсан том нүхэнд унаж, ган торхон дээр ойчоод мөрөө мулталчихжээ.

Буудлыг юу ч үлдээлгүй тонон дээрэмдсэн улаан арьстануудыг урц овоохойдоо эргэж ирэхэд, эмс хүүхнүүдийнх нь баярлаж хөөрсөн нь туйлгүй. Удсангүй энэ хязгаарт хандгайн сүрэг үзэгдэж, гөрөөчдийг ангийн тэнгэр ивээж, бөөгийн нэр сүр бадраад, түүнийг тэнгэр нэртэй үг хэлэлцдэг гэж хүртэл ярилцах болов.

Бүгдийг явсны дараахан мөнөөх хоньч нохой голомт нь харласан буудал дээр эргэж ирээд бүхэл шөнөжин өдөржингөө ульж, амь үрэгдэгсдийн араас эмгэнэн харуусч байснаа төдөлгүй алга болжээ. Хэдэн жил өнгөрсний хойно улаан арьст гөрөөчид ойн чононуудын үс арьсанд урьд нэг ч чононд үзэгдэж байгаагүй ер бусын тод өнгөтэй толбо тодрон гарч ирснийг олж үзэх болжээ.

Амьдралын жам

Коскуш өвгөн шимтэнгүй чих тавин сууна. Түүний хараа хэдийнээ бөхсөн ч сонсгол нь урьдын адил ялимгүй чимээнд сэрхийдэг хэвээрээ, үрчлээт магнайнх нь чанад зурсхийх бодолд айсуй цагийн үйл нэг л ёозгүй эргэлдэнэ. Сит Кум То Ха-гийн энэ яхир дуу юу. Тэр бүсгүй ноходдоо хөллөгөө углах зуураа хашгичин жанчиж байна. Сит Кум То Ха хэдийвээр ач охин нь ч гэсэн, бүхэнд мартагдаад цасан дээр орь ганцаар өрөвдөлтэйеэ суугаа эл өтөл өвгөнтэй дэмий цаг нөхцөөх зай зав түүнд байсангүй. Бууринаасаа

ховхрох цаг болжээ. Өдөр богинохон. Цаг хугацаа тэднийг ямар хүлээх биш. Холын аян тоссоор л байгаа. Ач охиныг нь амьдрал даллаж, ажил төрөл дуудаж байгаагаас биш, ямар үхэл хүлээж байгаа биш дээ.

Гэтэл өвгөнд бол үхэлд нэг л ойрхон оччихоод байгаа юм шиг.

Энэ бодол өвгөнд арга буюу айдас авчрах агаад тэрбээр гараа сарвайн дэргэдээ овоолоостой хэдэн мөчрийг тэмтэрч үзнэ. Хажуудаа мөчир байгааг мэдмэгц элэгдэж гүйцсэн адсаган доогуур гараз шургуулаад ахин чих тавилаа.

Бугын царцанги хөлдүү арьсны
тачигнах чимээ омгийн тэргүүний
овоохойг буулгаж дуусаад
арьснуудыг нь юманд чихэн эвтэйхэн
баглаж буйг илтгэнэ. Түүний хүү нь
омгийн тэргүүн юм. Чац том,
хүчирхэг, сайн ангуучин. Аргагүй
овгийн толгой. За тэр, бөөн цөөн
юмаа эмхэлж ядсан болхи толхи
авгай нарыг шавдуулж буй нь түүний
дуу. Коскуш хөгшин анир тосон
чагнаархана.

Нүүдэл суудлын тэр дуу чимээг
тэрбээр сүүлчийн удаа сонсож
байгаа. Джиохоугийн овоохойг,
Тускены овоохойг ч буулгачихаж.
Долоо, найм, арав дахь нь. Одоо

ганцхан бөөгийн овоохой үлдэж. За
одоо түүнийг буулгаж эхлэв
бололтой. Чарган дээр овоохойгоо
ачаалж буй бөөгийн үглэх нь
Коскушт бас дуулдана. Хүүхэд
часхийн чарлахад хүүхэн аргил
намуухнаар дуулан саатуулах авай.
Энэ Ку Ти хариугүй бие султай, танхи
нялх амьтан даа хөөрхий хэмээн
өвгөн бодов. Аягүй бол энэ удалгүй
өөд болж цаадуул нь тундрын мөнх
хөлдүү газар гал ноцоож нүх
малтаад нутаглуулж, нохой зээхнээс
хамгаалан дээгүүр нь чулуу хаялах ч
юм билүү. За даа, энэ надад ямар
хамаа байхав дээ. Цатгаланаасаа
өлөн зэлмүүн явах нь олонтаа,

сайндаа хэдэн жил амьд явна биз.
Эцсийн бүлэгт мөнхийн өлөн
зэлмүүн хэн бүхнийг үхэл хэзээд
хүлээж байдгаас хойш.

Юу болж байна энэ чинь! Аа, эрчүүл
чаргатай ачааныхаа татлагыг
чивчиртэл нь чангалж байна.

Мөдхөн юу ч дуулахаа больж нам
гүмд ганцаар хоцрох энэ хүн мөн л
чих тавьсаар.

Ташуурын дуун исгэрэн ноход дээр
тас нясхийн буулаа. Дуулав уу,
улилдаж байгааг нь.

Айхтар бэрх аянд дургүй нь хүрэлгүй
яахав, хөөрхийс. Хөдөллөө!

Чарганууд ар араасаа анир чимээгүй
рүү гулсан одов. Яваад өглөө. Тэд
түүнээс хагацан одож, эцсийнхээ
хүнд хүчир цагийг өвгөн орь ганцаар
угтах нь. Гэтэл үгүй юмаа, тээр тэнд
арьсан гутлын дор цас чихарч
байгааг дуулав уу. Тэгтэл хэн нэг нь
хүрч ирээд толгойд нь гараа зөөлхөн
хүргэлээ. Хүү нь түүнд ийм хайртай
билээ. Уг нь өвгөд хөгшдөө
орхичихоод үр хүүхдүүд нь отог
овгийнхонтойгоо яваад өгдөг
заншилтай сан. Гэтэл түүний хүү
тийм биш ажээ. Өвгөнийг ухаан
бодлоороо өнгөрсөн улирсан руу
одоод байхад хүүгийнх нь дуу
ийнхүү эгүүлэн авчрав.

-Бие тань дажгүй юу гэж хүү нь асуулаа.

-Өө, зүгээр хэмээн өвгөн хариулав.

-Дэргэд тань хуурай мөчир байгаа. Түүдэг сайхан ноцож байна. Өглөө нэг л бүүдгэр байх чинь. Хүйтний эрч харина биз. Удахгүй цас хаялна Даа. Одоо ч орж байна шүү дээ гэж хүү нь өгүүлэв.

-Тийм ээ орж байна.

-Улсууд их адгаж байна. Ачаа нь хүнд дээ. Тэд минь өлөн зэлмүүнээсээ болоод бүр сальдчихаж. Зам хол болохоор яарч

байна. Би явъя даа. Та дажгүй биз дээ?

-Би дажгүй ээ. Би гэдэг чинь мөчиртөө тогтож ядаж байгаа намрын навч шиг болчихож.

Салхины анхны исгэрээгээр унаж одох биз. Дуу шуу ч гэж яг чавганцынхаа. Нүд мөрөө үзэхээ больж хөл даагдахаа байлаа. Би аргагүй ядарчээ. Бүх юм жамаараа, ёсоороо.

Цасны гаслантайяа чихрах дуун алсад замхран замхартал сэтгэл хангалуун гэгч тэргүүнээ гудайлгаж суусан Коскуш хүүгийнхээ дууг ахин

хэзээ ч дуулахааргүй боллоо гэдгээ эрхгүй мэдэрч байлаа. Тэгснээ өөрийн мэдэлгүй гар сунган мөчрүүдийг шалмаг гэгч тэмтчиж үзэв. Гагцхүү энэ тэвэр мөчир л түүнийг тосон буй орчлонгийн мөнх бусаас арайхийн зааглаж буй. Тэвэр хуурай мөчир түүний амьдралын эцсийн хэмжүүр болжээ. Ганц ганцхан мөчрөөр түүдгээ тордон буй түүн рүү үхэл алхам алхмаар дөтлөсөөр. Хамгийн сүүлчийн мөчир илчээ өгч дуусах тэр цагт жавар салхи эрх дархаа эдлэх буюу. Эхлээд хөл нь мэдээ алдаж, дараа нь гар нь, тэгээд бүх бие нь хөшнө. Толгой нь өвдөгтэйгээ золгоод мөнхийн

амирлангуйд одно. Тэр бүхэн хачин
амар хялбархан юм шиг. Үхнэ гэдэг
бүхний хувь хойно Коскушт
харамсах юм байсангүй. Амьдрал
иймээс хойш шударга нь сайхан.
Газар дэлхийтэй шадархан төрж
өссөн түүнд жам ёс шинэ юм биш.
Энэ бол амьд амьтны тавилан.
Байгаль зарим амьтанд дэндүү
өршөөлгүй хандах нь бий. Байгалийн
араншин нь арьсны өнгө, төрөл
зүйлээр ялгаварладагтаа байдаг юм
шиг. Уужуухан бодолт Коскушийн
эгэл ухаанд хэдийвээр ахадсан ч энэ
жамыг харин хатуу ойлгожээ. Мод
шүүсээ дуслуулан, нялх ногоон
нахиагаа задалж, бас нэгэн цагт

шаргал навчсаа гөвөх нь нэгэн тойрог төөрөг дууссаны тэмдэг. Ер байгаль амьд бүхэнд үүргийг нь тохооно. Түүнийг нь гүйцээсэн ч, гүйцээгээгүй ч мөхнө. Байгаль цөлх, хэнэггүй. Түүнд захирагдагсад үй олон. Гэсэн ч мөнх оршино гэгч ердөө л түүнд захирагдагсдад бус, сүслэн дагагсдад л оногдоно.

Коскушийн өвөг дээдэс их эртнийх. Түүний санан дурсдаг өтгөс ч балчир ахуйдаа өмнөх үеийнхээ хөгшдийг мэддэг байсан.

Овог омгоороо энх тунх оршин буй нь булш хиргисүүр нь хэдийнээ мартагдсан элэнц хуланцынхаа сүсэг бишрэлд үнэнч байсны ач болой.

Хальж одогсод цөөхөн. Тэд л үл захирагдана.

Тэд нүүх үүлс мэт тэнгэрт одоцгоосон. Тэр өөрөө бас тийшээ очно. Байгаль цөлх, хайхрамжгүй шүү дээ. Амьдрал хүнд нэг зорилго оноож, нэг жам заяадаг. Амьдралын зорилго нь үр удмаа үлдээх, харин хальж одох нь түүний жам ёс.

Бүсгүй хүнийг харахад нүдэнд хичнээн дулаахан. Тэрбээр цээж түрсэн, гунхсан эрмэг алхаатай, цоглог алаг нүдтэй. Бүсгүйг их хувь заяа тосч буй. Түүний нүд очтон гэрэлтэж, алхаа гишгээ нь түргэсэн идэр эрстэй нэгэн бол нүүрэмгий,

нэгэн бол ичингүй аашилж, зовлон
гунирхлаараа тэднийг нууцхан
даллана. Ийнхүү тэр өдрөөс өдэрт
зүс орон жавхаажиж, хэн нэгэн
анчин эр түүнийг үр хүүхдийнхээ
элбэрэлт эх нь болог, ажил үйлсээ
хамжилцаг хэмээн тостой тогоогоо
бариулахаар овоохойдоо аваачдаг
билээ. Гэтэл ууган хүүхдээ
төрүүлмэгц л гоо үзэсгэлэн нь
хүүхнийг орхин одож, алхаа гишгээ
нь хүндэрч, нүд нь бүүдийгээд,
гагцхүү балчирхан үрс л голомтоо
сахин суугаа тэрхүү эмгэний үрчлээт
хацарт баяртайгаар наалдан байдаг
болно. Ийнхүү тэрбээр үүргээ
биелүүлнэ. Өлсгөлөнгийн анхны

аймшиг нөмрөх буюу их нүүдлийн эхэнд эдүгээ энэ өвгөнийг орхисон шиг тэвэр гишүүний хажууд цасан дээр түүнийг хаяад одоцгоодог. Амьдралын жам ийм бөлгөө.

Коскуш гал руу хуурай мөчир ягуухан орхиод дахин бодолд автлаа. Юм гэж хаа сайгүй л ийм байдаг. Анхны жавраар шумуул алга болно. Бяцхан хэрэм үхэхээ болохоор шивэр ширэнгэ рүү шургана. Он цагийн эрхэнд туулай сурьдаж урьдынх шигээ дайснаас цахилан зугатах тэнхээгүй болно. Баагай хүртэл хөгшрөхийн хэрээр юм үзэхээ байж болхи дүйнгэ болоод сүрэг ярдаг ноход түүнийг унагаж авна.

Тэдэн дээр эм тангийн авдар,
мөргөлийн судар чирсэн шашны
сурталч ирсэн тэр өвөл Клондайкийн
эхэнд зцгийгээ яажшуухан орхисноо
Коскуш саналаа. Коскуш тэр авдрыг
санах бүртээ уруулаа долоон,
хорхойсдог асан ч одоо түүний
аманд шүлс байхгүй болжээ,
Бурхныг номлогч, овгийнхонд нь
дараа болно. Түүний ховдгийг хэлэх
үү. Тэгсэн атлаа ганц шувууны мах
олоод ирэхгүй юм гэж анчид түүнийг
муучилдагсан. Сүүл сүүлдээ нөгөөх
чинь Сэйогийн ойролцоох нэгэн гол
Дээр ханиадаар үхсэн. Түүний дээр
овоолсон чулууг ноход тарааж
хаялаад ясан дээр нь хэмлэлдэж

дууссан. Коскуш түүдэг рүү дахин нэг гишүү хаяад өнгөрсөн улирсны тухай бодолдоо улам бүр дарагдан авай. Аймшигт өлсгөлөнгийн үеэр өвгөд галд ойртон суугаад Юкон гол бүтэн гурван өвөл зайрмаг ч үгүй мяралзан урсаж, хожим нь бүтэн гурван зун мөсөн баринтагнаасаа салаагүй тухай эртний нэгэн домгийг амнаасаа унагадагсан. Тэр өлсгөлөнгөөр Коскуш ээжийгээ алдсан. Зун нь хандгайн нүүдэл ч өнгөрсөнгүй. Овог аймгаараа өвлийг, бугын нүүдлийг тэсч ядан хүлээлээ. Гэтэл өвөл жамаараа ирсэн ч буга ирсэнгүй. Өвгөдийн ухаанд багтамгүй тийм юм ер тохиолдож

байгаагүй байлтай. Бугын бараа ч зэгдэлгүй байсаар өлсгөлөнгийн долоо дахь жил улирав. Туулай хүртэл үржихээ больж, ноход яс арьс болов. Урт өвлийн түнэр харанхуйд хүүхдүүд бархиралдсаар байгаад өнгөрч, хөгшид хүүхнүүд нүд аницгааж, хавар болж нар буцахад арван хүнээс ердөө ганц нь амь хэлтрэв. Тийм ээ, тэр ёстой өлсгөлөн байж дээ.

Эрчүүд үргэсэн шувуу харчихаад намналгүй орхиж, хүүхнүүд жирэмслэх төрөх дуртай, овоохойгоор нь нэг хүүхэд багачуул бужигналдан мөлхсөн, өөхөлж гүйцсэн ноход алмайрч, мах шөл

муудаж ялзарсан тийм элбэг дэлбэг цагийг тэрбээр үээж л байсан. Тийм цагт эрчүүл эрэлхүү дээрэлхүү болж, юм л бол урьдын хэрүүл маргаанаа сөхнө. Пелли омгийнхныг даран сөнөөхөөр тэртээ өмнө зүгт уулс даван одож, танан омгийнхны голомт бөхөхийг үзэхээр баруун зүгт аялж байсан сан. Хүүхэд ахуйд нь нэгэн тийм элбэг дэлбэг жил болж чонон сүрэг нэгэн хандгайг тасар татан хаяхыг харснаа бас дурсан санав. Хожмоо сүрхий ангуучин болж, Юконы харзанд унан насан хальсан Зинг Ха-тай тэгэхэд цасан дээр зэрэцээд хэвтэж байсан. Түүнийг харзны өрхнөөс бүсэлхийгээ

хүртэл гараад, мөстэй барьцалдаад хөлдчихсөн байсныг сарын дараа олж билээ.

Нөгөө хандгай яалаа. Тэр өдөр Зинг Ха бид хоёр аав нараа дуурайж ан ав хийж тоглохоор явсан. Тэгээд хөлдсөн гол дээр хандгайн, тэр хандгайн араас мөшгөсөн чонон сүргийн шинэхэн мөр байхыг харцгааж билээ. Мөр тайлахдаа хэзээний сүрхий Зинг Ха "Хөгшин юм байна. Сүргээсээ тасарчихаж.

Чононууд сүргээс нь нэг тасалсан бол одоо орхино гэж байхгүй дээ" гэлээ. Үнэхээр ч тэгсэн. Чонын ёс гэж тийм юм чинь. Хамрынх нь өмнүүр араа шүдээ тачигнуулсаар өдөр

шөнөгүй, цурам хийлгүй өсгийг нь
гишгэн алдан, өртөөлөн хөөсөөр
эцсээ хүртэл хоцролгүй архиралдан
урхиралдан мөшгөнө шүү дээ. Хоёр
хөвгүүний цус огших шиг болжээ.
Авын төгсгөлийг харалгүй өнгөрч
яхин болох билээ. Тэр хоёр тэсч
ядан улам улам цаашилсаар, хараа
тааруухантай мөр тайлахдаа
маруухан Коскуш хүртэл нүдээ
аниад явсан ч алдамгүй тийм тод
мөр дурайсаар. Мөр шив шинэхэн.
Тэр хоёр алхам тутамдаа дөнгөж сая
бичигдсэн мөшгил нэхлийн аймшигт
намтрыг тайлсаар явлаа. Энд
хандгай зогсчээ. Гурван алдын
дайтай газрын цас гишиглэгдэн

дагтаршжээ.

Голд нь хандгайн хос туурайн гүн мөр, эргэн тойронд нь чонын хөнгөн нимгэн мөр. Нэг хэсэг нь хөөрхий рүү ноцон дайрч байх хооронд нөгөөдүүл нь цасан дээр цагираглан амсхийж байсан бололтой-Хэдхэн хормын өмнө боссон бололтой хэвтрийнх нь мөр тов тодхон. Нэг боохой улангассан хандгайн хөлд өртөн бяц дэвсүүлжээ. Зулгарч хэмхлүүлсэн бөөн яс үс үүнийг өгүүлнэ.

Тэр хоёр ахиад зогсосхийлээ. Энд бас аймшигт тулаан болжээ. Хоёр удаа хандгайг газар сөхрүүлэн

унагасан боловч тэр дайснуудаа ширвэж хаяад дахин хөл дээрээ боссоныг цас хүүрнэнэ. Сөхөрвөл сөхрөхөөр болсон ч түүнд амьдрал хэмжээлшгүй үнэтэй аж. Чононд нэг бүүрлүүлж унасан хандгай хэзээ ч хөл дээрээ эргэж босч ирдэггүй хэмээн Зинг Ха тэгэхэд хэлж байсан. Гэтэл тэр босчээ.

Хожим тэр хоёр энэ тухай омгийн бөөд ярьтал цаадах нь ид шид, нэг юмны ёр совин доо гэж билээ.

Мань хоёр яв явсаар, хандгайн ой руу шургахаар эрэг өөд мацсан газар хүрч ирлээ. Гэтэл өстнүүд нь араас нь хонгодон зулгааж, хандгай хойд хөл

дээрээ цоройн гэдэргээ харуулдаж
унахдаа хоёрыг нь дарж алжээ.
Нэхэл нэгэнтээ төгссөн болохоор
өнөөдүүл цасан дээр гулдайж хэвтээ
тэднийгээ хөндсөн ч үгүй тэр чигт нь
орхисон аж. Хоёр анчин тулааны
талбарын хажуугаар өнгөрлөө.
Мөнөөх мөр цусаар будагдан том
амьтны жигдхэн алхаа солжирч
солбиод иржээ. Тэгээд мань хоёр
тулааны анхны дуу, ан авын хоолой
нийлүүлсэн царгиа улилдааныг бус,
чонын соёо хандгайн хонгонд
ойртсоныг илтгэн буй богинохон
тасалданги архиралдааныг сонслоо.
Зинг Ха салхин доороос нь цасан
дундуур элэглэн мөлхөв. Араас нь,

цагийн эрхээр овгийн тэргүүн болох хувь хүлээж буй Коскуш мөлхөж гарлаа. Тэд зулзган гачуурын мөчрийг сэмээрхэн ярж шагайн тулааны шувтаргыг олж харжээ.

Тэр зураг балчир ахуйнх нь хамаг дуртгалууд лугаа адил одоо хүртэл Коскушийн сэтгэлд илхэн агаад нэхлийн төгсгөл түүний бөхсөн нүднийх нь өмнө мөнөөх алс цагийнх шигээ тов тодхон харагдав. Коскуш энэ бүхнийг гайхаад бардаггүй юм. Хожмын өдөр бүх эрсийнхээ хошууч, омгийн тэргүүн болчихоод нэгэн гардан тулаанд харийн нэг цагаан арьстны амийг хутгаар бүрэлгэсэн тухай нь Пелли

омгийнхон хэлэлцэж, нэрийг нь
хараалын оронд хараал болгон
хэлдэг байжээ. Ер тэрбээр олон бэрх
хэргийг үйлдэж явсан билээ.

Коскуш идэр ахуйнхаа тэр
өдрүүдийн тухай нэн удаан
бодлогошрон суув. Төдөлгүй түүдэг
бөхөх тийшээ хандаж, жавар
тачигнаад ирлээ. Энэ удаа үлдсэн
хоёр мөчрөө гал руу чулуудаад
үхлийг тэр хэр удаан хазаарлахаа
эрхгүй цэгнэн суув. Сит Кум То Ха
өвөөгөө арай илүү өрөвдөж
хайрласан бол, арай олон гишүү
цуглуулаад тавьчихсан бол түүний
амьдрал яльгүй ч гэлээ уртсах ч
байсан юм билүү. Сит Кум То Ха

хэзээний халамжаар харам. Зинг Ха-
гийн ач Минттай зүгээргүй
болсноосоо хoiш өвөг дээдсээ бүр
хүндэтгэхээ больсон. За даа, энэ нэг
их учир начиртай юм биш дээ.

Балчиртаа гэр тийм овоо байсан юм
гэж үү? Коскуш нэгэн мөч анир
чимээгүйд чих тавин чагнав.

Хүүгийнх нь зүрх шимширч уясаад
нөхөдтэйгээ эргэн ирж овог
омгийнхонтойгоо хамт муу хөгшин
эцгээ аваад бөөр нь түхийтлээ
таргалсан олон цаа бугатай тэр
газар руу аваад одох ч юм билүү.

Анир тосон чагнахуйяа тархи мэдрэл
нь мөнөөхөн хүнд бодлыг нь

сарниан сая амсхийв. Өчүүхэн ч
аниргүй нам гүм. Энэ нам гүмд
түүний өөрийнх нь амьсгалах
дуулдана. Элчилгүй ганцаардал! Чу!
Энэ чинь юу байдаг билээ. Түүний
бүх бие хүйт оргиод явчихав. Танил
гэгч урт улиан нам гүмийг хага зүсэн
цочоолоо. Бүр энүүхэнд ойрхон шүү.
Хажуу бөөрөөрөө хүү хүү татуулж
цусаа асгаруулсан хөгшин эр хандгай
сүүлчийнхээ хүчийг шавхан сэрвээгээ
сүртэйеэ босгоод олон салаа аварга
эврээ сэжин сэжин тулалдаж асан
тэр зураг Коскушийн бөхсөн нүднийх
нь өмнүүр хий үзэгдэл мэт
жирэлзээд өнгөрөв. Тэрбээр чонын
гулилзсан саарал бие, гялалзсан хурц

нүд, цагаан соёо, хэлнээс нь савирах шүлсийг хүртэл тов тодхон үзэв. Зэгэл саарал тойрог зай завсаргүй нягтарсаар дагтаршиж гүйцсэн цасан дээрх бяцхан бараан толботой аажуу алгуурхан нийлэхийг ч харах мэт боллоо.

Нэгэн хүйтэн хоншоор хацарт нь хүрэхэд сая түүний ухаан санаа эдүгээд эргэж ирэв. Тэр ухасхийн түүдэг рүү гар сунгаад галтай цучил шүүрлээ. Хүнээс айдаг айдас хүйдэстээ автсан араатан ижлээ дуудаж уртаар ульсаар ухрав. Нөгөөдүүл нь тэр дороо хариу улилдсаар шүлсээ савируулан түүдэг тойрон бүчээд ирлээ. Өвгөн энэ

бүхнийг дуулангуутаа цучлаа өргөн
даллавал араатнууд ер ухрах янзгүй.
Харин ч улиан нь түрхрээн архираан
болон хувирав. Бүр байчихаад нэг
нь урагш цогнойн хойд хоёр хөлөө
чирэн ойртоход хоёр дахь, гурав
дахь нь дагалдав. Нэг нь ч
ухарсангүй. Ийм болсон хойно
амьдралтай зууралдаад яах ч юм
билээ дээ хэмээн Коскуш өөрөө
өөрөөсөө асууснаа цучлаа
чулуудчихав. Цучил цасан дээр
шархийгээд бөхлөө. Түгшүүртэйеэ
архиралдах чононууд байрнаасаа
хөдөлсөн ч үгүй. Хандгайн сүүлчийн
тулааныг сэтгэлдээ нэхэн харсан
хөөрхий Коскуш толгойгоо өвдөг

дээрээ талбив. Эцсийн эцэст бүгд л
ийм хувьтайгаас хойш яая гэхэв.
Амьдралын жам гэгч ийм бус уу?

Кишийн хүү Киш

-За, би давхар хаваастай, зургаан дулаан хөнжил, бөх том зургаан хөрөө, хялгасан талбиур болсон иртэй Удзон хийцийн зургаан урт хутга, эдийн дээдийг бүтээгч агуу Могум хийцийн хоёр дамар, хөллөгөөндөө хосгүй бяралхуу, өлчир чийрэг арван том нохой, бас гурван буу өгье. Нэгнийх нь гох хугархай ч сайн буу, засч додомдож болно.

Киш дув дуугай, адтай сониуч, хянамгай, баргар олон царайг тойруулан харлаа. Их загас агнуурын цаг хаяанд ирж, тэрбээр охин Су-Сугаа эхнэр болгон өгөөч хэмээн

Гнобоос царайчлан буй нь энэ. Зуу
зуун бээрийн алсад нутаглагч бүх
овог омог цугласан Юкон голын
хөвөөнөө, Ариун

Георгийн төлөөлөгчийн газрын
ойролцоо энэ явдал болжээ. Тэд
умар, өмнө, дорно, өрнөдөөс, тэр ч
байтугай Тоцикакат, алс холын
Тананаас хүртэл ийш ирцгээсэн
ажээ.

-Эрхэм Гноб сонстугай! Та танан
омгийн оройн дээд, харин би
тлунгетуудын тэргүүн Кишийн
хөвгүүн Киш билээ. Тийм болохоор
чиний охин алтан хэвлийдээ миний
үрийг тээвээс бидний овгийн

хооронд холбоо, агуу холбоо
тогтож, танан, тлунгетууд цагийн
уртад мах цусны ахан дүүс
болцгооно. Би хэлсэн, хэлсэндээ
заавал хүрнэ. Эрхэм Гноб энэ тухай
юу гэж айлдахсан бол?

Гноб ихэмсэгээр толгой дохив.
Үрчлээ атираанд баригдсан, херзгөр
хүйтэн царайд нь бодол санааны
нэгээхэн ч илэрхийлэл үл тодрох
агаад тасалданги аргил дуугаар:

-Энэ юу ч биш ээ хөө гэж хэлэхэд
хоёр аньсаганых нь завсрын
нарийхан зураасны цаанаас нүд нь
нүүрсний цог шиг гэрэлтээд ирэв.

-Тэгээд өөр юу байх ёстой юм?
хэмээн асуугаад Киш: -Би ёстой
ханасан үнэ өгөөгүй гэж үү?

Ийм их сүй авч байсан бүсгүй танан
омогт хэзээ байсан юм бэ? Нэрлээд
аль над!

Дугуйран суусан олны доогтой,
шивэр авир яриа эргэн тойронд нь
дуулдаж, Киш бүхний нүдний өмнө
шившиг болсноо сая ойлгов.

-Үгүй дээ, үгүй, сайхан сэтгэлт Киш
минь, миний үгийн учрыг ойлго-
сонгүй -хэмээн Гноб түүнийг
тайвшруулан гараа сажаад: -Үнэ ч
ёстой үнэ. Энэ бол жинхэнэ үнэ.

Хугархай гох хамаа юун, би зөвшөөрч байна. Гэхдээ үүгээр бүх юм дуусахгүй. Гэтэл хүн нь өөрөө ямаршуухан билээ.

-Тийм ээ, тийм, ямаршуухан хүн бэ гэж дугуйран суугсад хорон үгээр түрцгээв.

-Улсын хэлэлцэх нь, Киш эцэг өвгөдийнхөө замаар замнаагүй хүн гэнэ. Олны ярилцах нь, тэр харийн зүгийн бурхадын эрэлд түнэр харанхуй дундуур бэдэчсээр тун аймхай хулчгар болчихсон гэх юм хэмээн Гнобын хахир тасалданги дуун дахиад цуурайтаад явчихав.

Кишийн царай барайгаад ирлээ.

-Тэр худлаа! Киш хэнээс ч айдаггүй гэж тэр бачимдан хашгирчээ.

-Олны өгүүлэх нь, тэр Их Овоохойн цагаан хүмүүсийн үгийг дуулдаг болж, цагаан хүмүүсийн бурхадын өмнө тэргүүнээ гудайлган мөргөж. цагаан улсын тэр бурхан нь цус үзэж чаддаггүй гэнэ хэмээн өтөл хөгшин Гноб цааш өгүүлвэй.

Киш нүд буруулан тонгойж, салгалсан гараа бадайртал тас атгажээ. Дугуйрсан улс доогтой инээлдэцгээн, домч, омгийн тэргүүн тайлгач, бөө Мадван Гнобын чихнээ

нэгийг шивнэх аж. Дараа нь тэр түүдгийн гэгээ гийсэн тойргоос сэвхийн харанхуй руу одож, тэндээс өндөр гоолиг хөвүүн дагуулж ирэн, Киштэй улаан халз нүүрэлдүүлж зогсоогоод Кишийн гарт хутга атгуулав.

-Киш! Эрхэм Киш! Чи хүний амь тасалж чадах уу! Харж бай! Энэ бол миний боол Киц-Ну.

Түүн рүү гараа далай, эрхэм Киш, чи түүн рүү хүчит гараа далайгаач!

Киц-Ну цохилтоос дальдчин чичирнэ. Киш хөвүүн рүү харахуйяа, ухаан сэтгэлд нь Браун ноёнтоны ариун

сургаалт үгс гялсхийн бууж, ноён
Брауны тамын гал дөл дүрэлзэн
цоргилж буй нь нүднийх нь өмнө
үзэгджээ. Хутга газар ойчиход хөвүүн
сүүрс алдсанаа, тэндээс холдон
одоход өвдөг нь салганан чичирч
байлаа. Гнобын хөлд хэвтэж байсан
үлэмж биет нохой соёо юугаа
ярзалзуулах агаад хүүгийн араас
дайрахад бэв бэлэн. Гэтэл тайлгач
араатныг хөлөөрөө түлхэж орхисон
нь Гнобын сэтгэлд нэгэн сэргэг
бодол дагуулсан аж.

-Сонсооч, эрхэм Киш! Хэрэв чамтай
ингэж харьцваас чи яах вэ? Ийн
өгүүлээд Гноб Цагаан Соёотод
хатаасан загасны үмх мах сарвайж,

нохой өвдөл цөвдөлийн хойноос
ухасхийнгүүт, хоншоор дундуур нь
саваагаар өгчилгөөд орхив.

-Яг ингэвэл эрхэм Киш, дараа нь бас
иймийг хийх үү, аан?

Газар навтасхийснээ Цагаан Соёо
Гнобын гарыг долоолоо.

-Дуулж бай! гэснээ Гноб Мадваны
гарыг түшин босч: -Би их өтөлж, тийн
өтөлсний учир чамд энийг хэлж
байна, Чиний эцэг Киш агуу хүн
байсан. Тетива тулаанд яаж
дуулдгийг тэр сонсох дуртайсан, бас
тэр жадаа хэрхэн шидэж, өстөний нь
толгой яаж өнхөрч ойчихыг миний

НҮД ҮЗСЭН.

Гэтэл чи тийм биш ажээ. Хэрээнээс нүүр буруулж, Чононд мөргөж эхэлсэн тэр цагаасаа хойш чи цуснаас зүрх алддаг болж, чиний ард түмэн бас айдаг байгаасай гэж хүсдэг болж чи. Энэ муу. Намайг Киц-Ну шиг цэл залуу байхад манай орон, улс даяар ганц цагаан хүн байгаагүй. Гэтэл тэд, энэ цагаан хүмүүс нэг нэгийнхээ араас ирцгээсэн, одоо тэд олуул болжээ. Энэ бол тайвширдаггүй омгийнхон. Ханаж цадчихаад тэд маргааш мах хаанаас олох билээ хэмээн бодолгүй түүдгийн дэргэд тайван амарч хэвтэж чаддаггүй улс шүү дээ. Эдний

дээр муу ёр, хараал зүхэл хуралдаж,
тэд хэзээнээсээ цагийн мөнхөд гар
хумхихгүй, хөдлөж байх заяатай
төрсөн улс.

Киш мэл гайхаж хоцров. Эрт дээр
цагт амьдарч байсан ямархан нэгэн
Адамын тухай ноён Брауны хэлснийг
тэр бүүр түүрхэн санав. Тэгэхээр
ноён Браун үнэн хэлж байж.

-Цагаан улс хаа сайгүй бядан явж,
харсан бүхэндээ хуруу дүрнэ, тэдний
харахгүй юм ч гэж алга. Тэд улам
улам олон болсоор, хэрэв бид гар
хумхих аваас бүх орон улсыг маань
булааж, Хэрээний омгийнхонд
амьдрах орон үлдэхгүй нь.

Нэгийг нь ч амьд үлдээлгүй эдэнтэй үзэлцэх ёстойгийн утга учир үүнд л байна, Тэр цагт бүх зам харгүй, бүх нутаг орон бидэнд харьяалагдаж, магадгүй бидний үр хүүхэд, үр хүүхдийн маань хүүхдүүд элбэг хангалуун амьдарч, таргалж тэвээрэх ёстой бус уу. Хэрээ Чоно хоёр хүч үзэх тэр цаг ирэхэд агуу их тулаан болно, гэтэл Киш хамаг олонтойгоо хамт алалцаж тулалдахгүй нь, өөрийнхөө омгийг араасаа дагуулахгүй нь. Яагаад охиноо түүн . эхнэр болгон өгөх дургүй байгаагийн минь учир энэ. Танан омгийн тэргүүн Гноб би ийм юм чамд хэлэх гэсэн юм.

-Гэхдээ цагаан хүмүүсийн сэтгэл уужим, аугаа хүчирхэг билээ гэж Киш хариу өчөөд:

-Цагаан хүмүүс биднийг олон юманд сургасан. Бидний хэзээ ч хийж чадахгүй буу, хутга, хөнжил тэргүүтнийг цагаан хүмүүс бидэнд өгсөн. Тэднийг ирэхээс урьд бид яаж амьжиргаагаа залгуулдаг байсныг би санадаг. Би тэр үед төрөөгүй байсан ч гэсэн, эцэг минь тэр талаар над ярьсан. Гөрөөлөхдөө, хандгайд ойртохын тулд бид өчнөөн мөлхдөг байсан, жадаа түүнд лавхан шаахын тулд тэр шүү дээ. Одоо бол цагаан хүний буу байгаа хойно хүүхдийн хашгирах ч дууламгүй тийм холоос

амьтныг унагаж байна. Манайхан загас, мах, жимс иддэг байсан, өөр идчихмээр юм ч байгаагүй, байгаагаа давсгүй цохино, одоо харин загас, махаа давсгүй идье гэх ганц хүн та нарын дунд байна уу?

Кишийг ийн ярьж дуусахаас өмнө Мадван суудлаасаа ухасхийн босоогүйсэн бол энэ үг олон хүний сэтгэлийг урвуулах байсан биз.

-Эхлээд миний нэг асуултад хариулаад орхи, Киш. Том Овоохойн цагаан хүн чамд амь таслах цээртэй гэж хэлж. Гэтэл цагаан улс хүн алдгийг бид мэдэхгүй юү? Коюкукын их тулааны тухай бас гурван цагаан

арьстан тоцикакат омгийн хорин
хүнийг хүйс тэмтэрсэн
Нуклукайтогийн их тулааны тухай
бид мартчихсан гэж үү? Цагаан арьст
Меклротын зүйл дуусгасан тана-нау
омгийн гурван хүнийг бид мартсан
гэж чи санаа юу? Хэлээд өг, эрхэм
Киш, Браун тайлгач амь тасалж
болохгүй гэж чамд айлддаг мөртлөө
түүний ахан дүүс яахаараа хүн алдаг
юм бэ?

Киш энэ хэцүү асуултад яаж
хариулахаа бодон хямарч байх зуурт
Гноб:

-Үгүй үгүй, чиний хариулт бидэнд
хэрэггүй -хэмээн сөрөөд:

-Бүх юм эв энгийн. Бусад нь зулгааж байх хооронд чиний тэр сайхан сэтгэлт Браун ламтан Хэрээгийнхнийг ам дамаггүй барьж байх гээд тэчъядаад байна шүү дээ. Ийн хэлээд Гнобын дуу улам чангарч:

-Гэхдээ гар далайх чадалтай ганц ч гэсэн эр хүн, эс бөгөөс хүү төрүүлж чадах ганц ч гэсэн бүсгүй танан омгоос үлдсэн байхад Хэрээний өд сөд бүтэн байх болно гэлээ.

Гноб түүдгийн дэргэд сууж буй нуруулаг, бадриун залуу руу эргэж:

-Чи юу гэмээр байна даа, Су-Сугын

ах Макамук.

Макамук бослоо. Урт сорви түүний нүүрийг хага ярж, дээд уруул нь мөнхийн хөх инээдээр мурийчихсан нь нүднийх нь догшин харцтай яагаад ч үп авцалдах аж.

-Өнөөдөр би Меклрот худалдаачны урцны үүдээр өнгөрсөн гэж тэр хариултаас овжин нь аргагүй мултраад ийн ярьж эхлэв.

-Нарны өөдөөс мишээсэн балчир хаалган дээрээ гарч ирэхийг би үзэв. Хүүхэд над руу Меклротын нүдээр хараад учиргүй айлаа, эх нь түүн рүү гүйж ирээд тайтгаруулсан. Тэрний эх

Зиска тлунгетуудын омгийн хүүхэн.

Түүний үг уур хилэнгийн түрхрээнийг дарсан ч, Макамук жир бус янзтай гараа өргөн, Киш рүү хуруугаараа зангаад, бүхнийг чимээгүй болгочихов.

-Ийм л байна. Тлунгетууд та нар өөрсдийнхөө хүүхнүүдийг харьд өгчихөөд тананууд бидэн дээр ирж байдаг. Гэтэл бидний бүсгүйчүүл бидэнд өөрсдөд маань хэрэгтэй, Киш. Яагаад гэвэл Хэрээ Чонотой уралцах тэр өдрийг хүртэл бид олон олон эрчүүлийг өсгөж өндийлгөх ёстой.

Сайшаалын уухайн дундаас Гнобын
паргиа дуун хадаж,

-Харин чи юу хэлмээр байна, Су-
Сугын хайртай ах Носсабок гэлээ.

Носсабок хэмээх идэрхэн улаан
арьст залуу нуруулаг, гоолиг агаад
хянган бүргэд хамартай, хавчиг
өндөр духтай боловч олныг өгүүлэн
нүд ирмэж буй мэт нэг зовхи нь
үргэлж дээш таталдах аж. Өдгөө
босоод зогссоных нь дараа
залуугийн зовхи татваганаад, нүдийг
нь таглачихав. Харин энэ удаа
Носсабокыг хараад хэн ч инээсэнгүй,
бүхний царай зүс төлөв баргар
байлаа.

-Би ч гэсэн Меклрот худалдаачны урцны дэргэдүүр өнгөрсөн гээд Дүүгийнхээ хоолойтой дэндүү адилхан бараг л хүүхэн хүний гэмээр хонгор зөөлөн дуу нь цангинаад ирэв.

-Би бас улаан арьстануудыг харсан. Тэдний хөлс асгарч, ядарч зүдэрсэндээ хөл нь чичирч байсан. Меклрот худалдаачны барьж буй агуулахын хүнд хүнд дүнзэн дор ёолон гиншиж буй улаан арьстануудыг би харснаа ярьж байна. Жаварт урт шөнөөр тайлгач Браун овоохойгоо дулаацуулах түлээг тэд хагалж буйг би нүдээрээ харсан. Энэ чинь эмийн үйл,

тананууд хэзээ ч ийм юм хийхгүй.
Бид эр улстай ураг барилдахад
гажрах юм алга, харин тлугетууд эр
улс биш, эмсүүд!

Гэнэтхэн нам жим болчихов.
Хүмүүсийн нүдний харц Киш дээр
тусчээ. Тэр дүгрэглэн суусан улсыг
анхааралтай тойруулан харлаа.

-За за, -гэж тэр юу ч болоогүй мэт
өгүүлээд: -За, тийм байдаг байж
хэмээн хэлснээ эргээд, ганц үг
ганхийлгүй харанхуйд уусан алга
болов.

Газраар мөлхсөн хүүхдүүд, шаралхан
архиралдах нохдын дундуур

зүтгэлсээр, Киш буудлыг нэг захаас
нь ногөө захыг нь хүртэл нэгжээд,
түүдгийн дэргэд нэг юм хийж суугаа
бүсгүйг сая олж харав. Тэрбээр
зэрлэг ороонгоны үндэснээс хуу
татсан хальсаар хахуулийн шижим
томж байлаа. Түүний эвлэгхэн гар
орооцолдсон бөөн хальсыг
яажшуухан эвлүүлж сүлжиж буйг
Киш баахан харж зогссон бөгөөд эх
болохын төлөөнөө төрсөн, бундгар
хөхтэй, дүгрэг ташаатай, чийрэг энэ
бүсгүй тонголзон тонголзон үйл
бүтээж буйг харахнаа түүний сэтгэл
өөг байлаа. Хүүхний толигор хүрэл
царай нь түүдгийн гялан гялан
туяанд алтран гийж, үс нь хэрзэний

далавчны өнгөөр гил харлан, нүд нь гэрэлт чулуу мэт гялалзана.

-Су-Су минь! гэж тэр арайхийн хэлээд: -Чи намайг саяхан л энхрийлэн харж байсан. Тэр өдрүүд дөнгөж саяхны мэт...

-Тлунгетуудын удирдагч байсан болохоор чинь, ийм хүчирхэг, нүд дүүрэн том болохоор чинь би чамайг үнэн сэтгэлээсээ энхрийлэн харж байсан гэж бүсгүй дуржигнатал хариулав.

-Харин одоо?

-Энэ чинь аль эрт, бид загас агнаж

явсан тэр цагт, Браун бөө ч"амайг олиггүй юманд сургаж, хар элэгтний замаар дагуулахаас өмнө болсон явдал шүү дээ гэж Су-Су яаран хэлснээ.

- Гэхдээ би чамд ярьсан шүү дээ, нөгөө... гээд гараа сажсан нь Кишт түүний эцгийг эрхгүй сануулав.

-Киш, чиний амнаас ямархан үг нисч гарахыг би мэднэ! Гэхдээ би чамд хариулнаа. Загас уснаа, араатан ойдоо өөртэйгээ адилхныг төрүүлдэг хувьтай. Энэ нь ч сайхан. Хүүхнүүд бас ийм хувьтай, тэд өөртэйгээ адилхныг төрүүлэх ёстой. Бүсгүй хүн бүр охин хонгор байхдаа эх хүний

зовлонг, хөх чинэрэхийг мэдэрч,
могжгор бяцхан гар яаж хүзүүгээр нь
тэврэхийг зөгнөн байдаг, Ийм
мэдрэхүй түүнийг бүрнээ
эзэмдэхийн цагт хүүхдүүдийнх нь
эцэг болж чадах эр хүнийг
бүсгүй өөртөө нууцхан сонгодог.
Чамайг харж явахдаа би ч гэсэн тэгж
шаналж, чиний ямар хүчирхэг, том
хүн болохыг харж байсан. Чи бол
хүчин мөхөсдөхийн цагт намайг
өмгөөлөх, хоёрын өмнөөс ганцаар
тулах, ундлахын цагт над хоол унд
дөхүүлэх чадалтай анч гөрөөч,
дайчин эр гэдгийг чинь би мэднэ.
Гэхдээ энэ бүхэн Браун бөө манай
нутагт ирж чамайг ухуулж

сэнхрүүлэхээс хавьгүй өмнийн...

-Энэ худлаа шүү, Су-Су! Би түүнээс гагцхүү сайн сайхан үг дуулсан...

-Амь тасалж болохгүй гэж үү?
Чамайг ингэж хэлнэ гэж би мэдээд бэйсан юм. Тэгвэл амьтны амь тасалдаггүй өөр шигээ тийм хүнийг өөрөө төрүүлэхгүй юү, дахиад танан руу битгий ингэж ирээрэй, Хэрээ Чонотой тулах цаг удахгүй ирнэ гэж ярилцаж байгаа бус уу. Хэзээ ийм юм болохыг мэддэг нь би биш, энэ эрчүүлийн хэрэг, гэхдээ тийм цаг ирэхийн наана би дайчин эрсийг төрүүлэх ёстойгоо харин мэднэ.

-Су-Су, чи миний үгийг сонс л доо гэж Киш гуйв.

-Эр хүн юм бол чи намайг саваагаар дэлсээд үгийг минь хэлүүпнэ биз дээ гэж Су-Су зэвүүцэл дүүрэн хөх инээд алдан хэлээд: -Харин чи бол... үүнийг ав! гэж тэр мань эрийн гарт баглаа хальс атгуулчихсанаа: -Би Кишт биеэ өгч чадахгүй, харин энийг бол авч бай. Энэ түүнд таарна. Энэ бол эмсийн ажил.

Киш баглаатай хальсыг газар чулуудаж орхив. Түүний хүрлийн өнгөт царайд цус харван барайгаад ирлээ.

-Би чамд бас нэг юм хэлье! хэмээн
Су-Су өгүүлээд: -Чиний эцэг, миний
эцэг зайлж чадаагүй эртний ёс бий.
Хэн тулаанд унана, ялагч түүнээс
хуйхыг нь хуу татдаг байсан. Энэ нь ч
сайхан, Гэтэл Хэрээнээс нүүр
буруулсан чи тэрнээс ихийг хийх
ёстой бус уу. Чи надад хуйх биш
харин толгой, бүр хоёр толгой
авчир, тэр цагт би чамд боодол
хальс бус, өлбөнгөөр чимж оёсон
бүс, бас уртаа орос хутга хуйтай нь
өгнө. Тэр цагт би чамайг дахиад
энхрийлэн харна, бүх юм сайхан
болно.

-Тийм үү? гэж Киш бодолд дарагдан
өчив.

-Тиймээ...

Дараа нь тэр эргэн, харанхуй дунд алга болов.

-Үгүй шүү Киш. Хоёр биш, дор хаяж гурван толгой гэж бүсгүй түүний араас хашгирчээ,

Гэтэл Киш өөрийн шинэ сүжгээс няцаагүйгээр үл барам өчүүхэн ч нүгэл хилэнцгүй амьдарч, Христийн доншууч санваартан Жексон Брауны түүнд айлдсан сургаалыг даган бишрэхийг омгийнхоо улсаас шаардсаар авай. Загас агнуур өрнөсөн бүхий л хугацаанд тэр тананы хүмүүсийг анзаарсан ч үгүй,

бусад отог омгийн эмсийн доогтой
инээд, доромж үгийг ч тоосонгүй.
Агнуурын дараа Гноб утсан,
хатаасан загас нөөж аваад,
өөрийнхөө омогтой Танан голын
эхээр гөрөөлөхөөр одов. Тэд замд
гарахаар завгүй бужигнаж байсан ч,
Киш юм л бол очиж залбирдаг,
чуцашгүй унзад хоолойгоор найрал
дуунд нь дуулдаг шашин номынхоо
газрын мөргөлийг ганц удаа
тасалсангүй.

Тэр цуцашгүй унзад хоолой нь гэгээн
эцэг Жексон Брауныг туйлгүй
бишрүүлдэг бөгөөд бурханд дагаар
орсон хүмүүсээс үнэн сүжигтэй нь
Киш гэж боддог билээ. Гэтэл

худалдаачин Меклрот үүнд эргэлздэг төдийгүй ерөөс Христос бурханы сургаалаар бөөгийн мөргөлтнийг дагуулна гэдэгт ч итгэдэггүй, өөрийн энэ бодлыг нуух хэрэг юун хэмээн үзнэ. Ноён Браун уужуухан бодолтой нэгэн бөгөөд намрын урт шөнө өөрийн зөвийг нэг удаа ид хавтай нотолсноор барахгүй эцэс сүүлдээ нөгөө худалдаачин бүр цөхөрч гүйцээд:

-Би энд газрын гаваар орог. Браун, харин Киш дахиад хоёр жил тэсдэг юм бол би ч гэсэн үнэн сүсэгт Христийн номлолтон болно, гайгүй хэмээн дуу алджээ.

Ийм учир тохиолыг алдахгүй
гэсэндээ ноён Браун хэлцээгээ
шийдмэг гар барилтаар бататгасан
бөгөөд үхлийн дараа Меклротын
сүнс хааш одох нь тийнхүү Кишийн
авир аашаас хамаарах болов.

Анхны цас газарт хөглөрөн буусны
дараахан нэг удаа ариун Георгийн
төлөөний газарт элч ирэв. Сум
авахаар ирсэн танан омгийн тэр
хөгшин Гнобын голомтод их сүй
тавьсан зоригт анчин залуу Ни-
Кугаас Су-Су нүд салгахаа больсон
гэсэй үгтэй иржээ. Яг тэр үед гэгээн
эцэг Жексон Браун гол руу одсон
ойн зам дээр Киштэй тааралджээ.
Кишийн хөллөгөөнд түүний шилдэг

ноход цовхчиж, чарган дээр нь цоо шинэ том хос цана тавиатай байлаа.

Ноён Браун улаан арьстануудын яриаг дуурайж,

-Аль замаар хаа явж байна, эрхэм Киш? Ангуучилж явна уу хэмээн үгэнд дурлажээ.

Киш түүний нүд рүү хэдэн эгшин цоо ширтсэнээ нохдоо хөдөлгөлөө. Хэдэн алхам яваад сэвхийтэл эргэн харж, Христийн сурталч руу зүрх зүсэм харцаа ахин илгээгээд,

-Үгүй ээ, би там руу очдог замаар явж байна гэж эрсхэн хариулжээ.

Ойн бяцхан чөлөөнд золгүй
ганцаардлаас аврагдах гэсэн мэт
цасанд умбартлаа шигдсэн гурван
ноорхой овоохой шовойлдох авай.
Овоохойнуудыг тал бүрээс нь балар
хөвч хашжээ. Цэлмэг хөх тэнгэрийг
халхалсан будант бүгээн саарал үүлс
цасан шамрага зөгнөн бараагнана.
Аниргүй цагаан дайд, цаснаас өөр
юмгүй агаад салхи савир ч алга,
чимээ имээ ч үгүй. Гөрөөч нар бугын
сүргийг хөөж гүйцээд, ангийн гэнгор
ивээсэн болохоор тэр буудал
очүүхэн ч хөл үймээнгүй, нэг сар
мацаг барьсны хойно ийнхүү элбэг
дэлбэг цаг ирж. анчид бугын арьсан
овоохойдоо гэгээн цагаан өдрөөр

бөх гэгч нойрсож байдаг болж.

Овоохойнуудын нэгнийх нь гадаа
үүдэнд дүрэлзэн буй түүдгийн
дэргэд Су-Су сууж, таван хос цана
хажууд нь тавиатай байлаа,

Хэрэмний арьсан дээлнийх нь юүдэн
хүзүүнд нь чанга бүчлээстэй ч
шөрмөс сүвлээстэй зүү барьсан гар
нь шунхан улаан даавуугаар чимсэн
суран бүсэн дээрх адармаатай
чамин хээний сүүлчийн оёог шаглаж,
уран шалмаг хөдлөх ажээ.

Овоохойнуудын ард хаа нэгтээ
нохой хуцах дуун зүрх зүсэм
цуурайлснаа, тэр дороо таг чиг

болчихов. Овоохойд эцэг нь нойрон дундаа хоолойгоо хяхнуулснаа гиншин ёолж байна. Хар дарж байна, аав өтөлж дээ, тэр сүүлчийн халбагатайг өгдөггүй байж, ер нь овоо идсэн гэж бодсоноо бүсгүй инээмсэглэж суулаа.

Дахин нэг өлбөн хадсаныхаа дараа шөрмөсөн утсаа зангидаж бэхлээд, хуурай гишүү галдаа орхин түүдгийн дөл рүү гөлөрч суутал, хөр цаснаа бугын арьсан гутлын чихраан дуулдах нь тэр. Бүсгүй цочин өлийж харлаа.

Үүрсэн юмныхаа хүндэд үл мэдэг бөгтийсөн Киш өмнө нь зогсож байх

юм. Бугын элдсэн арьсанд юмаа баадагнажээ. Баадантайгаа цасан дээр хайнгадуухан чулуудаж орхиод, тэр түүдгийн хажууд суулаа. Тэд бие бие рүүгээ харан, чимээгүй нэг хэсэг суув.

-Чи урт зам туулжээ, Киш. Юкон дахь Ариун Георгийн төлөөний газраас нааших зам урт шүү хэмээн Су-Су арайхийн хэлэв.

-Тийм ээ -гэж Киш хайнгадуухан хариу хэлээд оёж буй бүс рүү нь сүрхий харж хэмжээ дамжааг нь нүдээрээ багцаалдсанаа: -Харин нөгөө хутга чинь хаа байна гэж гэнэт сонирхов.

-Энэ байна. Бүсгүй дээлнийхээ энгэрийг суйлан, хутга гаргаад ирсэнд торгон ир нь түүдгийн гэрэлд харлан харагдана. -Сайн хутга шүү!

-Алив над өгөөтөх гэж Киш өтгөн дуугаар захирав.

-Үгүй дээ, Киш. Чи үүнийг зүүх хувгүй ч юм билүү гэснээ Су-Су инээд алдчих нь тэр.

-Над өгөөтөх. Би зүүх хувьтай хүн гэж нөгөө дуугаараа давтлаа.

Су-Су бугын арьсан баадан руу саваагүй зангаар гүймэгхэн харснаа, доорхи цас нь аажуухан улаарч

байгааг үзэв.

-Киш, энэ цус уу? гэж тэр асуужээ.

-Тийм ээ, энэ цус. Бүс, урт орос хутгаа над өг дөө.

Су-Суг гэнэт айдас эзэмдээд авсан ч, Киш түүний гараас бүсийг нь булаан авахад баяр бахдал оргилоод иржээ. Бүсгүй түүн рүү энхрий ялдамхан харах агаад хөх нь чинэж өвдөхийг, хүзүүгээр нь тэврэх өөдсөн чинээ гарын халууныг эрхгүй зөгнөн мэдэрчээ.

-Туранхай хүнд хийсэн бүс байна гэж Киш гунигтай өгүүлээд, гэдсээ татан

байж эхний ухлаадас руу нь бүсээ горхилов.

Су-Су ялдамхан мишээж, нүд нь улам энхрийхэн гэрэлтээд ирэв. Могжгор бяцхан гар хүзүүгээр нь тэвэрч байгааг тэр ахиад мэдрэв. Киш нүд дүүрэн сайхан залуу, харин бүс дэндүү бачуухан байх нь аргагүй, арай туранхай нэгэнд зориулж оёсон юм чинь. Гэхдээ энэ бүхэн хамаа юун. Тэр дахиад олон бүс оёно.

-Энэ цус уу? Цус биз дээ, Киш? Энэ чинь... Энэ... толгой юу... гэж тэр асуухдаа нууцхан итгэлээр гийгээд иржээ.

-Тийм ээ.

-Эднийг дөнгөж саяхан авч дээ, янз нь, тийм биш бол цус нь хөлдчихнө биз дээ.

-Нэг их хүйтэн биш байна, харин цус нь шинэхэн, дөнгөж саяхных.

-Киш минь! Эднийг чи над авчраа юу? гээд хүүхний царайд баяр бахдал тодроод ирэв.

Тийм ээ, чамд авчирсан юм.

Тэр бугын арьсны сэжүүрээс шүүрэн дугтарч орхитол хэдэн толгой цасан дээр өнхрөлдөн унав.

-Гурав уу? Үгүй ээ, багаар гэхнээ дөрөв гэж бүсгүй бачимдан багтарсандаа арайхийн шивнэв.

Су-Су айсандаа мэлэрчихэв. Ни-Кугийн хавчиг толгой, өтөл буурал, үрчлээ дүүрэн Гнобын тэргүүн, доогтой инээх мэт дээд уруулаа таталдуулсан Макамук, хамгийн цаана олныг өгүүлэн нүдээ үргэлжид жийхайлгах Носсабокын толгой бөндийлдөн байна.

Тэд тийнхүү бүсгүйн өмнө түүдгийн гэрэлд тодхон харагдах агаад цасан дээр шунхан улаан цусан толбо нэвчүүлсээр байж байна.

Түүдгийн хажууханд буй Гнобын тэргүүн доорхи хөр цасаа хайлуулан доош суунгуутаа газрын хэвгийн эрхээр Су-Сугийн хөл рүү амьд лугаа адил өнхөрлөө. Гэтэл бүсгүй давхийсэн ч үгүй, Киш бас хөдлөлгүй суусаар, нүдээ цавчсан ч үгүй, бүсгүй рүү цоо ширтсээр авай.

Хөвчид хаа нэгтээ нарс мод бөөн цас шилгээн газарт унагаж, цуурай нь хавцал дундуур бүгтхэн нүргэлэн түглээ. Гэтэл нөгөө хоёр урьдын адил таг дуугүй суусаар. Цагаан Соёо түүдэг рүү гүйж ирэх үед богино өдрийн үдшийн гэгээ яах ийхийн зуургүй замхарч, буудал руу түнэр харанхуй хэдийнээ гэтэн ойртож

байлаа. Мөнөөх нохой, хөөж туухгүй
байгаа гэсэн шиг хулмалзан
зогссоноо, аажуухан ойртож ирээд
сарьсан хоншоор нь учиргүй
сарталзаж, зооных нь үс гэнэт
өрвөсхийгээд явчихав. Тэр өчүүхэн
эргэлзээгүй танил үнэр авч, эзнийхээ
толгойн дэргэд зогссоноо, түүнийг
болгоомжтой үнэрлэн урт улаан
хэлээрээ духыг нь долоох аж.
Тэгснээ цогцойн суугаад тэнгэрт
бүдэгхэн гялалзан түгэж буй эхний
оддын зүг өлийн, чонын дуугаар урт
гэгч ульж гарав.

Тэгэхэд л сая Су-Су ухаан орж, орос
хутгыг хуйнаас нь сугалаад, шинжих
мэт харж суугаа Кишийн зүг нүд

өргөлээ. Кишийн царай шийдмэг,
ухарч няцашгүй барайсан агаад Су-
Су харцнаас нь өөрийнхөө хувь
тавиланг уншжээ. Дээлнийхээ
юүдэнг хойш буулган, хүзүүгээ
задгайлснаа босч, хагацлын гөлрөнги
харцаар ойн бяцхан чөлөө, тэнгэрт
гялалзах одод, буудал, цасан дээрх
цана руу хяламхийж, түүний
амьдрал буцалж байсан сүүлчийн
буудлыг гаслант харцаараа
тэмтэрлээ.

Зөөлөн салхи туг үсийг нь хийсгэх
агаад элгээ эмтэртэл сүүрс алдсан
тэрээр толгойгоо эргүүлж, нүүрээрээ
салхины өөдөөс сөржээ. Хэзээ ч
түүнээс төрөхгүй хүүхдүүдийн тухай

бодсон Су-Су Киш рүү дөтөлснөө:

-Би бэлэн! хэмээн өчжээ.

Жис-Укын түүх

Өглөг золиос гэж бий. Гэхдээ золиос хэзээд ганц утга учиртай. Түүний гайхалтай утга учир нь хүн хамгаас үнэтэй бүхнийхээ төлөө үнэтэй цайтай юунаасаа ч юм бэ хагацах явдал билээ.

Хэзээний ийм байсан. Авель өөрийнхөө анхны өвөг сүрэг, тэдний бордооноос авчирч байхад ч тийм байсан. Анхны өвөг сүрэг, бордооноос нь эрхэм үнэтэй юм ертөнцөд байгаагүй ч, бурхантай найрсаг харилцаагаа хадгалахын эрхэнд түүнийгээ хүртэл өгсөн. Хүү Исаака Авраам золиосын тавцан

дээр тавихад ийм л байсан. Тэр Исаакт хайртай, гэхдээ яагаад ч юм бэ бурханд бүр илүү хайртай, сүжигтэй. Магадгүй, түүнээс зүгээр айсан ч юм билүү. Юу ч болсон байлаа гэсэн, хэдэн тэрбум хүн Авраам гагцхүү бурханыг хайрлаж, түүнд зүтгэхээр амь тэмцсэн хэмээн өнөөг хүртэл жолоогүй итгэсээр авай.

Хайр бол хүчин зүтгэл хэмээн ойлгох аваас өөрийгөө золиослох ч бас хүчин зүтгэл гэсэн үг. Энэ бүхнээс ургуулан бодохуйяа Жис-Ук гэдэг борхон арьст эгэл тэр бүсгүй эгэлгүй хайраар шатаж явжээ. Жис-Ук хүүгээрээ тахиж аргадахаар зэхэж

байтал сахиусан тэнгэрүүд тайлагыг
нь зогсоосон домогтой.

Гагцхүү тэнгэрийн зураг, ангийн мөр
уншиж чаддаг боловч шашны ариун
түүхийг огт мэдэхгүй, Авелийн тухай,
Авраамын тухай хэзээ ч дуулаагүй.
Ариун Загалмайн сайхан сэтгэлт
хандмаа нарын халамж анхаарлын
хаагуур өнгөрсөн юм, алс газрын хар
элгийн хүүхний төлөө өөрийн бурхан
шүтээнээ хүртэл золигт гаргадаг
мавр хүүхэн Руфигийн тухай хэн ч
туунд ярьж өгөөгүйсэн.

Шийдмийн далайлт дор нохой,
хулгайлсан ясаа орхидог ганц
золиосыг Жис-Ук харин сайн мэдэх

билээ. Гэхдээ цагаа тулахаар тэр цагаан арьстаны хаанчлалын оргилд хүрч чадсанаар барахгүй, жинхэнэ агуу өглөг золиосын эзэн болсон бүлгээ.

Жис-Укын хувь заяаны тухай, Нийл Боннер, Китти Боннер, Нийл Боннерын хоёр хүүхдийн хувь тавилангийн тухай түүх энэ буй заа.

Жис-Укын зүс бараан боловч тэр улаан арьстан ч биш, эскимос ч биш, иннуит ч биш байсан юм. Ам дамжсан яриагаар бол Сколкза гэдэг нэр дуулддаг бөгөөд Юконы тойат омгийн тэр улаан арьстан, идэр залуудаа Их Дельтагийн иннуит

ястаны суурин хүрч, тэнд Олилли гэдэг нэртэй хүүхзнтэй учирчээ. Олилли хүүхний ээж нь эскимос, аав нь иннуит. Тийнхүү Сколкза Олилли хоёроос хагас нь тойат, хагасын тал нь иннуит, мөн тал нь эскимос цусны Хали охин мэндэлжээ.

Гурван омгийн цус судсанд нь холилдож орхисон Хали цаашдын хольцооноос зүрхшээсэн ч, Тарган хэмээх гуншингаараа цуутай, ангийн үсний орос худалдаачин Шпактай дэр нийлүүлжээ. Өөр оноочих нэр олдоогүй учир Шпак энд орос гэж нэрлэгдсэн болохоос биш, түүний эцэг Оросын цөллөгийн ялтан мөнгөн усны уурхайгаас зүүн Сибирь

рүү оргон босч, тэнд Бугын омгийн
бүсгүй Зимбатай учирч, тэр Шпакын
ээж болсон байж. Тэр ялтан Жис-
Укын өвөө юм. Хойд мөсөн далайн
эргээр амин зуулгаа чадан ядан
залгуулагч Тэнгисийн хүмүүс Шпакыг
хүүхэд ахуй Цагт нь булааж
одоогүйсэн бол тэр Жис-Укын өвөө
болохгүй, ярих ч юмгүй байхсан.
Гэвч Тэнгисийн хүмүүс түүнийг
булаан авч, мань хүн тэднээс оргож
Камчатка хүрээд, тэндээсээ
Норвегийн халим агнуурын хөлөг
онгоцоор Балтын тэнгис хүрчээ.
Дараа нь Шпак Петербургт ирж,
хэдэн жил өнгөрөөгүй байтал, өнөөх
чинь хагас зуун жилийн өмнө

эцгийнхээ гав гинжтэй туулсан тэр бэрх зам харгуйгаар Дорно зүгт оджээ. Тэгэхдээ Шпак Оросын үнэт үсний компанид албан хаагч, эрх чөлөөт хүмүүний ёсоор аялан явсан юм. Өөрийн үүргийг биелүүлсээр, тэр Дорно зүгт улам алслан зүтгэсээр, эцэс сүүлдээ бүр Берингийн тэнгисийг гэтэлж, Оросын Америкт Пастиликт, Юкон голын Их Дельтийн дэргэд Жис-Укын эмээ Халигийн ёст нөхөр болсон авай. Тэр хоёрын дундаас Тюксен охин мэндэлжээ.

Энэ бүхэн 1850 онд болсон бөгөөд чухамхүү тэр 1850 онд Нулато руу улаан арьстанууд довтолж, тосгоныг

газрын хөрснөөс арчиж орхижээ, Шпак Хали хоёр ч тийнхүү хорвоог орхив. Тэр аймшигт шөнө Тюксен ор сураггүй алга болжээ. Тойатууд өнөөг хүртэл өөрсдийгөө тэр дайралтад хамаагүй хэмээн ам тангараг өгдөг ч, тийм ч бай, үгүй ч бай Тюксен охин тэдний дунд торнисон нь аргагүй үнэн баримт билээ.

Тюксен хоёронтаа эрд очсон боловч түүнд үнэрлэх үр заяасангүй. Тийм болохоор хар элгийн эмс толгой сэгсэрсээр, хүүхэд гаргадаггүй бэлэвсэн эхнэртэй суухыг хүсэгч гурав дахь тойат эр олдсонгүй. Гэтэл яг тэрхэн үед голын эхээд хэдэн зуун

бээрийн алсад Юкон Фортод Спайк О'Брайен гэдэг нэртэй хүн амьдарч байж. Юкон Форт Гудзоны булангийн компанид харьяалагдаж, харин Спайк Брайен тэдний албан хаагчдын нэг байв. Тэрбээр албаа сайн гүйцэлдүүлэх авч, ажил ер нь олиггүй зүйл гэж нот итгэчихээд цагаа болохоор ажлаа орхин оргож боссон нь үүний нотолгоо болжээ. Гудзоны булангийн Йоркын худалдааны суурин хүртэл, нэг харуулаас нөгөө харуул орохын тулд бүтэн жил болов. Түүнээс гадна харуул бүхэн компанийнх хойно тэр зам дээр түүний савраас зайцах аргагүй гэдгээ О'Брайен мэдэж

байлаа. Ганц зам үлдэж буй нь Юконоор уруудах Үнэндээ тэр хүртэл ганц ч цагаан арьстан Юкон голоор уруудаж үзээгүй, ганц ч цагаан арьстан Юкон Берингийн тэнгист цутгадаг уу, Хойт мөсөн далайд нийлдэг үү гэдгийг мэдэхгүй байсан ч, Спайк О'Брайен кельт хүн хойно, аюул занал түүний хувьд хэзээний дур татам зүйл нь байж.

Хэдэн долоо хоногийн дараа уранхай ноорхой, өлөн зэлмүүн, дээр нь хумхаа тусч арайхийн амь зайцсан тэр завиа тойатуудын тосгоны ойрмогхон харгианд хаяв уу, үгүй юу тэр дороо ухаан балартан хөсөр унажээ. Тэндээ

хэвтсээр, тэнхээ тамир оров уу яав
Тюксенийг олж харж цаадах нь ч
түүнд таалагджээ. Шпакын эцэг
Сибирийн Бугын омгийнхон дунд
насан өндөр болтлоо амь зуусан
бөгөөд О'Брайен чгэсэн тойатуудын
дунд тийнхүү өтөлж байсан ч түүний
зүрх сэтгэл адал явдлаар ангаж,
алсын алсад мань хүнийг далласаар
авай. Тэр Йоркын худалдааны
суурингаас Форт Юкон хүртэлх
замыг нэгэнт туулчихсан болохоор
өдгөө Форт Юконоос тэнгис хүрч,
Умард-Өрнөдийн хуурай замын
гарцыг анх нээсэн хүний алдрын
навчин титмийг хүртэж болох
байлаа. Үүний учир тэр гол уруудан

хөвж, мөнөөхөн навчин титмийг
авсан боловч нэр нь тодролгүй,
гавьяа нь дурсагдалгүй мартагджээ.
Хожмоо тэр Сан-Францискод усан
цэргийн уушийн газрын эзэн болоод
тэр тухайгаа чин үнэнээр нь ярьсаар
эцэст нь дэгс худал яриатай хэмээн
цууд гарчээ. Харин нөгөө Тюксен. үр
хүүхэдгүй Тюксен чинь зулайг нь
үнэрлэх үртэй болов. Энэ бол Жис-Ук
байлаа. Түүний удам судрыг энд ийм
гүн гүнзгий мөшгөсний учир юу вэ
хэмээвээс, тэр улаан арьстан ч биш,
эскимос ч биш, иннуит ч биш, өөр
хэн нэгэн ч биш гэдгийг үзүүлэхийн
тулд, басхүү хүмүүний үр удмын зам
мөрийн нүгэл хилэнцийг наманчилж

баршгүй бөгөөд бид цөмөөрөө эцэс
төгсгөлгүй жигтэй сонин
шүтэлцээний тоглоом гэдгийг нотлох
гэсэн хэрэг билээ.

Ийнхүү олон омгийн цус судсаар нь
бургилж буй Жис-Ук гайхам сайхан
бүсгүй болон өсч торнив. Түүний гоо
үзэсгэлэн ер бусын агаад дэндүү
дорно зүгийнх учир ямар ч угсаатны
зүйчийн толгойг эргүүлж дөнгөхөөр.
Жис-Ук уян налархай, уран гоолиг,
Кельтийн хэмээн маргашгүй юм нь
зөвхөн түүний оргилуун сэргэлэн
ухаан. Чухам Кельтийн халуун цус л
түүний царай зүсийг арай бор
болгочихоогүй байж магад, харин
бие нь арай цагаан, үүгээрээ тэр

слав дээдсийнхээ арьсны өнгийг
өвлөсөн Тарган Шпакт талархах
ёстой байж мэднэ. Жис-Укын томоос
том, туяарсан хар нүд үү, эрлийз
бүсгүйн бүйлс лугаа адил, сэтгэл
уярам тэр мэлмий бараан, цагаан
арьстнуудын мөргөлдөөний тэмдэг
агаад үйж үхмээр даанч сайхан.
Өөрт нь цагаан хүмүүсийн цус
бургилж буй гэдгийг мэдэрснээс ч
тэр үү, Жис-Укт учир битүүлэг омог
төгөлдөр бодол үргэлж төрнө.
Бусдаар бол тэр дадал зуршил,
амьдралд хандах хандлагаараа
жинхэнэ улаан арьст тойат хүүхэн
байлаа. Хэзээ ч билээ дээ, дүн
өвлөөр Жис-Укыг идэр балчир

шахам байхад түүний амьдралд
Нийл Боннер иржээ. Түүний
амьдралд байтугай Аляскт тэр
өөрийнхөө дур зоригоор ирээгүй.
Эцэг нь эсгүүр хайчилж, сарнай цэцэг
тарьж, ээж нь язгууртны зугаа
хөөцөлдөж байх зуурт Нийл Боннер
замаа алдаж гүйцжээ. Төрөлхийн
олиггүй нэгэн бус ч, хүн гэдэс
цатгалан, хийх юмаа олж цөхөхөөр,
бяр хүсэл нь гарах газаргүй болдог
лугаа адил Нийл Боннер гэдэс
цатгалан, хийх юмгүй байж. Тийнхүү
мань эр өөрийнхөө хамаг бяр
хүслийг учир тоймгүй гарздаж,
аймшигт сүйрэл хариугүй
нүүрлэхийн даваэн дээр эцэг нь, их-

Нийл Боннер сарнай цэцэгс дотроос мөлхөн гарч ирснээ, өөрийн үр удмыг гайхан харж гэнэ. Дараа нь эсгүүр.. сарнайн талын зөвлөх, хуучин нөхөр рүүгээ очиж, бага Нийл Боннерын хувь тавиланг тэд хамтдаа шийдэв. Тэр алс газар одож, өө сэвгүй зан авираараа болчимгүй явдлаа цагаатган, цагийн аясаар тэдэн шиг олонд тустай нийгмийн гишүүн болох ёстой болов.

Гаргасан шийдвэрээ тэд биелүүлж ядахнаа юу байхав. Бага-Нийл Боннер ичиж, гэм нүглээ хүлээсэн бөгөөд харин аавынх нь хуучин нөхөд Номхон далайн эргийн компанийн нэр төртэй хувь

нийлүүлэгчид, гол мөрөн, далайн хөлгийн флотыг эзэмшигч энэ компани зөвхөн далайгаар ч шан татдаггүй, газрын зураг дээр цав цагаан толбоор тэмдэглэгдсэн хэдэн зуун мянган шоо дөрвөлжин бээр газрыг басхүү эзэмшилдээ авчихсан байсан юмсанж. Ингээд компани бага-Нийл Боннерыг цагаан толбо болсон тэр газар руу, өөрсдийнхөө төлөө ажиллуулахаар, цаг хугацааны эрхээр эцгийнхээ журамт хүү нь болог хэмээн Умар зүг илгээжээ. "Толгой эргүүлсэн юмнаас холхон, байгальтай дөт, таван жилийн борог амьдрал түүнийг хүн болгох биз" гэж Нийл Боннер айлдсанаа, сарнай

цэцэгс рүүгээ эргээд мөлхчихжээ. Бага Нийл шүдээ зууж, шийдмэг янзтай дээгүүр харан, Умардынхаа ажилд оржээ. Тэр сайн ажилтан болохоор төдөлгүй дарга даамлынхаа итгэлийг олжээ. Ажил нь түүнд учиргүй таалагдаж байсан гэж хэлж боломгүй ч, гагцхүү энэ л түүнийг солиорлоос аварч байлаа.

Эхний жилийнхээ турш тэр Умардад үхлийг дуудав. Удаахь жилийг тужид тэр бурханд хараал зүхэл илгээв. Харин гуравдахь жил ирэхийн сацуу тэр үхлийг ч дуудаж, бурханыг ч харааж, сүүлдээ өөрийнхөө хүсэлд төөрч орхиод, албаны хүмүүс, эд мөнгөтэй эрхтэн дархтантай хий

маргалдаж гарав. Эл маргаанд тэр
ялж гарсан боловч эцсийн үг албань
улс, эд мөнгөтэй эрхтэн
дархтануудын талд үлдсэн агаад
чухамхүү тэр үг Нийл Боннерыг ийм
бөглүү буйдад, урьдын газар нь
үүнтэй харьцуулахнаа диваажин мэт
санагдах энэ газарт илгээсэн билээ.
Гэхдээ Умард нутаг түүнийг нэгэнт
хүн болгочихсон болохоор Нийл хэл
амгүй яваад өгсөнсөн.

Газрын зургийн цагаан толбоны энд
тэнд "О" үсэг аятай өчүүхэн дугуй
тэмдгүүд харагдаж, дэргэд нь "Форт
Гамильтон", "Тананы харуул"
"Хорьдугаар бээр" гэсэн нэрс
үзэгдэж, цагаан толбо чинь хот,

тосгодоор дүүрэн юм байна гэж бодогдмоор. Гэтэл энэ зөвхөн танд тэгж төсөөлөгдөж байгаа юм. Бусад бүх худалдааны суурингуудын адил Хорьдугаар бээр гэдэг нь жижиг хүнсний мухлагийн дайтай, дээд давхрыг нь суугчдад хөлслүүлдэг ганц дүнзэн байшин шүү дээ. Арын чөлөөнд нь өндөр шон дээр барьсан агуулах, хоёр пин бий. Тэр чөлөө нь хашаа хаалтгүй, тэнгэр газрын савслага түүнээс алсад цэлийн одно. Юконы доод биеэр хоёр бээр хэртэй газарт тойатууд хааяа өвлийн буудал засдагийг эс тооцвоос хажууд нь өөр сууц гэхээр юм үгүй. Номхон далайн эргийн компанийн тоолж баршгүй

олон тэмтрүүлийн нэг, Хорьдугаар бээр гэдэг ийм л газар! Тэнд компанийн төлөөлөгч, түүний туслах хоёр улаан арьстануудтай үнэт үсний наймаа хийж, санаандгүй бядан ирэгч алтны хайгуулчдаас алтан элсийг нь бараагаар арилжиж авна. Компанийн төлөөлөгч, түүний туслах хоёр өвлийн тужид хаврыг хүлээн, харин хавар ирэхтэй нь зэрэг орчлон хорвоогийн хамаг бүхнийг хараалын муухайгаар булсаар, Юкон хальж байшинг нь угааж байх зуурт дээвэр дээрээ авирч гарна. Умардад суусан дөрөв дэх жилээ Нийл Боннер ажил хэргээ өөрийнхөө гарт авахаар энэ газар иржээ.

Тэрбээр хэнийг ч хоолгүй болгоогүй бөгөөд туслагчийнх нь өгүүлснээр "хүнд бэрх нөхцөлийн" улмаас өмнөх төлөөлөгч нь өөрийн гараар амиа хорлон хорвоог орхисон аж. Тойатуудын түүдгийн дэргэдээс үүнээс арай өөр юм дуулддаг нь үнэн л дээ. Туслагч нь гэж бөгтөр, ханхар цээжтэй, хацар нь хонхойгоод шуугдчихсан, армаг тармаг хар хуузтай нэгэн, уушгийг нь сүрьеэ сархинаг болгож буй бололтой байн байн бөгшүүлсээр, сүрьеэ сүүлчийнхээ шатанд орохоор ямар байдаг билээ, тэр л ёсоор нүд нь солиорлын галаар тэчъядан гялалзах авай. Түүнийг Пентли-Амос

Пентли гэнэ. Ганцаардаж, цөхрөнгөө барсан тэр хүнийг үнэхээр өрөвдсөн ч, Боннерт тэр таалагдсангүй. Тэгээд ч тэр хоёр эвээ олсонгүй. Уг нь айсуу их хүйтэн, анир чимээгүй урт өвлийн тас харанхуйд тэдэнд эв найраас илүү хэрэгтэй юм юусан билээ.

Сүүлдээ Боннер Амос зүгээргүй, эрүүл бус юм байна гэсэн дүгнэлтэд хүрч, түүнийг оролдохгүй байхаар шийдээд, тогоо барихаас бусад бүх ажлыг өөрөө гүйцэлдүүлэх болжээ. Гэтэл Амос түүн рүү хорсол дүүрэн хялалзсан хэвээр, өөрийнхөө өшөө хорсолыг нуухыг хүссэнгүй. Боннерт хэцүү байлгүй яахав. Зовлон зүдгүүр дунд төрсөн эв найр, сэргэлэн хошин

үг, баясал дүүрэн царай түүний хувьд энэ газар олон зүйлийг орлож буй билээ. Гэтэл өвөл дөнгөж ирж байдаг.

Ийм туслагчтай өмнөх төлөөлөгчид амиа хорлох шалтгаан хангалттай байсныг Нийл Боннер сая ойлгожээ.

Хорьдугаар бээрт орь ганцаардахын эрхэнд бүр гасалмаар уйтай байлаа. Тэнгэр газрын савслага хүртэл эргэн тойрон оргүй хоосон цөл.

Цас, бүр тодорхой хэлбэл цан хүүрэг газар дэлхийг цагаан цувцаагаар хучаад хамаг юм үхлийн анир чимээгүйд автжээ. Тэнгэр цэв цэлмэг

авч, тас нясхийсэн жавар хэдэн долоо хоног тачигнаж, хэмжигчийн заалт тасралтгүй тэгээс доош дөч, тавин хэмийг заасаар авай.

Дараа нь арай уясов. Чийг агаар мандалд аажуухан нэвтрэн. тугалган енгөт эмх замбараагүй үүлс болж хувирав. Дулаарлаа. Хэмжигч хасах хорь хүртэл дээшлээд, хөл дор хуурай цас, элсэн чихэр лугаа адил шажигнан хатуу цасан талстууд газарт унаж эхэллээ. Тэгснээ дараа нь цэв цэлмэг, тас нясхийсэн хүйтэн цаг агаар тогтнож, харин газар дэлхийг хүйтэн жавраас хаацайлж чадахуйц овоо чийг агаэрт хуримтлагдангуут сая дахиад

дулаарна. Тэгээд гүйцээ. Өөр юу ч болохгүй. Салхи шуурга ч, усны цалгиа, модод хугарч унах тачигнаан ч дуулдахгүй, мөсөн талст байнга хаялахаас өөр юу ч үгүй. Энэ уртаас урт, уй гаслант долоо хоногуудын хамгийн том үйл явдал гэвээс мөнгөн ус үзэгдэж дуулдаагүй өндөрт, арван таван хэмд хүрсэн яедал биз. Дараа нь өс хонзон авах гэсэн мэт сансар хурмастын жавар газрыг тас базаж, мөнгөн ус тас хөлдөөд, харин спирттэй хэмжигч хоёр долоо хоногийн тужид дал дээр таг зогсов, Сүүлдээ тэр нь ч хага буудаад, агаарын хэм үүнээс доош хэд хүртэл унасан нь тодорхойгүй

болов. Өөрийнхөө давтамжаар нэгэн хэвийн хэмнэлд орчихсон өөр нэг явдал бол өдөр нь түнэр харанхуйг эсгэсэн цагаан гэгээний гялбаа болж хувираад, шөнө нь хязгааргүй урт болсон явдал бүлгээ.

Нийл Боннер өөртэйгээ адилхан улсын хүрээлэлд дуртай билээ. Өдгөө гэмшин гашуудаж буй түүний хамгийн сүрхий алдаа нь өөрийнх нь дэндүү нийтэч байдлаас үүдсэн буй заа. Ингээд тэр өөрийнхөө цөллөгийн дөрөв дэх жил дээрээ үгээ залгисан, дүнсгэр, онцын шалтгаангүй атлаа хязгааргүй үзэн ядалт харцанд нь нуугдсан тийм ганцаардмал хүний хань хамсаа

болчихжээ. Хүрээлэн гэдэг энэ үг энд гашуун даажигнал мэт дуулдана. Найрсаг яриа хөөрөө агаар мэт хэрэгтэй байсан Боннер урьдынхаа амьдралын баяр баясгалант дурдатгалд тарчилж гүйцсэн хий сүг аятай амьдарч байлаа. Өдөр нь түүний царайд мэдэгдэх юм үгүй, уруул нь жимийгээстэй, шөнө нь хуруу гараа хугалах шахам базалж, хүүхэд аятай мэгшин орондоо хөрвөж, эрхтэн дархтан эд хөрөнгөтэй албаны улсыг үе үе санан, урт шөнийн турш тэдэнд хараалын мууг илгээнэ. Бурханыг хүртэл зүхнэ. Гэтэл бурхан бүхнийг ойлгох агаад түүний зүрх сэтгэлд

Аляскт өөрийг нь харааж зүхэж буй
өчүүхэн мөнх бус амьдралтанг
буруушаах хүсэл даанч төрсөнгүй
бололтой.

Тийнхүү байтал Жис-Ук гурил, гахайн
утсан мах, үйл үртсэндээ хэрэглэх
хурц өнгийн бөс, сувс худалдаж
авахаар ийшээ Хорьдугаар бээрт
ирж, хэдий үүнийг тэр өөрөө
мэдээгүй боловч Хорьдугаар бээрт
буй ганцаардаж гүйцсэн хүн түүнийг
ороод гарсны хойно, шөнө
нойрондоо хий хоосныг тас
тэвэртлээ бүр ч ганцаардах болжээ.
Аргагүй шүү дээ, Нийл Боннер эр хүн
юм чинь. Жис-Ук агуулахад анх орж
ирэхэд, мань эр түүн рүү ангаж үхэх

гэж байгаа хүн тунгалаг уст булаг харсан лугаа адил мэл гайхан гөлөрч хоцорчээ. Харин судсанд нь Спайк О'Брайены цус бургилж буй сайхь бүсгүй хаанчилж буй хүмүүсийн өөдөөс бараан царайтнууд яаж инээх ёстой тэр ёсоор инээсэнгүй, бүсгүй хүн эр хүн рүү инээдэг шигээ мишээжээ. Алсдаа болох ёстой юм болж, харин мань эр үүнийг ойлгосонгүй, Жис-Ук хичнээн хүчтэй сэтгэлийг нь эзэмдэх тусам дур хүсэлтэйгээ тэр төдий улайран тэмцэлдсээр байж. Харин бүсгүй? Тэр бол Жис-Ук хойно, хэдий ясны биш боловч хүмүүжлээрээ тойат омгийн жинхэнэ улаан арьст хүүхэн

байлаа.

Тэр элдэв юм авахаар худалдааны сууринд байнга ирдэг, хэл хугалчихмаар англи хэлээр Нийл Боннертой хөөрөлдөхөөр том пийшингийн хажууд саатан суудаг болжээ. Нөгөөх нь бүсгүйг хүлээж цөхөөд, үзэгдээгүй өдөр хоногуудад нь хийх юмаа олж ядан, тарчилж гүйцнэ. Тэр хааяа энэ бүх явдлын тухай сэрхийтэл санааширдаг бөгөөд тэр үедээ Жис-Укыг биеэ барин хүйтнээр угтаж, бүсгүй түүний хуурамч авирлаж байгааг гадарладаг ч уур нь хүрч, учраа олохоо больчихно. Гэхдээ Боннер санааширч зүрхлээгүй байтал,

худалдааны сууринд инээд хөөр,
чалчаа үг цуурайтаад явчих нь
олонтаа. Элсэн дээр хаясан загас шиг
амь нь тэнцсэн Амос Пентли хүүрийн
үнэрт, бөглүү ханиалгандаа салганан
тэднийг харах бүртээ даажинтайхан
инээмсэглэж сууна. Амьд явахыг
хязгааргүй хүсэгч тэр хүн үйлээ ирж
буйг мэдчихээд бусад улс амьд
үлдэнэ гэж бодохоос учиргүй
тэчъядана. Эрүүл, амьдрах эрч
хүчээр дүүрэн байгаагийн төлөө,
Жис-Укын бараанаар тэсгэлгүй
баярлаж байгаагийн төлөө тэр
Боннерыг үзэн ядна. Амос өөрөө
бүсгүйн тухай бодов уу үгүй юү, зүрх
нь булгилан, гүрээ рүү нь цус нь

хөөрөөд ирнэ.

Жис-Ук эгэл энгүүн, шулуухан, эргэлтгүй сэтгэх бөгөөд амьдралын нарийн ширийнийг тунгааж сураагүй түүний хувьд Амос Пентли дэлгээтэй ном байлаа.

Тэр илүү үг хэлэлгүй, хоёрдмол санаагүйгээр Боннерыг аюулаас илэрхий сэрэмжлүүлэх боловч соёлт ертөнцийн ёсорхолд дасчихсан нөгөөх нь нөхцөл байдлыг зөв үнэлж чадахгүй, бүсгүйн айдсаар тоглоом тохуу хийнэ. Түүний хувьд Амос Пентли өвчинд баригдан, үхлээ хүлээсэн хөөрхийлөлтэй нэгэн, тэгээд ч Боннер зовлон зүдгүүр туулсныхаа

эцэст хүнийг өршөөж
нигүүлсэж сурчээ.

Ид хүйтний үеэр нэг өглөө мань эр
ундныхаа дараа ширээний араас
босч, агуулах руугаа очжээ. Аян
замын салхинд улайчихсан Жис-Ук
шуудай гурил авахаар тэнд хүлээж
байсан бегөөд хэдхэн минутын
дараа Нийл шуудайтай юмыг чарган
дээр нь даруулж байлаа. Гэтэл
тонгойнгуутаа хүзүүнийх нь шөрмөс
татаж буйг мэдэрч, гай зовлон
зөгнөсөн түгшүүрт совин түүнийг
базаад авах нь тэр. Сүүлчийн уяаг
зангидаж орхиод, нуруугаа цэхлэн
өндийх гэтэл хамаг бие нь
салганан, цасан дээр харуулдаж

ойчжээ. Толгой нь байдгаараа
гэдийж, нуруу нь тахийж бөхийгөөд,
хөл гар нь эгэл бусаар тарайн
хөшиж, татагнан чичирсэн бие нь
хэсэг бусгаараа тасар татагдаж
байгаа юм шиг сүйд болов. Хашгирч
гууглаа ч үгүй, ганц үг дуугараагүй
Жис-Ук түүний дэргэд цасан дээр
ойчсон бөгөөд мань хүн бүсгүйн
гарыг тас атгачихсан болохоор
таталт дуустал тэр юу ч хийж
чадсангүй. Хэдэн хоромын дараа
ашгүй агчилт өнгөрч, хамаг бие нь
салхийн сулраад явчихад, Боннерын
духнаа хүйтэн хөлс бурзайж, уруулыг
нь цагаан хөөс бүрхээд иржээ.

-Бушуул! Бушуулаач! Байшинд оръё

хэмээн сөөнгөтөн шивнэх нь тэр.

Тэрбээр дөрвөн мөчөөрөө мөлхмөөр аядтал, Жис-Ук түүнийг хүчирхэг гараараа шүүрэн авч, дэмнэсээр арай гэж агуулах хүрчээ. Тэнд дахиад татаж эхэлсэн бөгөөд бүсгүй түүнийг тэвэрч барьж дийлсэнгүй. тэр салганан агдагасхийж шалан дээгүүр эвхрэлдэв. Гаднаас орж ирсэн Амос Пентли тэр явдлыг тун сонирхсон янзтай харах ажээ.

-Хөөе Амос! Тэр үхэж... Аан хэмээн Жис-Ук өөрийн арчаагүйгээ ухаарсандаа, айж ширвээтсэндээ биеэ мартан орилжээ. Гэтэл Амос мөрөө хавчисхийгээд бах нь ханасан

мэт харсаар авай.

Боннерын бие сулбагасхийж, агчилт нь тавигдан, царай нь арай хөнгөрсөн мэт боллоо.

-Бушуул хэмээн тэр хоолойгоо хяхтнуулан хэлэв. Хариугүй дөхсөн таталтаа давах гэж хүчилсэндээ уруул нь чичирнэ. -Бушуул! Жис-Ук! Эм! Надад аваад ир! Аваад ир!

Жижигхэн эмийн сан өрөөний мухарт, пийшингийн цаана байдгийг бүсгүй мэдэх болохоор дахиад татах гээд салганан буй эрийн хөлөөс чирсээр тийш зүтгэв. Таталт зайчсан болохоор Нийл ядралаа гэтэлж ядан,

эмийнхээ санг арайхийн нээжээ. Ноход тийнхүү таталдан үхдэгийг харахаас аргагүй явдал тохиолдож байсан учир юу хийх ёстойг мэдэх билээ. Хлоралгидратын савыг гаргаад ирсэн авч, тэнийхээ больсон хуруунууд нь бөглөөг нь сугалж хүчирсэнгүй, түүнийг дахин татаад эвхрэлдэж байх зуурт Жис-Ук үүнийг амжуулсан бөгөөд ухаан оронгуутаа нээлттэй бяцхан сав өмнөө байгааг харахын сацуу Жис-Укын мэлмэрсэн хар нүднээс эрчүүл үерхдэг бүсгүйнхээ нүднээс үргэлж уншдаг тэр бүхнийг хоромхноо олж үзжээ. Тэрбээр мансууруулах эмнээс овоохон тунг залгиад, дараагийн

таталт гэмгүй өнгөрөхөд тохой дээрээ арайхийн өндийжээ.

-Дуулж бай, Жис-Ук -хэмээн тэр цаг алдаж болохгүйг ойлгож буй ч яарч самгардахаас зүрхшээсэн бололтой аажуухан: -Миний хэлснийг хийгтүн. Энд бай, гэхдээ надад бүү хүрээрэй. Надад хүрч хэрэггүй, гэхдээ надаас бүү холд. Түүний эрүүний шөрмөс татаж эхэлсэн бөгөөд нүүр нь үрчилзэвч шүлсээ залгиад, оволзоод ирсэн агчилтаа давах санаатай хүчилнз.

-Битгий холдоорой, Амосыг алдав. Ойлгов уу? Амос бас эндээ байх ёстой шүү.

Бүсгүй толгой дохив. Таталт нэг нь нөгөөгийнхөө араас үргэлжилсээр боловч сүүл тийшээ арай сулхан, тоо нь арай цөөн болжээ. Жис-Ук Боннероос холдоогүй авч, түүний захисан ёсоор мань хүнд хүрч зүрхэлсэнгүй, харин Амос гэнэтхэн дав дэвхийн гал тогоо руу зүглэх гэтэл бүсгүйн нүдэнд гялсхийсэн заналт харц түүнийг тушиж, нэг мэдэхийн гагц хүнд амьсгаа, бүгшүүлж ханиах нь л түүнийг энд байгааг сануулж байв.

Боннер нойрсчээ. Богино өдрийн гэгээ бөхөв. Жис-Укын цоргисон харцан дор Амос гаршийн тосон дэнлүү асаалаа. Шөнө айсуй. Умар

зүг харсан цонхоор тэнгэрт туйлын
туяа гийж байснаа төдөлгүй галт
жирвэлзээн мэт болоод бөхөж,
түнэр харанхуйгаар солигдлоо.

Ахиад хэсэгхэн хугацаа өнгөрөхөд
Нийл Боннер сэргэж, юун түрүүн Амос
гараад явчихаагүйг лавтай мэдээд,
Жис-Ук руу инээснээ бослоо. Түүний
бие хөшчихөөд, булчин бүр нь
янгинан, бэлхүүсээ тэмтрэн илснээ
гашуухан инээвхийлжээ. Тэгснээ
царай нь эрс шийдэмгий, яахаас ч
буцахгүй барайгаад ирэв.

-Жис-Ук, лаагаа аваад гал тогоо руу
ор доо. Тэнд ширээн дээр хатаасан
талх, шош, гахайн утсан мах гээд
идэш ууш байгаа. Аа, бас пийшин

дээр кофе бий. Наадуулаа бүгдийг нь нааш нь тавиур дээр тавиад аваад ир. Бас шилэн аяга. ус, виски авчраарай. Шүүгээний дээд талын тавиур дээр шилтэй бий.

Виски мартав хэмээн тэр хэлэв.

Хольцгүй виски шилэн аягаар нэг татчихаад, Нийл бяцхан эмийн сан доторхийг анхааралтай ажиглаж эхэлснээ, зарим савтай шилтэйг хажуу тийш нь тавьж, тедөлгүй аяганы хийцний үлдэгдлийг авч, туршилт хийхээр оролдож эхэллээ. Хэзээ билээ дээ, коллежид лабораторид ажиллахаас аргагүй болж, харин ч овоо бүтээгч,

элдэвлэгч нэгэн байсан болохоор одоо хэрэгтэй бүхэн нь гарын дор байхгүй ч, өөрийнхөө зорьсонд хүрнэ хэмээн зүтгэжээ. Таталтыг дагалдан буй чичрэгийн шинж тэмдэг хэцүү бодлыг нь хөнгөлж, чухам юу хайх ёстойгоо Боннер мэдэж, кофег шинжлээд үр дүнд хүрсэнгүй, шошинд юу ч байсангүй, хатаасан талхтай бүр чамбай ноцолдов.

Хувилахуйн ухааны талаар ямарч ойлголтгүй Амос түүний үйл хөдлөлийг сонирхон ажиглаж, харин Жис-Ук цагаан арьстаны мэргэн ухаан, тэр тусмаа Нийл Боннерын цэцэн ухаанд гүнээ итгэдэг болохоор

өөрөө юу ч мэдэхгүйгээ ухахын сацуу
гар руу нь бус, Нийлийн царай өөд
ширтсээр авай.

Нэгийн араас нөгөөг туршин арга
чаргаа барсаар Нийл эцсийн эцэст
сүүлчийн туршилтдаа оров. Тэр
хуруун шилний оронд хэрэглэж буй
нарийхан шилэн бортогоо гэрэлд
харснаа, доторхи шингэнд нь давс
бужигнан алгуурхан тунаж буйг үзэв.
Таамаглаж байснаа олж үзсэн
боловч тэрбээр ганц үг дуугарсангүй,
гүүний царайнаас нүд салгаагүй
Жис-Ук харин юу ч юм олж үзэж.
Бүсгүй эмэгчин бар лугаа адил Амос
руу ухасхийж, бахдаж бишрэм,
хүчирхэг, уян налархай

хөдөлгөөнөөр түүнийг өвдөг доороо
тэнгэр харуулан унагаад, юу юугүй
дэнгийн гэрэлд хутга гялсхийх нь тэр.
Амос хорсголонтой гийнаж, ирт мэс
ширхийн буухын завдгүй Боннер
хажуугаас нь оролцож,

-Ухаалаг шүү, Жис-Ук. Гэхдээ
хэрэггүй. Наадахаа тавьчих гэлээ.

Тэр тун дурамжхан үгэнд нь орсон
бөгөөд Амос шалан дээр пидхийн
унаж, Боннер түүнийг бойтогны
оймстой хөлөөрөө түлхэн:

-Бос. Амос -хэмээн зандраад: -Та
өнөөдөртөө замд гарч үз -гэсэнд:

-Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж Амос бачимдан бувтнав.

-Энэ бол та намайг алахыг завдсан гэсэн үг. Компани амиа хорлосон гэж үзсэн ч, та бас Бердзалын амийг бусниулсан гэсэн үг. Та намайг стрихнинээр хордуулсан, харин түүнийг юугаар хорлосныг бурхан л мэдэх байх. Чамайг би дүүжилж чадашгүй нь, чи тэртээ тэргүй амьд хүүр. Ямар ч гэсэн хоёул амьдрах зай Хорьдугаар бээрт бидэнд алга. Тэгэхээр чи зайлж үз. Ариун Загалмайн төлөөний газар хүртэл хоёр зуун бээр, хүч чадлаа гамнавал хүрчих биз, чамд би хүнс хоол, чарга, гурван нохой өгнө, таныг энд

цоожлоод ямар ч хэрэг алга, энэ газраас тэртээ тэргүй хов-хорч чадахгүй юм чинь. Би танд ганц боломж олгоё, та булшныхаа нүхний ирмэг дээр зогсч байгаа, яахав би хавар болтол компанид юу ч мэдэгдэхгүй. тайван амьсгаа хураах хугацаа олголоо шүү. За шалавлаж үз!

-Чи хажуулж амар. Чи өвчтэй байгаа шүү дээ гэж, Амосыг түнэр хзранхуйд далд оронгуут Жис-Ук түүнийг шахамдуулав.

-Чи сайн бүсгүй. Тийм ээ, Жис-Ук! Миний гар энэ байна. Одоо харь даа гэж Нийл хариу өчив.

-Би чамд таалагдахгүй байна уу? гэж бүсгүй юу ч болоогүй мэт хэлэв. Тэр инээвхийлснээ, дээлээ өмсөхөд нь хамжилцаад, хаалга хүртэл гаргаж өглөө.

-Дэндүү таалагдаж байна. Бүр дэндүү гэж мань эр аяархан хэллээ. Умардын түнэр шөнийн нөмрөг газар дэлхийг бин битүү ороогоод авахуйяа, Нийл Боннер гол нь тасарч буй алуурч Амосын баргар царайг дэндүү тоомжиргүй харж байснаа эрхгүй ухаарчээ. Ийнхүү Хорьдугаар бээрийг ганцаардал нөмөрлөө. Голын эхээд гурван зуугаад бээрт оршдог Форт Гамильтонд суугаа Компанийн төлөөлөгчид тэр

"Прентис, бурханыг бодож, над руу хэн нэгнийг ирүүлээч" гэж бичиж байлаа. Зургаан долоо хоногийн дараа улаан арьст элч "Ажил хэрэг гэж авах юм алга. Хоёр хөлөө хөлдөөчихлөө. Өөрт хэрэгтэй байна. Прентис" гэсэн товч тодорхой хариутай эргэж ирэв.

Тойатуудын олонхи нь карibu бугын сүргийн араас нутгийн гүн рүү одож, Жис-Ук тэдэнтэй явчихсан болохоор бүр гасламаар. Бүсгүйгээс хичнээн хол байх тусам бүр энүүхэнд мэт санагдаад, Боннерын ухаан бодол үргэлжид түүнийг замд яваа мэт, эс бөгөөс буудал дээрээ байгаагаар төсөөлнө. Ганцаараа байх

аймшигтай ажээ. Мань эр аниргүй
агуулахаас малгай ч үгүй байн байн
гүйн гарч, хурмастын өмнөд
этгээдэд, өдөр болсныг дохиолдог
гэрэлт нарийхан зурвас руу нударга
зангидан эаналхийлдэг билээ. Бас
цэлмэг, хүйтэн шөнө дөлөөр жаварт
гүйн гарч уушигныхаа хамаг хүчээр
анир чимээгүйг өдөн бархирч, өнөөх
нь амьд амьтан лугаа адил энэ уриа
дуудлагыг нь хүлээн авч чадах юм
шиг чадлаараа орь дуу тавьдаг
авай. Заримдаа тэр бүр унтаж буй
ноход руугаа, нөгөөдүүл нь сэрж
улилдаж эхэлтэл бархирна. Сүүлдээ
нэгэн сагсгар нохойг гэртээ
оруулж, Прентисийн илгээх шинэ

туслахын дүрд тоглуулан, хүн шиг
шөнө нь бүтээлэг нөмрүүлж
унтуулан, ширээний ард ам
хөдөлгөж сургах гэж оролдтол,
гаршуулсан чонын удам угсаа, гичий
нохой захирагдахыг үл хүсч,
харанхуй бупангаар нуугдсаар,
архирсаар, түүний хөлийг зууж
орхисон учир эцсийн эцэст баахан
зодоод хөөж гаргав. Тэгтэл Нийл
Боннерыг сүнс сүүдэрт итгэдэг дон
эзэмдлээ. Байгалийн бүх хүчин амьд
биет болж хувираад, түүнтэй
харьцаж эхэлсэн агаад тэр балар
эртний үеийн мөргөлийн шүтээн
хүртэл бүтээж, наранд өргөл өргөдөг
гонхон хүртэл дархалж, түүндээ

гахайн өөх, дэнгийн тос шатаадаг болж, хашаагүй арын чөлөөндөө шон дээр барьсан агуулахын тэнд цасан чөтгөр босгоод, мөнгөн ус хөлдчихөөр түүнийхээ янзыг үзэж, нүүр амаа хачин янз хувиргадаг болжээ. Мэдээж энэ бүхэн тоглоом л доо.

Тэрбээр дахин дахин өөртөө итгүүлэхийг оролдовч тэр мэт ухаангүй солиорол нь өөрөө өөрийнхөө омнө хуурамч аяглах, тоглоом наадмаар илэрч байгааг үл мэднэ.

Нэг удаа өвлийн дундуур иезуитийн шашин номлогч, гэгээн эцэг Шампро

Хорьдугаар бээрээр дайраад
өнгөрөв. Боннер түүн рүү ухасхийж.
худалдааныхаа суурин руу чирч
авчраад, тэвэрч эхэр татан уйлсан
бөгөөд санваартан өрөвдсөндөө
тэсэлгүй бас уйлж орхижээ. Дараа нь
ухаан мадаггүй баярлаж, гийчнийг
хааш нь ч явуулахгүй хэмээн андгай
тангараг тавьж, элбэг дэлбэг найр
хийсэн ч, гэгээн эцэг Шампро өөрийн
сүмийн хойшлуулашгүй ажлаар
Давст Ус руу яаруу бачуу яваа гэсээр,
миний цус сахил санваарт толгой
дээр чинь асгарна шүү гэсэн
Боннерын занал зүхлийн үгээр
үдүүлэн маргааш өглөө нь замаа
хөөжээ.

Мөнөөхөн занал зүхлээ хариугүй
хэрэгжүүлдэгийн даваан дээр, амиа
хорлохдоо тулаад байтал ашгүй
тойатууд урт гөрөөнийхөө эцэст
өвлийнхөө бууцанд эгэн ирвээ. Үнэт
үс ч гэж тоо томшгүй, хорьдугаар
бээрт арилжаа наймаа буцалж, Жис-
Ук сувс, хурц өнгөт бөс авахаар орж
гарч, Боннер алгуур аажуу
өөрийнхөө хүн төрхөд орж эхлэв.
Долоо хоногийн турш мань эр амь
тэмцжээ. Дараа нь нэг үдэш Жис-Ук
явахаар бостол, яагаад ч юм хамаг
юм сая төгсөв. Яаж түүнийг
түлхсэнийг бүсгүй хараахан
мартаагүй, тэгээд ч сэтгэлд нь
Умард-Өмнөдийн хуурай замын

гарцыг нээхээр давхисан Спайк
О'Брайены агуу омогшил, бахархая
оргилж байгаа юм чинь.

-Би явлаа. Сайхан нойрсоорой, Нийл
гэж бүсгүй дуугарчээ. Тэр хаалганы
тэнд бүсгүйг гүйцэж очлоо. -Битгий
яв л даа гэж тэр хэлэв.

Юу юугүй гэрэлтээд ирсэн царайгаа
бүсгүй түүн рүү харуулангуут мань эр
ариун үйлийг бүтээж буй лугаа адил
сүрлэг, алгуурхан тонгойж, уруул
дээр нь озоотохжээ. Тойатууд уруул
дээр үнсэхийн учир начрыг мэдэхгүй
ч хүүхэн нэгийг ухаарч, жигтэйхэн
баярлажээ.

Жис-Укыг нүүж ирэнгүүт түүний амьдрал гийгээд явчихав. Жис-Ук ч дээдсийн жаргалд умбаж, мань хүн ч бүсгүйтэй жаргалаа эдэлж байлаа. Түүний эгэл ухаан бодол, түүний гэнэн сээтэгнүүр ааль соёл иргэншилд залхаж, өршөөл энэрэлийг ханатлаа хүртсэн хүний сэтгэлийг гайхуулан бишрүүлж авай. Бүсгүй орь ганцаардлынх нь жирийн нэгтайлал, тайтгарал бус, түүний шулуун шударга зан сэтгэлийг нь донсолгон шинэчлэв. Ужид төөрөгдлийн эцэст тэр байгаль эхийн өмнө өвдөг сөхрөн, тэргүүн гудайлгаж байгаа мэт санагдахыг яана. Товчхон хэлвээс Жис-Укаар тэр

замбутивийн идэр ахуй, онгон залуу нас, оргилсон хүч, баяр баясгаланг төсөөлдөг болов.

Тэгтэл Нийлийн амьдралын сүүлчийн зайг дүүргэхээр, басхүү Жис-Ук тэр хоёр бие биеэсээ бүү уйдаг гэсэн шиг, хоноцын түүдгийн дэргэд бол дуу аяланхан, нохдынхоо араас бол исгэрэнхэн гүйж явдаг, хэзээний хаанахын хэнээс ч илүү найзархуу, нийтэч Сэнди Макферсон гэгч Хорьдугаар бээрт хүрч ирлээ. Юконы эхээд хоёр зуугаад бээрийн тэртээд, бүр тэгэхээс тэгэх гэсэн аятай найзынх нь цогцосны тэргүүн дээр сэтгэлийг нь ариусгах маань хэлэхээр хэн ч билээ нэгэн ламбугай

яг таарч иржээ. Ламбугай явахынхаа
өмнө,

-Хүү минь, чи өдгөө орь ганцаардалд
унав уу гэсэнсэн.

Сэнди ч гаслантайяа толгой дохижээ.

-Хорьдугаар бээрт ганцаардсан
хүний үр бий. Та нар бие биедээ
хэрэгтэй, хүү минь гэж санваартан
нэмж хэлсэн буй заа.

Тийнхүү Сэнди худалдааны
суурингийн гурав дахь хүслэнт хүн нь
болж, тэнд амьдрагч эр, эм хоёрын
ах нь болов. Тэрбээр чоно, хандгай
агнахыг Боннерт зааж, хариуд нь

Боннер салбарч гүйцсэн, хичнээн уншсан юм бүү мэд, нэг боть олж өгтөл, Шекспирт сэтгэл нь алдарсан Сэнди тун удалгүй зөрүүдлэсэн ноход руугаа шүлэглэсэн яруу үгс урсгадаг болж, урт үдэш эрчүүл криббедж тоглож, замбутивийн тухай маргалдаж байх зуурт Жис-Ук буйдан сандалд тухлан шигдээд, тэдний оймсыг цойлдож, бугын арьсан бойтогийг янзалж суудаг болжээ.

Төдөлгүй хавар ирлээ. Өмнө зүгээс наран эргэж ирэв. Ертөнц Даяанчийнхаа жанчийг охидын хөнгөн нимгэн гоёлоор солилоо. Энд тэндгүй гэрэл гэгээ гийж, амьдрал

буцална.

Илч дулаан ивээсэн өдөр улам урт болсоор, харин шөнө бүр алга болон болтлоо богинослоо. Гол мөсөн хуягаа шилгээж, хөлөг онгоцны түжигнээн аглаг аниргүйг цочоон, шуугиж, хөл үймээн, шинэ зүс царай, шинэ сонин хөвөрсөөр, Хорьдугаар бээрт шинэ туслах ирж, Сэнди Макферсон алтны хайгуулчдын бүлэгтэй Коюкук голын хөндийг судлахаар одов. Харин Нийл Боннер сонин, сэтгүүл, захидал хүлээн авч, омгийнхон нь далайн чанадаас түүнтэй ярьж байгаа нь энэ хэмээн ойлгож мэдсэн Жис-Ук харин түүнийг дотроо баахан түгшүүртэй

ажсаар байлаа. Эцгийнх нь үхлийн тухай мэдээ Нийлийг тэгтлээ донсолгосонгүй Насан эцэслэж буй хүний хэлж өгч бичүүлсэн дотно үгтэй өршөөлийн захидал бас худалдааныхаа сууринг туслагчдаа шилжүүлээд хэзээ хүсэмжилсэн цагтаа Умардаас ирж болохыг Боннерт зөвшөөрсөн ялдамхан үгс бүхий компанийн албан захидлыг шуудан түүнд авчирч, мөн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн илгээсэн хууль эрхзүйн урт баримт бичиг эцгийнх нь гэрээсэлснээр Боннерт шилжиж буй хувьцаа, үнэт цаас, эзэмшил газар, бас бус хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн эцэс төгсгөлгүй

жагсаалтыг багтаасан байлаа.

Угалзалсан үсэг бүхий чамин цаасан дээр хонгор Нийлийг тайтгаршгүй хайрт эхдээ яаран ирэхийг мөргөн гуйсан гуйлт ч байв.

Нийл Боннер юмыг хурдан шийдэхдээ хэзээний сурмаг. "Юконы гоо бүсгүй" хөлөг Берингийн тэнгисийг зорин хөдлөхөөр эргийн тэрүүхэнд нүргэлэн байх зуурт замд гарсан бөгөөд даруй эргэж ирэх тухай өнө эртний худал үг түүний амнаас цоглог, чин үнэнч гэмээр цангинажээ.

-Би цас унахаас өмнө эргэж ирнэ.

Жис-Ук, хонгор минь! гэж тэр сүүлчийн үнсэлтийнхээ завсарт тавцан дээр ам алдсансан.

Тэр зөвхөн амласан төдийгүй тийм явдал тохиолдсон олонхи эрчүүлийн адил хэлсэн бүхэндээ нот итгэж байв. Тэрбээр бас шишээ төлөөний хүн Жон Томпсонд эхнэр Жис-Уктаа хязгаарлалтгүй зээлийн данс нээж өгөхийг тушаажээ. "Юконы гоо бүсгүйн" тавцангаас сүүлчийн удаа эргэж харахдаа энэ голдоо хамгийн тохилог байшинг, Жис-Укын, бас түүний, Нийл Боннерынх ч болох, анхны цасны өмнө босох тэр байшинг барихад хэрэглэх дүнзийг араг гаруй ажилчин яажшуухан зөөж

буйг харжээ. Мань хүн үнэхээр Умардад эргэж ирнэ гэж бодсон бөгөөд Жис-Ук түүнд эрхэм бас Умардад алтан ирээдүй түүнийг хүлээж буй болохоор, эцгээсээ өвлөсөн мөнгөө чухам тэр ирээдүйн хөрөнгө оруулалтад хэрэглэнэ хэмээн санажээ. Дөрвөн жилийн туршлагд компанийн нөхөрсөг дэмжлэгийн хүчээр Аляскийн Сесил Родс болно гэсэн алдар хүндийн гайхам мөрөөдөл түүнийг эзэмдэнхэн, бараг мэдэхгүй эцгийнхээ ажил хэргийг цэгцэлж, мартаж орхисон эхийгээ тайвшруулаад даруй эргэж ирнэ гэж бодсонсон.

Нийлийн Умардаас эргэж ирсэн нь
их шуугиан тарьлаа. Голомтынх нь
гал дүрэлзэн асч, тарган цатгалан улс
хатгуулсан мэт босон харайцгааж,
энэ бүхэн ямар сайхан зүйл болохыг
тэр мэдэрч, олж харав, Тэр борлож,
эр бие тэгширсэн төдийгүй, даруу
төлөв, буурь суурьтай, хэрсүү огт өөр
нэгэн болчихоод иржээ. Дээхэн
цагийнхаа болчимгүй зугаанд
оролцохоос дургүйцэж, лонхны
хуучин андуудаа мэл гайхуулснаар
барахгүй эцгийнх нь эртний анд,
өдгөө хөнгөмсөг залуусыг залж
засдаг талаараа хүлээн
зөвшөөрөгдөж, алдар хүндийн
дээдэд хүрсэн тэр эрхэм л харин

баясгалантайгаар алгаа үрчин байлаа.

Дөрвөн жилийн хугацаанд Нийл Боннерын ухаан санаа шинэ сэтгэгдлээр бараг баяжаагүй ч, нүгэлт, өнгөн хийсвэр бүхнээс ариусах өвөрмөц янзын шалгарлын үйл явц болжээ. Боннер идэр залуудаа эргэх хургах юмгүй амьдарсаар, дараа нь харин чих хулга газар очингуут хураасан туршлагынхаа эх адаггүй байдлыг эмхлэх цаг түүнд олдсон аж. Түүний урьдын хөнгөн хуумгай байдал салхинд туугдан замхарч, оронд нь шинэ, бүр гүн гүнзгий, ул суурьтай үзэл бодол буй болж, тэр соёл

иргэншлийг цоо шинээр үнэлж,
газрын үнэрийг мэддэг болж,
амьдралыг эгэл бүхнээр нь харж, энэ
нь соёл иргэншлийн дотоод мөи
чанарыг ойлгоход түүнд тусалсан
төдийгүй сул хийгээд хүчтэй талыг нь
өөрт нь мэдрүүлжээ. Мань эрийн
шинэ гүн ухаан эв энгийн агаад
шударга амьдрал аврал руу хөтөлнө,
биелүүлсэн үүрэг чинь амьдралыг
чинь цагаатгана, хөдөлмөрлөхийн
тулд хүн шардарга амьдарч,
өөрийнхөө үүргийг биелүүлэх ёстой,
хөдөлмөрт л цагаатгал
оршдог, хөдөлмөрлөсөөр амьдралаа
улам улам элбэг дэлбэг болгох нь
байгалийн гэрээслэл, бурханы хүсэл

зоригийг биелүүлж байгаа хэрэг гэдгийг ойлгожээ.

Нийл хотын хөвүүн байжээ. Түүний үзэж мэдэрсэн газар дэлхийд ойр ахуй нь хүний дүр төрхийн шинэ сэргэг, зориг төгөлдөр ойлголт, соёл иргэншлийг улам илүү таньж хайрлан дурлах боломж түүнд олгожээ. Хотын хүмүүс түүнд өдрөөс өдөрт улам үнэ хүндтэй, чухал хэрэгтэй болсоор, ертөнц улам уужим болсоор авай. Өдрөөс өдөрт Аляск алсран холдож, бодит бус болов. Тэр өөрийн хүрээний, зүс нэгтэй, Юконд анхны цас малгайлдаг тэр өдөр, цаг, жилийг умарттал зүрхийг нь эзэмдсэн Китти Шаронтай

нэг л өдөр нүүр учраа.

Жис-Ук гайхалтай сайхан шинэ байшиндаа нүүн орж, алтан зуны гурван сарыг мөрөөдлөөрөө үдлээ. Тэгтэл ахархан намар айсуй өвлийг бүрээдэн дуудаж, агаарт хүйтэн жавар тас нясхийгээд, өдөр богино, улам хүйтэн болж, голын үрсгал аажуурч, дөлгөөн газраа зайр гүйгээд, нүүж чадах бүхэн өмнө этгээд рүү одож, эл хуль ахуй газар дэлхийд эргэн буув аа. Анхны цасан ширхэг эргэлдэхийн цагт сүүлчийн хөлөг онгоц мөсөн зайр дундуур бачимдан зүтгэсээр одохуйд дараахан нь жинхэнэ мөс, мөсөн овоо уулс, мөсөн тал цэлийгээд,

Юкон эргээ дүүрэн жирэлзэн байтал,
гэнэт хамаг бүхэн амьсгаа хураах
мэт голын урсгал зогсож, өдрийн
гялбаа түнэр харанхуй дунд бөхөв.

Шинэ төлөөлөгч Жон Томпсон
шоолж байсан ч, Жис-Ук замын
тотгорт итгэсээр, Нийл Боннер
Чилкутын хавцал, Сент Майклын
хооронд хаа нэгтээ мөсөнд
боогдчихсон байж магад,
хожимдсон аянчид мөсөнд хэзээний
хаагдчихдаг, тэгээд завиа чаргаар
сольж, ноход хөлөглөн урагш
зүтгэдэг гэж бодсоор.

Гэтэл Хорьдугаар бээрт ганц ч
хөтөлгөөт чарга давхиж ирсэнгүй.

Жон Томпсон баярласнаа
олигтойхон нууж чадалгүй, Боннер
хэзээ ч эгэж ирэхгүй хэмээн Жис-Укт
хэлээд, ичиж зовсон шинжгүй,
бүдүүлэг гэгч нь өөртэйгээ
ханилагтун гэжээ. Жис-Ук нүүр рүү
нь инээчихээд, шинэ байшин руугаа
буцав. Харин ид өвлийн хүйтнээр
амьдрал амьсгаа хураан, горь тасрах
тэр өдрүүдэд түүний зээл дууссаныг
Жис-Ук мэдэв. Жис-Укын байшин руу
хялам хяламхийсээр гараа үрчин,
өрөөндөө урагш хойш холхих
Томпсон ийм хэрэг хийчихээд анан
хүлээж байжээ. Гэтэл тэр удаан
хүлээх болж. Жис-Ук өөрийнхөө
нохдыг алтны хайгуулчдад

худалдаад, идэш уушныхаа төлөө
бэлэн мөнгө төлж эхэлтэл, Томпсон
түүнээс мөнгө авахаа хүртэл больж,
тойат улаан арьстанууд түүний
хэрэгтэй бүхнийг худалдан авч, шөнө
дөлөөр хүүхний гэрт сэм
хүргэж өгдөг болов.

Хоёрдугаар сард мөсөн дээгүүр
өвлийн анхны шуудан ирэхэд Жон
Томпсон сонины язгууртны
мэдээний хэсгээс Нийл Боннер,
Китти Шарон нарын хуримын тухай
таван сарын тэртээх мэдээг олоод
уншчихжээ. Жис-Ук хаалгаа
онгойлгосон ч Томпсоныг
оруулсангүй, тэр өөрт нь хэлэхээр
ирсэн үгийг сонсоод, бардам аргагүй

инээмсэглээд огт итгэсэнгүй.
Гуравдугаар сард хүүхэн орьганцаараа байхдаа нярайлж, хүүтэй болов. Шинэ амьдралынх нь энэ бяцхан гэрэл гэгээ Жис-Укыг гайхал, бишрэлээр бялхаажээ. Гэтэл жилийн хойно яг энэ цагт Нийл Боннер өөр нэг орны дэргэд суугаад, газарт мандсан амьдралын өөр нэгэн гэрэл гэгээг шагшран байжээ.

Газар цасаа шилгээж, Юкон мөсөн баринтагаа тайлав. Өдөр уртассаар, дараа нь дахиад богиносов.

Нохдоороо олсон мөнгө нь барагдаж Жис-Ук омогтоо буцаж очтол, хийморьлог гөрөөч Оч-Иш өөртэйгээ дэр нэгтгэвээс түүнд,

хүүхдэд нь загас гохдож, ан унагаж
өгч байя хэмээн өгүүлэв. Зоригт,
идэр гөрөөч Имего, Ха-Йо, Уи-Нуч
нар бас тийнхүү гуйжээ. Гэвч Жис-Ук
ганцаар амьдрахаа илүүд үзэж, загас
анг өөрөө өөртөө унагасаар, туг
үсээр чимж, сувс оёсон гоёмсог, бөх,
дулаахан бээлий, дээл, бойтог оёж,
улс оронд жил ирэх тусам улам олон
болсоор буй алтны хайгуулчдад
овоо мөнгөөр худалдаж байлаа.
Тийм байдлаар Жис-Ук өөрийгөө,
хүүгээ тэжээж чадсанаар барахгүй
мөнгөө хураасаар, нэг л өдөр
"Юконы гоо бүсгүй" түүнийг гол
уруудуулан авч одвой.

Сент-Майклд тэр худалдааны

суурингийн гал тогоонд аяга таваг угааж явсансан. Хөөрхөн хүүхэдтэй, энэ сайхан хүүхэн хэн бэ хэмээн компанийн албан хаагчид гайхаад учраа олохгүй байсан ч, тэд гау ч асууж шалгаасангүй. Хүүхэн ч таг чиг.

Харин Берингийн тэнгисийн усан замын хөдөлгөөн хаагдахын өмнөхөн Жис-Ук Сент- Майклд санамсаргүй тэнүүчилж ирсэн далайн муурын ангуучдын хөлөг онгоцонд суугаад өмнө зүгт зорчлоо. Өвөл нь тэр ахмад Маркхеймын гэрт тогоочоор ажиллачихаад, харин /авар нь виски пиг аччихсан завинд суун өмнө этгээдэд, бүр цаашлан Ситху хүрэв. Хожим нь тэр

Пенхендлийн өмнөд хэсэгт буй
ариун Марийгаас холгүй
Метлакатлед үзэгдэж, хулд загасны
их гөрөөний цагаар нөөшний
үйлдвэрт ажиллаж байлаа. Намар
болж улаан арьст сиваш загасчид
Пюджетийн хоолойн зүг орон
гэрээдээ тэмцэхэд өөр хоёр ч айл
байрлачихсан байсан томоо хушин
завинд Жис-Ук хүүгийнхээ хамт
төвхнөөд, тэдэнтэй Аляск, Канадын
эрэг хавийн арлуудын зүдгүүр
зовлонт урт замыг нэвт туулж,
эцсийн эцэст Хуан-де-Фукын хоолойг
ардаа орхиод, нэг мэдэхнээ Сиэтл
хотын чулуу дэвссэн гудмаар
хөвүүнээ хөтөлж явжээ.

Салхи исгэрсэн тэндхийн
уулзваруудын нэгэн дээр хүүхэн
гэнэт Сенди Макферсонтой
тааралдчихжээ. Мань эр туйлгүй
гайхширч, түүний өгүүлснийг
сонссоныхоо дараа бүр бачуурч
хилэgnэсэн агаад хэрэв Китти Шарон
гэгч байдаг тухай мэдсэнсэн бол бүр
уурлах байсан биз. Гэтэл 'Кис-Ук
түүний тухай ганц үг ганхийгээгүй,
тэр анхнаасаа ер итгээгүй билээ.
Хүүхнийг зүгээр хөсөр хаячихаж гэж
санасан Сенди, Нийл Боннерын
өргөө буй Сан- Франциско орох
аянаасаа татгалзагтун хэмээн
түүнийг ятгах гэж оролдоод
барсангүй, харин ажил төрлийг нь

өөртөө авч, тасалбар авч өгч, уурын
галт тэргэнд суулгаад салах ёс
гүйцэтгэж хүүхэн рүү инээж байхдаа,
сахал дотроо "Ямар бузар явдал вэ"
хэмээн бувтнаж байсансан.

Түчигнээн, хангир жингэр дунд,
өдөржин шөнөжин, үүрийн гэгээнээс
өглөөн гялаан хүртэл, нэг бол өвлийн
цасан дундуур дүүлж, эс бөгөөс
цэцэгт хөндийгөөр шунган, нүх гууг
тойрч, уулсыг хага яран Жис-Ук ,
түүний хөвүүн Өмнөд этгээд рүү
довтолгосон агаад Жис-Ук ган
хүлгээс зүрхшээсэнгүй, Нийл
Боннерын омог нэгтний хүчирхэг
соёл иргэншил түүнийг
дөжрүүлсэнгүй, гагцхүү бурханы

гэмээр энэ омгийн хүн түүнийг
өөрийнхөө элгэнд тэвэрч байсан нь
ямар ид шид вэ гэдгийг улам тов
тодорхой, гайхан мэдэрсээр авай.

Хөлөг онгоцны эх адаггүй
бужигнаан, фабрикын хар утаа,
гудамны нүргээн, Сан-
Францискогийн шуугиант хөл үймээн
ч түүнийг эгдүүцүүлсэнгүй, зөвхөн
Хорьдугаар бээр, бугын арьсан
овоохойт тойатуудын суурин ямар
өрөвдөм өчүүхэн тойром байсныг
сая ойлгосон буй заа. Басхүү эцэг нь
ийм хүн байж хэмээн гайхан
гайхсаар, гараас нь зуурсан хөвүүн
рүүгээ байн байн харсаар явав.

Түүнээс тав дахин их хөлс нэхсэн хөтчид мөнгийг нь төлчихөөд. Жис-Ук Нийл Боннерын ёслолын сүрлэг хаалга өөд чулуун шатаар өгслөө. Баахан үр дүнгүй хөөрөлдөөний эцэст долир япон түүнийг өргөөнд оруулсан агаад тэгснээ алга болчихов. Тэр эгэлхэн, зүрх сэтгэлдээ гийчинд зориулсан өрөө юм хэмээн санасан хөлийн танхимд, эзэн нь хамаг эд баяпагаа бардам гэгч дэлгэн үзүүлэхээр тавьсан тэр газар. хана, таазыг нь гялалзтал өнгөлсөн улаан модоор чимэглэсэн хөлийн өрөөнд хөвгүүнтэйгээ хоцров. Шал нь өө сэвгүй мөс лугаа адил тэв тэгш, гялгар болохоор Жис-Ук хальтирах

вий гэж айсандаа тэнд дэвсээстэй
нэгэн амьтны үнэт арьсан дээр гарч
зогслоо. Холын нэг мухэрт асар том
ханын ил пийшин онгойж харлах
агаад "Хэдий хэрийн түлш залгидаг
бол гэж тэр бодож байлаа. Өнгөт
шилнээ арай буурч зөөлөрсөн хурц
гэгээ өрөөг тэр чигт нь сүлж, өрөөний
гүнд гантиг баримал гөлчигнөн
гялалзанз. Гэтэл долир зарц эргэн
ирж, олигтойхон ч харж амжаагүй
өөр нэгэи өрөө рүү, бас гурав дахь
руу нь түүнийг дагуулж орохул,
урьдахаас ер бишийг үзэв. Тэр
өрөөнүүдийн дэргэд хөлийн өрөөний
гялбам ахуй сааралтаад явчихжээ.
Аварга тэр байшинд иймэрхүү

өрөөнүүд дуусахгүй мэт санагдаж,
тэр нь ямар уужим ямар өндөр юм
бэ. Цагаан хүмүүсийн соёл
иргэншлийн өмнө сүрдэм бишрэм
айдас анх удаа түүнийг эзэмджээ.
Нийл, түүний Нийл энэ байшинд
амьдарч, энэ агаараар амьсгалж,
шөнө энд нойрсож байсан. Түүний
үзсэн бүхэн өнгөлөг сайхан.
нүдэнддулаахан боловч тэр бүхний
ард мэргэн ухаан, сүр хүчин нуугдаж
буйг мэдэрч, сүр хүчин энд өөрийн
илэрхийллийг агуу гоо сайхнаар
олсныг, түүний хүч зоригийг хүүхэн
дороо, эндүүрэл үгүй таамаглаж
авай.

Тэгтэл өндөр, хийморь төгөлдөр,

наран мэт туяарах үсэн титмээр
зүсээ чимсэн хүүхэн өрөөнд ороод
ирэв. Түүний хөдөлгөөн уян
налархай, дашинз нь дуу аялгуу
гаргах мэт намирсаар, дөлгөөн усан
дээгүүр яруу хөгжим дуурсах мэт
Жис-Укын өөдөөс тэр айсуй. Жис-Ук
өөрөө зүрх сэт- гэлийг булаагч
төдийгүй тэр л эрх хүчийг нь
мэдэрсэн Нийл Боннер, Жон
Томпсон, өөр ч цагаан арьстануудыг
эс тооцон, Оч-Иш, Името, Ха-Йо, Уи-
Нуч нарыг дурсахнаа хангалттай
бүлгээ. Гэтэл тосоод ирж буй
хүүхний том цэнхэр нүд,
булбарайхан цагаан арьсыг харж, эр
хүн яаж цэгнэдэг билээ түүн шиг

бүсгүйг сонжоод, туяарсан энэ л гоо үзэсгэлэн-гийн өмнө өчүүхэн шалыүй, жижигхэн болж буйгаа эрхгүй мэдэрчээ.

-Та миний нөхөртэй уулзахыг хүсээ юү гэж хүүхнийг асуухад Жис-Ук мөнгөн хонх жингэнэх лугаа адил түүний хоолойн сайханд сэтгэл нь түгшээд явчихав. Энэ хүүхэн хээрийн боохой аятай архиралдах ноход руу хашгирдаггүй, төвөнхний авиат үгэнд хоолой нь дасчихаагүй, жавар салхи, хээрийн буудлын түүдгийн утаанд дуу нь эвдрээгүй аж.

-Үгүй гэж өөрийнхөө англи хэлний мэдлэгийг үзүүлэх санаатай үгээ

хичээнгүй гэгч сонгон аажуухан
хариу өчсөнөө,

-Би Нийл Боннертой уулзах гэсэн юм
гэлээ.

-Тэр миний нөхөр гэж хүүхэн
мишээн өгүүлвэй.

Даанч дээ, тэр бүхэн үнэн байж!
Хоёрдугаар сарын тэр бүгээн бараан
өдөр нүүр рүү нь бардам мишээгээд,
хаалгаа тасхийтэл хааж байхад Жон
Томпсон худал хэлээгүй байж.
Хэзээ билээ дээ. Амос Пентлиг өөр
рүүгээ, өвдөг дээрээ гуд татан,
дээрээс нь мэс далайхад хүргэсэн
тэр гашуун хорсголот уур хилэн нь

өдгөө энэ хүүхэн рүү шунган дайрч,
хөсөр унагаад, гоо сайхан биеэс
амьдралыг нь өм цөм татаад орхи
хэмээн тэвчишгүй оволзоод ирсэн ч,
Жис-Укын толгойд бодол хүсэл нь
догшин шуурга шиг харанхуйлаад
ирсэн ч, тэр өөрийгөө илчилсэнгүй,
Китти Боннер энэ мөчид үхэлд ямар
ойрхон байснаа даанч мэдсэнгүй.

Жис-Ук ойлгосны тэмдэг болгож
толгой дохитол Китти Боннер, Нийл
хэдхэн мөчийн дараа ирэх ёстой гэж
хэлэв. Дараа нь тэд тухлагаараа
хачин соньхон буйдан сандалд сууж,
Китти гайхалтай гийчнээ яриа
хөөрөөгөөр сатааруулахаар шамдаж,
Жис-Ук түүнд чадах ядахаараа

хамжилцав.

-Та миний нөхөртэй Умардад уулзаж байсан уу гэж Китти үгийн далимд сонирхов.

-Тийм ээ, би түүний юмыг угааж байсан гэж Жис-Ук өчив. Түүний англи хэл мэдэгдэхүйц муудаж эхэллээ.

-Энэ таны хүү юу? Харин би охинтой гээд Китти охиныхоо араас хүн явуулж, жаалууд танилцаж байх хооронд ээжүүд ээж нарынхаа яриаг дэлгэж, цай ууж, шаазан нь нимгэхэн гэж жигтэйхэн, Жис-Ук аягаа хага атгачих вий гэж айсан

бөгөөд тэрбээр анх удаа ийм гоёмсог, хэврэг аяга үзжээ. Цай аягалж буй хүүхнийг дотроо аягатайгаа харьцуулж, тэрхэн зуурт өөрийн мэдэлгүй тойатуудын төмөр, модон дашмаг, Хорьдугаар бээрийн бүдүүн хадуун шавар аягыг санасан бөгөөд түүнийг өөртэйгээ дүйцүүлж боджээ. Нийлийн сонголт Жис-Укт иймэрхүү байдлаар дүрслэгдэв. Тэр өөрийнхөө ялагдлыг гашуухан хүлээн зөвшөөрч байлаа. Нийлийн хүүхдүүдийн эх болохноо илүү нийцтэй, өөр хүүхэн олдож, аргагүй дээ тэдний омог овог өөрийнхөөс нь хүчирхэг, эмс нь түүнээс хавьгүй илүү юм чинь.

Тэдний эрчүүл ертөнцийг эрхшээж буйтай адил хүүхнүүд нь эрчүүлийн сэтгэлийг булаана. Жис-Ук Китти Боннерын булбарай ягаахан хацрыг харснаа наранд түлэгдсэн өөрийнхийгөө санавай. Дараа нь тэр бараан өнгөт гараасаа цав цагаахан гар руу нь харц гүйлгэв. Нэгнийх нь шилбүүрийн саваа, сэлүүртэй ноцолдсоор эвэр, шалбархай, зулархайгаар дүүрэн байхул нөгөөгийнх нь нялх хүүхдийн гар шиг булбарай, анхилхан, Ямартай ч энэ хүүхний гаднах өнгө нь хэврэг, зөөлөн налархай боловч цэнхэр нүднээс нь Нийл Боннер, Нийл Боннерын омгийнхны нүднээс

тодордог тэр мохошгүй их хүчийг
Жис-Ук олж үзэв.

-Энэ чинь Жис-Ук байна шүү дээ
хэмээн, гаднаас орж ирсэн Нийл
Боннер хэлэв. Тэрбээр энэ үгийг
бүсгүйн хоёр гарыг атган, тайван,
зүрхний чанадаас гэмээр хэлсэн
хэдий ч, харцнаас нь түгшүүр олж
үзээд улаан арьст хүүхэн бүхнийг
ойлгожээ.

-Сайн байна уу, Нийл! Яажшуухан
амьдарч байна даа гэж хүүхэн хариу
хэллээ.

Мань эр тэдний хооронд юу болсныг
мэдчих санаатай Китти рүү нууцхан

хяламхийснээ,

-Сайн, сайн, Жис-Ук хэмээн хөгжилтэй хариулав. Гэвч тэр эхнэрээ андахгүй. Бүр адгийн муу юм болоод өнгөрсөн ч түүний царайнаас юу ч уншиж чадахгүйгээ мэдэх билээ.

-Би чамайг харж байгаадаа үнэхээр баярлаж байна. Юу болсон бэ? Чи алтны судлаа олсон уу? Ингэхэд чи хэзээ ирэв гэж тэр цааш өгүүлэв.

-О-о-а, би өнөөдөр ирлээ -хэмээн төвөнхийн авиаг өөрөө ч мэдэлгүй өргөн тодруулсаар тэр хариулаад: - Би Нийлийг олдоггүй ээ. Ахмад

Маркхеймыг мэднэ шүү дээ, би тэдний байшинг зендөө янээлсан. Мөнгө хураана, ийм их. Би шийдсэн, цагаан хүмүүсийн нутгийг сайн харах. Цагаан улсын газар их сайхан! Ихээ сайхан гэж тэр хэлэв.

Түүний яриа хөөрөө Нийлийг мэл гайхуулав. Тэр Сэндитэй хоёул түүнд англи хэл хичээнгүйлэн зааж, хүүхэн сайн сурагч гэдгээ харуулсансан. Гэтэл өдгөө нутгийнхан шигээ ярьж байна, түүний царай юу, цайлган, гэнэхэн, уцааргүй царайгаар нь юу ч тааварлах аргагүй, эхнэрийнх нь амар амгалан байдал ч Боннерын толгойг эргүүлж орхив. Чухам юу болов? Юу ярилцсан бол? Үгийн

солиогүй юу ойлгож мэдэлцсэн юм бол?

Энэ асуултын учрыг олох санаатай оролдож байх зуурт Жис-Ук сонголтоо эцэслэх санаатай тарчилж, (энэ эр хэзээ ч ийм сайхан, дур булаам харагдаж байгаагүйсэн) бусад нь цөм дуугаа хураажээ.

-Бодоод үз дээ, та миний нөхөртэй Аляскт уулзаж байсан гэж Китти Боннер аяархан хэлэв.

-Уулзаж байсан! гээд түүнд төрүүлж егсөн хүү рүүгээ илгээсэн харцаа Жис-Ук даанч нууж хүчирсэнгүй. Нийл өөрийн эрхгүй түүний харсан

зүгт, цонхны дэргэд наадаж буй
хүүхдүүд рүү нүд өргөхүйеэ, төмөр
цагираг толгойг нь тас хавчаад авах
мэт дотор нь манасхийж, зүрх нь
аюулхайн цаанаас алх цохих мэт
лугхийгээд явчихав. Хүү! Түүний
зүүдэнд ч ороогүйсэн.

Хөнгөхөн даашинзтай буйг нь
харахул үлгэрийн гүнж мэт, ягаахан
хацарт, цэнхэр нүдэн балчирхан
Китти Боннер хөвүүнийг үнсэх
санаатай аальгүй янзтай хошуу
цорвойлгох боловч амьтны саварт
хөл, хатгамал хээ угалзаар чимсэн,
басхүү аян замд мэдэгдэм элэгдсэн
ангийн үсэн хувцастай туранхай, уян
налархай, салхинд долоолгож,

наранд борлосон царайтай жаалхүү
түүний хамаг арга мэхийг барж, ер
үл тоомсорлох аж. зэрлэг хүний
хүүхдүүд яаж биеэ барьдаг билээ
түүн шиг хөвүүн-биеэ эгцлэн, байж
ядсан янзтай зогсоно.

Харийн хүн харь оронд байгаа
хойно тэр уурласан ч үгүй, айсан ч
үгүй, харин чимээ аниргүй,
болгоомжилсон араатны зулзагыг
санагдуулах авай. Хархан нүд нь
бүхний царайг гүйлгэн харж,
одоохондоо хамаг юм тайван, тэр
өөрөө ч амгалан байнз харин аюул
заналын өчүүхэн сэжиг мэдэгдвээс
тэр харайн босч, амьдралынхаа
төлөө хазаж самардан туйлдатлаа

тэмцэлдэх нь эрхгүй мэдэгдэнэ.

Хүүхдүүд хоорондоо дэндүү ялгаатай ч, хөөрхийлүүлэх юм хүүд байсангүй, Шпак, О'Брайен, Боннерын үр ачийн биед хязгааргүй сүр хүчин оволзож байлаа. Бараг л сонгодог гэмээр эршүүд дүр төрх, царайных нь чанад Тэнгисийн хүмүүст олзлогдож, Камчатка руу босч явсан бүдүүн хочит шантаршгүй Шпак, өвөө, эцгийнх нь эрэмгий зориг. шавхагдашгүй хүч тэнхээ нуугдаж байлаа.

Нийл Боннер өөрийнхөө мэдрэхүйг нухчин дарахыг хичээж, ухаан бодлоо боомилон байж хуучин

нөхэдтэйгээ уулзсан юм аятай
хэнэггүй царайлан найрсгаар
мишээнэ.

-Чиний хүү юү, Жис-Ук гэснээ тэр
Киттид хандан, -Сайхан хүү байна.
Том болохоороо мундаг хүн болно
гэдэгт итгэлтэй байна хэмээн нэмж
хэлэв.

Китти толгой дохилоо.

-Чамайг хэн гэдэг вэ гэж тэр
сониучирхав.

Бяцхан зэрлэг хүү яагаад түүнээс энэ
тухай асууж буйг ойлгох санаатай
хүүхнийг сонирхон харав.

- Нийл гэж тэр харсныхаа үр дүнд сэтгэл ханасан янзтай яаралгүй хариулав.

-Улаан арьстаны яриа хэмээн тэр даруй шинэ хэл бодож олсон Жис-Ук хажуунаас нь оролцож, -Тэр улаан арьстан "ни-эл" гэж ярина, "хатаасан талх" гэсэн үг. Бага байсан, хатаасан талханд дуртай, хатаасан талх нэхнэ, үргэлж "ни-эл", "ни-эл" гэж ярина. Харин би түүнд өөрийн нь нэр ийм гэж хэлнэ. Тэгээд Ниэл гэж дууддаг болсон хэмээн ярив.

Жис-Укын энэ худал үг Нийл Боннерын чихэнд ид шидэт хөгжим мэт дуурсчээ. Киттигийн амгалан

байгаа нь ийм учиртай юмсанж.

-Түүний эцэг нь? Мэдээж сайхан л хүн байх даа гэж Китти асуужээ.

-О-о-о-а, тийм шүү. Түүний эцэг сайхан хүн гэсэн хариу дуулдав.

-Чи тэрнийг мэдэх үү, Нийл гэж Китти сонирхов.

-Мэднээ. Их ойр дотно явсан хэмээн Нийл өчив.

Тэгтэл таг чиг дүнсгэр Хорьдугаар бээр, нам гүмд өөрийн бодолтойгоо хоёулахнаа үлдсэн нэгэн эр түүний нүдний өмнө тодроод, аньсага нь

чийг татаад ирэв.

Жис-Укын түүхийг энд ингээд дуусгачихаж болох боловч тэр өөрийнхөө агуу өглөг золиосыг яажшуухан төлүүлснийг бас ярих үлдэж. Тэрбээр Умард этгээдэд буцаж ирээд өөрийнхөө том байшинд дахин төвхнөнгүүт, компани цаашдаа түүний тусыг авахгүйгээр болгохоор хичээж буйг Жон Томпсон мэдээтэхжээ. Шинэ төлөөний хүн, бас түүний үйл хэргийг үргэлжлүүлэгч хүн бүхэн Жис-Ук хэмээх нэртэй эмэгтэйд дуртай эд бараа, хоол хүнсээ ямар хэмжээгээр хүснэв, тэр хэмжээгээр нь ямар ч хөлс мөнгө нэхэлгүйгээр үг дуугүй

олгож байх тушаал хүлээж авчээ. Түүгээр ч барахгүй компани Жис-Ук нэртэй эмэгтэйд жил бүр таван мянган долларын тэтгэвэр төлөх болов. Хүү өсч өндийхийн цагт гэгээн эцэг Шампро түүнийг сургах болж, удалгүй Жис-Укын нэр дээр Мерилендийн иезуитын шашны коллежоос байнга захидал ирэх болжээ. Хожим нь Италиас, түүнээс арай хожуухан Францаас тийм захидлууд ирсээр, нэг мэдэхийн төрөлх нутагтаа олон буян бүтээсэн гэгээн эцэг Нийл гээч хүн Аляскт ирж, өөрийн үйл хэргийн хүрээг улам уужим болгож, сүүлдээ шашин сүмдээ нэн өндөр алдарт хүрсэн аж.

Умард нутагтаа эгэн ирэх үедээ Жис-Ук бас л идэр золбоотой, эрчүүл урьдын адил түүнийг харсаар, шохоорхсоор байсан ч, чигч шударга амьдарсаар, түүний тухай гагцхүү сайн сайхан үг дуулдаж байлаа. Тэр Ариун загалмайн сүмийн төлөөний газрын хандмаа нарын дунд хэсэг хугацаанд байгаад амжсан, тэнд уншиж бичиж сурсан төдийгүй өвчин эмгэг анагаах тухай бага сага юм сурчээ. Өөрийнхөө том байшинд буцаж ирснийхээ дараа амьдралынх нь замыг зааж өгөхийн тулд тойатуудын тссгоны охидыг гэртээ цуглуулдаг болж, Нийл Боннерын Жис-Укт, эхнэртээ зориулж

барилсан энэ байшин дахь түүний сургуулийг протестант ч, католик ч хэмээн нэрлэхийн аргагүй боловч түүнийг эсэн бусын шашны сурталч нар цөм ав адилхан дэмждэг авай. Өвөл ч, зун ч тэдний хаалга үргэлж нээлттэй болохоор эцэж ядарсан алтны хайгуулч нар, зовж зүдэрсэн аянчид Жис-Укын голомтод дулаацаж, ясаа амраахаар замаасаа гажин ийш ирдэг билээ. Харин Өмнөдөд, Америкт амьдрагч Китти Боннер Аляск дахь боловсролын асуудалд шимтдэг нөхрийнхөө нэгэн сонирхол, энэ зорилгод их мөнгө хандивладгийг нь сайшаадаг төдийгүй хэдий түүнийг хаа нэг

шоолж, янзыг нь үздэг ч, зүрх
сэтгэлийнхээ гүнд түүгээр улам
бахархдаг болсон билээ.

Өвөгчүүлийн баг

Хуаранд хүн шүүж, түүний үхэл амьдралын тухай яриа ернөж авай. Тэр хүн нь Ла-Барж нуурын доод биеэр Юконд цутгадаг Цагаан загас голоор нутагладаг улаан арьст өвгөн. Бүх Доусон, гагц Доусон ч бус, голын гүльдрилаас хоёр тийшээ мянга мянган бээрийн доторхи Юконы хязгаар нутгийг тэр чигт нь түйвээн донсолгосон эр билээ. Тэнгист бол далайн дээрэмчин, газарт бол доншуур тонуулч удамтай англо-саксууд эрт цагаас булаан эзэлсэн ард түмэндээ элдэв хууль дүрэм тулгаж, зарим үед тэр хууль цааз нь

даанч харгис хатуу байсан аж. Гэтэл энд Имберийн хэрэгт, хууль анх удаа ууч зөөлөн, хүлцэнгүй хандав.

Үйлдсэн хэрэгт нь таацахуйц, тоо бодлогын энгийн үйлдлээр ч бодчихмоор тийм ялыг хуулийн дагуу урьдчилан зэхээ ч үгүй юмсанж. Гэмт этгээд ялын дээд хэмжээ хүртэх нь гарцаагүй, үүнд өчүүхэн ч эргэлзээ байх ёсгүй бөгөөд хэдийгээр дээд хэмжээгээр түүнийг цаазлан хороож болох боловч Имбер л өөрийнхөө ганц олдох амиар хохирно. Гэтэл цаана нь бас түүний нүгэлт сэтгэлийн золиос болсон олон олон амь байгаа шүү дээ.

Хэрэг дээрээ Имбер хичнээн хүний цусаар гараа будсан ч юм билээ, түүний золиос бологсдыг яг таг тоолчих боломж байсангүй. Тэр нутгийнхан аяны буудалд гаанс толгойгоо угзарч суух зуураа, пийшингийн халуун илчинд хийх юмаа олж ядан нозоорч цөхөхдөө, тэр өвгөн хичнээн хүний аминд хүрснийг ойролцоохон багцаалджээ. Тэр олон золгүй хөөрхийсийн пийлэнх нь цагаан арьстанууд бөгөөд тэд ганцаар, хоёул. баг бүлгээрээ амиа алдсан.

Ямар ч утга учиргүй, шалтгаан сэжүүргүй болохоор Хатан хааны морьт цагдаагийнхны хувьд ч, тэр

байтугай гол мөрнөөс алт угааж
эхлэнгүүт хязгаар нутаг,
эрдэнэсийнхээ төлөө мөнгө төлөх
ёстой хэмээн шаардах зорилгын
учир өөртөө засах орны Засгийн
газраас ийш илгээсэн амбан
захирагчийн үед ч, ер урт удаан
хугацааны турш тэр алаан хядаан
оньсого хэвээр байсаар ирсэн.

Гэтэл шүүхэд биеэ тушаахаар Имбер
өөрийн биеэр Доусонд хүрээд ирсэн
нь хүмүүст дээр өгүүлснээс хавьгүй
бэрх оньсого мэт санагджээ. Хаврын
хуучдаар Юкон мөсөн хучилгандаа
багтаж ядан бачимдан урхирч ахуй
үест улаан арьст тэр өвгөн мөсөн
дээгүүр зурайсан харгуйгаас хазайж,

эргийн хэвгий өөд арайхийн мацаж
гараад, мэгдсэн янзтай нүдээ
цавчлан, төв гудамжнаа саатан
зогссон аж. Түүний ирэхийг харсан
хэн бүхэн жигтэй эцэнхий дорой
нэгэн болохыг нь эрхгүй ажиглажээ.
Тэрбээр хураалттай дүнз рүү гуйваж
найгасаар очиж суугаад, дэргэдүүр
нь өнгөрч буй цагаан хүмүүсийн эцэс
төгсгөлгүй урсгалыг гярхай нь
аргагүй ажин харсаар, тэндээ
өдрийн туж сууж, олон хүн түүнийг
сониучирхан байн байн эргэж
харсаар, гайхам этгээд царайтай тэр
сиваш өвгөний тухай зарим нь бүр
чанга чанга дуугаар ярилцан явжээ.

Хожим нь улаан арьстаны этгээд дүр

төрх тэднийг эрхгүй гай-хуулсныг хэдэн арван хүн нэхэн санаснаар барахгүй, тэд амьдралынхаа эцсийн өдрийг хүртэл өөрсдийн мэргэн ухаан, эгэл бус бүхнийг мэдрэгч зөн билгээрээ бахдан гайхуулсаар байсан юм.

Гэхдээ тэр өдрийн баатраар жижиг Диккенсен тодров. Жижиг Диккенсен сайхан мөрөөдлөөр дүүрэн, халаасандаа боодол доллартай тэр хязгаарт ирж, төдөлгүй нөгөө хүсэл мөрөөдөл нь халаасан дахь юмтай нь хамт замхарч одоод, Америк буцах зордлаа олохын эрхэнд бөөний худалдааны "Холбрук ба Мейсон"

контортоо бүртгэгчийн алба хаших болсон билээ. Имберийн сандайлж суусан баахан гуалин "Холбрук ба Мейсон" конторын яг эсрэг талд хураалттай байсан юм. Диккенсен өглөөнийхөө унданд явахын өмнөхөн цонхоор өнгийхдөө өвгөнийг анх харсан бөгөөд ундаа уучихаад контортоо эргэн ирж ахин цонхоор шагайтал өвгөн сиваш нөгөө газраа урьдын адил шовойтол суусаар байж.

Диккенсен цонхоор байн байн хялавхийн харсаар, мань эр дараа нь бас л мэргэн ухаан, бүхнийг мэдэрдэг эгэл бус зөн совингоороо бахархах болсон юм.

Жижиг Диккенсен гэнэн цайлган нэгэн хойно, хөделгөөнгүй суугаа бөөгийн мөргөлт буурлын царайнаэс шороон түмэн англосакс эээрхийлэгчдийг үл тайлагдах нууцлаг амгалан харцаар болгоож буй сивашийн ард олны дүр төрхийг олж харжээ.

Цаг явсаар атал Имбер мөнөөх хөшинге янзаараа шовойн, нэгээхэн хөдлөөгүй болохоор, Диккенсен урьд нэг удаа төв гудамны тэхий дунд зогссон чарган дээр нэг хүн яг тийнхүү хөшиж царцчихсан мэт суугаад байсны дэргэдүүр хойш урагш холхигч олон цөм түүнийг зүгээр амарч сууна хэмээн санээд

огт анзаарсангүй. Дараа нь харин хэн нэгэн түүнд санаандгүй хүрээд орхитол хэзээний амь тавьчихсан, бүр херч хөшиж гүйцсэн байсан төдийгүй гудамны хөл хөс дунд тас хөлдчихсөн байсныг гэнэт санажээ. Тэр шарилыг янзлахын тулд түүдэг рүү чирч аваачин гэсгээхээс аргагүйдсэн бөгөөд өөрөөр яэж түүнийг авсанд нь багтаах билээ. Тийн бодоод Диккенсен өөрийн эрхгүй давхийн цочив.

Хэсэг байзнаж байгаад Диккенсен салхинд гарч, навчин тамхиа угзрах санаатай гудманд хөл тавиад ганц минут өнгөрөв үү, үгүй юү, Эмили Тревис түүн дээр хүрч иржээ. Эмили

Тревис дур булаам гоолиг, туранхай. эмзэг эевэрүү хатагтай бөгөөд сая саяын эзэн, уулын инженерийн охины хүсэл зоргоор Лондонд ч, Клондайкад ч хаа сайгүй ав адилхан хувцаслах бүлгээ, Жижиг Диккенсен навчин тамхиа цонхны янз модон дээр яаран тавиад, бүрх малгайгаа тэргүүн дээрээ өргөн мэндчилэв.

Арван минут хэртэй тайван хөөрөлдөж байсан Эмили Тревис гэнэт Диккенсений мөрөн дээгүүр өнгийн харснаа учиргүй айсан янзтай дуу алдсанд Диккенсен цочин эргэж хараад өөрөө бас айсандаа дотор нь палхийжээ. Имбер аль хэдийн босч, гудамж хөндлөн гэрч

ирээд, бараан сүүдэр лүгээ адил хариугүй дэргэд нь зогсож, бүсгүйг хөдөлгөөнгүй дүрлэгэр нүдээрээ ховсдох гэсэн аятай цоо ширтэж байлаа.

-Хөөе, чамд юу хэрэгтэй вэ? хэмээн жижиг Диккенсен омогтой биш зормигхон янзтай асуугаатахлаа.

Имбер юу ч юм бэ бувтнаснаа, Эмили Тревист бүр ойртож очоод. ямар нэг юм үлдээчих вий гэсэн шиг хөлөөс толгойг нь хүртэл хамаг байдгийг нь улам хянамгай ажин харлаа. Бүсгүйн элгэн хүрэн өнгөт торгомсог үс, эрвээхэйн далавч адил хонгор зөөлөн үсээр эмжээстэй

ягаахан хацар өвгөний сонирхлыг
бүр их татаж, хүлэг морины бие
бялдар завины хийцийг шинжиж буй
мэт гярхай харцаа салгалгүй бүр
тойрон яваад ажиж байна. Бүсгүйн
ягаахан чихийг жаргаж буй нарны
туяа нэвт харван туяэруулж буйг тэр
үзээд, бүр гайхаж гүйцсэн бололтой
гэнэт зогсчихов. Гэгээд өвгөн бүсгүйн
царай зүсийг улам шимтэн ажиглаж,
цэнхэр нүдийг нь удаан анхааралтай
харж байснаа ахиад юу ч юм
бувтнаад, бугалган дээр нь алгаараа
дарж, нөгөө гараараа тохойг нь
нугалж үзвээ. Улаан арьстаны
царайд жигшил, гайхал тодроод,
зэвүүрхэн бувтнаснаа Эмилийн

гарыг сая буулгав. Тэгснээ төвөнхний ямар нэгэн авиаг бүгтхэн хүнгэнүүлээд, бүсгүйг орхин эргэж, Диккенсенд нэг үг хэллээ.

Диккенсен түүний хэлийг ойлгох биш. Эмили Тревисийг гэнэтхэн инээд алдахад Имбер хөмсгөө зангидан, Диккенсен рүү нэг, бүсгүй рүү нэг харсан боловч цаадуул нь дэмий л толгой сэгсэрнэ. Өвгөнийг тэднээс хариугүй холдож одохын даваан дээр бүсгүй

-Хөөе Жимми! Нааш ирээч хэмээн хашгирчээ.

Ашгүй, Жимми гудамны нөгөө

талаас ирж явжээ. Тэр бол харин цагаан арьстнуудын ёс жаягаар хувцаслаж, Эльдорадогийн вангуудын өмсдөг шиг том далбагар хүрээт бүрх духдуулсан, өндөр, болхи улаан арьстан байлаа. Түгдэрч ээрэн, авиа бүхэн дээр хахаж цацах мэт дуугарч, Имбертэй үг хэлээ арай ядан ололцож эхлэв ээ, тэр. Жимми ситха овгийнх учир улс орны буйд гүнд амьдрагч овгийнхны хамгийн энгийн ойр зуурын үгсийг л мэддэг аж.

-Цагаан загас овгийн хүн гэнээ. Би хэлийг нь сайн ойлгохгүй юм. Тэр цагаан хүмүүсийн тэргүүнтэй нүүр учирмаар байна гэнэ хэмээн тэр

Эмили Тревист уламжлав.

-Амбан захирагч уу? гэж Диккенсен ярианд хөндлөнгөөс оров.

Жимми Цагаан загасны овгийн хүнтэй дахин хэдэн үг сольсоноо, хэлсэн үгийнх нь учрыг гүйцэд ухаагүйдээ түгшсэн мэт царай нь барайгаад явчихлаа.

-Түүнд ахмад Александр хэрэгтэй юм байна гэж би бодож байна. Тэр цагаан эр, цагаан эмэгтэй, цагаан хүүхэд алсан, олон олон цагаан хүн алсан гэж ярьж байна. Тэр үхэхийг хүсчээ гэж Жимми хэлэв.

-Солиорчихсон юм болов уу гэж
Диккенсен үг нэмэрлэлээ.

-Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж
Жиммийг түүнээс сонирхтол,
Диккенсен магнайгаа хатгах гэсэн
мэт хуруугаа духандаа цочмог
хүргээд, тэндээ тэг зурах мэт яаран
эргүүлэв.

Цагаан хүмүүсийн тэргүүнтэй
уулзуулж өг гэж шаардсаар зогсоо
Имбер рүү эргэж харах зуураа
Жимми,

-Магадгүй, магадгүй хэмээн түүнтэй
санал нэгсжээ.

Хатан хааны морьт цагдаагийн газраас (Клондайт тэр морьгүй болоод байгаа) ирсэн цагдаа. Имбер хэрэг зоригоо яажшуухан давтан давтан өгүүлэхийг сонссон бөгөөд мөр ханхар, цээж тэвхгэр, бэлхүүс гоолиг, хөл хүчирхэг том, бярлаг чийрэг нэгэн учир Имбер хэдий чацархаг ч гэсэн тэр цагдаагаас хагас толгойгоор намхан байлаа

Цагдаагийн нүд хүйтэн, саарал өнгөтэй, харц шийдмэг, өвөг дээдсээс уламжлан зуун зуун дамжин хат сууж ирсэн өөрийнхөө хүч чадалд жолоогүй итгэгч тэр чанар нь бүх л бие цогцсоос нь өөрийн эрхгүй мэдрэгдэх бүлгээ.

Цагдаагийн эрэлхэг зоримог төрхийг идэр насны нь цог жавхаа илтгэн харуулах авч чухам үнэндээ бол тэр толигор хацар нь томоогүй охины хацар лугаа адил тийм хурдан, хоромхноо ягаараад ирдэг балчир насны хөвгүүн байж.

Өдгөө Имбер зөвхөн цагдааг шимтэн харж байснаа залуугийн эрүүн дээрх илдний сорвийг олж үзэв үү, үгүй юү, улаан арьст хөгшний нүдэнд ямар нэгэн учир битүүлэг оч гэрэл гялсхийвэй. Хатингар гараараа цагдаа хөвгүүний ташаанд хүрч зангирмал булчинт хөлийг нь энхрийхэн илснээ, ясан хуруугаараа ханхар цээжийг нь тогшиж, сүүлдээ

бүр хүүгийн мөрийг даргар ногоон даавуу мэт бүрхсэн яргай эр махыг илж үзэв. Тэр хооронд тэднийг тойрон ханагар цээжит, урт хөлт цагаан арьстны хамаг үр сад, алтны хайгуулч, уулсын эзэд, онгон зэрлэг нутгийг нээгч нар, сониуч улс хэдийнэ цуглаж, Имбер нэгээс нь нөгөө рүү нь харц гүйлгэн, эцэстээ Цагаан загас омгийн хэлээр юу ч юм бэ өндөр дуугаар өгүүлэв.

-Тэр юу хэлэв? гэж Диккенсен асуулаа.

-Энэ бүх улс цөм энэ цагдаатай адилхан юм гэж тэр хэллээ гэж

Жимми орчуулав.

Жижиг Диккенсен нуруу давжаа
хойно Тревис хатагтайн дэргэд
өөрөө ийм асуулт тавьсандаа
учиргүй сэтгэл гонсойж, цагдаа түүнд
тус дэм болохоор шийдэн, сэтгэлийг
нь засах санаатай,

-Тэрний сэтгэлд ямар нэгэн учир
битүүлэг юм байгаа бололтой. Би
түүнийг ахмадад хүргэж өгье. Надтай
хамт яв гэж түүнд хэлээд
орхиоч Жимми гэлээ.

Жиммийг дахиад хахаж цацан
дуугарахад, Имбер хэдий амандаа
нэг юм бувтнасан ч түүний царай

сэтгэл хангалуун янзтай
туяараад явчихлаа.

-Жимми, миний гараас барихдаа тэр юу гэж ярьсан, юу гэж бодсоныг нь асуугаад орхиоч? гэж Эмили Тревисийг хэлэхэд Жимми асуултыг хөрвүүлээд,

-Таныг хулчгар бус хүн байна гэж тэр хэлсэн юм байна гэжээ.

Тийм үг дуулсан Эмили Тревис баяр хөөрөө яахин нууж чадах билээ.

-Таныг нас балчир, өчүүхэн бяргүй, жижиг хүүхэд шиг булбарай амьтан гэж тэр хэлсэн. Тэр улаан гараараа

таныг бяцхан бяцхан өөдөс болтол тасар татахнаа даанч юмгүй. Энэ цагдаа шиг ийм том, ийм хүчирхэг эр хүнийг та яаж төрүүлнэ вэ гэж тэр зөндөө гайхсан, зөндөө инээсэн...

Эмили Тревис нүд буруулахгүй байх зүрх гаргасан ч, хацар нь харин улайгаад ирлээ.

Жижиг Диккенсен ч намуу цэцэг мэт улсхийн, учиргүй бачуурч, цагдаагийн хүүхдээрээ царай үснийхээ угт хүртэл час улайгаад:

-За, чи хөдөл! хэмээн олныг мөрөөрөө түлхэнгээ эрсхэн захирав. Өөрийн сайн дураар үйлдсэн гэм

зэмээ бүрэн дүүрэн хүлээсэн тэр газраа, ахин хаашаа ч мултран гарч үл чадах тэр л хуарандаа Имбер тийнхүү хүрч ирсэн аж.

Имбер хачин зүдэнгэ харагдана. Тэр өтөл эцэнгэр, юунд ч үл найдна. Тэр бүхэн цөм царай дээр нь бичээтэй. Өвгөн бөгтийн нурмайж, нүднийх нь гал бөхөөд, үс нь уг нь буурал баймаар атал нар, тэнгэрийн муухай хоёр өнгө зүсгүй, амьдын шинжгүй сөөсгөр хэдэн тугнууд болгон налмайтал шатааж, хордуулж орхиж. Эргэн тойрон юу болж буйг тэр сонирхсон шинжгүй агаад танхим дүүрэн анч гөрөөч, алтны хайгуулч нарын бүгийхэн, зэвүүн,

хоржоонт түрхэрээн Имберийн
чихнээ эргийн агуйн адар доорхи
тэнгисийн хүрхрээн мэт нүргэлнэ.

Тэрбээр цонхны дэргэд суух агаад
өмнө нь цэлийн буй уйтгарт дүр
бараанаа тоомжиргүй харц нь хаа
нэг алмайран саатна. Үүлс
хөшиглөсөн тэнгэрээс хөхөмдөг
шиврээ бороо намирна. Юкон шар
усны үерт хальжээ. Хэдийн цөн түрж
гүйцээд, голын ус хот руу нэлийн,
амарлингуйг хэзээ ч үл мэдэх улс төв
гудмаар завьтай нааш цааш хөвж,
тэр нэг завь, бас өөр завь ч
гудамнаас эргэн, хуарангийн өмнөх
усанд автсан тавцан руу эргэснээ,
хариугүй энүүхэнд хөвж ирээд,

нүднээс далд орж, төдөлгүй дүнзэн ханыг яажшуухан бөглүүхэн түншин, хүмүүс нь цонхоор байшин РУУ үсрэлдэн орж буй нь Имберт дуулдана. Тэгснээ тэр хүмүүс хөлөөрөө ус шал палхийлгэн доод давхраар өнгөрч, шатаар хэрхэн өгсөж байгаа нь сонсогдоно. Усны нойтон гуталтай тэр олон, малгайгаа аван танхимд орж ирээд, шүүхийг хүлээж суугаа олонтой нийлнэ.

Ашгүй энэ өөрийнхөө ялыг хүртэх нь хэмээн сэтгэл нь ханасан олон өөрийг нь дайсагнан харсаар ийнхүү сууж байх зуурт, Имбер тэдэн рүү бас харсаар, эдний жаяг ёс, хэв журмын тухай, зуун зууныг улиртал

байсан, цаашдаа ч байх, сайхан муухай цагийг ч, үер, өлсгөлөн, зовлон зүдгүүр, аймшиг, үхлийг ч үл хайхрагч сонор соргог хууль ёсных нь тухай тунгаан боджээ. Ямартай ч Имберт тэгж санагдсан буй заа.

Хэн нэгэн хүн ширээ тогшингуут яриа хөөрөө намжиж, анир гүм болсон бөгөөд Имбер ширээ тогшигч эрхэмийн зүг харав. Тэр хүн эрх мэдлийг эрхшээгч мэт санагдавч хамгийг мэдэгч, бүр ширээ нүдэгч эрхэмийг хүртэл захирагч нь огт өөр, ширээний ард тэр арай цаахна суугаа ханхар цээжит нэгэн гэдгийг Имбер эрхгүй ойлгожээ. Ширээний араас дахин нэг хүн өндийж, олон

хуудас нимгэн цаас аваад,
өнөөдүүлээ бидэртсэн дуугаар
уншиж эхэлсэн бөгөөд шинэ хуудас
эхлэх бүрийнхээ өмнө бүгтхэн
ханиалгаж, ханиаж дуусахаараа
харин хуруугаа шүлстэх нь сонин.
Тэр хүн юу ярьж байгааг Имбер
ойлгоогүй ч, бусад бүх хүн ойлгож,
тэд уурлаж буй нь хараажаар илхэн.
Үе үе тэд туйлгүй хилэгнэж, нэг удаа
бүр хэн нэг нь Имберийг цухалданги
богино үгээр зүхвээс ширээний ард
суугч хүн хуруугаараа тогшин, үг үл
дуулагчийг амаа хамхихыг тушаалаа.

Цаас барьсан хүн эцэс төгсгөлгүй
удаан уншлаа. Түүний уйтгарт, нэгэн
хөгт дуунд Имбер зүүрмэглээд,

уншлага дуусах үед мань хүн бүр гүн
нойрт автжээ. Цагаан загас омгийн
хэлээр хэн нэгэн түүнийг дуудахуйяа,
сая сэрсэн агаад аль эрт уугуул
нутгаасаа гарч, цагаан хүмүүсийн
дунд амьдарч буй улаан арьст залуу,
эгчийнхээ хүүгийн царайг үзээд,
өчүүхэн төдий гайхсангүй.

-Чи мэдээж намайг санахгүй байгаа
даа хэмээн нөгөөх нь амар мэндийн
оронд асуув.

-Үгүй, саналгүй яахав. Хаукан чи
биднээс аль хэзээний явчихаа биз
дээ. Эх чинь талийгч болсон гэж тэр
хариулав.

-Өтөл настай авгай байсан даа, тэр гэж Хаукан дуугарчээ.

Нэг мэдэхнээ Имбер хариу хэлэхийг нь дуулахаа больж, Хаукан мөрнөөс нь сэгсрэн, түүнийг ахин сэрээжээ.

-Энэ хүн юу уншсаныг би чамд хэлнэ. Чиний үйлдсэн, мунхаг агаад ахмад Александрт өчиг мэдүүлэн хүлээсэн бүх бузар гэмт хэргийн чинь тухай тэр дуудаж уншсан юм. Тэр бүхэн үнэн худал алин болохыг чи тунгаан бодоод хэлэх ёстой.

Хаукан шашин номлоочийнд амьдарч ахуйдаа тэднээс уншиж бичихийг сурсан болохоор өдгөө

ширээний ард суугаа эрхэмийн
уншсан нөгөө жигтэй нимгэн хуудас
цааснуудыг гартаа барьж байна.
Тэнд нь ахмад Александрын
байцаалт дээр Жиммигээр
дамжуулан Имберийн өчсөн бүхэн
бий. Хэсэг сонссоноо, царайд нь
гайхшрал тээнэгэлзэл тодорч, түүний
үгийг гэнэ сэнэгүй таслаад:

-Энэ чинь миний үг, Хаукан. Харин
чиний чих энэ үгийг дуулаагүй атал
уруулаас чинь унаж буй нь юусан
билээ.

-Үгүй дээ, Имбер. Цааснаа ч бас үг
тодордог. Чих минь тэрнийг
дуулаагүй ч, үг бүхэн чинь цааснаа

тодорч, нүдээр дамжин толгойд ороод, дараа нь харин миний уруул чамд дамжуулж байгаа юм. Хаанаас дуулдаж буй нь ийм учиртай.

-Хаанаас дуулдаж буй нь ийм учиртай юм бий. Тэгэхээр эд чинь цаасан дээрээс ирж байна гэсэн үг үү хэмээн Имбер сүжигтэйеэ шивнэн асууснаа цаасыг тэмтэрч, дүүрэн тэмдэгнүүдийг айдас хүйдэстэй ажиглав.

-Энэ чинь хязгааргүй ид шид, харин чи Хаукан, жинхэнэ бөө болж.

-Юу ч биш, юу ч биш гэж бахдал баяраа нууж эс чадсан залуу

хайнгадуу хэллээ.

Тэрбээр хуудас цааснуудаас нэгийг нь таамгаар аваад, уншиж эхлэв.

- "Тэр жил цөн түрэхийн урьдхан нэг өвгөн, хазгар хөлт хөвүүнтэйгээ ирж билээ. Тэднийг бас би цааш нь харуулсан, харин хөгийн аймшигтай орь дуу тавьсан".

- Энэ үнээн гэж Имбер амь тэмцсэн хоолойгоор үгийг нь таслаад:

- Тэр өчнөөн хашгирч, тэмцэлдсэн, үхэхийг ер хүсээгүйг яана. Чи энийг яаж мэдээ вэ, Хаукан? Цагаан хүмүүсийн тэргүүн чамд хэлсэн юм

уу? Тэднийг би яаж тонилгосныг
үзсэн хүн үгүй, харин гагц
захирагчид л ярьсан.

Хаукан төвөгшөөсөн янзтай толгой
сэгсэрнэ.

-Мунхаг минь, энэ бүхэн цаасан дээр
бичээтэй гэж би чамд хэлээ биз дээ?

Имбер бэхэн тэмдгээр эрээлжлэх
хуудсыг шимтэн харна.

-Гөрөөч цас үзээд ярьдаг даа. За
үүгээр өчигдөр туулай дэгдэж, Харин
шугуйд хярж, анир чагнаснаа дараа
нь юунаас ч юм айгаад гүйн одож,
энэ газраас тэр гэдрэг буцсан, энэ

хавиар хурдан хурдан харайж, хол хол үсэрсэн, гэтэл бас яг түүгээр шилүүс бүр хурдан харайсаар, яг энд мөр нь цасанд умбарч орхилоо, шилүүс алд алд цовхорч туулайг энүүхэнд гүйцжээ, бас нуруугаараа холбирч, цаашаа ганц шилүүсиин мөр хөтөлнө, туулай хэдийн үгүй болов. Цасан дээр мөр шинжээд анчин энд тийм, харин тэнд өөр юм болж гээд юу эс ярьдаг билээ. Чи түүн шиг цаас хараад энд тэр, бас тэнд энэ гээд, хамаг юмыг Имбер өвгөн хийсэн гээд ярих нь ээ?

-Тийм ээ, яг тийм гэж Хаукан хариулаад: -Харин одоо чих тавиад сонс, чамд ярь гэж тушаагаагүй цагт

өөрийнхөө чавганц хэлийг татаж байгтун.

Тийнхүү Хаукан Имберт өөрийнх нь өчгийг удтал уншиж, цаадах нь бодолд автаад таг чиг нугдайв аа. Тэгснээ Хауканыг дуугай болонгуут Имбер түүнд:

-Энэ бол яах аргагүй миний үг, үнэн үг минь, Хаукан, гэхдээ би их өтөлж, захирагчийн мэдэж дуулах ёстой, аль дивангарын мартагдсан хэргийг одоо сая саналаа, сонсогтун. Нэг удаа Мөсөн уулсын чанадаас хүн ирсэн чинь түүнд жигтэй сонин төмөр хавх байх юм, тэрнийг Цагаан загас гол дээр минжинд ангуучилж

явахад нь би тонилгож
орхисон. Дараа нь бас гурван хүн
Цагаан загас голоос алт хайхаар
ирлээ. Тэднийг ч би хүйс тэмтэрч,
нохой зээхний хоол болгосон.
Нээрээ тийм, бас Файв Фингерзийн
орчим нэг хүн алсан, тэр хүн голоор
салтай хөвж явсан юм тэр ямар их
мах шөл бэлдэж нөөцөлсөн байсан
гээч.

Имбер нэгийг санахаар минут
хэртэй дуугаа хураахуйяа, Хаукан
түүний үгийг хөрвүүлж, данс хөтлөгч
цааснаа буулгаж авай. Имбер улаан
шаргал үст, онигор нүдэт эрийг
алсаас нум сумаар нам унагаснаа
ярин ярьтал, өгүүлсэн бүхэн нь

багахан эмгэнэлт түүхийг агуулж буй түүний энэ ноомой хүүрнэлийг цугласан олон амгалан, хайнгадуухан сонссон буйзаа.

-Чөтгөр аваг хэмээн эхний эгнээний сонсогчдын нэг дуу алдахуйяа. үй гуниг, уур цухалд хоолой нь гарилтаад явчихав.

-Чөтгөр аваг, ээ халаг, энэ чинь миний ах Билл хэмээн тэр хүнгэнэлүүлэв.

Тийнхүү шүүх хурал болж байхад танхимд үе үе "Чөтгөр аваг" гасэн хилэнт үг дуурсаж, нөхдийнх нь гуйлга ятгалга, ширээний ард суугаа

хүний сануулга ч улаан үстийн амыг
хамхиж дийлсэнгүй.

Имбер тэргүүнээ цээж рүүгээ дахин
гудайлгахад, нүд нь бин битүү
харанхуйлах мэт хүрээлэн буй
ертөнцийг үзэхээ болиод, идэр
болчимгүй насны орь хоосон,
хязгааргүй мөрөөслөө буурал ядмаг
насандаа хүн ямраар дурсдаг билээ,
тийнхүү бодол санаашралдаа
умбажээ. Хаүкан ахин түүнийг
түлхэв. _

-Имбер босоотох! Яахаараа энэ
хүмүүсийн амииг бусниулж,
бусармаг хэрэг үйлдсэн, дараа нь
цаазыг эрж, ийш ирснийхээ учрыг

хэл гэж чамд түшааж байна.

Имбер туйлдсандаа гуйвасхийн арайхийн хөл дээрээ босч. ялимгүй чичирсэн, бөглүү дуугаар ярьж эхэлтэл Хаукан түүний үгийг тасалчихав.

Тэр том духтай хүн рүү хандан:

-Энэ өвгөн зөнөглөж гүйцэж. Хүүхэд шиг мунхаг юм яриад байна хэмээн англиар хэллээ.

-Бид түүний мунхаг үгийг дуулмаар байна. Бид тэр бүхнийг үг, үгээр нь дуустал нь сонсмоор байна.Та ойлгов уу гэж их духт эрхэм

зарлигджээ.

Хаукан бүхнийг ойлгов. Харин Имбер нүдээ гялалзуулсаар, эгчиинх нь хүү цагаан хүмүүсийн тэргүүнтэй юун тухай хэлэлцсэнийг там тум гадарлав.

Тэрбээр нүгэл хилэнцээ тийнхүү наминчилж эхэлсэн бөгөөд айсуй хойч үеийнхэнд нь зориулан хүрэл хөшөөнөө сийлэм гавьяа баигуулагч бараан зүст эх орончийн ер бусын түүх эхэлж буй нь тэр билээ. Хурсан олон сэтгэл булаагдсан мэт амьсгаа дараад, их духт шүүгч. улаан арьстаны зүрх сэтгэлийн, түүний ард түмний ч сэтгэлийн нандин бүхнийг

дуулж буй мэт шанаа тулан чих
тавив.

Орчуулагчийн хахир үгээр таслагдах
Имберийн төвөнхөөрөө өгүүлэгч
дуун анир гүмийг эзэгнэх агаад
улаан үст эрхэм үе үехэн "Чөтгөр
аваг хэмээн гаслантайяа уугчих нь
тэнгэр бурханы хонхон дуун лугаа
адил

-Би Имбер, Цагаан загас омгийнх
хэмээсэн өвгөний үгийг Хаукан
хөрвүүлэн хэлэнгүүт, түүний чих
Имберийн ярианаас унаган төрөлх
айзам. дахилт, хэмнэлээ олж
сонсоод, Христийг номлоочоос
олсон хүмүүжил, соёл иргэншлийн

өнгөр сүүдэр нь тэр даруйхнаа
хиисэн арилж, зэрлэг авир нь сэргэн
тодроод иржээ.

-Миний эцэг Отсбаок шантаршгүй
дайчин эр байсан юм. Намаиг
балчир хөвгүүн байхад ивээлт наран
бидний газар шороог дулаацуулж,
баяр баясгалан зүрхийг минь
хөгжөөдөг, үл мэдэх юмныхаа араас
хүмүүс үхэн хатан хөөцөлддөггүй,
харийн дуу хоолойг сонсдоггүй, эцэг
евгөдиинх нь ёс тэдний жудаг ёс
болж, идэр хөвгүүд бүсгүйчүүл рүү
сэтгэл дүүрэн харж харин бүсгүйчүүл
нь тэдний нүдийг эрхгүй булаадаг
баилаа. Хүүхнүүд улаан нялзрай
нялхсаа хөхөөрөө амилуулж, тэдний

алтан хэвлий ариун олон үр
удамдаа хүндрэнхэн, омог маань
өнөр олуул, тэр өдрүүдэд эр нь ёстой
эр улс шиг, тэд элбэг дэлбэг, энх
амгалан өдрүүдэд ч эр хүн шиг, дайн
дажин, тарчиг өлсгөлөнгийн цагт ч
эр хүн шиг байсан.

Тэр цагт өнөөг бодохноо гол усанд
загас элбэг, уул хөвчид ан гөрөө
арвин, ноход маань боохойн
удмынх хойно, зузаан арьсан дороо
халуухан, нүдгүй шуурга, тэсгэм
жавраас юундаа халирах билээ. Бид
өөрсдөө нохдоосоо өөрцгүй бас л
тийм байсан. Бид аймшигт шуурга.
чөмөг царцам жавраас юундаа ч
эмээх билээ. Харин пелли омгийн

хүмүүс манай нутаг руу халдаар
ирэхүйеэ манайхан ч тэднийг хүйс
тэмтэрсэн. тэд ч манайхнаас
хороосон, бид жинхэнэ эрчүүл,
Цагаан загас омгийнхон хойно, эцэг
дээдэс минь, эцгийн минь эцгүүд ч
пелли омгийнхонтой тулалдаж,
нутаг орныхоо хил хязгаарыг баталж
байсан юм.

Бидний ноход шантаршгүй, бид
өөрсдөө зориг цөстэй байсан гэж би
хэлсэн шүү дээ. Гэтэл нэг удаа бидэн
дээр хамгийн анхны цагаан хүн
ирвээ. Бүр дөрвөн мөчөөрөө цас
самардсаар ирсэн, яг ингээд... Арьс
нь шуумайтлаа таталдаад, арьсан
цаанаас яс нь харагдмаар, бид хэзээ

ч тийм хүн үзээгүй болохоор гайхаж алмайраад, тэр ямар омог овгоос, хаа газраас ирснийг нь таах төдий. Тэр эцэнги дорой, бүр бага хүүхэд шиг дэндүү арчаагүй нэгэн байсан учир, бид гал голомтынхоо дэргэд зай гаргаж, дулаан арьс дэвсэж өгөөд нялх хүүхдийг яаж амлуулдаг билээ, тийнхүү түүнийг тэжээв. Манай гурвын гурван нохойтой дүйцмээр биетэй нохой тэрнийг дагаж ирсэн, бас хариугүй эцэнхий зүдэг, арьс үс тачир, юуны илч байхав. Хонгорцог сүүл нь тас хөлдчихсөн болохоор үзүүр нь хүртэл өмрөөд уначихсан. Тэр хачин жигтэй нохойг бид ундалж тэжээж,

голомтынхоо хажууд дулаацуулсаар,
бас өөрсдийнхөө нохдоос
хаацайлаагүйсэн бол өнөөдүүл
хэзээний тасар татчих байсан биз.

Бугын мах, хатаасан хулд загас идсэн
хүн нохой хоёрын хүч, тамир бага
багаар эргэлгүй яахав. Тэнхээ
оронгуутаа харин таргалаад, зүрх
зориг орсон гэж сүрхий, өндөр
дуугаар ярьж, хөгшид, залуусыг
тохуурхан дооглож, бүсгүйчүүл рүү
маань эрээгүй харах болсныг яана.
Тэгтэл нөгөө нохой нь манайхны
ноходтой уралцаж, арьс үс зөөлөн
налархай, тачир атал нэг удаа бүр
гурван нохойг маань тасар татчих нь
тэр,

Ямар аймаг овгийнх вэ гэж тэр хүнээс бид сонирхтол "Би олон ах дүүстэй" гэж хэлээд, сэтгэл хүйт оргим инээж билээ, Тэр эр тэнхэрч сэргэж гүйцсэн хойноо манайхнаас явж. овгийн тэргүүний охин Нода түүнтэй хамт одов. Тэр бүхний дараахан манай нэг гичий гөлөглөж, бид хэзээ ч тийм гөлөг үзээгүй юмдаг, толгой том, эрүүний булчин шөрмөс чанга, үсгүй шахам хачин өрөвдмөөр амьтас байж билээ.

Миний эцэг Остбаок мохошгүй дайчин эр, тэр дорой үхээнц гөлөгнүүдийг хараад хилэгнэсэндээ царай нь хувьсхийн барайсныг санаж байна. Тэр яг ингэж чулуу

шүүрээд. харин дараа нь ганц
ингээд, гөлегнүүдийг зүйл дуусгасан.
Тэрнээс хойш хоёр зун улирсны
хуучдаар Нода эргэн ирсэн бөгөөд
бяцхан хөвгүүн гартаа тэвэрсээр
харьж ирсэн.

Тэгэж л хамаг юм эхэлсэн. Дараа нь
хоёр дахь цагаан хүн, тачир уст
ноходтойгоо ирж, нохдоо орхиод
өөрөө алга болчихсон. Гэхдээ тэр
манай гайхам хүчит зургаан нохойг
авч, оронд нь миний ээжийн дүү Ку-
Со-Ти-д биширмээр сонин жижиг
буу өгсөн, зургаан удаа угсран,
даанч хурдан бууддагсан, тэр гар
буу нь. Тэр буугаараа Ку-Со-Ти-гийн
гайхуулсныг ээ, бидний нум сумаар

бүр даажин хийн, авгайчуулын тоглоом гэж нэрлэв. Буугаа атгаад мань хүн баавгай руу дайрсан гээч. Баавгай руу гар буутай ухасхийгээд яавч барахгүй гэдгийг одоо цөм мэднэ. Гэтэл тэр цагт бид үүнийг хаанаасаа мэдэх вэ. Ку-Со-Ти ч яаж үүнийг мэдэх билээ. Тэр баавгай руу ямар зүрхтэй дөтөлж очсон гэж санана, гар буугаараа зургаа угсруулан буудаж орхитол харин баавгай ганцхан урхираад Ку-Со-Тигийн цээжин биеийг өндөг лугаа адил няц дараад, зөгийн үүрнээс бал гоождог шиг, газраар тархийг нь нялгадаж орхисон юмдаг. Тэр ямар сайн гөрөөч байлаа, гэтэл өдгөө

эхнэр, үр хүүхдэд нь ангуучлах хүн үгүй болов. Бид цөм элэг эмтрэн, "Цагаан хүнд сайн сайхан бүхэн бидэнд саар муу" хэмээн ярьж суусан сан. Энэ үнээн. Цагаан хүмүүс өнөр олуул, цагаан хүмүүс тарган цатгалан, гэтэл бид тэднээс болоод улам цөөрч, улам хатингиршсаар авай.

Тэгтэл гурав дахь цагаан хүн ирж, түүнд олон олон янзын гайхам амтат аяганы хийц, элдэв эд агуурс байсныг хэлэх үү, тэр бидний зүйргүй бянтай хорин нохойг маань эд баялгаараа сольж, арилжиж аваад, бас бэлэг сэпт, сайхан үгээр урвуулан манай арван залуу

гөрөөчийг араасаа дагуулж одсон
агаад тэд альхан тийш одсоныг хэн ч
үл мэдэв.

Нэгээхэн хүний үр хүрч байгаагүй
Мөсөн уулсын хязгаарын цаадтайх
Аниргүй толгодод тэд ясаа тавьсан
гэж улс ярьдагсан. Тийм ч байсан,
Үгүй ч байсан Цагаан загас
овгийнхон тэр ноход, идэр анчидаа
дахин хэзээ ч хараагүй билээ.

Цагаан арьстнууд дахин дахин
ирсээр, бэлэг сэлт авчирч манай
залуусыг дагуулж одсоор, залуус
маань эргэж ирээд пелли
омгийнхны нутаг усны чанадтай буй
холхи хязгаарт тэдний үзэж туулсан

хүнд бэрх, аюул заналын тухай гайхалтай хууч яриаг нь бид дуулдаг бол, заримдаа залуус маань эргэж ирэхгүй байх нь ч бий. Тэгэхээр нь бид "Цагаан хүмүүс юунаас ч зүрхшээдэггүй нь тэдний өнөр олуул байдгаас тэр. Харин бид, Цагаан загасны хүмүүс цөөхөн, манай залуус дахиад биднээс холдох ёсгүй" хэмээн ярилцав. Гэвч идэр эрс ямар боловч зайлж одсоор, залуу бүсгүйчүүл ч явчихдаг болов, бидний уур хилэн цээж төөнөсөөр авай.

-Үнэндээ бид давсалсан гахайн мах, гурил идэж, учиргүй цайсаг болчихсон, хэрэв цай цүйгүй үлдвээс тэрэн шиг адгийн юм үгүй, ярья

үггүй, уурлавал жолоогүй болчихно. Ингээд нэг мэдэхнээ манайхантай арилжаа наймаа хийхээр цагаан хүмүүсийн авчирдаг эд агуурсын тухай бид мөрөөддөг болов оо. Наймаалцах! Наймаалцах! Бид гагцхүү арилжаа наймааны төлөө тэчъядан санаашрана. Нэг удаа дүн өвлөөр ангийнхаа хамаг олз омгийг явдаггүй цаг, иргүй хөрөө, сумгүй гар буугаар өгчихөөд төдөлгүй өлсгөлөн гачлан нөмрөнгүүт, үмх мах ч үгүй хоцорч, хаврын урь орохыг үзэж чадалгүй дөрвөн арван хүнээ нүд аниулчихаж билээ. "Ингээд сөхөрлөө, пелли омгийнхон дайлаар ирж, газар нутгийг минь эзэгнэнэ

дээ" гэж бид гаслана. Гэтэл аюул зовлон зөвхөн бидэнд тохиолдоогүй, пелли омгийнхонд ч нүүрлээд, тэднийхэн цөхөрч туйлдаад, юун бидэнтэй дайтах манатай.

Миний эцэг Отсбаок эрэлхэг дайчин, тэр үед ихэд насжаад ухаан саруул болсныг хэлэх үү, овгийн тэргүүнд ийм үг хэлж билээ. "Хар даа, манай ноход гэж авах юм алга. Эдний нөгөө өтгөн үс ноос хаачив, эд тамир тэнхээгээ гээж хөллөгөөнд явж чадахаа болиод, хүйтэн жаварт тэсэхээ больжээ. Эднийг тонилгож орхиод зөвхөн чонын угсаат гичийнүүдийг нь үлдээчихье, тэгээд уяаг нь тайлж, хээрийн зэрлэг

боохойтой нийлэлдтэл нь шөнө дөлөөр хөвч рүү тавьчихаад байя. Тэгвээс бид дахиад жавар даах арьстай, тэнхээт ноходтой болно".

Ашгүй, тэргүүн тэр үгийг нь сонссоноор барахгүй удалгүй Цагаан загас овгийнхон хязгаар нутаг даяар хосгүй сайн нохдоороо цууд гарлаа. Гэхдээ хүмүүсээрээ бус гагц нохдоороо. Бидний сор болсон залуус, бүсгүйчүүл цагаан хүмүүстэй хамт алсын харгүй, гол усаар хаашааг бүү мэд, биднээсээ хагацан одсоор байв. Бүсгүйчүүл нь Нодагийн буцаж ирсэн лугаа адил харьж ирэх боловч өвчинд баригдчихсан, өтөлчихсөн, эс бөгөөс

ерөөс эргэж үл ирнэ. Идэр эрс нь хэрэв буцаж ирвээс биднийхээ голомтын дэргэд тухлан суух ч үгүй, бядан явах цагтаа олиггүй үг, жолоогүй авирт дасчихсан хойно чөтгөрийн унд хүртэж, өдөржин шенөжин хөзөр тоглож байгаад цагаан хүний анхны дуудлагаар үл мэдэгдэх орон хязгаар руу тэмцэж одно. Тэд өтгөсийг өргөмжлөх ёстойгоо умартаад, хэнд ч хүндлэл асрамж үл үзүүлнэ. Бидний эрт хуучдын ёс жудгийг доромжлохоор барахгүй тэргүүн зайрангийн өөдөөс элэг доог хийх нь даанч хэтэрхий.

Цагаан загас омгийн хүмүүс бид сулдгар, арчаагүй, дорой болчихсон

гэж би хэлсэн шүү дээ. Тамхи, виски, өмсөхөөр хүйтэн жаварт дагжиж хоцордог нимгэн цаасан даавуун хувцасны оронд үнэт ангийн үс, дулаан арьсаа өгчихнө. Ханиад томуу бидэн рүү довтолж, эрчүүл хүүхнүүдгүй өвдөөд, бүгшүүлж байснаа дараа нь бүх л шөнөжингөө хар хөлсөө асгаруулан тарчлах агаад харин гөрөөч нар нь хөвчид гарсан хойноо цасан дээр цусаар нулимчина. Тэгснээ нэгнийх нь, бас нөгөөгийнх нь хоолой багалзуураас цус садран, хүмүүс энэнээсээ болоод түргэн зуурт тэнгэрт халих нь олонтаа.

Хүүхнүүд хүүхэд төрүүлэх нь өдрийн

Од шиг, за тэгээд мэндэлсэн нялхас нь үлбэгэр туранхай, өвчин ороомтгой, цагаан хүмүүс бидний хэзээ ч үл мэдэх өөр өвчин авчирсан, тэр өвчнийг улаан бурхан, цэцэг хэмээн нэрийддэг гэж над ярьсан. Түүнээс болж намар түрсээ шахаж дуусаад амьдрах учрал тохиол ахин үгүй учир голын чимээгүй салаанд хулд загас яаж үхдэг билээ, түүн лүгээ адил бид хиарч байлаа.

Гэхдээ хамгийн гайхалтай нь цагаан улс бидэнд үхэл авчирч, тэдний хамаг хэв зуршил нь үхэл хагацал өөд хөтөлдөг ч, самсааных нь амьсгаа хүртэл үхлийн жавартай ч, өөрсдөө харин үхлийг үл мэднэ.

Тэдэнд тамхи, виски, тачир үст
ноход бий, хөхүүл ханиалга, цусан
ханиалга, улаан бурхан, цэцэг гээд
өчнөөн олон өвчин хуучтай тэд,
эдний арьс цагаан, цасан шуурга,
тэсгэм жавраас зүрхшээх нь туйлгүй,
бас зургаан удаа угсран буудагч
мангар гар буу байгаа. Ийм мөртлөө
хамаг өвчин тахлыг үл хайрхан, тэд
таргалж дэвжиж цэцэглээд, хүнд
савраараа замбутивийг Дарж, бүх л
ард түмнийг дэвсчиж буй. Бас эдний
хүүхнүүд алдрай жаалхүү мэт
булбарай хонгорхон, дүр байдал нь
тийм турьхан атлаа ачир дээрээ
зүйргүй хүчирхэг үлэмж том, чадал
ихт эрчүүлийн эх билээ. Тэгэхээр

танхил ахуй, өвчин хууч, дорой
үхээнц нь бяр тэнхээ, агуу хүч чадал,
эрх мэдэл болон хувирч байгаа биз
дээ. Цагаан хүмүүс нэг бол бурхан
тэнгэр, эсвэл ад чөтгөр, гэхдээ би
яаж мэдэх вэ. Хөөрхий Цагаан загас
омгийн хөгшин Имбер би юу мэдэж
чадахсан билээ дээ. Харин би нэг л
юумыг мэднэ. Газар усыг нээгч, дайнч
тулаанч энэ цагаан хүмүүсийг
ойлгож ухварлах аргагүй гэдгийг
харин мэднэ.

Агнах жигүүртэн шувуу хөвчид улам
улам цөөрсөөр буй тухай би хэлсэн
шүү дээ. Энэ үнэн, цагаан хүний буу
даанч сайхан зэвсэг, хол тусгалтай,
гэхдээ унагах шувуугүй болбоос

бууны тус гэж юу байхав. Миний хүүхэд ахуй цагт Цагаан загас овгийн газар нутгийн гүвээ толгод бүхэнд хандгай тааралдаж, карибу буга жил бүхэн хичнээн ирж байсан гээч, тоо томшгүй. Өдгөө гөрөөч жим хөөж арав хоног бэдрээд ганц хандгай үзэж нүд баясгахгүй, урьдын тоо томшгүй байсан карибу буга бүүр ор тас арга болсон. Буу ч гэж буу, алс хол тусдаг ч буудах юм үгүй болбоос түүний тус юухан гэж би хэлсэн билээ.

Имбер би Цагаан загас овог яаж мөхөж сүйрч буйг, пелли овог хязгаар нутгийн бусад бүх омог аймаг эрсдэн дуусч буйг, хөвчид

агнах жигүүртэн дууссан шиг эд
маань хиарч буйг харж байхдаа энэ
тухай бодсонсон. Би удаан бодсоон.
Би удган зайрантай, ухаант
өвөгчүүлтэй уулзсан. Хүмүүсийн
шуугиан бодож бясалгахад минь бүү
саад болог гээд би суурингаас алс
ойд хулжиж, ходоодны хүнд намайг
бүү дараг, хараа сонорыг минь бүү
балартуулаг хэмээсэндээ би мах
идэхээ ч больсон. Нойроо умартаад,
тайгад би удаан суулаа. Нүд
миньтэнгэрийн тэмдгийг хүлээж,
харин сонор чих минь бүхнийг
болгоох ёстой тэр үгийг чагнаархан
байв аа.

Түнэр шөнөөр салхи ёолж, ус уйлах

голын хөвөөнөө би орь ганцаар очсон бегөөд ухаант өтгөс, тэнгэрт хальсан зайрангуудын сүүдэртэй тэнд, мододын дунд уулзаж, тэднээс үг дуулах гэсэн юм.

Юутай ч гэсэн эцсийн бүлэгт надад хий юм, мөнөөх дур гутаам ахархан үст нохос үзэгдэхэд сая би юу хийх ёстойгоо ойлгож билээ. Миний эцэг, эрэлхэг дайчин эр Отсбаокын ухаант үйлийн ачаар бидний ноход чонын удам угсаагаа ариун хадгалж, тэдэнд маань илчит дулаан арьс үс нь байна, хөллөгөөнд цамнах бяр тэнхээ ч хангалттай. Тэгээд би сууриндаа эргэж ирээд, өөрийнхөө үгийг дайчин цэрэг эрстээ хэлэв.

"Цагаан хүмүүс эд нар нэг овог, бүр агуу том овог, нутаг оронд нь агнах шувуу үгүй болоод манай нутгийг эзэрхийлэхээр ирж, биднийг доройтуулж, бид хиарч байна. Заяагүй харамч улс. Хар л даа, одоо манай хязгаар нутагт гөрөөлөх шувуу үгүй болж, хэрэв бид амьд мэнд үлдмээр байгаа бол нохдыг нь яалаа, өөрсдийг нь бас тэгэх ёстой бус уу".

Би бас өөр олон үг хэлсэн. Үзэлцэцгээе хэмээн ятгав. Цагаан загасны хүмүүс намайг сонссон ч, нэг нь нэг юм бувтнаад, нөгөөх нь өөр юм хэлээд, бүр болшгүй тэнэг үг ярьсан ч хүн бий. Гэхдээ ганц ч

дайчнаас би зориг төгс, дайнч үг дуулсангүй, идэр залуус маань хулчгар, үхээнц болчихож. Харин чимээгүй суугч өвгөдийн нүднээ гал бадамлаад явчихыг үзэв.

Суурингийнхнаа унтсан хойно, үдэш орой өвгөдийг ойд нууцгай дуудаад, тэдэнтэй дахин уулзалдлаа. Бид үгсэн тохиролцоод, нутаг орон маань чөлөөтэй тэнүүн байх үеийн нар хур, баяр хөөр, элбэг дэлбэг цагаа, бидний борви тэнийх үеийн сайхан өдрүүдийг дурсаж санагалзан, бие биеэ ахан дүүс хэмээн нэрийдэж, нууцаа чанд хадгалах ам өгцгөөн, бидэн рүү ирсэн санаа муут овгийнхноос нутаг

орноо цэвэрлэж авахаар агуу андгай тангараг тавилцав, хөөрхийс. Одоо бол үүн шиг мунхаг хэрэг хаа байхав, гэтэл Цагаан загас овгийн хөгшчүүл бид тэр цагт үүнийг яаж мэдэх вэ?

Тэднийг уриалан дуудаж, бусдад үлгэрлэхийн төлөөнөө би хамгийн эхний аллагыг үйлдэж билээ. Би Юконы хөвөөнд хэвтчихээд цагаан хүмүүсийн завийг отон хүлээлээ. Завинд хоёул явсан бөгөөд намайг босч гараа өргөхийг үзээд тэд нааш эргэж, эргийн зүг сэлүүрдсээр, завины хошуунаа суугаа хүн надад юу хэрэгтэйг мэдэх санаатай тэргүүнээ өргөнгүүт миний сүм

агаарт исгэрэн шунгинаж, яах
ийхийн завдгүй шууд багалзуурт нь
зоогдсон агаад надад юу хэрэгтэй
байсныг тэр эгшинд ойлгоо биз.

Бөгсөнд сууж залуур атгаж байсан
нөгөөх нь мөрөн дэх буундаа хүрч
амжаагүй байтал би түүнийг
жадаараа нэвт сүлбэсэн. Бас ч үгүй
хоёр жад үлдэж билээ над.

"Энэ анхных нь. Хэсэг азнасны хойно
бид бүх овгийн бүх өвгөчүүлийг,
дараа нь бас гартаа бүлтэй үлдсэн
залуусыг нэгтгэнэ, тэгэхээр хэрэг
явдал хурдсах биз" хэмээн над руу
хүрч ирсэн өвгөчүүлд хэлж билээ, би.

Амиа алдсан цагаан хүмүүсийг дараа нь бид гол руу чулуудчихсан. Харин тэдний завь гэж ёстой сайхан эд байсныг нь шатаачихсан. Бас завинд ямар л юм байсан бүгдийг нь галдсан. Тэр хамаг юм нь савхин Цүнхтэй байсан болохоор юмсыг нь үзэхээсээ урьд хутгаар хага хага татахаас аргагүйдэж, цүнхэнд Хаукан чиний уншсан лугаа адил бичиг Цаас өчнөөн олон байсан бөгөөд цөм элдэв тэмдгээр дүүрэн, тэр сонин тэмдгүүд биднийг гайхуулж, ямар учиртайг нь ойлгоо ч үгүй. Өнөө би Ухаажгаад, ойлгохоор боллоо, чиний над хэлснээр бол тэр бүгд хүний Үг...

Завин дээрх хоёр хүний үхлийн

тухай өгүүлснийг Хаукан хөрвүүлж хэлэв үү үгүй юү, танхимаар дүүрэн чихэлдсэн олон түрхрэлдэн. шивэр авир гээд явчихав.

-Энэ чинь ерэн нэгэн онд алга болсон шуудан. Питер Жеймс, Дилени хоёр авч явсан. Ла- Барж нуурын тэнд хоёул явахыг нь Меттьюз хамгийн сүүлд харсан гэсэн хэмээн хэн нэгний дуу цангинаад явчихлаа.

Данс хөтлөгч хичээнгүйлэн бичсээр, Умард нутгийн түүхнээ нэгэн шинэ бүлэг ийнхүү нэмэгджээ.

-Надад хэлэх юм бараг үлдсэнгүй

хэмээн Имбер аажуухан өгүүлэв.

-Бидний үйлдсэн бүхэн цаасан дээр байгаа. Өвгөчүүл бид юу хийж байгаагаа ойлгоо ч үгүй, нууцаа чанд хадгалсаар, бид хөнөөгөөд л байсан, алаад л байсан, үзэж туулсан он жилүүд маань өөрийн ажил хэргээ яаралгүй, гэхдээ шалмаг амжуулахад сургасны учир хүний амь таслахдаа хүртэл хар санахыг нь яана. Нэг удаа цагаан улс манайд ирж, хорсголот нүдээр биднийг цоо ширтэн зүхлийн үгээр булж байснаа зургаан сайхан залууг маань гарыг нь төмрөөр дөнгөлөөд авч одов. Бүр овтой, бүр олныг цааш нь харуулах ёстойгоо тэгэхэд ойлгож билээ. Ингээд

өвгөчүүл нэг нэгийнхээ араас гол
өгсөн уруудан, үзэж дуулаагүй
хязгаар нутаг руу мордоцгоож, ийм
хэрэгт зүрх цөс гаргах нь хэт, мануус
хэдий өтөл буурай, хэзээний юунаас
ч айж эмээх больсон ч холхи харийн
нутагт одохын өмнөх айдас хүйдэс
чинь өвгөчүүлийн хувьд гол зурмаар
айдас байхгүй юу.

Тэгээд яаралгүй, их ов заль гарган
амьтны голыг тасалж эхэлсэн.
Цагаан хүн хаа өөрийнхөө буудлыг
засна, хаагуур зам гаргана, тэр газар
бүрт, Чилкут, Дельтийн тэрүүхэнд
даваан дээр, тэнгисийн хөвөөнөө
бид тэднийг хүйс тэмтэрсэн. Тийм
ээ, цагаан арьстнууд үхээд байдаг,

гэтэл энэ нь бидэнд лав өчүүхэн тус
үгүй, тэд уулсын чанадаас ирдгээрээ
ирсээр, тэд улам олон болсоор,
харин бид хөгшчүүл бүр цөөрч
хоцров, хөөрхийс. Би санаж байна.
Бугын хавцалд нэг цагаан хүн
буудлаа засч, нуруу дэндүү давжаа
тэр хүн рүү унтаж байхад нь манай
гурван хөгшин дайрч дээ. Маргааш
нь би тэр цагаан хүн, өвгөчүүлийн
дээрээс орчихсон Дөрвийн дөрвөн
хүнээс ганц цагаан хүн нь
амьсгаатай, амь тасрахаасаа өмнө
намайг харааж, аль муугаар зүхэх
тэнхээтэй байсан юм даа.

Үнэхээр тийм байсан. Өнөөдөр нэг
хөгшин тэнгэрт халихад, маргааш

нөгөөх нь, заримдаа өчнөөн цаг улирсны хойно манайхны хэн нэгний үхлийн тухай сураг бидэнд ирж, заримдаа ирэх ч үгүй, бусад овгийн хөгшчүүл арчаагүй дорой, үхээнц хулчгартаа бидэнд дэм болохыг хүссэнгүй. Тийнхүү өнөөдөр нэг буурал, маргааш нөгөөх нь амиа зольсоор. Цагаан загас овгийн Имбер би орь ганцаар үлдсэн нь энэ.

Миний эцэг Отсбаок, эрэлхэг дайчин байсан. Өдгөө Цагаан загас овог гэж үгүй болов. Би энэ овгийн сүүлчийн ганц буурай нь. Харин идэр эрс, залуу эмс маань газар нутгаасаа оин гарч, зарим нь пелли омгийнхон руу,

нэг хэсэг нь хулд загасны омгийнхон руу, гэхдээ дийлэнх олонхи нь цагаан хүмүүс рүү одоцгоосон. Би хариугүй зөнөж, их зүдэрлээ. Би Хууль цаазтай дэмий тэмцэлдэж. Хаукан чи үнэн хэлж, би Хууль цаазыг эрэлхийлж ийшээ ирсэн юм.

-Чи үнэхээр мунхаг хүн юм, Имбер хэмээн Хаукан өгүүлвэй.

Гэвч өөрийн хий бодолдоо автсан Имбер хэдийн юу ч дуулж сонсохоо больжээ. Их духт шүүгч эрхэм бас хий үзэгдэлт бодолдоо автсан агаад хууль цаазыг эрхшээн, өөр бусад ард түмний хувь тавиланг дэнслэгч, болдоор хамгаалагдаж хуяг дуулгаа

агссан өөрийнх нь арьс өнгө нэгтнүүд
бултаараа түүний өмнүүр сүр хүчин
төгөлдөр ярайн жагсаж өнгөрчээ.

Дүнсгэр тэнгисийн мандал, харанхуй
хөвчийн дээгүүр хүрэн улаанаар
гийн цацрагч төрөлх түүхийнхээ
үүрийн гэгээг тэр харж байлаа. Тэр
үүрийн гэгээ цог жавхлант, илч
гэрлээр дуртмал жин үд рүү
алгуурлах ахуйдаа яажшуухан цусан
улаан дөлөөр ноцож буйг тэр үзэж,
басхүү уулсын араар сүүдэр
хүүшлээд, элснээ шингэсэн цус лугаа
адил шөнө яажшуухан хүрэнтэн
бараантан айсуйг харж байлаа...

Басхүү тэр бүхний цаанаас, түүний
хүнд бэрхийн дор амь тавигч, түүний

нэрийн өмнөөс гүйцэтгэгч тэр л
өчүүхэн дорой хүмүүнийг бодохноо
эгнэшгүй хүчит. харгисдогшин,
өөрчлөшгүй, өрөвдөх нинжин
сэтгэлгүй, агуу хүчит хууль цааз
тодроод ирэх шиг болж, мөнөөхөн
хүмүүнээс нь хавьгүй давилуун
шүүгчийн зүрх сэтгэл хүртэл өршөөл
энэрэлийг гуйх амой.

Этгээдчин

Боллоо би, өдрийнхөө ажилд одлоо

*Бурхан минь, хөдөлмөрлөгч булчинг
минь эрчилж өгөөч.*

Хэрэв надад үхлийн хувь оногдвоос

*Хөдөлмөр, ажлаа дуусгах хувь
хүртээгээч хэмээн*

Бүхнийг бүтээгчээс мөргөн гуйнам.

Аминь.

-Одоохон бос Жонни, тэгэхгүй бол
идэх юм горьдолтгүй шүү.

Сүрдүүлэг хөвүүнд нөлөөлсөнгүй. Тэр сэрэхгүй юмсан хэмээн нөрлөж, нойрмог, харанхуй мансууралдаа хургасаар байлаа. Нударгаа зангидах гэж дэмий нэг оролдон гараа сарвагануулах агаад улбагар, эмх замбараагүй хоосон, хий цохилт хийх ажээ. Энэ угсраа цохилт ээж рүү нь чиглэж буй боловч тэр хэзээ язааны овтой гэгч нь бултаад, мөрнөөс нь цөхрөх янзгүй сэгсчсээр.

-Гайгүй ээ, чамайг!...

Шүлэг нойрны чанадаас дуулдах энэ бүгт хашгираан яах ийхийн завдгүй бачуурсан чарлаан болж хувираад тэгснээ таг чиг болж, төдөлгүй утга

учиргүй гиншигнээн залгав. Энэ бол барагдашгүй уур хилэн, зовлон зүдгүүрээр дүүрэн араатны архираан, тамд унасан нүгэлтний орь дуун байлаа.

Гэтэл эх нь түүнийг ер дуулаагүй мэт. Ширгэмэл гунигт нүдтэй, эцэнхий ядруу царайтай энэ авгай еглөөнийхөө эл зовлонт үйлд дасчихсан, өдрөөс едөрт, бүх амьдралынх нь турш ийнхүү давтагдаж байгаа хойно арга ч үгүй биз. Тэр хөвүүний хөнжлийг хуу татах гэж оролдтол, цаадах нь харин нударгаа савчихаа больчихоод хөнжлийнхөө сэжүүрээс тас зуурчих нь тэр. Орон дээрээ атигасхийн биеэ

хураагаад хөнжлөөрөө биеэ ороож,
юун түүнийгээ өгөхтэй манатай.
Тэгэхээр нь эх нь хамаг ор дэртэй нь
шалан дээр хөлбөрүүлэн унагах
санаатай оролдоод үзэв. Хөвгүүн
эсэргүүцсээр байлаа. Авгай байдаг
чадлаараа ноцолдсоор, дийлэлгүй
хаачив гэж. Хөнжлөө алдчих вий
гэсэндээ хүү арай л шалан дээр
өнхөрч ойчсонгүй. Галлагаагүй муу
өрөө эрүү ам зуурчихмаар хүйтэн
хойно тэгэх нь ч аргагүй.

Хүү хариугүй онхолдоод ойчих нь
гэмээр орны ирмэг дээр дэнжигнэн
сарвалзсанаа ашгүй сая ухаан оров.
Тэр яаж ийж байгаад тэнцвэрээ
олон өндийснөө, дараа нь хөл

дээрээ босоод ирлээ. Ээж нь тэр даруй түүний мөрнөөс зууран учиргүй сэгсчжээ. Хөвгүүн дахиад нударгаа урагш өгчилгөсөн агаад энэ удаа харин хүчтэй, оновчтой цохиж, нүд нь нээгдлээ. Эх нь түүнийг тавьчихав.

Тэр сая нойрноосоо сэржээ.

-За яахав хэмээн тэр бувтнана.

Ээж нь түүнийг харанхуйд орхичихоод, чийдэнгээ аван хурдхан гарч одов.

- Цалинг чинь суутгачихаар ухаарнаа, гайгүй чи гэж гарч явах

зуураа тэр үг хаяна. Харанхуй түүнд хамаа ч үгүй. Өмд, хүрмээ өмсөөд тэр гал тогооныхоо өрөөнд орлоо. Түүний энэ алхаа гишгээ юү, ийм гурьхан хохигор биед дэндүү ахадмаар нүсэр. Хөлөө дааж ядан чирэх бөгөөд энэ нь хүртэл ойлгомжгүй, гэтэл хөл нь туранхай, ясархаг. Тэр яайжгий сандлаа ширээ рүү түлхлээ.

-Жонни! хэмээн ээж нь тасхийтэл дуудав.

Хүү мөн гэнэт огло харайн босч, тосгуур руу чимээгүй очлоо. Өнөөх нь тос нүүгэлтсэн бохир заваан, ёроолын нүхнээс нь өмхий самхай

ханхлан байна. Тэр үүнийг үл тооно.
Гал тогооны сав суулганы бохир
бүхэн шигсэн савангаар угаана гэж
юу байхав, хөөс ч гэж юу гарах вэ.
түүн лугаа адил өмхий үнэрт тосгуур
мэт нь түүний хувьд байдаг л юмны
нэг. Гоожуурын хүйтэн уснаас
алгаараа хэд тосч цацлаад, угаал
өндөрлөв. Тэр шүдээ угаадаггүй, тэр
битгий хэл шүдний сойз гэж юмыг
хэзээ ч үзээгүй, шүд цэвэрлэх мэтийн
мунхаг үйл хийдэг улс хорвоод
байдаг гэдгийг ч үл мэднэ.

-Өдөртөө ганц удаа ч болтугай
хэлүүлэлгүй гар нүүрээ угаачихаж
бай хэмээн эх нь зэмлэнэ.

Хагархай тагийг нь кофе чанагч дээрээ барьж хоёр аяганд тэр кофе аягаллаа. Жонни зэмлэлийн хариуд юм хэлсэнгүй, тэгээд ч энэ бол мөнхийн хэрүүлийн шалтгаан, ээж нь цахиур чулуу мэт эрсхэн хатуу байдаг ганц юм нь хүү нь өдөрт ганц удаа боловч гар нүүрээ угаах явдал.

-Бид дэндүү хол амьдрах юм даа. Тийм ээ, би чадлаараа хичээж байна шүү дээ! Чи өөрөө мэдэж байгаа. Гэхдээ энд арай саруулхан, бас нэг доллараар хямд, ганц доллар ямар гудамджинд хэвтэж байдаг биш. Чи эрхбиш мэдэх байлгүй гэж Жонниг ширээнд суух зуур ээж нь үглэв.

Жонни сонсохтой үгүйтэй. Тэр энэ бүхнийг хичнээн олон удаа сонсов доо. Түүний бодол хүслийн бэлчир явцуухан болохоор фабрикаас ийм хол амьдрах бидэнд ямар олиг байх вэ хэмээн цагийн мөнхөд үглэнэ.

-Ганц долларт өчнөөн идэш уушны юм авч болно. Би алхахнаа алдах юун, харин оронд нь арвихан идэж ууж байя гэж тэр ухаалаг аргагүй өчнө.

Хүү талхаа халуун кофегоор даруулан бараг зажлалгүй, яаруухан гүдсхийтэл залгилаа. Халуун, булингарт шингэнийг тэд ингэж нэрлэх агаад Жонни үнэхээр сайхан

кофе хэмээн нот итгэнэ. Энэ бол түүний сэтгэлд үлдсэн цөөхөн хуурмаг сайхан бодлынх нь нэг. Жинхэнэ кофег бол тэр хэзээ ч амсаж үзээгүй.

Талхнаас гадна бас зүсэм хүйтэн гахайн мах бий. Ээж нь хүүдээ хоёр дахь аягыг нь дүүргэж барив. Талхаа идчихээд дахиад өгөх нь үү гэсэн шиг өлбөлзөн нүд өргөжээ. Ээж нь түүний нэхүүл харцыг анзаарснаа,

-Битгий шуналтаад бай. Чи өөрийнхөө хувийг хүртээ биз дээ Багачуулд юу үлдээх. вэ гэлээ. Жонни хариу дуугарсангүй. Ерөөс яриа хөөрөөтэй нэгэн биш, гэхдээ

түүний өлөн харц илүүг хүсэмжлэхээ хэдийн больчихсон байлаа. Хүү гомдлын ганц үг хэлсэнгүй. Ийм юманд сургаж хатуужуулсан амьдралын тэр сургууль шиг нь энэхүү хүлцэл дагал нь амьсгаа давчдуулам аймшигтай. Тэр кофегоо ууж уруулаа гараараа шударчихаад хариугүй босохоор завдав.

-Жаахан хүлээ. Дахиад нэг зүсэм авчихаж болох байх, гэхдээ зузаан биш шүү.

Энэ бол ёстойжинхэнэ гарын уран илбэ. Талхны захаас ганц зүсмийг хэрчиж буй дүр үзүүлэнгээ, ээж нь хайрцаг руу түүнийгээ шалавхан

хийчихээд, түүнд өөрийнхөө хоёр
зүсэм талхны нэгийг сэмхэн өгчихөв.

Хүүгээ хуурчихлаа гэж тэр бодсон ч,
илбийг нь тэр мэдэлгүй яахав. Гэхдээ
тэр өчүүхэн сэтгэл зовнисон
шинжгүй талхыг авчээ. Ээж цаг
үргэлж өвчин ороож, хэзээний
хоолонд муу юм чинь гэж хөвүүн юу
ч болоогүй мэт хайнгадуухан
боджээ.

Хуурай талх зажилж буйг харсан эх
нь ширээн дээгүүр өнгийснөө,
өөрийнхөө аяганаас түүнд кофе хийж
өгчээ.

-Яагаад ч юм энэнээс миний дотор

харанхуйлаад байх болж гэж тэр тайлбарлана.

Дотор хүйт оргиулам, тэртээх холын яндангийн урт хүнгэнээн тэднийг огло харайтал нь цочоов. Эх нь тавиур дээр байсан сэрүүлэгтэй цаг руу хяламхийн харвал цагийн зүүнүүд зургаа гучийг зааж, фабрикийн ажилчид дөнгөж нойрноосоо арайхийн өндийж байлаа. Тэр ноосон алчуураа мөрөн дээрээ хаяад, хэвээ алдсан хуучин бүрхээ углав.

-Гүйлгүй горьгүй нь гэж тэр дэнлүүний голыг эргүүлэн, дөлийг нь үлээж унтраах зуураа сандчин

өгүүлээд, хоёул тэмтэчсээр гэрээсээ гарч, шатаар уруудлаа. Гадаа хүйтэн, цэлмэг, Жонни жаеарт жихүүцсэндээ хамаг биеэ хураан бөхийжээ.

Ододын гэгээ арай сүүмийн бөхөх болоогүй, хот түнэр харанхуйд умбажээ. Хөлөө дааж ядан чирсээр Жонни ээжтэйгээ ажин түжин чимээгүй алхсаар, газраас гутлынхаа улыг олипойхон хөндийрүүлье ч гэсэн тэдний тэнхэл үл хүрнэ.

Арван таван минутын дараа ээж нь баруун гар тийшээ эргэж одов.

-Хожигдсон байгаад үзээрэй гэж ээж нь салж одохынхоо өмнө ууртай анхааруулсан агаад удаж төдөлгүй

харанхуй түүнийг залгичихав.

Тэр хариу дуугарсан ч үгүй, замаа хөөн алхав. Фабрикийн хорооллын энд тэндгүй хаалга онголзон, Жонни удалгүй харанхуйд пир пир алхлах ажилчин олонтой нийлэлдэн, түүнийг фабрикийн хаалгаар оров уу үгүй юу яндангийн дуун хоёр дахиа хүнгэнээд, тэр өөрийн эрхгүй дорно зүгт өлийн харав. Урагдсан мэт ундуй сундуй дээврийн зурлага дээгүүр Цэнхигор бүгээн туяа сүүмийн гийжээ. Түүнд оногдож буй өдрийн бүх л гэрэл гэгээ энэ. Хүү гэрэл рүү нуруугаараа эргээд олны дүйвээнд цех рүүгээ орлоо.

Суурь машины урт эгнээнд тэр өөрийнхөө байрыг эзэлсэн бөгөөд түүний урд дүүрэн жижиг дэмартай хайрцагнуудын дээхнэ арай томхон Дамарнууд нүд эрээлжлэм хурдан эргэлдэж, мань хүн жижиг дамрын Маалинган утсыг түүнд ороож өгөх ёстой. Зүдэргээтэй хэцүү ажил биш, гагцхүү гавшгай, шалмаг хөдлөх учиртай. Утас жижиг дамраас томд ороогдох нь яах ийхийн завдгүй, эвшээхийн ч чөлөө үгүй.

Жонни машин лугаа адил ажиллана. Жижиг дамруудын нэг ороогдоод дуусангуут зүүн гараа тормоз мэт өргөж, том дамрыг зогсоохын зуурт дав даруй эрхий, долоовор

хуруугаараа чөлөөтэй утасны үзүүрээс чимхээд авна. Баруун гар нь тэр хооронд шинэ жижиг дамрын үзүүрийг хэдийнээ атгачихсан байдагсан. Энэ бүхнийг тэр хоёр гараараа гайхам хурдан, яг таг амжуулна.

Дараа нь ганц гялсхийн утасны үзүүрийг дамартай зангидаад тавьчихна. Нэхмэлийн зангилаа уях амархан л даа. Тэр яагаад ч билээ шүлэг нойрондоо үүнийг өлхөн хийж чадна хэмээн сайрхаж явсан удаа бий. Хэрэг дээрээ үнэхээр тийм байсан. Жонни тоо томшгүй үргэлжлэгч нэхмэлийн зангилааг урт шөнийн туж зангидах нь байдаг л

ЮМНЫ НЭГ.

Зарим хөвгүүд ажлаасаа залхаад
жижиг дамрын утас дуусчихаар
солилгүй суурь машинаа хоосон
ажиллуулаад орхичихдог явдал бий.
Гэхдээ мастер энэ мэтийг харалгүй
хайчив гэж. Мэлэрч орхисон
Жоннигийн хөршийг тэр нэг удаа
барьж аваад чихийг нь тасдчих нь уу
гэмээр мушгиснаа,

-Жонниг хараач, ингээд ажиллаж
чадахгүй нь үү хэмээн зандарч
билээ.

Жоннигийн дамрууд болохоор эцэс
төгсгөлгүй эргэлдэнэ, гэхдээ магтаал

түүнийг баярлуулахаа нэгэнт
өнгөрсөн. Тийм цаг байсан...
Харамсалтай нь дээр үед, аль
дивангарын юм. Өөрөөр нь үлгэр
жишээ авч буйг санасан хүүгийн
мэлгэр хайнга царайд ямар ч бодол
үл тодорно. Тэр үлгэр жишээ
ажилчин, өөрөө үүнийгээ мэднэ.
Түүнд энэ тухай байнга хэлдэг,
магтаал эв энгийн, ердийн зүйл
хойно түүний хувьд аль хэзээний үнэ
цэнээ алдаж, үлгэр жишээ
ажилчнаас тэр гайхмаар үлгэр
жишээ машин болж хувирчээ. Хэрэв
түүний ажил ахихгүй болбоос суурь
машин бас яг адилхан түгдчинэ. Энэ
бол түүхий эд тааруухан байна гэсэн

үг. Төгс төгөлдөр хадаасны суурь машин хадаасаа буруу зөрүү хэвлэнэ гэж байдаггүй шиг түүний хувьд алдана гэж хол.

Үүнд гайхах юун. Тэр бүхий л амьдралынхаа турш машинтай зүйргүй ойр дотно байсан. Машин түүний мах цусанд хүртэл орчиж, ямар ч гэсэн түүнийг хүний зэрэгт хүргэсэн гэж ч хэлж болмоор. 12 жилийн өмнө энэ фабрикийн нэхэх цехэд хөөрхөн хөл үймээн дэгджээ. Тулгар биетэй Жоннигийн ээж өвдөж эхэлжээ. Түүнийг тачигнаж түжигнэсэн суурь машинуудын хооронд шалан дээр хэвтүүлээд настай хоёр нэхмэлчнийг дуудаж,

мастер тэдэнд хамжилцав. Хэдхэн минутын дараа нэхмэлийн цехэд нэг шинэ хүн нэмэгдсэн бөгөөд мөнөөх шинэ хүн нь Жонни. тэр

нэхмэлийн суурь машины гүжигнээн тачигнаан, хяхнаан дунд мэндэлж, анхныхаа амьсгааг авахдаа хөвөнгийн тоос бужигнасан. чийгт, бүгчим агаараар цээжээ дүүргэсэн билээ.

Амьдралынхаа анхны тэр цаг мөчид уушгиа тоосноос зайцуулах санаатай хэзээний ханиалгаж эхэлсэн бөгөөд мөн тийм шалтгаанаар өнөөг хүртэл бөгшүүлсээр яваа.

Жоннигийн дэргэд ажиллаж буй хөвүүн битүүхэн гиншсэнээ, хамраа шуухитнуулна. Алсаас түүн рүү юм л бол заналтайяа хялалзах мастерыг үзэнгүүтээ түүний царай тэчъяал, үзэн ядалтаар барайгаад ирэх ч, хоосон дамар харин үзэгдэхээ больжээ. Өмнөө эрчлэн эргэж байгаа дамар руу хөвгүүн адгийн муухай хараал зүхэл хашгичих авч ямар ч авиа дуун хол үл дуулдана. Цехэд нүргэлэн буй тачигнаан түүний хашгирааныг хана мэт хааж орхино.

Харин Жонни юунд ч үл сатаарна. Тэр ертөнцийн юухныг ч үл тооно. Эцэс сүүлдээ юм бүхэн идэгдээд

уусчихдаг хойно. Энэ мэтийн үйл явдлыг тэр өчнөөн харж байсан бус уу. Мастертэй харгалдах нь машинтай тэмцэлдэх аятай өчүүхэн үр дүнгүй хэрэг юм шиг түүнд санагдана. Тов тодорхой байдлаар ажиллаж, тодорхой ажил үйлийг биелүүлэхийн төлөө машиныг бүтээдэг. Мастер ч бас адилхан.

Тэгтэл арван хоёр цагийн алдад цехэд үймэлдээд явчих нь тэр. Ямар нэгэн нууцлаг далд замаар үймээн сандчаан тэр дорхноо бүхэнд халдварлав. Жоннигийн нөгөө талд ажиллаж байсан ганц хөлт балчир хөвгүүн яаруухан хазгас хазгасхийн хоосон вагон руу очоод, тийш

харайн таягтай юутай хээтэйгээ
нүднээсдалдарчээ. Эрхлэгч, үл таних
залуугийн хамт цехэд орж ирсэн
бөгөөд танихгүй хүн Жоннигийн
ойлголтоор сайхан хувцасласан,
цардсан дотуур цамцтай боловсон
эр, тэр байтугай байцаагч эрхэм
байлаа.

Суурь машинуудын хоорондуур
өнгөрөхдөө байцаагч түшмэл
хүүхдүүдийг цоо ширтэх аж. Тэрбээр
хоолойгоо гарилттал хашгирах агаад
Учиргүй хүчилснээс царай нь хачин
жигтэй үрчилзэн, гүймэг харц нь
Жоннигийн дэргэдэх эзэнгүй суурь
машин дээр туссан ч юм хэлсэнгүй
өнгөрөв. Жонни бас түүний

анхаарлыг өөр дээрээ татаахлаа.
Гэнэт зогссоноо сайхь эр түүний
бугуйнаас дээхнүүр гарыг нь тас
атган, суурь машинаас холдуулав.
Тэгснээ гайхан дуу алдаад тэр
дороо тавив.

-Жаахан туранхай байгаа биз гэснээ
эрхлэгч байцаагч руу тавгүйрхэн
хяламхийгээд учиргүй хөхөрнө.

-Яс арьс гэсэн хариу дуулдав.

-Энэ хөлийг нь хар даа. Сульдаатай
хүүхэд байна, эхний үедээ яваа,
эргэлзэх юм алга. Сүрьеэ түрүүлээд
амь голыг нь тэмтэрчихдэггүй юм
гэхэд унадаг өвчин дуусгах нь

гарцаагүй. Жонни сонссон ч юун тухай яриад буйг нь ойлгосонгүй, тэгээд ч юун тэр ирээдүй хойчийн гай түйтгэртэй манатай айсан ч үгүй, байцаагч түшмэлийн царайнаас арай дөтийн илүү бэргэм аймшиг түүнийг түгшүүлжээ.

-За хүү минь, яг үнэнээр нь хэлэгтүн. Чи хэдэн настай вэ хэмээн байцаагч чихэн дээр нь бөхийж ирээд хэлэв. Хэлэх ч гэж уугчин хашгирав.

-Арван дөрөвтэй гэж Жонни хэлсэн агаад өөрийнхөө уушигны хамаг чадлаар худал хэлэв. Өглөөжингөө уушгинд нь орсон хамаг тоосыг пурхийж гартал тийм чанга худал

хэлсэн болохоор мань хүн удтал хув хуурай, тасалданги бөглүү дуугаар ханиалгав.

-Харахад хэзээний арван зургаатай шүү гэж эрхлэгч үг нэмэрлэнэ.

-Жар гарчихаж гэмээр юм хэмээн байцаагч үгийг нь тасална.

-Энэ хэзээний ийм.

-Хэдийнээс ийм болчихоо вэ? гэж байцаагч шавдуулав.

-Хэдэн жил ч болов доо. Том болж шалихгүй юм байна шүү дээ.

-Залуужихгүй нь мэдээж гэж хэлмээр байна. Энэ бүх хугацаанд тэр энд ажилласан уу?

-Хааяа нэг завсарлаж байсан. Гэхдээ энэ чинь шинэ хууль хүчин төгөлдөр болохоос аль өмнө гэж эрхлэгч яаруухан нэмж хэлэв.

-Энэ суурь машин эзэнгүй юм уу? гэж Жоннигийн хажуухантай хагас ороогдсон дамарнууд салхи татуулан эргэх хүнгүй зай руу заангаа байцаагч түшмэл асуув.

-Тийм юм байлгүй гэснээ эрхлэгч мастерыг занган дуудаад, суурь машиныг заан чихэнд нь юу ч юм бэ

хашгирлаа.

-Эзгүй гэнэ хэмээн тэр байцаагчид тайлбарлав.

Ашгүй тэд цаашаа яваад өглөө. Гай түйтгэр тойрлоо хэмээн сэтгэл нь амарсан Жонни ажилдаа оров. Харин ганц хөлт хөвгүүний аз дутагч Өлөн нүдэт байцаагч түүнийг жижигхэн вагоноос чирч гаргасан агаад хүүгийн уруул чичрэн царай нь төсөөлшгүй, туулж давшгүй золгүй явдалд дайрагдсан нэгний царай лугаа адил зэвхийрээд ирэв. Мастер тахир дутуу хүүг амьдралдаа анх харж буй аятай гайхсан янзтай гараа

алдлана. Харин эрхлэгч сэтгэл
дундуурхан ярвайлаа.

-Би энэ хүүг танина гэж байцаагч
түшмэл шавдуухан өгүүлээд: -Энэ
арван хоёрхон настай. Энэ жил би
түүнийг гурван ч фабрикаас халахыг
тушаасан юмсан. Танайх дөрөв дэх
нь. Тэр ганц хөлт хөзгүүн рүү
эргэснээ,

-Чи чинь сургуульд явна гэж над
амлаа биз дээ, ам өчгөө өгөөгүй
билүү? гэв.

Хүүгийн нулимс сул асгачихав.

-Өршөө, ноёнтоон, миний хоёр нялх

дүү хоёулаа үхчихсэн. Гэрт идэх юм байхгүй.

-Чи юунаас ингэтлээ бүгшүүлээд байгаа юм бэ? гэж байцаагч түүнийг хүнд ялт хэрэгт буруутгасан янзтай ширүүн асуух аж.

Өөрийгөө зөвтгөж байгаа аятай ганц хөлт хүү,

-Энэ юу ч биш ээ, би өнгөрдөг долоо хоногт ханиад хүрчихсэн юм, ноёнтоон, ердөөл энэ. Эцсийн бүлэгт байцаагч хөвгүүнийг цехээс авч одов. Түгшиж уурласан эрхлэгч тэдний араас дагалдлаа. Тэр бүхний дараа сая хамаг юм хуучин янзандаа

оров. Урт өглөө, түүнээс хавьгүй урт өдөр шувтарч, яндангийн дуун ээлж дууссаныг хангинатал зарлахуйяа, Жонниг фабрикийн хаалгаар гарч ирж ахуйд харанхуй нөмөрч, энэ хугацаанд нар хурмастын алтан шатаар хэдийн мандсанаар үл барам, өнө дэлгэр илчээрээ ертөнцийг ивээсээр баруун зүгт доошлон доошилсоор дээврийн элбэн салбан бараан зураасны цаагуур шингэж амжжээ.

Оройн хоол гэр бүлийн ганц цугларалт. Зөвхөн энэ үед Жонни эрэгтэй, эмэгтэй дүү нартайгаа нүүр учирдаг буй заа. Энэ бол жинхэнэ мөргөлдөөн, өөрөө тэр даанч дээ

гэмээр өтөл хөгшин, харин тэд түүнийг доромжилж буй юм шиг цэл залуухнаараа, энэ мөрөөдөөд хүршгүй орь залуу танхил ахуй түүнийг өөрийн мэдэлгүй эвгүйцүүлдэг билээ. Тэр үүний учрыг үл ухна. Түүний өөрийнх нь хүүхэд нас тэртээ алсад хойно хол хоцорсон болохоор арга ч үгүй биз.

Түүнд дэндүү мунхаг тэнэг явдал мэт санагдах энэ амгалан, цолгиун төрхгүй ааш авир үглээ уймраа өвгөн шиг болчихсон Жоннигийн дурыг гутаахыг яана. Тэр тавган дээрээ тонгойн чимээгүйхэн ярвайх агаад эд удахгүй ажилд оролгүй хаачив гэж, энэ нь тэднийг нуга хуга

дараад, өөрөө ямар билээ, яг түүн лүгээ адил төлөв томоотой, намба төрхтэй болгоно гэсэн хорон бодлоор сэтгэлээ тайтгаруулж байлаа. Бүх л эгэл хүний ёсоор Жонни хамаг юмыг өөрийнхөө хэмжүүрээр хэмждэг билээ.

Оройн хоолон дээр ээж нь өөр өөр янз маягаар нэг юмаа ахин дахин Давтсаар, би чадах ядахаараа хичээгээгүй гэж үү хэмээсээр байсан учир ядмагхан зоог өндөрлөв үү үгүй юу, Жонни сэтгэл нь онгойсон янзтай сандлаа түлхчихээд бослоо.

Унтахаар хэвтэх үү. гудманд гарах үү гэж минут хэртэй эргэлзсэнээ эцэстээ сүүлчийнхийг нь сонгов. Гэхдээ тэр

хол явсангүй, хавчиг мөрөө
нугдайлган, тохойгоороо өвдгөө
тулаад, алгаараа эрүүгээ тагласан
шиг шатан дээр суулаа.

Тэр ийнхүү суухдаа юун тухай ч
бодсонгүй, санагалзсангүй. Тэр
зүгээр амарч, ухаан бодол нь унтаа
байлаа. Түүний эрэгтэй, эмэгтэй дүү
нар бөөн шуугиан үймээн дэгдээж,
наадаж буй хүүхдүүд рүү гудамжны
дэнлүүний хурц гэрэл мэлсхийтэл
тусгах агаад Жонни цухал арвинтай,
юм л бол дүрсхийгээд явчихдагийг
тэд андахгүй ч түүнийг өдөөд орхиоч
хэмээн ямар нэгэн чөтгөр шулам
тэднийг хатгаад буй аятай байлаа.
Тэд гар гараасаа бариад, хөлөө

хэмнэлтэйеэ товшин, түүний нүдэн дээр олиггүй үглээ, доогтой дуу дуултал, Жонни эхлээд шазав татавхийн мастеруудаас сурсан хараал зүхлээрээ жаалуудыг булж гарав. Төдөлгүй үүний тус үгүйг ойлгоод, эр биед хүрсэн эрхэмийн өөг бардам зангаар дахин царай барайлган дуугаа хураажээ.

Жоннигийн удаахь дүү, хоёрдахь хүү, арван настай Вилли үймээний гол эзэн нь. Жонни түүнийг учиргүй эвийлж энхрийлээд байдаггүй, түүний төлөө тэртэй тэргүй биеэ зольж, Виллид найр тавих үргэлжийн шахалт шаардлагаас болж амьдрал нь аль эрт бүүдийж

орхисноос хойш арга ч үгүй. Дүү нь түүний өмнө үлэмж их өртэй атлаа ачийг нь ер боддоггүй гэдэгт Жонни үл эргэлзэнэ. Тэгээд ч Виллийг харж асрах зайлшгүй үүрэг Жоннигийн тоглож наадах ёстой байсан тэр он жилүүдийг, хүүхэд насных нь дийлэнх хэсгийг түүнээс хулгайлчихсан билээ. Вилли тэр үед цурав нялх, харин ээж нь өнөөгийнх шигээ өдөржингөө фабрикт ажиллан, Жоннид аав, ээжийгээ орлох үүрэг давхар ногддог байсан.

Том ахынх нь асрамж халамж, өөрийгөө зольсон нь хараажаар Виллид зохижээ. Түүний бие бялдар

уян, бярлаг шөрмөслөг, нуруугаар
Жоннигоос намгүй, түүнээс хавьгүй
зузаан махлаг, нэгнийх нь хамаг цус.
амь амьдралынх нь тэнхээ тамир
нөгөөгийнхөө судсанд юүлэгдсэн
мэт. Жонни болохоор эцэнгэр
хатингар, ноомой дуугай, үлбэгэр
атал дүүгийн.х нь омог хүч
цээжиндээ багтаж ядна.

Жаалууд нөгөө доогтой дуугаа улам
улам чанга хашгирсаар, Вилли
арвага сарвага цовхочсоор ойртоод
ирэв. Бүр хэлээ гаргаад эхэллээ.
Жонни гэнэтхэн зүүн гараараа
дүүгийнхээ хүзүүнээс тас базаад,
баруун гарынхаа нударгаар хамар
дундуур нь өгчилгөж орхив. Нударга

нь өрөвдөм яс арьс боловч хатуу чанга гэж тоймгүй. Виллигийн гол зурам орь дуу үүнийг хэлээд өгч байлаа. Айсан жаалууд орилоон чарлаан болж.

Жонни. Вилли хоёрын охин дүү Женни гэр рүүгээ ум хумгүй ухасхийлээ.

Жонни дүүгээ түлхсэнээ омогтой гэгч нь өшиглөөд, дараа нь бүр татаж унагаад, нүүрээр нь газар мөргүүлж эхлэх нь тэр Түгшүүр зовлон, эх хүний уур хилэнгийн биелэл болсон ээж нь яг амжиж ирэв.

-Яах гээд өдөөд байсан юм, тэр гэж

Жонни түүний зэмлэлийн хариуд
ечөөд: -Миний туйлдаж гүйцсэнийг
харахгүй байгаа юм уу?

-Би чамаас өндөр шүү гэж нулимс,
цус. шавар шавхай болсон
царайгаараа ээжийнхээ тэврээс ах
руугаа эргэнгээ Вилли хашгираад: -
Би чамаас өндөр болсон, удахгүй
бүр ч өснө! Тэр үед үзүүлээд өгнө
дөө!Хараарай.

-Тийм том болоод борви чинь
тэнийчихсэн юм бол ажил
хиймээрсэн дээ чи гэж Жонни шазав
татавхийв.

-Ажил хийх цаг чинь болж, чамд энэ

л дутаад байгаа юм байна. Ээж чамайг фабрикт оруулах байлгүй.

-Юу, амных нь салиа арилаагүй амьтныг хэмээн эх нь өрвөсхийн уурлаж: -Ийм балчир амьтныг хаа ажиллуулах гээ вэ?

-Би анх эхэлж байхдаа энэнээс балчир байсандаг.

Гомдол цухлаа цааш нь уудалж тайлмаар санагдан Жонни амаа аль хэзээний ангайсан ч гэнэт бодлоо өөрчлөөд, царайгаа барайлган эргэж гэртээ орвоос гал тогооноос дулаан орог гээд өрөөнийх нь хаалгыг дэлгэчихэж. Бүүдгэр харанхуйд

хувцсаа тайлах зуураа хөрш
авгайтай эхийнхээ ярьж буйг дуулав.
Эх нь уйлж, түүний үг өрөвдөм эхэр
таталт, мэгшээнтэй холилджээ.

-Жонни яачихсаныг ойлгохоо
болилоо гэж эх нь хэлээд: -Түүний
ийм байхыг би хэзээ ч үзээгүй.
Томоотой, сахиусан тэнгэрээс
өөрцгүй номхон байдагсан. Одоо ч
сайн хүү хэвээрээ л даа хэмээн тэр
хүүгээ өршөөх гэж яарна.

-Ажлаас хойш сууна, лазагнана гэж
үгүй, харин арай дэндүү эрт
ажиллаж эхэлсэн нь үнэн шүү. Би буг
/утай гэж үү? Би чадах ядахаараа
хичээсэн!

Тэгснээ эхэр татан мэгших дуулдав.
Харин Жонни нүдээ аних зуурт,

-Яг үнэн, залхуурдаггүй хэмээн
бувтнана.

Маргааш өглөө нь шүлэг нойрны
бачуухан тэврэлтээс ээж нь түүнийг
ахин суга татаж, өлөн зэлмүүн
өглөөний унд, түнэр харанхуй
дундуурхи урт зам, фабрикийн
хаалгаар орохын өмнө эргэн
нуруугаа харуулчихдаг өглөөний
бүгээн гэгээ. Олон өдөр хоногуудын
бас нэгэн өдөр нь, гэхдээ бүгд
хоорондоо ижилхэн, адилхан.

Зөвхөн өөр ажилд шилжүүлж, өвчин

тусахад түүний амьдрал өөрчлөгдөн хувирч байсан билээ. Зургаан настайдаа тэр Вилли, бусад дүү нараа харж асарсаар, долоотойдоо дамар солихоор фабрик руу гэлдэрдэг болж, наймтайдаа өөр газар ажилладаг болсон билээ. Шинэ ажил нь гайхмаар амархан, дэргэдүүрээ өнгөрч буй даавууны хөвөрсөн их намирааг гартаа саваа барьж суучихаад залаад байхнаа болчихно, даавууны энэ их цуваа машины эрүү амнаас савирсаар, халуун хүрдний доогуур орж, цаашаа хаашаа ч юм алга болно. Жонни тийнхүү өдрийн гэгээ үзэлгүй, нүд гялбам шатдаг хийн дэнлүүн дор

нэг газарт суун суусаар. машины эд анги болон хувирчээ.

Цехийн чийгт, аагим халууныг эс тооцвоос Жонни тэр ажил дээр өөрийгөө аз жаргалт хүмүүнд тооцож, тэр үед залуу ч байж, мөрөөдөж санааширна, хоосон мөрөөдлөөр өөрийгээ цэнгүүлэхнээ ч ядах юмгүй. Уур савссан даавуу дэргэдүүр нь эцэс төгсгөлгүй хөвөрч буйг харж байхдаа гайхамшигт мөрөөдөлдөө умбачихна. Гэхдээ ажил нь ямар ч хөдөлгөөн, ухаан бодлын өчүүхэн хүч үл шаардана. Тийнхүү хөвгүүн улам улам бага мөрөөдсөөр, ухаан санаа нь мунхарч хөшсөөр, харин долоо хоногт хоёр

доллар авдаг болжээ. Тэр хоёр доллар нь өлсгөлөн, ходоод дундуурхан идэхийн ялгааг яг таг илэрхийлнэ.

Тэгтэл есөн нас хүрэв үү, үгүй юү тэр ажлаа алдав. Буруутан нь цагаан бурхан. Эдгэж боссоныхоо дараа шилний үйлдвэрт ажилд орсон агаад цалин нь овоо, харин ажил нь хөөрхөн үр шаардана, хийснээрээ авдаг учир эвлэг шалмаг байх тусам төдий ихийг авна. Юуны төлөө . хичээж зүтгэх нь тодорхой хойно, Жонни биширмээр сайн ажилчин болжээ

Ажил нь хялбархан, жижигхэн

лонхнуудад шилэн бөглөө уяна
Жоннигийн бүсэнд өчнөөн боодол
уяа багсайлдан, хоёр гараараа зэрэг
ажиллахын тулд тэр лонхнуудыг
өвдгөн завсраа тас хавчина. Суугаа,
бөхийсөн байрлалаас болж түүний
хавчиг цээж улам авчийн, цээж нь
арван цаг туж атийгаастай учир
уушгинд ямар олиг байв гэж дээ.
Гэхдээ тэр өдөрт гурван мянга
зургаан зуун лонхны бөглөөг өлхөн
уячихдагсан. Эрхлэгчийн түүгээр
бахархаж бахдах нь тоймгүй, бүр
түүнийг үзүүлж харуулахаар
сонирхогч, үзэгч нар дагуулж
ирэхийг яана. Арван цагийн дотор
гурван мянга зургаан зуун ширхэг

лонх Жоннигийн гараар дамжина.
Энэ бол машины төгс төгөлдөр
чадамжид тэр бүрэн хүрчээ гэсэн үг.
Ганц ч илүү дутуу хөдөлгөөн үл
хийнэ. Түүний хатингар гарын
хөдөлгөөн бүр, савхан хурууных нь
дохилт бүр гайхам хурдан, яг таг.
Ийм ажил зүйргүй их хүч шаардана.
Сүүлдээ Жоннигийн оюун бодол
хүчрэхээ болив. Хүү нойрон дундаа
шөнө давхийн сэрднэ. Өдөр нь юун
өөр юманд сатаарах, амарч тавирах
манатай, цагийн мөнхөд биеэ
хураагаастай, гар нь өөрийн
мэдэлгүй татваганан салганаж,
царай нь шороон хар, байсхийгээд
бүгшүүлнэ. Хатингар, цээж дотор

муутай хөвгүүн сүүлдээ уушгины хурц хатгаа тусаад шилний үйлдвэр дэх ажлаасаа хагацав.

Тэгээд нэгэн цагт анх ажилд орж байсан маалингын фабриктаа эргэж ирэв. Сайн ажилчин байсан болохоор тэр эндээ ахиж дэвшинэ гэж бодолгүй яахав. Цаг нь болохоор түүнийг цардуулын цехэд шилжүүлнэ, дараа нь нэхмэлийнхэд, цаашаа харин бүтээмжээ олигтой нэмэхээс өөр юу үлдээ аж.

Өдгөө машинууд хавьгүй хурдан ажилладаг болж, Жоннигийн оюун ухаан улам бүдгэрч мунхарчээ. Тэр урьдынх шигээ мөрөөдөхөө ч болив.

Уг нь хөвгүүн нэг удаа бүр хөл алдан дурласан. Хүрднээс хөврөгч даавууны урсгалын дэргэд түүнийг зогсоосон тэр үед энэ явдал болсон бөгөөддурлал хайрыг нь эзэмдэгч нь эрхлэгчийн охин, хэдийн нас биед хүрсэн бүсгүй. Мань хүн тав зургаан удаа ч билүү, түүнийг зөвхөн алсаас харсан. Гэхдээ энэ хамаа юун.

Жонни дэргэдүүрээ хөврөгч даавуун дээр гэрэлт сайхан ирээдүйгээ зурна. Суурь машиныхаа ард гайхамшгийг бүтээж, ер бусын машин дархлан, чадал хүсэл төгөлдөр зохион бүтээгч болчихоод, эцсийн бүлэгт хайрт бүсгүйгээ халуун цээжиндээ тэвэрч, духан дээр нь эгэл боргилхон

үнсэх бүлгээ.

Өнөөгийнх шигээ ингэтлээ
өтөлчихөөгүй, туйлдаж
бохирчихоогүй, бас ч хайрлаж
дурлахтайгаа байсан аль элэрсэн
цагийн үйл явдал, тэгээд ч нөгөө
бүсгүй нь нөхөрт гараад алсад
одсон, түүний сэтгэл зүрх ч
харанхуйлаад эхэлсэн. Гэхдээ тэр цаг
илбэ шид, ер бусын гайхамшгийн
цаг байсан болохоор бусад хүмүүс
өгөөмөр сайхан сэтгэлт дагинаст
итгэдэг асан үеэ дурсдаг шиг мань
хүн тэр үеэ байн байн санадаг билээ.
Жонни өөрөө шидэт дагинас, Санта
Клауст хэзээний итгэдэггүй, харин
хүсэл, санаашрал нь уур савссан

даавуун дээр дүрслээд зурчихдаг баяр жаргалант ирээдүйн тухай өөрийнхөө зурагт л хязгааргүй итгэдэгсэн.

Жонни дэндүү эрт насжижээ. Долоотойд нь түүнд анхных нь цалинг өгч ахуйд тэр өсвөр нас руугаа хэвийж, толгой даасан давилуун байдалд автаад, эх хөвгүүний харьцаа хувьссанаар барахгүй ивээн тэжээгч, ажилтай хүмүүний ёсоор хүү нь эхтэйгээ эн зэрэгцээд ирж буй аятай байлаа. Шөнийн ээлжинд хагас жил ажилласны хойно арваннэгэн настайдаа тэр эрийн цээнд хүрсэн хүн гэдэг үгийн утгыг бүрнээ

эзэмдэв. Нэг ч хүүхэд шөнийн
ээлжинд ажиллаж чаддаггүй хойно
хүүхэд хэвээрээ үлдэнэ гэж юу
байхав.

Түүний амьдралд сэтгэл догдлуулам
үйл явдал хуруу дарам цөөхөн
тохиолдсон. Ээж нь нэг удаа
Калифорнийн хэр чавга жаахныг авч
өгсөн. бас тэр хоёр ч удаа цөцгий,
жимсний охь, шоколад хутгасан
чанамал амттан хийж билээ. Тийм
ээ, тэр бүхэн үнэхээр гайхам үйл
явдал байжээ. Хөвгүүн тэр тухай
сэтгэл догдлон дурсдаг. Тэр үед эх нь
"Хөвдөг арал" нэртэй тансаг чамин
амттаны тухай түүнд ярьж, хэзээ
нэгэн цагт заавал хийж өгнө хэмээн

амласан юмсанж. "Чанамал амттанаас хавыүй сайхан" гэж эх нь ярьсан агаад Жонни ширээнд сууж "Хөвдөг арлыг" амтлах тэр өдрийг, энэ мөрөөдөл нь хэзээ ч үл бүтэх хүсэл болон замхран замхартал он жилийн уртад өнөөг хүртэл горь тасралгүй хүлээсээр байгаа.

Яаж ч яваад билээ, тэр нэг удаа гудамжнаас хорин таван центын зоос олжээ. Энэ бас түүний амьдралын жигтэй том, эцэсгүй эмгэнэлт үйл явдал байж. Уг нь яах ёстойгоо мөнгө олохоосоо хэзээ урьд мэдэж байсан л даа. Гэр нь бахь байдгаараа идэх уух юмгүй хов хоосон, хагас сайн бүрт цалингаа

гэртээ авчирдаг шигээ тэр мөнгийг ормондоо аваад ирдэг байсан юм. Үүрэг нь ийм тов тодорхой боловч Жонни хэзээ халаасандаа мөнгөтэй явлаа, амттан гэж бодохоос шүлсэндээ цацаж үхэм, гагцхүү онцгой баяр ёслолын үеэр түүнд олддог ганц хатуу чихрийг санахуйяа хорхой нь гозогноно.

Тэр өөрийгөө хуурах гэж оролдсонгүй, нүгэл хилэнц үйлдэж буйгаа ойлгохын сацуу, арван таван центээр нь ходоодны баяр хийж явахдаа нүглээс айсангүй. Арвыг нь тэр хоёр дахь найрандаа хадгалж байтал мөнгө хадгалж сураагүй хүн хаячихалгүй яав гэж. Гашуухан

гэмшил нь түүнийг тарчлааж ахуйд
тэр золгүй явдал бас давхцэж,
дээрхээс оноосон зэм мэт
санагдсанаар барахгүй дэргэдээ буй
өршөөлгүй, аймшигт догшин
тэнгэрийг айдас дүүрэн мэдэрч,
хийсэн нүглийнх нь үрээс болтугай
хагацаадаг тэнгэр түүнийг харж
залхааж буйг мэдсэн

Жонни тэр явдлыг өөрийнхөө цорын
ганц гэмт явдал хэмээн сэтгэл
зүрхэндээ үргэлж санаж явдаг
төдийгүй тэр бүрийдээ зүрх нь
шимшрээд явчихна. Энэ бол түүний
нүгэл, түүний нууц. Гэхдээ бас
түүнийг харуусал ганихрал нь зүгээр
суулгахгүй ээ. Мөнгөө яаж үрэн

таран хийснээ санахаар гол нь харланэ. Түүгээр арай ахиухан юм авчихаж болох байж. Тэнгэрийн тийм яарам бачуу гэсгээлтийг мэдсэн ахул тэнгэрийг аргалж тойрч одоод, хорин таван центээ цөмийг нь дор нь шууд үрчихгүй юү. Тэр энэ хорин таван центийг сэтгэлдээ мянга дахин үрсэн, үрэх бүртээ бүр илүү ашигтай үрсэн гээч.

Бас эцэг нь хэрцгий хайр найргүй хөлөөрөө дэвсчин байж сэтгэл зүрхэнд нь үүрд үлдээсэн холын бүүр түүрхэн нэгэн дуртгал буй. Гэхдээ барим тавим үйл явдлын дурсамж дуртгал гэхээсээ илүүтэй шүлэг нойронд хүнийг эрхгүй эзэмдээд

авдаг, хүмүүний өвөг модон дээр
унтаж эсан тэр цагаас улбаатай
удмын зөн совин гэмээр айдас,
аймшиг дүүрэн бодол.

Өдрийн нартайд энэ дурсамж
Жоннигийн санаанд хэзээ ч үл орно.
Харин шөнө дүлээр оюун бодол нь
бөхөөд, гүн нойронд автах тэр цагт
сэвхийтэл босоод ирнэ. Тэр
айсандаа сэрчихнэ. Тарчлаантай
эхний хэдэн эгшинд бүр хөл дээрээ,
тэр ч бүү хэл орон дээрээ
хөндөлдөөд хэвтэж буй аятай дотор
лалхийгээд явчихыг нь яана. Гэтэл
орон дээр эцэг, эхийнх нь бүүр
түүрхэн бараан дүрс харагдлаа. Эцэг
минь ямархуу хүн байлаа гээд юу ч

санаж үл чадна. Эцгээс нь үлдсэн ганц юм гэвэл түүний аймшигтай хатуу, хайр найргүй том хөл.

Дээхнэ цагийн дурсамжууд түүний тархи толгойд хадаатай бол арай хожуу үеийнх нь онхи ор хоосон. Өдөр хоног бүхэн хоорондоо ив ижилхэн. Өчигдөр, өнгөрсөн жил-мянган жил, минуттай ав адилхан, хэзээ ч, юу ч болоогүй мэт. Цаг хугацааны урсгалыг тэмдэглэгч үйл явдал ч үгүй, цаг ер орчоогүй мэт байрандаа зогсчихоод, гагцхүү цуцахыг үл мэдэх машинууд хөдөлсөөр, хэдий хөдөлгөөн нь улам хурдасч буй ч тэд хаашаа ч үл холдоно.

Арван дөрөв хүрэв үү үгүй юү тэр цардах цех рүү шилжив. Тэр бол үнэхээр том үйл явдал. Цалин авдаг өдрөөс нь илүүтэй сэтгэлд хоногшим ийм үйл явдал болох гэж. Шинэ эрин эхэллээ. Жоннигийн хувьд энэ бол шинэ цаг тооллын эхлэл, ер бусын наадмаас өөрцгүй явдал. "Би цардах цехэд ажиллаж эхлэнгүүт", эс бөгөөс "Тэрнээс өмнө", үгүй бол "Цардах цехэд намайг шилжсэнээс хойш" мэтийн үгээр тэр өгүүлбэр бүрээ эхлэх нь халаггүй байсан.

Арван зургаан насныхаа баярыг Жонни нэхмэлийн цехэд, нэхэгч суурь машин дээр тэмдэглэсэн. Хийснээрээ авдаг хойно эрвийх

Дэрвийхээрээ зүтгэхэд бас учиртай.
Тэр энд ч ялгарч тодорч чадсан,
Фабрик аль хэзээний түүнийг төгс
төгөлдөр машин болгоод
цутгачихсан юм чинь аргагүй шүү
дээ. Гурван сарын дараа тэр хоёр
суурь машин дээр ажиллаж эхэлсэн,
хожим нь гурав, дөрөв болсон.

Хоёр жилийг тэр цехэд үдэхдээ мань
хүн өөр ямар ч нэхмэлчээс хавьгүй
олон ярд, арай аядуу хөдөлгөөнт
олон найз нөхдөөсөө даруй хоёр
дахин арвин их даавуу нэхсэн
юмсанж. Тэр нэхмэл гаргалтын
оргилд бараг хүрэв. Гэрийнх нь
амьдрал ч дээшилжээ. Гэхдээ түүний
цалин гэр бүлийнх нь хэрэглээг давж

гарсан гэж арай хэлж боломгүй, бага хүүхдүүд өсч өндийлөө, тэдний идэж уух нь гүйцэгдэхгүй, сургуульд сурч байна тэд, сурах бичиг ч бас мөнгө, яагаад ч юм Жонниг хурдан ажиллах тусам юмны үнэ төдийчинээ нэмэгдээд, байшин нь улам яайжийгээд байгаа мөртөө байрны үнэ хавьгүй өсчээ.

Жонни өсөөд байгаа хэрнээ энэнээсээ болж улам хатингаршаад тураад байгаа мэт. Дүнсгэр баргар, уур уцаартай, хийрхүү омогтой авир нь дийлээд, жаалууд орь гашуун туршлагаараа том ахаасаа дөлж зэнзийрхэж сурсан агаад орон гэрээ ганц тэжээгчийн ёсоор эх нь түүнийг

хайрлах боловч тэр хайр энхрийлэл айдас аймшигтай сүлэлдэх бүлгээ.

Жоннигийн амьдрал баяр баясгалангүй. Өдрийг үл үзнэ, шөнө нь түгшүүрт мэнэрээн дунд өнгөрнө, бусад үед нь тэр ажиллаж, оюун ухаан нь машины ухаан сэтгэхүйд хувирчихна. Үүнээс бусад юм бүхэн хов хоосон. Тэрбээр юу ч хүсч, хаашаа ч тэмүүлэхгүй, би дээд зэргийн кофе ууж байгаа гэсэн ганц хоосон өөг бодлоор сэтгэлээ цатгана, Жонни бол ухаант амьдралыг үл мэдэгч ажлын мал. Гэхдээ оюун бодлынх нь тэртээх мухарт, ажлын цаг хором бүр, гарынх нь хөдөлгөөн бүр,

булчингийнх нь ширхэг бүрийн
жирвэсхийлт өөрөөс нь онхи ангид
тэмдэглэгдсээр, тэр бүхэн түүнийг
өөрийг нь төдийгүй түүний бяцхан
ертөнцийт гайхал, цочролд умбуулах
тийм нэгэн тайлал төгсгөлд
бэлтгэсээр байлаа.

Зуны шинэдээр Жонни нэг удаа
урьдынхыгаа бодвол туйлгүй эцэж
ядарсан амьтан ажлаасаа ирэв.
Ширээний ард баяр хөөр буцалж
байсан ч тэр үүнийг анзаарах сөхөө ч
үгүй, өмнөө тавиатай бүхнийг
машин лугаа адил хомхойрон
залгиж, дүнсгэр чимээгүйхэн идэж
уужээ. Хүүхдүүд ээх уух болон уруул
амаа долооцгооно. Гэтэл тэр

ганцаараа таг чиг.

-Чи ер нь юу идэж ууснаа мэдэж байна уу? хэмээн эх нь сүүлдээ тэссэнгүй асуугаатахжээ.

Мань хүн юу ч ойлгоогүй янзтай таваг руугаа нэг харснаа дараа нь ээж рүүгээ өлийн харав.

-"Хөвдөг арал" гэж тэр баяр жавхлан дүүрэн зарлав.

-Аа хэмээн давтсанаа тэр хоёр гурав халбагадсаныхаа хойно,

-Өнөөдөр яагаад ч юм би нэг их идмээргүй байна гэж нэмж хэлэв

Тэр халбагаа тавьчихаад сандлаа
хойш түлхэн ядрангуй удаан
өндийлөө

-Би хэвтье дээ.

Гал тогоогоор өнгөрч явахдаа
Жонни хөлөө өмнөхөөсөө улам хүнд
пар пар чирэв. Хувцсаа тайлахын
төлөөнөө тэр хүмүүн бусын хүч
тэнхээ гаргав, туйлдсандаа бүр
уйлав, арга ядсандаа өрөөсөн гутлаа
тайлж дийлэлгүй тэр чигтээ орондоо
шургажээ.

Түүний толгойд ямар ч юм бэ хавдар
ургаж цэлцийгээд, үүнээс ч болсон
уу тархи толгой нь хөшиж,

царцангитна. Савхан хатингар
хуруунууд нь бугуйн чинээ бүдүүрч
хавагнаад, өндөгнийх нь үзүүр
монцойн хавджээ. Бүсэлхийгээр нь
тэсэхүйеэ бэрх янгинана. Хамаг яс нь
шархирна. Өвдөхгүй юм алга. Тэгтэл
толгойд нь сая сая нэхмэлийн суурь
машин тачигнаад, исгэчээд, чихраад,
нүргэлээд эхлэх нь тэр. Эрээлжлэн
эргэх дамарнууд ямар ч зай
завсаргүй пиг, тэд
ододын хоорондуур ороолдон,
урагш хойш үсчин, Жонни мянга
мянган суурь машин дээр ажиллаж,
өнөөдүүл нь эргэлтээ хурдасгасаар
бүр ч түргэн түргэн тачигнаж, тэгтэл
түүний тархи өдөөгдөж ээрэгдсээр,

учир тоймгүй хурдан хурдан
нитгэрэгдэн мянга мянган дамар руу
хөврөгч ганц утас болж хувирав.

Маргааш өглөө нь тэр ажилдаа явж
хүчирсэнгүй, толгойд нь тачигнах
мянга мянган нэхмэлийн суурь
машинаа бодоод амсхийх ч сөхөөгүй
байлаа. Эх нь фабрик руугаа одсон ч
эхлээд эмч рүү хүн явуулж, нөгөөх нь
ханиадны хүнд хэлбэр байна
хэмээсэн бөгөөд Женни ахыгаа
асарч, эмчийн хэлсэн, бичиж
үлдээсэн бүхнийг гүйцэлдүүлэв.

Өвчин хүндхэн ширвэж, долоо
хоногийн дараа Жонни сая чүү
чамай хувцсаа эгэлдэргэлж, өрөөн

дотроо салдархийлэх тэнхэлтэй болов. Дахиад долоо хоноход ажилдаа орохтойгоо болно гэж эмч хэлжээ. Түүнийг овоо хөнгөрч сэргэсэн анхны өдөр, бүтэн сайнд нэхэх цехийн мастер түүнийг эргэж ирээд, Жонни цехийн маань хамгийн мундаг нэхэгч, түүнд ажлыг нь хадгалж байгаа, ирэх даваа гариг хүртэл очихгүй байхнаа болно гэж эхэд нь хэлжээ.

-Чи нэг урмын үг хэлж болноо доо, Жонни хэмээн эх нь сэтгэл зовонгуй өгүүлэх аж.

-Одоо хэр ухаан бодол нь тэгшрээгүй, жигтэйхэн муудсан шүү

хөөрхий гож тэр гэмшсэн аятай
зочиндоо тайлбарлав.

Жонни нугдайж суучихаад, шал руу
цоргитол ширтсээр байлаа.

Мастерыг гарч одсоны дараа тэр
янзаараа өчнөөн удаан суув.

Гудманд урин дулаахан, үдийн
хоолны дараа тэр шатан дээр суух
санаатай гарч ирсэн бөгөөд уруул нь
хаа нэг ширвэгнэн, эцэс төгсгөлгүй
ямар нэгэн тоо тоололд умбаж
орхиж гэлтэй.

Маргааш нь нар налайтал төөнөж
эхлэхүйеэ тэр дахиад шатан дээрээ
гарч суулаа. Гартаа харандаа, цаас
бариад, учиргүй хүчлэн юуг бүү мэд

байдгаараа тоолж гарав.

-Саяын дараа ямар тоо байдаг билээ. Тэрийг нь яаж тоолдог юм бэ? гэж Виллиг үд дунд сургуулиасаа ирэв үү, үгүй юү асуугаатахлаа.

Ашгүй үдэш гэхэд тоолж дуусав. Ийнхүү Жонни өдөр бүхэн, гэхдээ шатан дээрээ харандаа цаасгүй гарч ирээд, гудамны нөгөө талд сүглийж буй өнчин ганц мод руу жигтэй хянамгай хараад мэлэрчихдэг болов. Тэр энэ модыг өчнөөн цагаар ширтэж, салхи мөчрүүдийг нь найгуулж, навчсыг нь сэрчигнүүлэхэд бүр бах нь ханасан аятай байна. Жонни энэ нэгэн долоо хоногийн

турш өөрөө өөртэйгээ уртын урт
яриа дэлгэв. Бүтэн сайнд аанай л бас
шатан дээр нугдайж суухдаа
хэдэнтээ түсхийтэл инээчихсэн нь
хичнээн жил түүний инээхийг
дуулалгүй төсөөрчихсөн эхийг нь
цочоов Маргааш өглөө нь үүрийн
үнэгэн харанхуйгаар хөвгүүнээ
сэрээхээр ор руу нь очдогоороо
очвоос долоо хоногийн дотор нойр
нь ханасан янзтай төвөггүй сэрлээ.
Эсэргүүцэж сүйд болсонгүй, урьдынх
шигээ хөнжлөө чангааж таталсангүй,
харин бүр тайван налайж хэвтээд
амгалан дуугаар

-Ингээд яах юм бэ, ээж ээ гэлээ.

-Хоцрох нь гэснээ тэр арай сэрээгүй юм болов уу гэж боджээ.

-Би унтаагүй байнаа ээж ээ, гэхдээ хамаа алга, ингээд яах юм. Чи явсан дээр биз. Би босохгүй.

-Ажилгүй болох чинь дутаа юу? хэмээн ээж орь дуу болов.

Тэр өглөө эх нь өөрөө ч ажилдаа гарсангүй. Энэ өвчин түүний мэдэх өвчин бүхнээс хамгийн адгийнх нь, хумхаа, дэмийрэл түүнийг яагаад ч гайхуулахгүй, айлгахгүй, гэтэл энэ цагаан солио юу! Хүүгээ хөнжлөөр нь хуччихаад Женниг эмч рүү гүйлгэв.

Эмчийг ирэхэд Жонни амгалан тэнүүн нойрсож байсан бөгөөд мөн тийнхүү тайван сэргэж, судсаа бариулав.

-Онцын юм алга даа, арай дэндүү турж эцжээ. Өөр юу гэхэв дээ. Юун солиорол... Бүр яс арьс гэж эмч хэлсэн юм.

-Манай энэ хэзээний ийм хүүхэд байгаа юм гэж эх нь өгүүлэв.

-Одоо явж үз ээж минь, намайг тайван унтуулаад өгөөч.

Жонни үүнийг түргэн, тайван хэлсэн шигээ нөгөө тийшээ тайван аядуухан

эргээд унтаж орхилоо.

Арван цагт тэр сэрээд босч, гал тогоондоо ортол эх нь айдас дүүрэн харцаар угтав.

-Би явлаа, ээж ээ. Салах ёс хийе дээ гэж тэр палхийтэл хэллээ.

Тэр хормогчоороо нүүрээ дараад, сандал дээр лагхийтэл унаснаа гашуунаар гиншив.

Жонни тэвчээр заан хүлээлээ.

-Би бүр мэдээд байсан юмаа гэж тэр нулимсандаа хахаж цацан хэлснээ, -
Чи хаашаа явах юм бэ гээд

нүүрнээсээ хормогчоо зайлуулан,
ядаж сониучирхал хүртэл үл тодрох
зовлон гуниг мэлмэрсэн нүдээ
Жонни руу тусгав.

-Мэдэхгүй... Хаашаа ч яахав дээ.

Гудамны нөгөө талд сүглийсэн мод
Жоннигийн нүдний өмнө жигтэйхэн
тодхон үзэгдээд ирнэ. Тэр мод
түүний ухаан санаанд тэгтлээ
хоногшсон бөгөөд дуртай цаг,
хором, мөчдөө түүнийг сэтгэлдээ
олж харахнаа даанч ядамгүй.

-Ажлаа яах вэ? хэмээн эх нь
хоолойгоо чичрүүлэн бувтнана. -Би
дахиад ажил хийхгүй.

-Бурхан минь Жонни, чи чинь юу хэлэх нь энэ вэ! гэж тэр бачимдан дуу алджээ.

Энэ бүхэн түүнд тэнгэрийн өөдөөс тэрсэлсэн хэрэг лүгээ адил санагдаад, хүүгийнх нь амнаас унасан тэнгэрт тэрс үг эхийн сэтгэлийг шимшрүүлдэг шиг Жоннигийн саяны хэдэн үг түүний голыг зураад явчихав.

-Чи чинь юу л болоод байна даа? гэж ширүүлээд үзэх доройхон оролдлого хийхээр тэр зүтгэв.

-Тоо гэж хүү нь хэлээд: -Тоо, тэгээд л гүйцээ. Би энэ долоо хоногийн турш

бодлоо. Өөрөө хүртэл мэл гайхлаа шүү дээ.

-Энэ чинь бас юун тоо вэ, ойлгох юм алга гэж эх нь сандарчээ. Жонни тэвчээртэй нь аргагүй мишээхэд, эх нь нөгөө хахир ярдаг зан нь хаачаа вэ хэмээн айдаст автав.

-Одоохон тайлбарлаад өгье гэж тэр хэлэв.

-Би туйлдаж гүйцжээ. Юунаас тэр вэ? Хөдөлгөөнөөс. Эхийн хэвлийгээс унасан цагаасаа хойш миний хийсэн ганц юм энэ. Би хөдөлсөөр байгаад эцчихэж, одоо боллоо. Би шилний үйлдвэрт хэзээ ажиллаж байсныг та

санаж байна уу? Би өдөрт гурван мянга зургаан зуун лонх гаргадаг байсан. Лонх бүрт арван хөдөлгөөн, яагаад ч багагүй, тэгэхээр өдөрт гучин зургаан мянган хөдөлгөөн болно, арав хоногт гурван зуун жаран мянга, сард сая наян мянга, наян мянгыг нь яахав хаячихъя гэж тэр өглөгч хүний уужим дуугаар дуржигнуулснаа,

-Наян мянгыг нь хаячихаар сардаа сая үлдэнэ, жилд арван хоёр сая! Нэхэгч машины ард би хоёр дахин олон хөдөлгөөн хийдэг, тэр нь жилд хорин таван сая болно, гэтэл над ийм юмыг бүр сая сая жил хийчихсэн мэт санагдаад байна шүү дээ. Харин

Энэ долоо хоногт би өчүүхэн ч хөдөлсөнгүй, бүхэл өдрийн туж нэг ч хөдөлгөөн хийсэнгүй юу ч хийхгүй, зүв зүгээр сууна гэдэг ямар сайхан юм бэ? Над хэзээ ч аз жаргал байгаагүй, хэзээ ч зав гарч байгаагүй, цагийн мөнхөд хөдөлнө, агдаганана, Энд ямар юмных нь баяр баясгалан байхав. Би одоо юу ч хийхгүй, суугаад л байна, суугаад л байна, амарна, амраад л байна, туж амарна,

-Вилли, хүүхдүүд маань яах вэ? гэж эх нь бүр цөхөрч бахардсан янзтай асуулаа.

-Нээрээ тийм, Вилли, хүүхдүүд...

хэмээн тэр давтана. Гэхдээ дууных нь өнгөнд харуусал үл тодорно. Эх нь хоёр дахь хөвгүүнийхээ төлөө ямар үнэ хүндтэй, гайхам мөрөөдөл сэтгэлдээ тээж явдгийг хэзээний мэдэх хэдий ч яагаад ч юм гомдол хорсол үл төрнө, өдгөө түүнд юу ч байсан хамаагүй санагдана, бүр ээжийнх нь саяын хэлдэг хүртэл шүү.

-Ээж ээ, Виллигийн төлөө юу бодож явдгийг чинь би мэднээ, тэр сургуулиа төгсч, нягтлан бодох болох ёстой. Үгүй дээ, миний хувьд ханалаа, цадлаа, одоо тэр ажил хийх ёстой.

-Би чамайг өдий зэрэгт хүргэсэн

гэснээ тэр мэгшчихэв. Тэгснээ хормогчоо ахиад өргөсөн ч нүүрэндээ хүргэж чадсангүй.

-Чи намайг өдий зэрэгт хүргээгүй ээ гэж тэр эг маг, гунигтай өгүүлээд. -Би өөрөө өөрийгөө өсгөж өндийлгөсөн, ээж ээ. Тэрнийг ч бас хүн болгосои. Вилли надаас булиа зузаан, шөрмөслөг, бас өндөр. Би бага байхаасаа цадталаа идэж уугаагүй юм байлгүй. Харин тэрнийг өсч өндийж байх хооронд би ажиллаж, түүнд талхыг нь залгуулж явсан. Одоо ингээд гүйцээ, Вилли ажил хийнэ үү байна уу, над шиг ингээд алга болно уу яана хамаа алга. Би ядарч байна. Би явъя. Чи яагаад

надтай салах ёс хийхгүй байгаа юм бэ?

Таг чиг. Эх нь дахиад хормогчоороо нүүрээ дараад шуг шуг мэгшив. Жонни хаалган дээрээ нэгэн эгшин саатлаа.

-Би чадлаараа л хичээсэн шүү дээ... гэж эх нь хахаж цацна.

Жонни байшингаас гарч, гудамжаар алхлаа. Өнчин ганц мод өөд харахуйяа түүний царай үл мэдэгхэн мишээлээр гийгээд ирлээ,

-Одоо юу ч хийхгүй гэж тэр өөрөө өөртөө намуухан, дахин дахи хэлж

явав. Дараа нь ихээ бодолд дарагдсан янзтай тэнгэр ширтвээс хурц наран гялбуулсанд нүдээ байдгаар нь онийлгожээ.

Түүнийг урт зам хүлээж байгаа ч яаралгүй, айвуу тайвуу алхлаа Тэр утасны үйлдвэр харагдаж байна. Нэхмэлийн цехийн бөглүүхэн түчигнээн чихнийх нь үзүүрт дуулдахад тэр өөрийн эрхгүй инээмсэглэжээ. Энэ бол бүрэгхэн, аниргүй инээмсэглэл байлаа. Эдүгээ юунд ч өшиж хорсохгүй байгаагаа тэр мэдэрчээ. Нүргэлж чихарсан тэр машинд хүртэл шүү. Зүрх сэтгэлд нь гашуун гуниг ч үгүй, гагц амар амгалангийн хязгааргүй хүсэлд

умбажээ.

Цаашаа алслан холдох тусам байшин, фабрик улам цөөхөн тааралдсаар, зам талбар улам уужимхан болсоор авай. Нэг мэдэхийн хот ард нь хоцорч, Жонни төмөр замын дагуух, сүүдэр

буусан модот гудамж руу орж ирэв. Тэр хүн шиг ч явсангүй, ерөөс хүнтэй адил юм түүнд үгүй билээ. Хүний олиггүй дууриамал дүрс, хавчиг цээжтэй, өлөн зэлмүүн, хатингар амьтан, хумхаатай сармагчин лугаа адил гараа сулбайтал унжуулан, махийтал бөгтийчихөөд, үзэшгүй эв хавгүй, аймаар салдархийлж яваа нь

ЭНЭ.

Тэр төмөр замын жижиг өртөө
өнгөрөөд модон дор ногоон дээр
хэвтээд өглөө. Өдөржин тэнд
тийнхүү хэвтэв. Нэг хэсэг таг унтаж
орхитол нойрон дунд нь булчин
шөрмөс нь таталдаад, нэг сэрснээ
тэр таг чиг хөдөлгөөнгүй хэвтэн,
шувуудын араас ажиглаж, толгой
дээрх мөчрийнхөө завсраар тэнгэр
харсан шиг саатав. Яагаад ч тэгсэн
юм бүү мэд, тэр хоёр ч удаа
түсхийтэл инээд алджээ.

Үдшийн бүрий шөнийн түнэр
харанхуй болон өтгөрөхийн алдад
ачааны галт тэрэг түжигнэж

тачигнасаар өртөө рүү орж ирсэн агаад уурын зүтгүүр зарим вагоныг нь бэлтгэл зам руу гаргаж байх хооронд Жонни сэмээрхэн цуваа руу дөхөж очив. Тэр хоосон ачааны вагоны хаалгыг онгойлгоод зориг муутайхан, арай чамай авирч оров. Дараа нь хаалгыг нь хаачихлаа. Тэгтэл ч уурын зүтгүүр шүглээ тасхийлгэв. Жонни харанхуйд сунаж хэвтээд, амихандаа жаргалтайяа инээмсэглэн байлаа.

Finis

Моргансон гахайн давсалсэн махныхаа сүүлчийн үмхийг идчихлээ. Тэр амьдралдаа ходоодоо хэзээ ч баярлуулж байгаагүй. Ходоод энэ бол тааруухан санаа тавьдаг, тэр бүр зовоогоод байдаггүй, өөрөө ч сэтгэл зовнидоггүй тийм нэгэн зүйл билээ. Гэтэл урт гачаал зэлмүүрийн эцэст давсархаг, шүүслэг, сайхан амттай гахайн үмх мах, амттан тэсэхүйеэ хүсэмжилсэн ходоодыг нь таатай амирлуулав.

Гаслант өлбөрөнги дүр төрх Моргансоны царайнаас үл арилах агаад хацар нь хонхойж, шанааных

нь арьс сулбайж унжаад, юун ч
улбагар арьстай юм бэ дээ гэж
бодогдмоор. Зэвхий цэнхэр
нүдээрээ амгалан харах боловч
харцанд нь гарцаагүй мөхлийн
өмнөх айдас хургаад, муу ёрын
совин, эргэлзээ, түгшүүр тодхон
үзэгдэнэ. Төрөлхийн нимгэн уруул нь
бүр хариугүй жимбийгээд, толийтол
хуссан хацар нь хайруул дээр үсчих
загас мэт юм л бол татвалзан
чичирнэ. Моргансон суугаад гаансаа
гаргаж, нэгд нэгэнгүй эргүүлж
тойруулж хараад тамхи байхгүй ч
толгойг нь алган дээрээ цохилсноо,
дараа нь хав загасны арьсан
хавтагаа эргүүлж урвуулан, доторт

нь наалдсан бүхнийг сэгсрээд,
тамхины үртэс, тоосонцор бүрийг
хямгатай нь аргагүй түүсэн ч
хуруувчны хэртэйгээс арвиныг
цуглуулж чадсангүй, халаасаа
онгичсоор, хоёр гэртаа өчүүхэн чимх
чимх хог цуглуулав. Тэр хогон дунд
нь тамхины үртэс ч эрхбиш
харагдана. Тэр хамгийн бяцхан
үртэсийг ч орхилгүй цөмийг нь
цуглуулсан бөгөөд ангийн үсэн
хүрэмнийх нь дотроос унаад, сар
өдрийн уртад халаасных нь ёроолд
хэвтсэн хэдэн бяцхан унгирал ноос
гээд хаа хамаагүй өчүүхэн юмсыг ч
нийлүүлэв.

Ямар ч гэсэн арван таван минутын

дараа тэр гаансныхаа идэшний тэлыг арайхийн дүүргэжээ. Мань эр гаансаа түүдгээс асаагаад бойтогтой хөлөө галын нөөлөгт ээсэн шиг, бүтээлэг дээр суугаад, утааны суунаг бүрийг амтархан тамхилав. Гаансаа угзарч угзарчихаад түүдгийн бөхөж буй дөл өөд бодлогошрон гөлөрсөөр байлаа. Төдөлгүй нүднийх нь харцнаас тавгүйрэл зовиур нь бага багаар хулжин арилж, шийдмэг зоримог гэрэлтээд явчихав. Нөмрөн ирсэн гай түйтгэрээс зайлах аргаа арайхийн олсон нь тэр биз. Гэхдээ тэр арга нь даанч олиггүй. Моргансоны царай хувьсхийж, хэрцгий догшин дүртэй болоод,

нимгэн уруулаа чанга жимийжээ.

Нэгэнт шийдсэнээс хойш гүйцээлгүй яахав. Моргансон арайхийн босч, майхнаа хурааж эхэлсэн бөгөөд хуйлсан бүтээлэг, хайруулын таваг, буу, сүх сэлтээ чарган дээрээ хураагаад, цөмийг нь олсоор даруулж, дараа нь галд гараа ээснээ, бээлийгээ углав. Түүний хөл янгинах агаад чарганы дэлбээ рүү явах зуурт хазагнаж байгаа нь илт мэдэгдээд иржээ. Мөрөн дээгүүрээ мөрөвчөө чулуудаад чаргаа байрнаас нь хөдөлгөхийн эрхэнд биеийнхээ хэмаг жингээр зүтгэхдээ өвдсөндөө өөрийн мэдэлгүй ярвайжээ. Холын замд мөрөвч мөрийг нь аль хэдүйн

холгочихож. Юконы хөлдсөн
гульдрилаар чарган зам зурайж
байлаэ. Дөрвөн цагийн дараа
Моргансон голын тохой хүрч, тойрч
гараад, толгодын орой дээр ойн
цоорхойд шаваарсан хэдэн урц,
ганц уушийн газар, хулсан дээвэрт
ганц байшинт Минто гацаа руу орж
очив. Моргансон хаалганы дэргэд
чаргаа орхичихоод уушийн газраар
шагайлаа.

Хараажийн хов хоосон, алтныхаа
хүүдийг тавцан дээр тавингаа тэр:

-Ганц аяганд хүрэх үү хэмээн
асуужээ.

Уушийн газрын эзэн эхлээд түүн рүү,
дараа нь уут руу нь цоргих мэт
харснаа лонхтой юм, шилэн аяга
хоёр тавцан дээр гаргаж тавилаа.

-Яахав дээ, энэнгүй ч болно.

-Үгүй дээ, авч үз гэж Моргансон
зүтгэв.

Уушийн газрын эзэн уутыг дэнсэн
дээр өргөн сэгсэртэл алтны элсний
хэдхэн өчүүхэн ширхэг унав.

Моргансон түүнээс уутыг авч, дотрыг
нь Урвуулаад дэнсэн дээр алтны
тоосыг зөөлхөн унагалаа.

-Би хагас доллараас илүүтэй байгаа

гэж бодсон юмсан гэж тэр хэлэв.

-Арай хүрсэнгүй. Зүгээр зүгээр. Өөр нэгнээс нь дүүргэж орхино гэж Уушийн газрын эзэн хариу өчив, Моргансон зэвүүрхсэн янзтай шилэн аяга руу багахан виски тонгойлгов.

-Аягал, дотроо халаахаар овоо аягалчих гэж уушийн газрын эзэн түүнийг зоригжуулах аж. Моргансон шилтэйг тонгойлгосоор аяганы амсраар цэлэлзтэл дүүргэв. Мань эр виски хэлийг нь яажшуухан дарвигнуулан, хоолойг нь төөнөж, ходоодоор нь таатайяа халуу оргиулан зураад явчихыг сэтгэл тэнүүн мэдэрч, тухтайхан уулаа.

-Чийг бам уу? гэж уушийн газрын эзэн сонирхов.

-Тийм, жаахан байгаа. Гэхдээ би арай хавагначихаагүй байна. Дайи хүрчихвэл тэнд шинэ ногоо бий, тэнхэрчих биз гэж Моргансон хариу өгүүлнэ.

-Баларч дээ, нохой ч үгүй, мөнгө ч үгүй, бас дээр нь чийг бамтай Хэрэв би чиний оронд байсан бол шилмүүсний ханд уугаад үзнэ дээ гэж нөгөө эр цайлганаар инээвхийлэн хэллээ.

Хагас цагийн дараа Моргансон уушны газрын эзэнтэй салах ёс

хийгээд зам руу хөдөллөө. Тэр холгож гүйцсэн мөрөн дээгүүрээ чарганыхаа оосрыг хаяад, голын гүльдрилаар зурайх чарган замаар өмнө зүгт замнав. Цагийн дараа тэр зогслоо. Голын баруун талаас орж ирсэн нарийн хөндийн адагт мань хүн чаргаа орхин, өөдөө хагас бээр орчим хазганан явж үзсэн бөгөөд тэндээс гол хүртэл гурван зуу орчим ярд ажээ. Давчуухан нам тэр газарт улиангар битүү ургажээ. Түүгээр явсаар Юкон руу хүрч ирвээс зам голын эрэг дагуу алсарч буй ч, мань хүн тийш шууд бууж очсонгүй, чарганы улаар дагтаршсан зам өмнө зүг өөд Селкеркийн зүгт цасан

дундуур зурайн, өргөссөөр одсон нь бүтэн бээрийн газарт тодхон харагдаж байлаа. Гэтэл умард этгээдэд, Минтогийн чигт, бээрийн дөрөвний нэг хэртэй зайд ой бараантсан эрэг замыг халхалжээ.

Үзлэгийнхээ үр дүнд сэтгэл ханасан Моргансон түрүүнийхээ нөгөө тойруу замаар чарган дээрээ эргэн ирж, оосороо мөрөвчлөөд, чаргаа хөндий өөд чирэв. Цас хөвсгөр зөөлөн, дагтаршиж амжаагүй учир чирэх гэж там, уланд нь цас товууцсан чарга урагш ахихгүй, хагас бээр хороогоогүй байтал Моргансон тамираа барж гүйцлээ. Умгар майхназ босгов уу үгүй юү бяцхан

төмөр зуухаа тавьж, жаахан гишүү хугалахыи зуурт юу юугүй түнэр шөнө харанхуйлав. Түүнд лаа байгаагүй хойно, аяга цайгаар сэтгэлээ хуурчихаад хөнжил доогуураа шургажээ.

Өглөө нь Моргансон бээлийгээ углан, чихэвчээ буулгачихазд улиангар ургасан хөндий дундуур Юкон руу одов. Буугаа авч явсан ч өчигдрийнх шигээ газрын нам руу буусангүй. Бүтэн цаг эзгүй замыг гөлийтөл ширтэж, дулаацчих санаатай хөлөө дэвсчин, алгаа үрж цохисоор яваад, сүүлдээ өглөөнийхөө ундыг уух гэж майхандаа буцаж ирэв. Төмөр

саванд нь таван удаа чанаж хүрэхтэй үгүйтэй цай үлдсэн болохоор тэр цайгаа эцэс төгсгөлгүй уух андгай сахил хүртсэн мэт тогоотой усандаа чимххэн цай үйжээ. Түүний хүнсний бүх нөөц гэвэл хугас шуудай гурил, задалчихсан жижиг савтай талхны хуурай хөрөнгө төдийхөн.

Тэр бин хайраад айвуу аажуу эмтэлж үмх бүрийг нь жаргалтайяа зажилсаар гурвыг идчихсэнээ, хэсэг бодолхийлээд, дөрөв дэхийн араас гар сунгасан ч, тээнэгэлзэн шуудайтай гурил руугаа харж өргөж үзэн, жинг нь багцаалав.

-Хоёр долоо хоногт хүрчих биз гэж

чанга хэлснээ, бингээ өөрөөсөө
холдуулан түлхээд,

-Гуравт ч хүрч юу магад хэмээн
нэмж өгүүлвэй.

Дараа нь тэр дахин бээлийгээ углаж,
чихэвчээ буулгаад, буугаа аван,
эргийн тагт дахь отлогынхоо газар
руу хөдлөв. Цасан дотор хэнд ч
харагдамгүй бүгээд, хараачилж
гарлаа. Хүйтэн жавар агдагасхийтэл
жиндүүлж эхлэх хүртэл мань хүн
хэдхэн минут тийнхүү огт хөдлөлгүй
суусан бөгөөд сүүлдээ өвдөг дээрээ
буугаа тавьчихаад алгаа үрэн
цохилж, хөлөөр нь хатгуулах өвчин
тэсэхүйеэ бэрх болоход эргээс

жаахан холдож, мододын дундуур хойш урагш холхиж эхэлжээ. Гэхдээ тэр зугаалга удаан үргэлжилсэнгүй. Тав арван минут өнгөрөв үү үгүй юү Моргансон эргийн хязгаар руу очиж, алсаас нэг хүний дүрс тодроод ирэх шиг болоход зам руу учиргүй хянамгай ширтсээр байлаа.

Түүнд дуусашгүй мэт санагдаад байсан ахархан өглөө яах ийхийн зуурдгүй өнгөрсөн ч харин зам урьдын адил хов хоосон, эль хуль.

Өдөр отлогонд хэвтэх амар ажээ. Агаарын хэм нэмэгдэж, цас хялмаалав. Сэвхийх ч салхи үгүй, өчүүхэн, хуурай цасан ширхгүүд

алгуурхан, аниргүй газарт бууж,
Моргансон нүдээ аниад, толгойгоо
өвдөгөн завсраа шургуулан зам дээр
юу болох нь вэ хэмээн хүлээх ч,
нохдын гийнаан, чарганы чихраан,
хөтөч нарын хашгираан, гууглааны
аль нь ч нам гүмийг сандаасангүй.
Харуй бүрийгээр Моргансон
майхандаа эргэн ирж, гишүү
хугачаад, хоёр бин цааш нь
харуулчихаад, хөнжил доогуураа
шургасан боловч амгалан нойрсож
чадсангүй, нойрондоо ёолж
гиншсээр, шөнө дундын хэрд босч,
дахин нэг бин шуналтайяа иджээ.

Өдөр ирэх тусам хүйтний эрч
чангарсаар авай. Моргансон

шилмүүсний халуун ханд өчнөөн ууж байсан ч дөрөвхөн муу гамбираар махбодын амьдралыг яахин тэтгэх. Хоол хошныхоо орцыг өглөө гурав, орой гурав хэмээн зургаан гамбирт хүргэж арвитгахаас аргэгүйдэв. Харин өдөр нь тэр хэлэн дээрээ юу ч үл тавин, халаглам шингэхэн ч хэдэц аяга жинхэнэ цайгаар сэтгэлээ зогооно. Тийнхүү өглөө нь гурван гамбир үдэд жинхэнэ цай, үдэш дахиад гурван гамбир гэсээр, өдөр хоног ч улирсаар. Завсар заалхайд нь Моргансон чийг бамын эм болгон шилмүүсний ханд уусаар, бингээ аль болох том хийхээр ядаад буйгаа өөрөө ойлгосон учир өөртэйгээ

хийсэн эрс ширүүн тулааны эцэст урьдын орцондоо арай гэж шилжжээ.

Тав дахь өдөр нь зам амь оров. Өмнөд этгээдэд хар цэг үзэгдээд алгуурхан тодорч, Моргансон сэрэмжилж эхэллээ. Тэр буугаа бэлэн зэхээд гол төмрийн хоолойд байсан сумыг сугалан авч, оронд нь шинийг цэнэглээд, авсныгээ хүхээгт нь эргүүлэн хийж, дараа нь бууныхаа гохыг сойлт дээр нь тавьчихаад, баруун гар бээрчих вий хэмээн бээлийгээ углав. Хар цэг ойртоод ирэнгүүт тэр хүн хөнгөн шалмаг, чарга ч үгүй, ноход ч үгүй явааг нь мэдэв. Моргансон сандарч

үймрээд гохоо татсанаа, дараа нь дахиад сойлт дээр нь тавьжээ. Нөгөө хүн нь улаан арьстан байсан учир Моргансон цээжээ эгштэл сүүрс алдаад, буугаа өвдөг дээрээ хөсөр орхилоо. Улаан арьстан дэргэдүүр нь өнгөрч, модот хошууг тойроод, Минтогийн чигтээ далд оров.

Моргансоныг шинэ санаа бодол эзэмдэх нь тэр. Улиангарын мөчир газар шүргэн хариугүй дор сэрийлдэх өөр байранд тэр шилжлээ. Улиангарын мөчир дээр тулгуурын хоёр гүн хэрчлээс сүхээр цавчаад, дараа нь бууныхаа гол төмрийг нэг хэрчлээс дээр нь тавьж, буугаа зам руу чиглүүлэв. Тийнхүү

замын нэг хэсэг тэр чигээрээ түүний овоо хараанд багтав. Моргансон бас буугаа зөөж, нөгөө нэг тулгуур дээрээ тавьснаа, дахиад зам руу чиглүүлж, тэр байрлалаас харгүй цаашаа далд орж буй модот хамар хүртэлх замын нөгөө хэсгийг овоо хараандаа оруулж авчээ. Моргансон доошоо буусангүй. Замаар яваа хүмүүн тэр өндөр эрэг дээр хэн нэгэн бүгж суугаа гэж таамаглах ч үгүй биз. Цасан хучилга нь жаахан ч сэмрээгүй, харгуйн хаанаас ч чарганы мөр салаагүй, сэжиг ажиггүй байх ёстой.

Шөнө уртсаад, Моргансоны өдрийн отлогын хугацаа хорогдож, нэг удаа

бүр харанхуйд замаар хонхон
дуутай чарга өнгөрөөд явчихуйяа.
мань хүн битүүхэн гасалсаар
гамбираа захиран, дэмий чимээ
чагнаж | суусансан. Хамаг бүхэн
түүнээс нүүр буруулжээ. Арав хоног
хүйтэн тамын зовлонг тэвчиж,
чилтлээ зам ширтсэн ч юу ч олж
долоосонгүй, зөвхөн хөнгөхөн яваа
ганц улаан арьстан өнгөрөв. Гэтэл
одоо отох харуулдах ч юм алга.
Шөнө дөлөөр хүмүүс. ноход, ачаатай
чарганууд өмнө этгээд рүү тэнгисийн
зүг, нарны зүг, соёл иргэншил тийш
довтолгосоор авай.

Отож буй чарганыхаа тухай тэр
ингэж бодож байлаа. Амьдрал,

түүний эмьдрал ч тэр чарган дээр
яваа. Биед нь бол амьдрал бөхөж
доройтоод, цасанд дарагдсан энэ
майханд тэр үхэлтэй арай ядан
тэмцэлдэж буй билээ. Өлөн
зэлмүүнээсээ тэр тамирдаж гүйцээд,
юун аян замаа үргэлжлүүлэхтэй
манатай харин түүний хүлээж буй
чарганд ноход зүтгэж яваа, тэнд
амьдралынх нь гал дөлийг бадраах
хоол хүнс байгаа, тэнд мөнгө бий, эд
бүгд түүнд тэнгис, нар, соёл
иргэншлийг өгөх буй заа. Тэнгис,
нар, соёл иргэншил тэр бүхэн
амьдрал, түүний өөрийнх нь
амьдралтай ав адилхан агуу утга
агуулгатай, тэр бүхэн түүний анаад

отоод байгаа тэр чарган дээр яваа.

Энэ бодол түүнийг бүрнээ эзэмдээд,
сүүлдээ бүр амьдрал бялхсан
чарганы хууль ёсны эзэн нь мэт,
өмчөө булаалгасан хууль ёсны эзэн
лугаа адил өөрийнхөө тухай бодох
болжээ.

Гурил нь барагдах тийшээ хандаж,
Моргансон өглөө хоёр, үдэш хоёр
гамбир гэсэн хуучин хувь орцондоо
эргэж орлоо. Зүүдрэл цөхрөл нь
даамжрах тусам хүйтэн жавар ясыг
нь улам улам бэрхтэйеэ янгинуулж
байсан ч, хорыг нь малтах аятай
үхлийн аниргүй янзаараа
дүнсийсээр, амь орохыг үл хүсэгч

замаа Моргансон урьдын адил өдрөөс өдөрт харуулдсаар суулаа. Удалгүй чийг бам дараагийн шатандаа орж, арьс нь цуснаас задралын хар хорыг зайлуулах чадвараа алдаад, бие нь хавагнаж эхэллээ. Ялангуяа хөлийнх нь ул хавагнаад, шөнө Моргансоныг удтал унтаж чадахгүй хөрвөж тэлчилтэл нь янгинадаг болжээ. Дараа нь хаван бүр өвдөгт нь тулж, өвчин улам догширлоо.

Тэгтэл гэнэт учиргүй хүйтрэв. Агаарын хэм тэгээс доош дөч, тавь, Жаран хэм хүртэл унажээ. Моргансонд агаарын хэмийг хэмжигч ямар байх биш, гэхдээ энэ

оронд амь зууж буй бүх хүний нэгэн адил тэрбээр Цасан дээр халиаж цацсан усны шийхнаан, жаврын хорон чимхээн, амьсгааны уур ямархан хурдан холдож байгаагаар, майхны дээвэр, зотон Даавуун хананд буусан цан хүүргийн зузаанаар гээд нэлээдгүй олон шинж байдлаар агаарын хэмийг тодорхойлж байлаа. Тэр эрэг дээрх отолтоо үргэлжлүүлэхээр адган, хүйтэнтэй дэмий нэг үзэлцсээр. Мань эр туйлдаж гүйцээд галын дэргэд дулаацан, майхандаа орж амь хэлтрэх гэсээр байтал жавар салхи араа шүдээ түүний биед хэзээний гүн шигтгээд, даанч

амархан дагжааж байлаа. Хамар,
хацар нь аль хэдийн хөлдөж
харлачихаад, зүүн гарынхаа эрхий
хурууг бүр бээлийтэй байхдаа
хөлдөөчихсөнийг яана.

Тэсгим жавар түүнийг тийнхүү
майханд нь тууж оруулаад байтал
мань хүнээр доог тохуу хийж буй
аятай зам гэнэт амь ордог байгаа.
Эхний өдөр нь гурван чарга,
маргааш нь хоёр чарга. Тэр хоёр
өдөр эрэг өөд гарсан ч хүйтэнд
ширвүүлээд зугтсаар амь гарч.
Явснаас нь хойш хагас цагийн дараа
эзгүй замаар чарганууд довтолгон
өнгөрчээ.

Тэгтэл ашгүй хүйтний эрч тавирлаа.
Эдүгээ Моргансон дахиад эрэг дээр
суух болсон ч харгүй ахиад амьгүй
мэт чих хулга. Мөчир дунд бүгэн тэр
дахиад бүтэн долоо хоног
харуулджээ. Гэтэл гол дээр
амьдралын өчүүхэн тэмдэг үгүй, ганц
амьд амьтан энэ тал руу ч, тэр тал
руу ч явж өнгөрсөнгүй. Моргансон
өдрийнхөө аяганы хийцийг үдэш нэг,
өглөө нэг бин болгон улам
багасгасан боловч яагаад ч юм бэ
энэ нь тэгтлээ мэдрэгдэж сүйд
болсонгүй. Заримдаа амьд мэнд
байгаадаа өөрөө ч гайхдаг бүлгээ.
Тийм эцэсгүй зовлон зүдгүүрийг тэсч
гарч болно хэмээн тэр хэзээ

ч төсөөлж байгаагүйсэн.

Зам дээр амьдрал ахуй дахин тодроод ирэхүйеэ, уул амьдралыг эзэмдэх бяр тэнхээ түүнд байсангүй.

Умард ернөдийн цагдаагийн газрын баг, хорин хүн ноход хөллөсөн чаргатай дэргэдүүр нь өнгөрөв.

Моргансон байдгаараа эвхэрчихээд эрэг дээр сууж байхад, амь нь тасарч буй хүний дүрээр замын хажууханд хургасан үхлийн аюул заналыг тэд даанч анзаарсангүй.

Хөлдөөчихсөн хуруу нь Моргансоныг түгшүүлэх авай. Хуруу минь бүлээцээд илаарших болов уу гэсэндээ юм л бол бээлийгээ суга

татан гараа сугандаа хавчуулдаг зуршилтай болов. Гэтэл харгуйгаар шуудан зөөгч айсуй. Шуудан хүргэгч содон чухал нэгэн болохоор хүмүүс түүнийг дорхноо үгүүлэх учир Моргансон зүрхэлсэнгүй өнгөрөөчихөв.

Гурил нь хоггүй дууссан тэр өдөр цас орлоо. Цас хаялахаар хэзээний дулаан болдог хойно Моргансон олз отсон хилэнцэт аалз шиг өчүүхэн хөдөлсөнгүй, хүлцэхийн зовлонд тарчилан, гол зурам өлөн хоосон чигтээ бүтэн найман цаг эрэгт суужээ. Гэтэл олзны бараа туруу ч алга, тэр харанхуйд яаж ийж байгаад майхандаа хүрч, хэдэн аяга

шилмүүсний ханд, халуун ус
уучихаад, унтахаар ойчоод өгөв.

Харин маргааш өглөө нь заяа төөрөг
нь түүнийг ивээжээ. Майхнаасзз
гарангуутаа түүнээс дөрвөн зуун
ярдын хэртэй хотгороор гарч яваа
аварга том хандгайг олж үзэв.
Судсаар нь цус яаж бургилан
оргилохыг Моргансон эрхгүй
мэдэрсэн авч төдөлгүй түүнийг
өгүүлэхийн аргагүй үлбэгэр дорой
байдал эзэмдэж, бөөн хар юм
хоолойд нь тулж. ухаан орохын тулд
цасан дээр салхийн сууж, нэгэн
хором хэртэй бсхирохоос аргагүй
болжээ. Тэгснээ буугаа шүүрч, нүдээ
бүрэлзтэл шагайв. Эхний сум

шагайсандаа тусав. Үүндээ тэр итгэлтэй байтал харин хандгай толгой сэжисхийн эргээд, модтой хажуу өөд ухасхийн харайлгажээ. Өөрийн отсоор суугаа амьдрал залгуулах ачаатай чарганд зориулах түүнд жигтэйхэн хэрэг болох сумнуудаа дэмий үрж буйгаа ойлгон ойлготлоо мод, бутны хоорондуур жирэлзэн довтолгох амьтны хойноос Моргансон сумаа ар араас нь ухаан сэхээгүй илгээсээр байлаа.

Тэр буудахаа болиод няхуур харж эхэлсэн төдийгүй хандгайн одсон чигийг багцаалж, гүвээний тээр дээр ойн цагаалж, тэнд буй унанги нарсны голыг модон завсраар олж

харав. Гүйдгийн нь чигийг сэтгэлдээ
багцаалсаар, хандгай тэр л нарсны
хажуугаар давхиад өнгөрөх ёстой,
дахиад ганц сум зольж үзье хэмээн
Моргансон сэтгэл шуудраад,
чичирсэн гартаа буугаа улам чанга
атган унанги модны дээрх хов
хоосон руу шагайлаа. Урд хөлөө
өргөн цоройлсон хандгай овоо
хараанд нь ороод ирэнгүүт
Моргансон гохоо даржээ. Буу
тасхийлээ. Хандгай агаарт эргэж
хөрвөх мэт болсноо цагаан тоос
манаруулан цасан дээр үхэтхийн
унажээ.

Моргансон уулын бэл хярлан
ухасхийж... үнэндээ ухасхийе гэж

жигтэйхэн хүссэн бүлгээ. Ухаан ороод тэр муурч унаснаа сая ойлгож, арай ядан хөл дээрээ босоод сая цаадах наадахыгаа ялгахтай болон. очүүхэн боловч тэнхээ орохын тулд үе үе амсхийсээр удаахан сажлав. Ямар ч гэсэн тэр салгалсаар яваад нөгөө унанги дархинд хүрчихэв. Хандгай наахна нь хэвтэж байлаа. Моргансон дээр нь лагхийтэл сууснаа инээдээ барьж дийлсэнгүй, дараа нь бээлийтэй гараараа нүүрээ дарснаа ахиад түсхийтэл инээчихэв.

Хийрхэлт хөх инээдээ барьж ядан байснаа, тэр ангийнхаа хутгыг сугалж тамир алдрах, гар янгинах

хоёроо шүд зуун тэсвэрлэж, чадах ядахаараа адгасаар ажлаа амжуулж дууслаа. Тэр хандгай өвчсөн ч үгүй, шууд арьс туруутай нь дөрвөн хэсэг хувааж орхилоо. Тэр бол бүхэл бүтэн Клондайк лугаа адил асар том мах.

Хандгайг хувааж дуусгаад зуун фунт хэрийн жинтэй том хэсгийг нь хилэн, майхан руугаа чиртэл цас хөвсгөр хойно тийм ачаа Моргансонд ахадалгүй яав гэж. Тэгэхээр нь мань эр хорин фунтын өөр нэг хэсэг мэх авч, байн байн амсхийн зогссоор, майхандаа сая нэг юм хүрч иржээ. Тэр жаахан мах шарж идчихээд дахиад идэх ч гэсэнгүй, дараа нь

отооныхоо газар руу өөрийн
мэдэлгүй хүрч очвоос, цасан дээгүүр
шинэхэн мөр зурайн одож, хандгай
эвдэж байх зуурт амьдрал залгуулах
ачаатай чарганууд хажуухнаар нь
довтолгон өнгөрч.

Гэвч тэр бухимдсангүй, харин чарга
хандгайтай учрахаас нь өмнө
өнгөрөөгүйд баярлав. Хандгай
түүний хамаг төлөвлөгөөг
өөрчилжээ. Фунт мах тавин центийн
үнэ хүрнэ, бас Минто хүртэл гурван
бээрээс арай зүтгүүхэн зайтай.

Амьдрал залгуулах ачаатай чаргыг
ахин хүлээхийн хэрэг юун, хандгай
түүнийг орлохоос хойш. Тэр махаа
зарчихаад Минтогоос хөллөгөөний

хос нохой, татах тамхи, идэх хоол худалдаж авна. Ноход нь түүнийг өмнө зүг рүү зурайн одсон замаар тэнгис, нар, соёл иргэншил рүү авч одно.

Тэр жигтэйхэн өлсдөг болов. Битүүхэн зовиурт өлсгөлөн нь сүүлдээ хоол ундны хурц, тэсвэрлэшгүй дон болж хувирчээ. Майхандаа арайхийн ирж, хэрчим мах шарж идчихээд, араас нь уусан цайныхаа хатаасан шаараар гаансныхаа идшийг хоёр дүүргэж угзарчихаад, ахиад хэрчим мах шажигнатал шарж гарлаа. Тэр бүхний дараа тамир тэнхээ ер бусаар амтагдаад явчихыг мэдэрч,

гарч гишүү хугачив. Араас нь ахиад хэрчим шарсан мах идэж, идэш хоол хорхойг нь хөдөлгөж орхисноос хойш өдгөө яаж сэтгэл нь ханах вэ. Моргансон тэсэхийн эцэсгүй болоод, сав л хийвэл мах шарахаас аргагүйтэв. Бага шиг хэрчим зүсэх гэж хичнээн оролдовч, ойр ойрхон идэх гээд байгаагаа тэр дороо мэдэрч байлаа.

Араатнууд махыг нь гударчихаж магад гэсэн бодол гэнэт толгойд нь гялсхийгээд явчихуйяа, сүх, мөрөвч, чарганыхаа татлагыг хамж аваад уулын бэл өөд мацав. Тэр дэндүү ядруу байсан болохоор агуулах газар барих, махаа тийш нь зөөх гэж

өдөржингийн юм болжээ. Хэдэн залуу мод унагаад, мөчрийг нь цавчиж цэвэрлэн, нийлүүлж баглаад, түүгээрээ өндөр шовгор аранга маягийн юм босголоо. Мань хүний хүссэн шиг тийм найдвартай агуулах болж чадаагүй ч түүнээс илүүг яаж хийж хүчрэх вэ. Харин махаа дээш нь гаргаж тавих гэж ясаа цайтал ноцолдов. Том том махыг дийлэхээ болиод Моргансон заль зохиож, өндөр модны мөчир дамнуулан олс чулуудаад нэг үзүүрт нь махаа уяж, нөгөө үзүүрээс нь өөрийнхөө хамаг жингээр дүүжигнэн чаргуулдан дээш татдаг болжээ.

Моргансон майхандаа буцаж ирээд

орь ганцаар "найраа" хөгжөөж
эхлэв. Түүнд хамт ууж идэх хүний
хэрэг байсангүй. Ходоод нь хань бүл
болчих юм чинь. Тэр хэрчим
хэрчмээр нь мах шарсаар, фунт,
фунтээр нь идсээр байлаа. Үлдсэн
жаахан жинхэнэ цайгаараа
аагтайхан цай чанав. Энэ сүүлчийн
ханд нь. Яадгийм, маргааш тэр
Минтогоос цай авчих юм чинь.
Голийтлоо цадчихаад тэр гаансаа
нэрэв. Уусан цайны хуурай шаарны
хамаг нөөцөөр нэгмөсөн баагиулав.
Зовлон биш ээ! Маргааш тэр ёстой
жинхэнэ тамхитай залгана. Мань эр
гаансныхаа толгойг тогшсоноо,
араас нь бас нэг зүсэм мах шарж

цохичихоод унтахаар хэвтэв.

Хагарчих вий хэмээн

айдас хургатлаа өчнөөн цусалсан ч,
удалгүй хөнжил дороосоо сугарч,
бас дахиад жаахан мах идэв.

Моргансон өглөө нь арайхийн сэрэв,
түүний нойр үхлээс өөрцгүй бөх

байлаа. Үл ойлгогдох чимээ чихэнд
нь дуулдана. Тэр бас хаа байгаагаа

ойлгосонгүй. Шүдний ором

дугуйрсан, сүүлчийн хэрчим мах

хэвтээ хайруулын тавгийг олж

үзтэлээ, эргэн тойрноо мэлрэн

харжээ. Түүнийг харангуутаа бүхнийг

сэргээн санаж, мөнөөх ойлгомжгүй

дуунаас агдагасхийн цочоод, хараал

зүхэл урсгасаар хөнжил дороосоо

суга үсрэн өндийлөө. Чийг бамд
улбайж гүйцсэн хөл нь гуйвж,
Моргансон өвчиндөө атигасхийснээ
ав дав огцом хөдөлгөөн хийхгүйг
хичээсээр гутлаа өмсөж,
майхнаасаа гарав.

Махаа хадгалсан тэр газраас нь,
толгодын тэндээс охорхон, гаслангуй
агаад үе үе тасалдах архираан
урхирааны чимээ сонстох ажээ.
Моргансон өвчнөө тоохоо больж,
алхаагаа хурдасгах зуураа хахир
чанга, заналхийлсэн, сүртэй дуугаар
хашгирч явлаа. Цөөвөр чононууд бут
руу харайлдаж, яасан ч олон юм,
нөгөө муу аранга нь цасан дээр
хэвтэж байлаа. Араатнууд аль

хэзээний бөөлжтөлөө цусалчихаад,
түүнд өвдөл цөвдөлхөн үлдээгээд,
зуларч одохноо баяртай байж.

Гай түйтгэр яаж ирснийг Моргансон
тааж ядсангүй. Махны үнэрт
улангасч л дээ, цөөврүүд. Нэг нь
унанги дархины гол дээрээс
харайгаад, аранга өөд гарчихаж.
Дархийг дарсан цасан дээр дурайж
буй чонын мөрийг Моргансон ялгаж
уншилгүй яахав. Чоно тийм өндөрт
харайгаад гарчихын чинээ санаагүй
билээ, тэр. Эхний цөөврийн араас
удаахь нь харайж, Дараа нь гурав
дөрөв дэх нь... дэнжигнэсэн муу
аранга тэдний зовлогыг яаж даах вэ,
нураад ойчоо л доо.

Моргансон гарз түйтгэрийнхээ хэмжээг багцаалдахуйяа, харц нь Дорхноо хэрцгий хорслоор цоноод, өшөөрхөл нь төдөлгүй урьдын мохоо хүлцэлээр солигдов. Моргансон юу ч үгүй болтол нь гялалзтал хэмлэж мэрж орхисон ясыг овоолон хурааж эхэллээ. Ядаж чөмөгтэй шүү дээ. Тэр бүү хэл гулгитлаа цусалсан араатнуудын хайхралгүй орхисон өвдөл цөвдөлхөнийг цас онгилж цуглуулав.

Сэгний үлдэгдлийг доош нь зөөсөөр өглөөг барлаа. Урьд нь түүний чирч ирсэн нөгөө махнаас арван фунтээс багагүй юм майханд нь үлдсэн байх ёстой. Өөрийнхөө нөөцийг ажин

хараад, "Хэдэн долоо хоногт хүрэлцэнэ" хэмээн Моргансон сэтгэл шуудрав.

Өлөн зэлмүүн үхлийн ирмэг дээр дэнжигнэн амь зогоож сурчихсан нэгэн билээ, тэр. Буугаа цэвэрлээд сумаа тоолоод үзтэл долоохон үлдэж. Буугаа цэнэглээд эрэг дээрх отлогынхоо газар руугаа сажлав. Өдөржин хоосон зам сахижээ. Долоо хоног чилийтлээ харуулдлаа. Гэтэл зам дээр амьдралын ямар ч шинж тэмдэг үл үзэгдэв.

Мах шөл түүнийг тэнхрүүлсэн боловч чийг бам улам улам тарчлаасаар, хөл нь яс яйрмаар янгинасаар.

Эдүгээ тэр ганц шөлөөр гол зогоож,
яс үйсэн усан шөл буцалган,
тогоо тогоогоор нь цааш
харуулсаар, ясаа үйрүүлэн, дахин
дахин пурхийлгэсээр сүүлдээ усан
шөл нь улам шингэрсээр байлаа.
Гэхдээ шимт махны хурц халуун шөл
түүнд тус болсон нь гарцаагүй.
Хандгай буудаж унагаснаас хойш
мань хүн илт тэнхэрчээ.

Дараагийн нь долоо хоногт
Моргансоны амьдралд нэг шинэ
зовиур буй болсон нь өнөөдөр
хэдний өдөр вэ гэдгийг санах гээд
ядчихдаг явдал юм. Тэр нь түүний
хувьд бүр улиг болов. Тэр хичнээн
бодож, өчнөөн тооловч тухай бүрт

үр дүн нь өөр өөр гарна. Тэр энэ бодолтойгоо өглөө сэрж, өдрийн туж зам ширтэн энэ тухай санааширч, үдэш мөн энэ бодолтойгоо унтана. Шөнө дөлөөр зөвхөн энэ тухай бодож, хэдэн цагаар нойроо хулжаан хэвтэнэ. Өнөөдөр хэдний өдөр вэ гэдгийг мэдэх нь ямар ч бодит учир холбогдолгүй атал өлсгөлөн шиг, амьд явахын хүслэн шиг тийм тэсвэрлэшгүй болтлоо түүний түгшүүр улам улам лавширсаар байв. Эцэстээ өнөөх нь дийлж, Моргансон гацаа орохоор шийдэв.

Түүнийг Минтод ирэхэд хэзээний харуй бүрий болчихсон байлаа.

Гэхдээ энэ нь ч мань хүнд олз, хэн ч түүнийг харахгүй, бас буцах замыг нь сар гийгүүлнэ, гэгээтэй байна. Тэр гүвээ өөд өгссөөр уушийн газрын хаалгыг нээтэл, гэрэл цэлсхийн гялбуулав. Тэнд ердөө хэдхэн лаа цоролзож байсан аж.

Моргансон дэндүү удаан харанхуй майханд амь зуужээ. Нүд нь гэрэлд дасаад ирэхийн алдад тэрбээр пийшин тойрон суусан гурван эрийг олж хараад, чаргаар довтолгож яваа юм байна, түүний хажуугаар өнгөрөөгүйг бодоход нөгөө талаас ирж гэдгийг дор нь ойлгов. Маргааш өглөө эд нар түүний майхны хажуугаар өнгөрнө.

Гайхсан уушийн газрын эзэн уртаар
сийгүүлэн исгэрснээ,

-Чамайг чинь нүд аньж гэж бодсон
юмсан хэмээн өгүүлэв.

-Яагаад гэж Моргансон түгдчин
асуулаа.

Тэр хүнтэй ярилцахаас бүр төсөөрч,
өөрт нь онхи харь, аргил бүдүүн
санагдах дуугаа ч таньсангүй.

-Чиний тухай лав хоёр сар юм
дуулдаагүй дээ -гэж уушийн газрын
хүн гайхширан: -Чи эндээс өмнө зүгт
хөдөлсөн мөртөө Селкерк хүрээгүй
байсан. Чи хаа байсан юм?

-Хөлөг онгоцны компанид өгөхөөр түлээ бэлдэж байсан юм гэж Моргансон итгэл муутайхан худал хэлэв.

Тэр бас өөрийнхөө дуу хоолойг захирч чадахгүй байлаа. Тэр босоо тавцан руу дөхөж очоод дээр нь тохойлдоод тэгнэчихэв.

Бодолтойхон худал хэлэх хэрэгтэй гэдгийг ойлгохын цаагуур ойлгож буй ч, тэр гаднаа хайнга дүйнгэ, санаа амар суугаа ч, зүрх нь пал палхийн хурдан хурдан цохилж, гэсэн атлаа пийшингийн дэргэдэх гурван эрийн зүг өлөн хүйтэн харцаа чулуудахгүй байж яаж чадах вэ. Амьдрал, түүний амьдралыг ивээх

хүмүүс эд шүү дээ.

-Чөтгөр аваг чамайг, энэ хугацаанд чи хаа нуугдаж байв аа? хэмээн уушийн газрын хүн ухаж төнхөхөө орхисонгүй.

-Нөгөө эрэгт. Өчнөөн овоолон түлээ бэлдлээ.

Нөгөөх нь ойлгосон аятай толгой дохисноо, инээмсэглэнэ.

-Тэнд мод огтолж байна гэж би дуулсан л даа. Чи байсан юм уу? Нэг дугтрах уу?

Моргансон хоёр гараараа өндөр

тавцангаас тас зуурчихав. Дугтрах уу! Тэр энэ хүний хөлийг үнсэхнээ бэлэн байлаа. Ганц үг ганхийх гэж дэмий бачимдаж байх зуурт харин уушийн газрын хүн түүний гуйхыг хүлээлгүй хэдийнээ өөдөөс нь лонхтой юм сарвайжээ.

-Харин чи тэнд юу идэж ууж байв даа. Миний бодохноо чи гишүү хугачих тэнхэлгүй байх шиг. Найз минь, чиний царай зүс авах юм алга.

Удтал хүлээсэн лонх руу шуналтайяа гар сунгаснаа, Моргансон шүлсээ хүдэсхийтэл залгижээ.

-Чийг бам намайг боорлохоос аль

өмнө би баахан мод огтолсон. Бас зүгээр ч үгүй хандгай унагалаа. Үгүй дээ, амин зуулга дажгүй шүү, харин чийг бам баллах нь -гээд тэр шилэн аягаа дүүргэснээ, -Би шилмүүсний Ханд ууж байгаа, овоо тустай юм хэмээн нэмж хэлэв.

-Ахиад хий, хий гэж уушийн газрын хүн найр тавин байлаа.

Өлөн хоосон дээрээ хүртчихсэн хоёр аяга виски Моргансоны улбагар бие махбодид тэр дороо үйлчлэв. Ухаан ороод нэг хартал пийшингийн бөөрөнд хайрцаг дээр сууж байлаа. Өнө удаан хугацаа өнгөрсөн мэт санагдана. Нуруулаг, живэр хар

сахалтай, цээж ханхар эрхэм
уушийн газрын эзэнтэй тооцоогоо
хийж, Моргансоны нүдний өмнүүр
манан тунараад явчихсан ч, сайхь эр
тэвхийсэн боодолтой дэвсгэртээс
нэгэн цаасан мөнгө яажшуухан
сугалж буйг нь тов тодхон
хараатахжээ. Тэгтэл будан эгшнээ
сарнин цэлмэв. Энэ бол зуун
долларын дэвсгэртүүд байлаа.

Амьдрал! Түүний амьдрал! Мөнгийг
нь шүүрч аваад харанхуй руу
ухасхийн шунгаж одом хязгааргүй
хүслээ тэр эрхгүй мэдрэв.

Живэр хар сахалт бостол түүний
хойноос нөхдийн нь нэг өндийлөө.

-Хөдөлбө, Ольсон хэмээн мөнөөх хар сахалт эрхэм улаа бутарсан царайтай, цагаан шаргал үстэй үлэмж биет гурав дахь замын ханьдаа хэлэв.

Ольсон эвшээсээр, байдгаараа сунан бас босоод ирлээ.

-Яав? Унтах нь уу? Арай эрт биш үү гэж уушийн газрын хүн дургүйлхэнэ.

-Маргааш Селкеркд байх ёстой хэмээн сахалт хариу өгүүлэв.

-Христосын мэндэлсний баярын эхний өдөр үү гэж уушийн газрын эзэн дуу алджээ.

-Өдөр нь хичнээн сайхан байна,
ажил төдийчинээ сайн бүтнэ гээд
нөгөөх нь инээмсэглэв.

Гурвуул гарч одохуйяа сая тэдний үг
Моргансоны ой тойнд хүрчээ.
Өнөөдөр хэдний өдөр вэ гэсэн чинь
энэ. Христосын мэндэлсний баярын
өдрүүд! Тэр үүнийг л мэдэхийн
төлөөнөө Минтод ирсэн бус уу. Гэтэл
гурван хүний дүрс, зуун долларын
зузаан боодол хамаг юмны өмнүүр
хөндөлсөөд ирэх гэж.

Хаалга тасхийлээ.

-Энэ чинь нөгөө Жон Томсон
Бонанзе. Хүчлийн горхиноос хоёр

саяын алт ухаад авчихсан хүн дээ.
Энэ хүн рүү мөнгө өөрөө хөвж ирдэг
гэсэн. За явж унтаж. Дахиад нэг
дугтрах уу гэж уушийн газрын эрхэм
үгээ ар араас нь давхцуулан хэлэв.

Моргансон тээнэгэлзлээ.

-Баяр болж байна. Зоволтгүй ээ.
Түлээгээ зарчихаад шууд төлчихгүй
юу гэж цаадах нь найр тавина.

Нөгөөхийг нь хөнтөрч орхиод салах
ёс хийчихээд зам руу гарч ирэхдээ
хэдийнээ согтчихсон байсан ч, өнгөн
дээрээ түүнээ хүнд мэдэгдэхгүй байх
тэнхээ тамир хангалттай байж. Сар
тодхон гийгүүлэх агаад түүний хувьд

зуун долларын боодол дэвсгэртүүд болон хувирсан амьдралынхаа хоосон мөрөөдлийг зовиуртайяа тээсээр цэлмэг, мөнгөлөг нам гүм дундуур аяархан гэлдэрч явсансан.

Моргансон давхийн сэрлээ. Хав харанхуй. Цааны арьсан бойтог, бээлий, чихийг нь буулгасан малгайгаа тайлалгүй тэр чигтээ хөнжлөө тунтуйлчихсан хэвтэж байх юм. Тэнхээ шавхан байж тэр шалмагхан босч, галаа асаагаад ус буцалгав. Тогоонд нарсны шилмүүс үйх зуураа өглөөний эхний бүгээн гэгээг ажингуутаа дав даруй буугаа ухасхийн шүүрч эрэг өөд яаран алхлаа. Цасан доторхи отооныхоо

газар бүгсэн хойноо шилмүүснийхээ хандыг уулгүй тэр чигтээ гарч одсоноо сая санажээ.

Бас Жон Томсон санаснаасаа буцаж магадгүй, Христосын мэндэлсний баярын эхний өдөр гээд замд гарахаа больчихвоос ямар сайн байх вэ дээ гэсэн бодол түүний толгойд оржээ.

Үүр тэмдгэрч, өдөр айсуй. Хүйтэн, цэлмэг байлаа. Жаран хэмээс багагүй хүйтэн байна даа хэмээн Моргансон багцаалав. Туйлын тэсгим хүйтэн, нам гүмийг өчүүхэн салхи ч үл эвдэх ажээ. Моргансон гэв гэнэт агдагасхийн биеэ цэхлэхэд

булчин шөрмөс нь хөвчирч,
хавагнасан хөл нь янгинаад явчих нь
тэр. Хэн нэгний дуу хоолойн алсын
чимээ, нохдын бүгийхэн гийнаан
холхи тэртээгээс түүнд ийнхүү хүрч
иржээ. Тэр гараараа гуяа алгадаж
гарав. Тэгээс доош жаран хэмийн
хүйтэнд бууны гох мултлахын тулд
бээлийгээ тайлна гэдэг хялбар бус,
хургаж хоцорсон ямар л илч байна,
тэр хамаг дулаанаа өгөхийг бие
махбодоосоо шаардах цаг ирэв.

Тэд модтой хошууны цаанаас гараад
ирлээ. Моргансон нэрийг нь үл
мэдэх гурав дахь нь хошуучлан
айсуй. Араас нь найман нохойтой
чарга довтолгоно. Жон Томсон тэр

чарганы хажууд нохдын явдлыг шилбүүрээр залан алхах аж. Цувааны бөгсөнд швед Ольсон явна. Хэрэмний арьсан дээлт, үлэмж биеттэр эрхэмийг харж байхдаа Моргансон "Ямар сайхан эр вэ" хэмээн сүүрс алджээ. Ноход, хүмүүсийн дүрс цагаан дайдад тов тодхон. Тэд хатуу цаасаар урласан дүрс лугаа адил өө зөөгүй сайхан Харагдах агаад явах хедлөх нь баадуутай мэт.

Моргансон гохоо татаад буугаа тулгуур дээр тавимагцаа хуруунууд нь хөшиж хоцорсныг тэрхэн зуурт мэдэв. Баруун гар нь нүцгэн, бээлийгээ яаж тайлснаа ч мэдсэнгүй,

мань эр үтэр түргэн бээлийгээ ахин
углажээ. Хүмүүс, ноход ойртоод
ирэв. Моргансон тэдний амьсгалын
уур цанг хүйтэн агаарт ялган харж
байлаа. Түрүүнд нь яваа нөгөө эрхэм
тавин ярд ойртоод ирэнгүүт
Моргансон бээлийгээ баруун
гараасаа ахин суга татан, долоовор
хуруугаа гохон дээрээ аяархан
тавьснаа шагайлаа. Буу тасхийж,
магнайн хүн сэвхийн эргэснээ, зам
дээр хөсөр ойчив.

Моргансон Жон Томсоныг яаруухан
онилсон чинь арай гудруулаад
авчихаж, нөгөөх нь гуйвснаа чарган
дээрээ суучих нь тэр. Моргансон
дээхнүүр шагайгаад дахиад

буудваас Жон Томсон чарган дээр
өөдөө харан гулдайж унав.

Моргансон өөрийнхөө хамаг
анхаарлыг Ольсон руу чиглүүлсэн
агаад тэр Минтогийн зүг ухаан
зулаггүй харайлгаж, харин ноход нь
зам хөндөлсөн хэвтэгч цогцост тулж
очоод зогсохыг харжээ. Мань хүн
Ольсон руу буудаад алдчихав,
нөгөөх нь хажуу тийш огло
харайгаад, нэг баруун тийш, нэг зүүн
тийш холбичин гүйх ажээ.

Моргансон түүн рүү дахиад хоёр сум
ар араас нь илгээсэн боловч
оносонгүй. Тэр гохоо ахин
мултлахаар тэчъядан байсан ч
арайхийн биеэ барив. Зургаан сум

гарзадлаа, одоо ганцхан үлдсэн, тэр нь дайзандаа буй, Энэ удаа гарцаагүй барьсандаа авах ёстой.

Буудаж болохгүй хэмээн Моргансон өөрийгөө захираад, Ольсон яаж харайлгаж буйг зүрх шимшрүүлэн зовиуртай ажиж байсан бөгөөд үлэмж биет эр тал тал тийш ухаангүй аятай үсчсээр, зам хөрөөдөн гүйж, дээлнийх нь хормой ард нь дэрвэх ажээ. Моргансон Ольсоны адармаатай үсчээнийг дагуулан бугаа шагайлаа. Гэтэл түүний хуруунууд нь хөшиж эхэллээ. Тэр бууныхаа гохыг бараг л мэдрэхгүй байлаа.

-Бурхан минь, туслаач хэмээн тэр өөрийн мэдэлгүй дуугарснаа, гохоо дарчихав. Ольсон гүйдэл дундаа элгээрээ харуулдаж унаад, дагтаршсан зам мөргөсөн бие нь овгосхийж, хэдэнтээ хөрвөжээ. Нэгэн эгшнээ гараараа цас балбаж байснаа төдөлгүй хөдлөхөө болив.

Моргансон буугаа хаячихаад (сүүлчийн сумаа гарзадсанаас хойш одоо хэрэг ч үгүй) зөөлөн цасан дээгүүр доош гулсав. Хэргээ гүйцээснээс хойш нуугдах хэрэг юун. Араатан хумсаа нуух адил тэр гараа бээлий дотроо чанга атгасаар чарганууд руу тэнтэр тунтар алхлаа.

Гэтэл нохдын архираан түүнийг зогсоов. Канадын ангууч, усанд шунгагчийн эрлийз томоо тэргүүлэгч нохой зам хөндлөн хөсөр хэвтээ цогцос дээр хүглийн зогсоод сэрвээнийхээ үсийг босгон, Моргансон руж араа шүдээ ярзайлган байна. Бусад долоон нохой нь ч бас сэрвээнийхээ үсийг босгон архирагдах ажээ. Моргансон чарга руу дахин нэг алхах гээд оролдтол хөллөгөөний ноход тэр чигтээ түүний өөдөөс ухасхийлдэв. Мань эр нэг зандчин, нэг эвийлсээр нохдыг номхруулах санаатай дахиад зогтусав. Тэргүүлэгч нохойн хөлний хоорондуур, амиа алдсан хүний

хувхай царайг харсан тэрбээр амьдрал тэсгим хүйтэнд ямар хурдан бууж өгч байгаад эрхгүй ширвээдэн гайхжээ. Жон Томсон ачаагаа тэгнэн чарган дээр хэвтэж байв. Тэргүүн нь хоёр шуудайтай юмны хоорондуур гулдайж ойчоод, Моргансон зөвхөн дээш сэрвэлзэн боссон хар сахлыг нь харж байлаа.

Ноход ойртуулахгүй нь гэдгийг мэдсэн Моргансон замаас гарч, гүн цасанд умбачин чаргануудыг тойрч эхэллээ. Тэргүүлэгчээ түүн рүү ухасхийнгүүт хөллөгөөний бүх ноход жолоо цулбууртаа ороолдон тэргүүлэгчийнхээ араас эргэн зүтгэцгээжээ. Өвчтэй хөл нь

Моргансонд шалавхан хөдлөх сэхээ өгсөнгүй, ноход өөрийг нь бүсэлж байгааг хараад ухрахыг завдтал, тэргүүлэгч нь ганцхан харайгаад яах ийхийн завдгүй түүнд тулж, хурц шүдээрээ хөлөөс нь зуучих нь тэр. Хөлийнх нь шилбэний булчинг туушид нь зуучихсан ч, Моргансон яаж ийгээд мултарч дөнгөв.

Тэрбээр нохдыг хараал зүхлээр булж гарсан ч, номхруулж хүчирсэнгүй. Хөллөгөөний ноход бултаараа архирч урхиран, сэрвээний-хээ үсийг босгон, хөллөгөөнийхөө сурыг тасар татаад, түүнд ойртох санаатай цовхчино. Моргансон Ольсоныг гэнэт санаад шууд эргэн замаар

алхсан агаад хазуулсан хөлөндөө санаа тавьсан ч үгүй. Шархнаас нь цус годгодоно, бодвол гол судас нь ярагдаа биз, гэтэл мань эр үүнийгээ мэдсэнгүй.

Моргансоныг бүхнээс илүүтэй гайхуулсан юм нь өчигдөрхөн улаа бутарч асан шведийн царайг дарсан өгөр зэвхий өнгө. Одоо бол бүр гантиг шиг хувхай цагаан болчихож. Цагаан шаргал сэвлэг, сормуус нь түүнийг гантиг барималтай улам адилхан болгосон агаад хэдхэн минутын өмнө энэ хүн амьд мэнд байсан гэж төсөөлөхийн аргагүй.

Моргансон бээлийгээ шувт татаад,

цогцсыг нэгжлээ. Хувцасных нь дотор талд мөнгөтэй бүс ч алга, алттай хүүдийг нь ч олсонгүй.

Дээлнийх нь энгэрийн халаасыг нь онгичсоор Моргансон жижиг хэтэвч оллоо. Хөщчихсөн хуруугаараа тэнд байсан бүхнийг онгичив. Гадаад тамга, марктай захидал, мөнгөний хэдэн баримт, юуны ч юм бэ тооцооны хуудас, зурвас, найман зуун долларын авлагын хуудас... Гүйцээ. Мөнгө алга.

Моргансон чарганууд руу буцаж очихоор эргэх гэтэл байрнаасаа хөдөлж чадсангүй, хөл нь замтай барьцалдаад хөлдчихөж. Доошоо харахдаа сая тэс хөлдүү ув улаан

шалбааг дунд зогсож буйгаа мэдэв.
Уранхай өмд, бугын арьсан бойтог
дээр нь ув улаан мөс товууцжээ.
Ганц ухасхийн, цуст мөсөн дөнгийг
хага татаж, замаар чарганууд руу
хазганав. Түүнийг зуусан хүглэгэр
том тэргүүлэгч нохой архираад
өөдөөс нь зүтгэлэхүйеэ хөллөгөөний
нохос цөм түүний араас
ухасхийлдэв.

Моргансон тал тал тийшээ гуйвчин
гашуухан мэгшин үйлж байснаа
төдөлгүй сормуусан дээрээ хөлдсөн
нулимсыг шударч унагав. Тэр бүхэн
доог даажингаас өөрцгүй, хорон
үйлийн нь үр түүнийг ийнхүү
даажигнаж байлаа. Жон Томсон

хүртэл сахлаараа тэнгэр ольчихоод
түүгээр даажигнаж байна.

Ухаан нь дэн дун Моргансон чарга
тойрон салгалав. Нэг бол арчаагүй
зүхэл хараал урсган, эс бөгөөс
гиншигнэн мэгшсээр, та нарын тэнд,
чаргэн дээр миний амьдрал байгаа
хэмээн нохосоос гуйж байлаа.

Төдөлгүй дотор нь онгойв. Ямар
жолоогүй мунхаглал вэ! Майхан
руугаа очиж, сүх авч ирээд энэ муу
адгууснуудын тархийг нялгадаад
хаячихъя. Одоохон та нарт үзүүлээд
өгье, гайгүй!

Майхан руугаа зүглэнэ гэхээр чарга,
улангассан нохдоос алсуурхан

даялахаас аргагүй. Моргансон замаас зөөлөн цас руу ортол толгой нь эргэж зогтусав. Ганц л алхвал газар шаагаад унаж магад хэмээн айсан тэрбээр тамирдсандаа гуйвалзаж буй хөл дээрээ займчсаар өчнөөн зогслоо. Дараа нь доошоо харахул хөл доорхи цас нь дахиад ув улаан болчихож. Шархнаас нь цус садарсаар. Ийм гүнзгий сэнжилчихнэ гэж хэн санах билээ!

Моргансон толгойгоо эргэхийг арайхийн тэсвэрлээд шархаа харахаар тонгойвоос цас түүний өөдөөс мэлсхийх шиг болж, цохиулсан мэт гэдэсхийтэл, унахгүй юмсан гэсэн хязгааргүй айдас

түүнийг эгшин зуурт эзэмдээд,
зүйрлэшгүй тэвчээр заан, яаж ийгээд
аргыг нь олон өндийжээ. Түүний
өөдөөс ахиад ухасхийж магадгүй
цаснаас хүртэл үхтлээ айжээ.

Тэгтэл эргэн тойрны нүд гялбам
цагаан цас гэнэт тас харлаад
явчихав. Моргансон ухаан орон
сэргэхүл цасан дээр хэвтэж байлаа.
Толгой нь эргэхээ больж, нүдэнд нь
хөшиглөх манан ч сарнив. Гэхдээ л
босч үл чадна, тэнхээ нь алдарч, бие
махбод нь амьгүй мэт болжээ.

Жигтэйхэн их хүчлэн байж
хажуугаараа эргэн хэвтсэн агаад
Жон Томсоны дээш сөрвөлзөх хар

сахал, чарга хоёрыг нь олж харав. Басхүү зам хөндөлдөн хэвтээ хүний нүүрийг долоож буй тэргүүлэгчийг ч үзэв. Моргансон түүнийг сонирхон ажигласаар авай. Тэргүүлэгч байж ядан, тэсвэрлэх тэнхэлгүй болсноо илэрхийлж, нөгөө хүнийг сэрээхийг хүссэн мэт үе үе тасалданги, уянгалаг дуугаар хуцаж, сүүлээ шарвалзуулан, чихээ соотойлгон түүнийг харж байснаа, дараа нь цогцойн суугаад дээш өлийн уртаар улилаа. Хөллөгөөний нохос цөм түүнийг даган улив.

Цасан дээр хэвтэж байхдаа Моргансон юунаас ч айж эмээхээ болив-Хөрч хөшсөн цогцсыг нь

хүмүүс яаж олж авч буйг төсөөлөн бодоод өөрийгөө өрөвдсөндөө тэр уйлчихав. Гэхдээ л түүнд аймшигтай биш байлаа. Тэмцэл дуусчээ. Тэр нүдээ нээхийг хүссэн боловч барьцалдаж хөлдсөн сормууснуудаа салгаж хүчирсэнгүй, нүдээ арчих ч гэж оролдсонгүй. Эдүгээ бүх юм өнгөрсөн бус уу. Улаан гол тасрах ийм амархан байхын чинээ санаж явсан удаагүй билээ.

Хичнээн олон долоо хоногийг тэмцэж тарчилж өнгөрөөлөө дөө гэхээс өөртөө уур нь хүрч байлаа. Түүнийг үхлээр хуурч, айлгаж байсан бус уу. Цаг нь ирэхээр үхэх гэдэг зовлонгүй аж. Түүний туулсан бүх л

зовлонг амьдрал авчирсан. Амьдрал
үхлийг гүжирдэж байж. Мөн ч хатуу
орчлон шүү!

Төдөлгүй бачуурал, бухимдал нь
бөхөв. Эдүгээ үнэнийг ухаарснаас
хойш, амьдралын тэр худал хуурмаг,
адал балмад явдал юуны хамаа
билээ.

Хамаг бие нь сулбайн нозоорч,
амарлингуй, хязгааргүй эрх
чөлөөний амлалтаар сэтгэл
уужруулах амтат нойр улам бүр
мансуурууланхан байлаа. Нохосын
улиан холоо дуулдана. Тэсгим
хүйтэн жавар биеийг минь
эрхшээгээд, өвтгөхөө хэдийнэ больж

гэсэн нэгэн бодол зурсхийснээ
төдөлгүй тэр бодол нь ч бөхөж,
түүний араас нулимс сувдран
хөлдсөн зовхиных нь завсраар
улалзан байсан гэрэл гэгээ ч алга
болж, тэр сэтгэлээ онгойлгон
ядрангуйхан нэг сүүрс алдаад зөөлөн
бөхөд үүрд автах нь тэр ээ.

Сакраменто голын хөвөөнөө

Салхи довтолно - хо-хо-хью!

Сэвсхийн Калифорни руу
довтолгоно. Сакраменто арвин баян
хязгаар. Алтыг тэнд хүрзээр хутгадаг!

Фриско боомтын зүг хөдлөхөөр
хүрдэн татуургаа эргүүлж, зангуугаа
татаж байхдаа орчлон ертөнцийн
хаа л бол хаа усан цэргүүд хоолой
мэдэн бархирдаг тэнгисийн нэгэн
дууг шулдгар туранхай жаалхүү
нарийн цангинаа хоолойгоор
жингэнэтэл хадааж авай. Тэнгис
далайг хэзээ ч нүдээрээ харж
яваагүй эгэлхэн балчир гэвэл энэ
агаад түүнээс ердөө хоёр зуухан

ярдын цаахантай, хадан цохионоос
Сакраменто гол хүрхрэн бургилан
бууж байгаа билээ. Хөвгүүнийг
жаалхүү Жерри хэмээн дууддаг
бөгөөд яагаад гэвээс хөвгүүний эцэг
өвгөн Жерри гэж бас бий. Саяын
дууг жаалхүү эцгээсээ сурсан агаад
түүнээс бас гялалзсан хурц улаан
шаргал сэвлэг, сортоотойхон цэнхэр
нүд, сэвх шавсан цав цагаан царай
нь өвлөн авчээ.

Жерри өвгөн усан цэрэг байсан
болохоор тэнгис далайгаар хэрэг
амьдралынхаа танагтай үеийг
элээсэн, тэгээд ч усан цэргийн хэлийг
дуу хуур аяндаа загатнуулж байдаг
хойно, нэг удаа Азийн ямар ч билээ

Боомтод өөр хорин усан цэргийн хамтаар дуулсан шигээ, хараал идсэн хүрдэн татуурганд тэнхээ тамираа барж ахуй үед нь энэ дууны үг анх түүнийг гүн санаашралд умбуулсан аж. Сан-Францискод ирэнгүүтээ тэрбээр хөлөг онгоц, тэнгис далайтайгаа салахын ёсон үйлдээд, Сакраменто голын барааг харахаар оджээ.

Тэнд харин тэр алт олж харсан юм. Мань эр "Алтан мөрөөдөл" уурхайд хөлсний ажилд орж, гол дээгүүр хоёр зуун футын өндөрт дүүжин зам угсрахын цагт түүнээс хэрэгтэй хүн үгүй болж орхив.

Хожим нь энэ зам тэр чигтээ сайхь эрийн хараа додомдлого дор үлджээ. Тэрбээр ган татлагыг нь харж шалгаж, эд ангийг нь бүтэн бүрэн байлгаж, улмаар түүндээ сэтгэл санаагаа бүхэлд нь зориулснаар үл барам, төдөлгүй "Алтан мөрөөдөл" уурхайн хэнээр ч сольшгүй чухал ажилчин нь болов. Мөн удалгүй тэр ялдам, хөөрхөн Маргарет Келлид хөл алдан дурлаад, харамсалтай нь тэр бүсгүй дөнгөн данган тэнтэр тунтар хөлд орж байсан өхөөрдөм бяцхан Жерри, тэр хоёрыг даанч яав даа гэмээр хурдан орхин одож, үлэмж аварга сүрлэг нарс моддын дундах

бяцхан оршуулгын газар сэршгүй
нойроор амирлажээ.

Жерри өвгөн далайнхаа албанд
эргэж очсон ч үгүй, дүүжин
замынхаа ойролцоо амин зуулгаа
залгуулж. зүрх сэтгэл нь ямар уужим
билээ, тэр хамаг хайр энхрийллээ
бүдүүн ган татлага, бяцхан Жерри
хоёрт зориулжээ. "Алтан мөрөөдөл"
уурхайд хар өдрүүд нүүрлэсэн тэр
үед ч өвгөн компанийнхаа албанд
үлдэж, хаягдмал аж ахуйгаа
манасаар хоцорчээ.

Гэтэл өнөөдөр өглөө яагаад ч юм бэ
түүний бараа харагдахгүй байлаа.
Гагцхүү бяцхан Жерри довжоон

дээрээ орь ганцаар суугаад, усан
цэргийн эртний дууг өр өмөртөл
цангинуулж байгаа нь тэр аж. Тэр
өөрөө өөртөө өглөөнийхөө ундыг
зэхэж, хэзээ язааны түүнийгээ
амжуулчихаад, одоо орчлон хорвоог
харахаар гарч иржээ. Түүнээс
холгүйхэн хориод алхмын зайд үзүүр
эцэсгүй төмөр татлагыг эвхэгч аварга
ган хүрд бараатайяа сүндэрлэнэ.
Хүрдний дэргэд нямбайлан
бэхэлсэн, хүдэр ачдаг жижиг
тэргэнцэр харагдана. Тэртээ өндөрт
эрэг Дамнан сунайх ган татлаганы
толгой эргэм барааг нүд гүйлгэн
харахуйяа, Жерри хүү холхи тэртээх
нөгөө эрэгт өөр нэг хүрд, бас нэг

тэргэнцэр буйг олж үзэв.

Тэр байгууламж эв энгийн, хүндийн хүчээр ажиллаж эхлэх агаад өөрийнхөө жинд татагдаж хөдөлсөн тэргэнцэр өнхөрч эхлэнгүүт мөн энэ үест нөгөө эргээс хоосон тэргэнцэр тосч ирнэ. Ачаатай тэргэнцэрийг хоосолж, харин хоосныг нь хүдрээр дүүргэнэ. Ийнхүү бүх юм дахин дахин давтагдана. Жерри өвгөнийг татлагат замын манаач болсон тэр цагаас хойш тэр бүхэн мөн ч олон зуу, мянгантаа давтагджээ.

Жаалхүү Жерри ойртон айсуй хөлийн чимээг дуулаад, сая дуулахаа болив. Хөх цамцтай, мөрөндөө

винтовтой, өндөр хүн нарсан дундаас гараад иржээ. Тэр бол Сакраментогийн эхээд эндээс бээр хэрээтэйд байдаг, бас нөгөө эргээд нь татлаган зам зурайсан "Шар луу" уурхайн манаач Холл байлаа.

-Мэнд үү, жаалхүү! Чи чинь энд гав ганцаархнаа юугаа хийж сууна вэ? хэмээн тэр хашгирав.

-Би энд одоо эзний оронд сууж байнаа гэж жаалхүү Жерри, ингэж ганцаар сууж буй маань анхных ч биш дээ гэсэн аятай бүр нэг хэнэггүй хариулах аж.

-Аав яваад өгснийг мэдсэн үү?

-Хаашаа явчихаа вэ?

-Сан-Франциско. Тэр аль өчигдөр үдэш хөдөлсөн. Хаа ч юм хуучин хотод ах нь нас барсан гэнэ. Тэгээд өмгөөлөгчтэй нь учир начираа олохоор явсан. Маргааш орой ирнэ.

Энэ үгсийг Жерри "Алтан мөрөөдөл" уурхайг манаж байх их хариуцлагыг би өөрийн биеэр хүлээсэн гэсэн бахдал омог дүүрэн өгүүлвэй. Басхүү гол дээгүүр өнгийсөн энэ хавцалд орь ганцаар амьдрах сиймхий гарч, өөрөө өөртөө өглөө, өдөр, оройныхоо хоолыг бэлтгэх гайхамшигт адал явдал тохиосонд туйлгүй баярлаж буй нь илхэн.

-За яахав, тэгвэл мэдээтэйхэн байгаарай, ган татлагаар оролдож тархигүйтэв. Би Майга хөлт үнээт хавцалаас буга унагаж чадах нь уу яах нь вэ, үзээд алдъя, харъя гэж бодоод явж байна гэж Холл түүнд зөвлөв.

-Бороо л битгий асгачихаасай гэж Жерри намбатай нь аргагүй үг унагав.

-Би ер нь яавал гэж дээ, норох л аймаар байв гэж гэснээ Холл инээд алдаад эргэж модон дундуур далд орж явчжээ.

Борооны хувьд Жерригийн зөнтэй үг

ях аргагүй биелэв. Арван цагийн үед аварга нарснууд хяхтнан найгалзаад, ёолон гиншиж, цонхны шиг доргин тачигнаж, урт урт ташуу дусалт бороо нижигнэн асгарлаа Арваннэг хагаст Жерри голомтдоо гал бадраагаад цаг арван хоёронтаа цохив уу үгүй юү, үдийнхээ хоолыг идэхээр суужээ.

Хоолныхоо дараа сав суулгаа хурааж, нэгд нэгэнгүй угаах зуураа тэр "Өнөөдөр зугаална ч гэж өнгөрөв бололтой" хэмээн бодов. "Холл щалбайтлаа норсон байлгүй. Тэр нөгөө бугаа унагаж чадсан болов уу, харин" гэж бас боджээ.

Өдөр нэг цагийн үед хаалга түчигнэтэл балбахаар нь Жерри нээтэл салхи цөм түлхчихэв үү яав гэлтэй, эр эм хоёр яах ийхийн завдгүй өрөөнд нь дайран орж ирэв. Тэд бол голоос арван хоёр бээрийн зайтай, эзгүй зэлүүд хөндийд аж төрдөг эхнэр нөхөр, фермер Спилленүүд авай.

-Холл хаа байна? гэж Спиллен тасалданги дуугаар хахаж цацан асууж байна.

Фермер юунд ч юм бачимдан давчуурч, хаашаа ч юм адгах агаад харин Спиллен авгай өвчтэй, хараажийн бүр санаагаар унаад

доройтчихсоныг Жерри
ажиглаатахжээ.

Тэр бол эцэнгэр туранхай, аль
хэзээний гундаж цонхийсон авгай
бөгөөд насан туршаа сөхөртлөө
ажиллаж, хүчир хар бор ажил
түүний царай зүснээ хирдхийм
зовлонт мөр үлдээснээр барахгүй
тэр л бүх бэрх зүдэг амьжиргаа
нөхрийнх нь ч нурууг бөгтийлгөн,
гарыг моонийлгоод, үсийг нь дэндүү
эрт хатуу хуурай болгож, үнсэн
саарал өнгөөр буджээ.

-Тэр Майга хөлт үнээт хавцал руу
гөрөөлөхөөр явсан. Та нарт бас тэр
зүг явах хэрэг гарсан уу?

Авгай бүлхэлзэн амьсгаадаад ирсэн бөгөөд харин Спиллен эцэсгүй гутралаа багтааж ядсандаа өөрийн мэдэлгүй дуу алджээ. Тэгснээ сайхь эр цонх руу очив. Жерри түүний хажууд зогсоод, татлагат замын зүг цонхоор мөн хараа тавьсан бөгөөд борооны өтгөн намиан дунд ган татлага үзэгдэхтэй үгүйтэй.

Ойр тойрны суурингийнхан төлөв "Шар луугийн" дүүжин замаар Сакраментог гаталдаг билээ. Гол гаргаж өгсний төлөө багахан хөлс төлнө, түүгээр нь "Шар луугийн" компани Холлын цалинг тавьдаг аж.

-Бид нөгөө эрэгт гарах хэрэгтэй

байна, Жерри гэж Спиллен хэлэв.

-Түүний эцэг... гэснээ мань эр шугшран уйлж суугаа эхнэр рүүгээ хуруугаараа зангаснаа, -
"Хошингорын навч"уурхайд хүдэртдарагдчихаж, тэнд дэлбэрэлт болсон гэнэ. Амь хэлтрэхгүй гэлцэнэ. Гэтэл бидэнд Дөнгөж сая дуулгадаг байна шүү гэлээ.

Зүрх нь ширхийгээд явчихыг Жерри мэдрэв. Спиллен "Алтан мөрөөдлийн" ган татлагаар гол гатлахсан хэмээн байж ядаж буйг тэр ойлгов. Гэтэл Жерри өвгөнгүйгээр тийм алхам хийж яавч зүрхлэхгүй, эдний энэ замаар

хүмүүсийг зөөж байгаагүй, бас өчнөөн удаан ажиллуулаагүй байдаг.

-Холл удахгүй хүрээд ирж магадгүй гэж хүү хэллээ. Спиллен толгой сэгсэрч: -Эцэг чинь хаа байна? гэж асуулаа.

-Сан-Францискод байгаа гэж Жерри эг маг хариу дуугарав. Спиллен паргиа дуугаар ёолох мөртөө нударгаараа алгаа учир зүггүй балбаж, эхнэр нь улам чанга хахаж цацсаар "Ээ, амжихгүй нь, амжихгүй нь, үхчих нь" гэж горьдлого тасран шивнэхийг Жерри сонсов.

Самсаа нь шархираад ирэхэд хөвүүн

өөрөө хариугүй уйлах нь гэдгээ мэдэрч яах учраа ололгүй, юу хийхээ мэдэлгүй тээнэгэлзэн зогсчээ, Тэгтэл Спиллен өмнөөс нь шийдчихэв.

-Сонсч бай, жаалхүү -хэмээн тэр татгалзахын аргагүй дуугаар хэлснээ, -Юу ч болдог бай хамаагүй, эхнэр бид хоёр чиний энэ замаар гол гатлахгүй бол горьгүй нь. Чи энэ хэрэгт бидэнд тусалж, энэ юмыг ажиллуулж чадах уу? гэлээ.

Халдаж хүрэх ёсгүй юунд ч юм хүрэхтүн гэж түүнд найр тавьсан лугаа адил Жерри өөрийн эрхгүй давхийжээ.

-Тэгсэн дор бол би Холл ирж байна уу, үгүй юү харчихаад ирье гэж Жерри зүрх алдан өгүүлэв. -Ирээгүй байвал яах вэ? Жерри дахиад унжийчихав.

-Хэрэвзээ юухан ч болбоос би бүхнийг хариуцъя. Жаалхүү минь, тэр талд гарах шиг аминд тулсан юм алга, харж байгаа биз дээ! Жерри эргэлзсэн янзтай толгой дохих аядав. -Холлыг хүлээгээд ямар ч хэрэг алга. Майга хөлт үнээт хавцалаас тэр тийм хурдан, амар ирэхгүйг чи өөрөө мэдэж байгаа. Тэгэхээр явцгаая, хүрдээ хөдөлгөөд орхи хэмээн тэр яаруулав.

Ёроол хярхаггүй мэт санагдах харанхуй халил руу өнгийж харснаа Жерри "Тэргэнцэр рүү ороход нь дэмнэж байхад Спиллен авгай айсандза царай нь зэвхийрээд байсан аргагүй юм " гэж боджээ. Үүлэн тасархайг догшин салхиар шавхчин, хөөс усан цацлага намиатуулах аадар бороон дунд долоон зуугаад футын зайд буй тэртээх эргийн бараа туруу ч үя үзэгдэнэ. Харин тэдний зогсож байгаа халил, бургилж манарсан ёроолгүй харанхуй руу хана аятай чанх доош толийж одоод, ган татлаганаас доош-юун хоёр зуун фут, багаар бодохноо бээр хэрээний

хөлгүй ангал байгаз мэт санагдахыг
яана.

-За бэлэн үү? гэж Жерри асуув.

-Болсоон гэж Спиллен салхины
чимээг давахын тулд хоолойн
чадлаар бархирчээ.

Жеррид харин энэ нь таалагдсангүй.

-Та нар хоёр гараараа зуурцгаа,
хийсгэж орхино шүү гэж тэр орилов.

Нөхөр нь тэр дороо эхнэртэйгээ гар
зөрүүлэн тэврэлдэж, тэргэнцрийн
амсраас тас базаад авахуйяа, Жерри
тоормосны хөшүүргийг
болгоомжтой буулгатал хүрд

алгуурхан эргэлдсэнээ үзүүр туйлгүй
ган татлага ороогдон, дээгүүрээ
татаатай замын хөдөлгөөнгүй ган
татлаганаас тэргэнцэр эргэлдэгч
дугуйгаараа зүүгдсээр, ёроолгүй
ангал руу зөөлхөн хөдөлж одов.

Жерри тэргэнцрийг анх хөдөлгөж
буй нь энэ биш л дээ. Гэхдээ өнөөг
хүртэл тэр гагц эцгийнхээ хараан
дор үүнийг хийж байсан. Хүү
хөдөлгөөний хурдыг тормосны
хөшүүрээр аядуухан тохируулж авай.
Тормос татах нь ч аргагүй, салхины
толгой эргэм цохилт, исгэрээнээс
тэргэнцэр жигтэйхэн холбичин
дайвалзаж буй болохоор арга ч үгүй,
тэр байтугай бороо усан хананы

цаагуур нэгмөсөн далдрахынхаа
өмнөхөн өнөөх чинь жигтэйхэн
савчин, амьд ачаагаа арай л ангал
руу сэрсэрчихсэнгүй.

Үүнээс хойш Жерри тэргэнцэрийн
хөдөлгөөнийг зөвхөн ган татлаганы
хөдөлгөөнөөр багцаалж байлаа. Ган
татлага хүрднээс яажшуухан хөвөрч
буйг тэр анхааралтай ажиглана.

-Гурван зуун фут -хэмээн, татлагын
дээрх тэмдэг жирэлзэн өнгөрөхийн
тоолонгоор шивнэх агаад, -Гурван
зуун тавь... Дөрвөн зуу... дөрвөн
зуу...

Татлага зогсчихов. Хөвгүүн ухасхийн

хоёр гараараа татлаганаас угзарч,
байрнаас нь хөдөлгөчих санаатай
дугтарлаа. Таг! Хаа ч юм бэ
гацчихаж. Гэтэл чухам хаана гэдгийг
нь тэр таах нь байтугай тэргэнцэр ч
харагдах бараагүй. Хүү дээш өлийн
харваас, ачаатай тэргэнцэр ямархан
хурдтай алслан одно, төдий хурдтай
түүн рүү айсах ёстой хоосон
тэргэнцэр агаарт бүүр түүрхэн
бүрэлзэж буйг үзэв. Өнөөх нь түүнээс
хоёр зуун тавин ярд хэртэй хол
байлаа. Энэ бол бараан саарал,
түнэр хөлгүй харанхуйн хаа нэгтээ,
бургилан сахрах гол дээр хоёр зуун
футын өндөрт, нөгөө эргээс хоёр зуун
тавин футын зайтай газар Спиллен

эхнэртэйгээ агаарт дүүжлээтэй
байна гэсэн үг.

Жерри уушигныхаа хамаг чадлаар
тэднийг гурвантаа дуудан гуугласан
боловч түүний дуу тэнгэрийн
нижигнэсэн уухайд булаагдчихаад
байлаа. Юу хийж, яасан дээр вэ
хэмээн түүнийг ухаан сэтгэлдээ
бачимдан адгаж байх тэрхэн мөчид
голын дээгүүр ханаран бужигнагч
үүлс гэнэт сарнин, хөвгүүн тээр дор
догшрон сахрах Сакраменто, агаарт
дүүжлээтэй савчих тэргэнцэрийг
нэгэн эгшнээ тодхон олж харав.
Төдөлгүй үүл ахин зангирч, гол
дээгүүр урьдахаасаа дор
харанхуйлаад явчих нь тэр.

Жаалхүү хүрдийг гайгүй шимтэн
ажигласан ч эвдэрч гэмтсэн зүйл олж
үзсэнгүй. Нөгөө зрэг дээрх хүрдний
юу нь ч юм болохоо больсон
бололтой. Нөгөө хоёр, исгэчин
гинших шуурган дунд яйжгий
тэргэнцэр дотор сэгсүүлэн, хөлгүй
ангалд яажшуухан хий дүүжигнэж
байгаа бол?! Гэнэтхэн яагаад
зогсчихсоноо ч мэдэхгүй байгаа
хэмээн төсөөлөхүйеэ голд хүйт
оргимоор. Өөрийг нь "Шар луугийн"
ган татуургаар нөгөө эрэгт гараагүй
цагт, хамаг юмыг түйвээж орхисон
тэр гайтай хүрдэнд хүрээгүй цагт,
тэд ингээд дүүжлээтэй сэгсүүлж
байна гэж бодохоос аймаар!

Гэтэл багаж хадгалдаг амбаарт татлага гүйлгэж хөдөлгөдөг оньс, олс сэлт байдгийг Жерри гэнэт санаад, түүнийг олж ирэхээр хөл мэдэн харайлгав. Хөвгүүн оньсоо ган татлаганд тэр дор нь бэхлээд, татаж эхлэв. Бүр гараа мөрнөөсөө мултартал, одоо л булчин нь бүлт үсрэх нь дээ гэтлээ чадлаараа чангаав. Ган татлага байрнаасаа хөдөлсөнгүй. Одоо бол харин нөгөө эрэгт гарахаас өөр ямар ч арга чарга үгүй.

Жерри аль хэдийн ясандаа хүргэл норчихсон болохоор юун борос мороо санахтай манатай, усан шавшааг тоосон ч үгүй "Шар луу" руу

харайлгав. Холлын
хамжилцаагүйгээр болгохоос
аргагүй нь, тэргэнцэрийг
тормослуулж зогсоох хүнгүй гэсэн
бодол айлгаж байсан ч, салхи араас
нь хөөж дэмнээд гүйхэд төвөггүй.
Тэрбээр бөххөн олсоор өөртөө
тоормос хийж авсан агаад
хөдөлгөөнгүй татлагыг ороогоод
зангидаад авахнаа болчихно биз.

Үс хуу татам догшин салхи түүн рүү
хуйлран дайрч, чихэнд нь исгэчин
гийнаж, тэргэнцэрийг нь савчуулаад
эхлэхүйеэ, Спиллен эхнэртэйгээ
яажшуухан байгаа нь жаалхүү
Жеррид ив илхэн төсөөлөгджээ. Энэ
нь түүнийг зоригжуулав.

Эсэн мэнд гол гатлаад, ташлуур өөд арайхийн мацаж, догшин салхинд хөл дээрээ дөнгөн данган тогтож байсан ч бас болоогүй, гүйхчээн аядсаар "Алтан мөрөөдлийн" хүрд рүү очив. Нөгөөхөө нягтлан хараад, жаалхүү хүрдний хамаг юм ёсоороо байгааг үзүүтээ дотор нь палхийгээд явчихав. Энд ч, нөгөө үзүүрт нь ч бүх юм янзаараа. Ийм байхад хаанаа гацчихдаг билээ? Тэг дундаа байхаас өөр хаа гэж!

Спиллений эр эм хоёрын суугаа тэргэнцэр түүнээс ердөө хоёр зуун тавьхан ярдын цэахан дүүжлээтэй баилаа. Байгалийн жэлоогүй хүчин тасар татаг хэмээн хаячихсан аятай

тэргэнцэрийн ёроолд атиралдсан эр,
эм хоёрыг намиатах бараан
хөшигний сиймхийгээр Жерри
арайхийн ялган харж авай. Гүйдэг
дугуйнууд нь зүгээр үү, шалгаад
орхиоч хэмээн шуурганы чөлөөнөөр
тэр Спиллен рүү хашгирав.

Спиллен ашгүй түүнийг дуулсан
бололтой. Яагаад гэвээс тэрбээр
өвдөг дээрээ болгоомжтой
өндийгөөд тэргэнцэрийн хоёр дугуйг
яажшуухан тэмтэрч буйг Жерри
харсан бөгөөд дараа нь тэр эрэг рүү
эргэснээ:

-Энд бүх юм ёсоороо, жаалхүү! гэж
хашгирчээ.

Жерри тэр үгийг хагас дутуу сонссон ч, чухам юу хэлж буйг нь тэр даруй ойлгожээ. Гэгэхээр юу болсон байж таарах вэ? Одоо хамаг явдал учир хоосон тэргэнцэрт буйд эргэлзэх юмгүй болов. Өнөөх нь эндээс бараа ч үгүй, гэхдээ Спиллений тэргэнцэрээс хоёр зуун футын цаана тэр аймшигт хөлгүй ангалд, тэрүүхэнд дэнжигнэн буй гэдгийг мэдэж байлаа.

Тэр элдвийг бодож түдсэн ч үгүй, юу хийх ёстойгоо шийдлээ. Энэ турьхан, шалмаг хөдөлгөөнтэй жаалхүү ердөө арван дөрөвтэй. гэхдээ уул тайгад хүн болж, эцэг нь түүнд усан цэргийн эрдэм ухааны нууцыг тайлсан

болохоор тэр өндрөөс сүрддэггүй билээ.

Хүрдний хажууд буй багажны хайрцагнаас тэр хуучин түлхүүр, багахан төмөр саваа, бараг шинэ бүтэн боодол манилийн гэгддэг уяа олж авлаа. Өөртөө усан цэргийн дүүжин сандал маягийн юм хийчих санаатай ямар нэгэн хавтгай самбар мод олох гээд ядчихав. Том том нимгэн банзнуудаас өөр олигтой юм гарынх нь дор таарсангүй, тийм юмыг юугаар ч хөрөөдөлтэй билээ. Хөвгүүн тухтай дүүжин суудалтай, суудалгүй учраа олохоос аргагүй болов.

Жерригийн өөртөө хийсэн дүүжин суудал нь энгийнээс энгийн. Хоосон тэргэнцэр дүүжлээтэй байгаа хөдөлгөөнгүй ган татлага давуулан бүдүүн олс чулуудаад, хоёр үзүүрийг нь бөхөөхөн зангидаж, уужуухан гогцоо гаргав. Тэр гогцоон дотроо орж суугаад татлага руу гараа сунгахнаа, бариад байхнаа ч ядах юмгүй. Харин гогцоо төмөр татлагаар гүйх ёстой, тэрүүхэнд нь хөвгүүн өөрийнхөө хүрмийг тохчихов. Яагаад гэвээс хичнээн эрээд бэдрээд ч даавуу шуувуу, хуучин шуудай мэтийг олоогүй аж.

Тэр мэт юмаа хам хум төхөөрч гүйцээд, Жерри өөрийнхөө дүүжин

гогцоонд суухын сацуу татлаганаас гараа сэлгүүлэн татсаар шуудхан хелгүй ангал руу одов. Тэр, түлхүүр, багахан төмөр саваа, хэдэн фут олс сэлт авч явжээ. Яваа зам нь хөндлөн зурайсан бус, бас ч өгсүүр. гэхдээ өгсөх бус харин аймшигтай салхи түүнийг зүдрээчихэв. Догшин салхи Жерриг нэг ийш нь, нэг тийш нь чулуудаад, арай л сэнсэртэл нь эргүүлэн алдахуйяа айсандаа зүрх нь зогсчих шиг... Гэтэл энэ ган татлага аль дивангарын өгөр хуучин эд. Гэнэт түүний хүндийг, энэ салхины галзуу догшин хүчийг даалгүй тасарчихвал яана?

Энэ бол нууж хаахын аргагүй айдас.

Аюулхай дээр нь яажшуухан
шимширч, өвдөг нь өөрийн эрхгүй
чичрээд, мань хүн хичнээн хичээгээд
биеэ барьж дийлэхгүй байгаагаа
мэдэрч байлаа.

Гэхдээ жаалхүү замаа шийдмэг,
эрсхэн хөөсөөр, анх удаа амсхийхээр
шийдэв. Спилленийхнийг хашгиран
дуудах санаатай зогсох үедээ өгөрч,
зулгарч гүйцсэн ган татлаганы
тасархай төмөр утасны үзүүрүүд тал
тал тийшээ арсайгаад, гарынх нь
цусыг шүүртэл хатгаж буйг сая
мэджээ. Тэд нарын тэргэнцэр өдгөө
түүний чанх дор, хэдхэн футын
зайтай дүүжигнэн байгаа хойно тэр
юу болсон, яагаад ийм аялал хийж

яваагийнхаа учрыг тэдэнд
тайлбарлаж бололгүй яахав.

-Чамд уг нь чадлаараа туслах санж.
Эхнэр маань даанч яадгаа
алдчихлаа. Жаалхүү минь мэдээтэй
яваарай! Би өөрөө ийм юм руу
зүтгэсэн хүн. Гэхдээ чамаас өөр хэн
биднийг эндээс аварч гаргах вэ дээ
хэмээн Спиллен хашгирах нь
дуулджээ.

-Би яалаа гэж та нарыг ингээд орхих
вэ. Ганц минут бололгүй нөгөө эрэгт
гарна гэж Спиллен авгайд хэлээрэй
хэмээн Жерри хариуд нь хашгирав.
Нүд харанхуйлам аадар бороон
дундуур, оньсноосоо мултарсан

дүүжин шиг тал тал тийшээ савчсаар,
хага хага хатгуулсан алганыхаа
тэсвэрлэшгүй өвчинг мэдрэхийн
сацуу байдгаараа хүчилсэндээ
амьсгаадаж гүйцсэн Жерри ашгүй
нэг юм хоосон тэргэнцэрт хүрэв.

Анх гүймэгхэн хараад л, хөвгүүн
дотор хүйт оргим аялал дэмий нэг
хийгээгүүйдээ итгэв.

Тэргэнцэр хоёр дугуйгаараа
дүүжигнэх учиртайсан, гэтэл нэг нь
эдэлгээний уртад
хуучраад, татлаганаасаа
холбирчихож. Бас татлага нь дугуй,
дугуйны онь хоёрын завсар тас
хавчигдаад гацчихаж.

Юун түрүүн дугуйг оньсноос нь мултлах хэрэгтэй нь ойлгомжтой ч, энэ ажлыг гүйцэлдүүлж байхдаа тэргэнцэрийг хөдөлгөөнгүй ган татлаганд олсоор бэхлэх ёстой.

Нэгэн мөчийн дараа Жерри ямар ч гэсэн тэргэнцэрийг тогтоогоод уячихав. Энэ бол хийж чадсан ганц юм нь. Дугуйг гол тэнхлэг дээр тогтоогч ганц чагт зэвэрч хоцроод, юун хөдөлгөх вэ. өнөөхийг нь Жерри нэг гараараа барьж, нөгөө гараараа хамаг хүчээрээ балбаж гарсан ч, салхи амьсгаа авах завдгүй давшлан, дэндүү олонтаа зөрж хий цохиод чагтыг онохгүй байлаа.

Түүний хамаг хүчин чармайлтын арваас ес нь уначихалгүй тэсч байхад чиглэсэн агаад түлхүүрээ алдчих вий хэмээн айсандаа нусныхаа алчуураар гартаа уячихсан билээ.

Хэдийнээ хагас цаг өнгөрчээ. Жерри чагтыг байрнаас нь хөдөлгөж дөнгөсөн ч татаад гаргачихаж даанч хүчирсэнгүй. Тэрбээр арвантаа цөхрөнгөө баран алдсан бөгөөд түүний хамаг хичээл зүтгэл, өөрийгөө тарчлаасан тэр аюул аймшиг, бүх юм ингээд талаар болж буй мэт санагдсаныг яана.

Гэтэл гэнэт сэтгэлд нь нэг юм

зурсхийгээд явчих шиг. Хөвгүүн галзуу солиотой мэт хамаг халаасаа яаруу сандруу онгичиж эхэллээ. Өөртөө хэрэгтэй байсан юмаа ашгүй олов. Урт бүдүүн хадаас.

Хэрэвзээ хэдийд, яаж халаасанд нь орсон нь үл мэдэгдэх энэ хадаас байгаагүй бол Жерри дахин эрэг рүү буцахаас өөр аргагүй болох байж. Чагтны нүх рүү хадаасаа шургуулаад сая нэг юм барьцтай болж, минут өнгөрөв үү яав, чагт голноосоо сая сугарав.

Дараа нь татлага, дугуйны оньсны хооронд гацсан дугуйг төмөр саваагаар гаргачих санаатай

ноцолдож эхлэвэй. Энийгээ
гүйцэлдүүлэв үү яав, Жерри дугуйг
хуучин байранд нь тавьж, басхүү
олсоор чангаан дэмнэсээр
тэргэнцэрийг татаж, дугуйг арайхийн
ган татлага дээр гаргаж ирэв.

Тэр бүхэнд чамгүй цаг гарзадсан буй
заа. Жерриг ийшээ хүрч ирсэн тэр
мөчөөс хойш хагас цаг өнгөрчээ.

Одоо бол харин тэр дүүжин суудал
буюу "Эмээлээсээ" сугарч, тэргэнцэр
рүү үсрэхээр сая сэтгэл шуудрав. Хүү
тэргэнцэрийг тогтоож байсан олсыг
тайлваас дугуйнууд ган татлагаар
ажуухан гулган өнхөрч эхэллээ.

Тэргэнцэр хөдөллөө! Хаа ч юм бэ
тэрүүхэн дор, түүнд харагдахгүй л

дээ, гэхдээ Спилленийхний тэргэнцэр бас торхийн хөдөлж байгаа гэдгийг хүү мэдэлгүй яахав. Гагцхүү эсрэг зүгт.

Өдгөө түүнд тоормосны хэрэг юун, яагаад гэвэл түүний биеийн хүнд, Нөгөө тэргэнцэрийн хүндийг хангалттай тэнцүүлж байгаа юм чинь. Удсан Ч үгүй үүлэн чанадаас өнийн танил, сэтгэлд өегхөн эргэлдэгч хүрд тодрон тодорсоор гарч ирвэй.

Жерри газар үсэрч буугаад оерийнхөө тэргэнцэрийг бэхлэв. Үүнийг тэр тайван, яг таг гүйцэлдүүлээ. Харин дараа нь гэв

гэнэт, ямар юмных нь баатрын ёс
донж байхав, хүрдний тэрүүхэн
хажууд газар харуулдаж унаад, юун
асгарах бороо, исгэрэх шуургыг
бодох манатай, енгинэтэл үйлчихав.

Тэгэх шалтаг даанч мундахгүй олон
байлаа. Хага хага татуулсан гарынх
нь тэсвэрлэшгүй янгинаан,
аймшигтай зүдэргээ ядаргаа,
Спиллен эдүгээ эхнэртэйгээ айх
аюулгүй болсныг тунхаглагч халуун
дулаахан, бялуурам баяр баясгалан,
өчнөөн цаг түүнээс холдоогүй
аймшигтай түгшүүр, сэтгэлийн
тамаас сая мултарч буйгаа мэдэрсэн
нь энэ бүлгээ.

Тэд хол байгаа, түүнд талархаж чадахгүй нь ч ойлгомжтой. Гэхдээ догширон бургилж улаан цагаанаар сахрах голын цаана, хаа нэгтээ тэд одоо "Хошингорын навч" уурхай руу зөрөг замаар яарч яваа гэдгийг тэр сайн мэдэж байлаа.

Жерри гуйван дайван гэр рүүгээ гэлдрэв. Түүнийг атгаад авангуут хаалганы цагаан бариул цусанд улааран будагдсан ч, энэ мэтийг хүртэл анзаарсангүй.

Хүү бахдал дүүрэн, өөртөө сэтгэл ханамжтай байсан агаад зөв юм хийсэн гэдгээ мэдэж буй юм чинь, тэгээд ч хуурч мэхлэхийг сураагүй

хойно, сайн сайхан үйл бүтээсэн
гэдгээ өөрөө өөртөө хүлээн
зөвшөөрөхөөс даанч нэг айсангүй.
Гагцхүү, ээ дээ, аав минь энд байсан
бол, намайг харсан ч болоосой гэсэн
бяцхан гашуун харамсал түүний
зүрхэнд оволзон байлаа.

Мапуигийн байшин

Хэдий хүнд нүсэр, сүр бараатай ч
сэвэлзэн үлээх цагаан салхинаа
"Аораи" далбаат хөлөг дуулгавартай,
гавшгай урагшилж, давалгаа
хуйлран эхэлж буй тэр газар арай
хүрэлгүй зангуугаа буулгахын өмнө
ахмад хөлгөө арал руу тун ойрхон
аваачив.

Хикуэру арал бол зуун ярд өргөн,
эрэг хөвөө нь хорин бээр урт,
далайн түрлэгийн дээд төвшнөөс
ердөө дөрөв тавхан фут өргөгдсөн,
бутармал шүрэн элснээс тогтсон
дүгрэг хуурай газар бүлгээ.

Ихээ уужим, толь лугаа адил тогтуун,
тунгалаг уст тэнгисийн булангийн
ёроолд сувдат дун нэн элбэг,
нарийхан шүрэн хүзүүвчний
цаахантай сувд эрэхээр шунгагч нар
ус руу үсрэн, эрэг дээр дахин гарч
ирж буй нь хөлгийн тавцангаас
харагдаж байлаа. Гэхдээ
худалдааны Хөлөг ч эл хүзүүвч рүү
орж эс чадна. Сэлүүрт жижиг онгоц
л аясын салхитайд тахиралдаж
тохойрсон гүехэн уст хоолойгоор
тийш хүрч очиж Чадахаас бус
далбаат хөлгүүд зогсоолд саатан,
эрэг рүү завь илгээдэг буй заа.

"Аораи"-аас яах ийхийн завдгүй завь
буулгаж, ташаандаа улаан бөс

зангидсан хэдэн хар арьст нүцгэн
усан цэрэг тийшээ харайлдан бууж
сэлүүр барьж авбаас, европ
эрхэмүүдийн халуун оронд өмсдөг
шиг цагаан Костюмт залуу залуур
атган, завины хитэг дээр суулаа.
Гэхдээ тэрбээр цэвэр цусны европ
хүн биш, түүний цагаан арьсных нь
алтан шаргал туяа, цэнхэр нүднээ
гялалзагч шаргал толбонууд нь
полинез цустайг нь илтгэнэ.

Тэр бол баян худалдаачин, зургаан
худалдааны далбаат онгоцны эзэн
авхай Мари Раулийн бага хүү Рауль,
Александр Рауль авай. Завь
тэнгисийн хоолойн босгон дээрх
усны эргүүлгийг гэтэлж, бургилан

сахрах давалгаан ханан дундуур
хага зүсэн гараад, толь шиг тогтуун
булангийн уснаа шунгав. Рауль
цагаан элсэн дээр харайж буугаад,
нутгийн нэгэн нуруулаг уугуултай гар
барин мэндчиллээ. Уугуулын цээж
мөр ханхар, нүд булаам боловч үе
үе яс нь цайран таталзах хэдхэн
дүйм мухар баруун гар нь махчин
аварга загастай учирсныг, түүнээс
хойш энэ хүн сүвдны хойноос
шумбаж дийлэхээ хэзээний болиод,
олиггүй луйварч, хошуу амаа
худалдагч болсныг илтгэх аж.

-Чи дуулсан уу, Алек гэсэн нь түүний
эхний үг байлаа. -Мапуи сүвд олсон,
Ямар гэж санана! Тиймийг Хикуэрүд

байтугай Паумоту даяар хаанаас ч,
бүр хамаг ертөнц дэлхийн хаанаас ч
олохгүй. Үнэ цохиод тэрийг нь авчих,
одоохондоо эзэндээ байгаа. Тэр
мунхаг үнэ хэлж юу шалиа аж. Би
чамд эхлээд дуулгасныг умартав.
Тамхи байна уу?

Рауль дээшээ эрэг даган өндөр дал
модны доорхи овоохой руу
алгуурлалгүй алхлаа. Тэрбээр
худалдааны төлөөлөгчөөр ээжийндээ
алба хаадаг бөгөөд Паумотугийн бүх
арлаар тойрч, дун, сувд худалдаж
авах нь түүний үүрэгт багтдаг билээ.

Тэр энэ албанаа шинэ хүн бөгөөд
дөнгөн данган хоёр дахиа

төлөөлөгчөөр хөвж буй болохоор
сувдаа үнэлж чадахгүй байх вий
хэмээн нууцхан түгшинэ. Харин
Мапуи түүнд сувдаа үзүүлэнгүүт
сэтгэлдээ гайхан дуун алдсанаа хав
дарж чадсанаар барахгүй,
тоомсоргүй, ажил хэрэгч хөндийхөн
дууныхаа өнгийг өчүүхэн ч
чичрүүлсэнгүй. Үнэндээ тэр сувд
түүнийг бүр мэлрүүлжээ. Том
жижгээрээ тагтааны өндгөн чинээ
өчүүхэн ч өө сэвгүй бөв бөөрөнхий,
гялбам цагаан тэр сувдны толион
дээр өнгө гэрэл бүхэн бүүдгэр
сүүмэн гэгээтэй ойж үзэгдэх ажээ.
Бүр яг амьд юм шиг тийм сувд. Рауль
хэзээ ч ийм юм үзээгүй. Мапуиг

түүний алган дээр сувдаа
тавихад хүнд жинтэйд нь мэл
гайхав. Тэр томруулдаг шилээр
хичнээн шимтэж хараад ч өчүүхэн ан
цав, сэв, цэг олж чадсангүй. хариугүй
ингээд агаарт замхраад сүлрээд алга
болох нь гэмээр тийм тунгалаг,
сүрлэг, цэмцгэр харагдах аж. Сүүдэр
газарт бол тэр сарны тунамал
солонгот гэгээ цацруулан туяарна.
Тэр тунамал цагаан өнгө нь Рауль
сүвдыг шилэн аягатай ус руу хаяваас
арай гэж ялгахаар тийм тунгалаг
байлаа. Аяганы ёроол руу хурдан
живсэнийг хэлэх үү, мань эр жинг нь
тэр дор нь цэгнэв.

-Энэ сувдаа тэгээд чи хэдээр өгөх юм

Бэ дээ? хэмээн жишим ч үгүй дүр эсгэн асуулаа.

-Би юу хүсч... гэж Мапуи дөнгөж хэлтэл, түүний хүрэл хүрэн царайн хажуугаар эхнэр, охин хоёр нь бас хүрэн нүүрээрээ урагш түрж, үгийг нь нотлон толгой дохиод басхүү догдлол хөөрлөө дарж ядан, нүдээ шуналтайяа гялалзуулсаар, хүзүүгээ бүр гүрдийлгэжээ.

-Над байшин хэрэгтэй хэмээн Мапуи цааш нь өгүүлэв. Цайрдмал төмөр дээвэртэй, ханандаа найман өнцөгт цагтай, тэгээд уртаараа дөчин фут байг, тойроод сэрүүн тавцантай ч байг. Бас голдоо том өрөөтэй, тэндээ

дугуй ширээтэй, ханандаа туухайт
унжлагатай гоё цаг дүүжилсэн, аа
бас тийм дөрвөн унтлагын өрөөтэй,
том өрөөний хана бүхэнд хоёр өрөө
байна гэсэн үг шүү дээ, унтлагын
өрөө бүхэнд төмөр ор, хоёр сандал,
гар нүүрийн угаагуур байх ёстой.
Байшингийн ард харин гал тогоо,
хоолны түмпэн сав, хайруулын таваг,
пийшинтэй сайхан гал тогоо байна.
Чи энэ байшинг миний төрөлх
Факарава арал дээр надад зориулж
барьж өгөх ёстой.

-Ингээд болов уу хэмээн Рауль итгэж
ядсан янзтай лавлав.

-Бас оёдлын машин хэрэгтэй гэж

Мапуигийн эхнэр Тэфара дуугарав.

-Дүүжинтэй ханын цаг заавал байх ёстой шүү гэж Мапуигийн эх Наури хошуу нэмлээ.

-За ингээд боллоо гэж Мапуи дуугарав.

Рауль тэссэнгүй инээд алдчихав. Тэр хөгжилтэй нь аргагүй элгээ эгштэл хөхрөв. Гэхдээ инээж байхдаа тэр ухаан бодолдоо тоо бодлогын хэцүү оньсогыг адгуухан тааж байсан бөгөөд тэр хэзээ ч байшин барьж үзээгүй, байшин барих тухай түүний ойлголт ч там тум. Юун инээж хөхрөхөө болих, Таити руу барилгын

хэрэглэгдэхүүний хойноос явах, Факарава руу буцах замын хөлс, эд агуурсаа буулгах, барилгын ажил сэлт хичнээн мөнгө болохыг дотроо тоймлов. Тэр бүхэнд асар их мөнгө, Дөрвөн мянган франц доллар өөрөөр хэлбэл, хорин мянган франк Хэрэгтэй болно. Ухаанд багтамгүй. Ийм сувд хэд хүрэхийг тэр яаж мэдэх вэ дээ. Хорин мянган франк чинь толгой эргэм их мөнгө, тэгээд ч тэр Мөнгө ээжийнх нь мэдэлд байдаг.

-Мапуи чи мулгуу амьтан. Мөнгөөр үнээ хэл гэж тэр хэлэв.

Тэгтэл Мапуи толгой сэгсэрч, ар дахь

гурван толгой нь бас сэгсэлзлээ.

-Надад байшин хэрэгтэй, урт нь дөчин фут, тойроод сэрүүн лавринтай бас гэж тэр хэлэв.

-Тийм ээ, тийм гэж Рауль түүний үгийг таслаад: -Байшингийн хувьд би бүгдийг ойлголоо,

гэхдээ энэ чинь яаж бүтэх юм бэ? Би чамд мянган чили доллар өгье...

Чив чимээгүй татгалзаж буй дохио аятай дөрвөн толгой дор дороо сэгсэлзэнэ.

-Зуун чили долларын зээл өгье.

-Надад байшин хэрэгтэй... гээд
Мапуи нөгөөхөө ярьж эхэллээ.

-Байшин чамд ямар хэрэгтэй юм бэ
гэж Рауль асуугаад: -Эхний далайн
шуурга түүнийг чинь далайд
чулуудчихна биз дээ. Чи өөрөө
үүнийг мэдэж байгаа шүү дээ.
Одоохон ингээд шуурга дэгдэж
мэднэ гэж ахмад Раффи ярьж
байсан.

-Факаравад бол харин тиймгүй шүү,
тэндхийн эрэг хамаагүй өндөр. Энд
бол ч ёстой чулуудчихаж магад,
Хикуэруд ямар ч шуурга бөөн аюул
Би Факаравад л байшин бариулмаар
байна, дөчин фут урт бас тойроод

сэхээвчтэй гэж Мапуи ярина.

Тийнхүү Рауль байшингийн тухай бүх яриа хөөрөөнийг дахиад нэг сонсов. Тэр улиг домог лугаа адил бодлыг уугуулын тархинаас гаргаж хаях гэж тэр хэдэн цагийн турш оролдоод ядчихав. Гэтэл эхнэр нь, Мапуигийн ээж ч, охин Нгакура нь хүртэл түүнийг дэмжсээр байлаа Хүслэнт байшингийн тухай дэлгэрэнгүй дүр зурагт тайлбарыг хорь дахь удаагаа сонсож ахуйдаа "Аораи"- гаас хоёр дахь завь эрэгт дөхөж ирж буйг Рауль овоохойн дэлгээтэй хаалгаар олж харав. Сэлүүрчид гараасаа сэлүүрээ үл салгана. Хараажаар тэд эндээс зайлъя хэмээн байж ядаж

яваа нь тэр биз. Далбаат хөлгийн ахмадын туслах элсэн дээр харайн буугаад, ганц гарт уугуулаас нэг юм асууснаа, Рауль руу түргэн түргэн алхлан айсуй. Гэнэт харанхуй болчих нь тэр, аянга цахилгааны үүлс нарыг халхалжээ. Овоохойн цаагуур тэнгис дээгүүр аймшигт салхины бараа гайхмаар түргэн, ямар сүртэй ойртож буй нь тодхон харагдана.

-Ахмад Раффи эндээс зайлах хэрэгтэй гэж хэлж байна хэмээн туслах шууд ярьж эхлээд - Сувд байсан ч хамаагүй зайлах хэрэгтэй, аз байвал дараа нь цуглуулж амжилгүй дээ хэмээн дамжуул гэж тэр тушаасан. Барометр хорин ес,

дал хүртэл уначихлаа.

Салхины уухичаан Раулийн тэргүүн дээрх дал модыг чичирч хяхнатал ганхуулаад, цааш шуугин одож, боловсорч гүйцсэн наргилын хэдэн самар газар түг түгхийн ойчив.

Бороо асгарлаа, эхлээд тэртээд. дараа нь догшин салхитай хавсран нааш нүүгэлтсээр, улам ойртсоор. тэнгисийн булангийн ус шавхраг намнанд автав. Навчисан дээгүүр түжиг тожиг буусан эхний дуслууд Раулийг ухасхийлгэн хөл дээр нь босголоо.

-Мянган чили доллар бэлнээр, Мапуи, бас хоёр зууг зээлээр... гэж

тэр хэллээ.

-Надад байшин хэрэгтэй... гээд
Мапуи үгээ зөөнө.

-Мапуи! Чи муу мулгуу гэж Рауль
салхины исгэчээн дундуур бархирав.

Тэр урцнаас огло харайн гарч, эрэг
дээр хүлээж буй завиндаа ахмадын
туслахтай хамт яаж ийж байгаад
дөхөж очив. Гэтэл завины бараа
алдрав. Халуун орны их аадар
бороо тэднийг хана мэт хүрээлэн
харанхуйлсан болохоор зөвхөн хөл
доорхи эргийнхээ бяцхан тасархайг,
тэнгисийн булангийн элснээс хазлах
хорон жижиг давалгаануудыг л харж

байлаа. Гэтэл дэргэд нь хүний дүрс тодроод ирлээ. Тэр бол мухар гарт Хуру-Хуру байлаа.

-Сувдыг нь авсан уу гэж тэр Раулийн чихнээ орилов.

-Мапуи муу тэнэг хэмээн тэр хашгирсан агаад дараагийн хоромд борооны харанхуй нижигнээн тэднийг салгав.

Хагас цагийн хойно Хуру-Хуру арлын тэнгис өөд хошуурсан талд зогсоод, далбаат хөлөг өөд хоёр завийг яажшуухан өргөж "Аораи" эргэн арлаас алсран далд орохыг харав.

Гэтэл яг тэр газар нь шуурган жигүүр хөлөглөж ирсэн мэт өөр нэг далбаат онгоц хүрч ирээд зангуугаа орхин зогсож, завь буулгалаа. Тэрбээр энэ далбаат хөлгийг мэдэх билээ. Энэ бол өөрөө арал хэсүүчлэн сувд худалдаж авдаг эрлийз, доншуур худалдаачин Торикийн "Орохена" хөлөг бөгөөд одоо тэр завиныхаа хитзг дээр зогсож яваа. Хуру-Хуру бачтай нь аргагүй хөхрөв. Мапуи Торикигоос аль ноднин бараа зээлээр худалдаж аваад өрөнд баригдсан гэдгийг тэр мэдэх билээ. Аянга цахилгаан өнгөрлөө. Нар төөнөж, тэнгисийн тохойн ус толь мэт тогтуун налайна. Гэхдээ агаар

цавуу шиг зунгааран хүнд оргиод,
уушиг бачууруулж, амьсгаа
давхцуулна.

-Чи сонин дуулаа биз дээ? Торики
гэж Хуру-Хуру шалгаана. Мапуи сувд
олсон. Хикуэруд бүү хэл Паумоту
даяар хаана ч, бүх дэлхий
ертөнцийн хаана ч, хэзээ ч тиймийг
олж байгаагүй. Мапуи мунхаг. Бас
тэр чамд өртэй. Би чамд анх
дуулгасныг мартав. Тамхи байна уу?

Ингээд Торики бас Мапуигийн
хулсан овоохойн зүг алхаж одлоо.
Тэр бол харин эзэрхий, давилуун
нэгэн, бас ухаан мөхөс. Тэр
гайхамшигт сувд Руу жишим ч үгүй

нүднийхээ булангаар хэрав. Бүр хяламхийснийг нь яана, Тэгснээ амгалан нь аргагүй өөрийнхөө халаасанд шургуулчих нь тэр.

-Муу хүний заяа түшиж. Сайхан сувд байна. Би чамд барааны зээл нээж өгье гэж тэр хэллээ.

-Надад байшин хэрэгтэй... хэмээн Мапуи айдас дүүрэн үгээ зөөн: - Дөчин футын урт...

-Тэр байшинтайгаа чи далд ороорой хэмээн худалдаачин түүнийг зандраад: -Өр ширнээсээ салж үз, чамд хэрэгтэй юм гэвэл энэ л байна. Чи надад мянга хоёр зуун чили

долларын өртэй байсан. Сайхан!
Одоо чи над ямар ч өр ширгүй. Бид
данс дугуйллаа. Тэрнээс гадна би
чамд хоёр зуун чили долларын зээл
нээж өгье. Хэрэв Таитид энэ сувдаа
боломжийн үнээр борлуулчих юм
бол чиний зээлийг дахиад зуугаар
нэмнэ, тэгэхээр бүгд нийлээд гурван
зуу болно. Гэхдээ зөвхөн үүнийг
ашигтай зарчих юм бол тэгнэ гэдгийг
санаж яваарай. Би үүнээс чинь
алдагдал хүлээж ч магад.

Мапуи гараа гаслантайяа элгэндээ
зөрүүлж, толгойгоо ганзагалав.
Түүнээс амин эрдэнийг нь
луйвардчихав. Шинэ байшинтай ч
болохгүй, тэр өрөө арай гэж даржээ.

Сувдныхаа оронд тэр юу ч авсангүй.

-Чи тэнэг хэмээн Тэфара хэлэв.

-Чи тэнэг, чи юу гэж тэрэнд сувдаа өгсөн юм бэ! гэж хөгшин Наури уурсав.

-Би яах ёстой байсан юм? Би тэрэнд өртэй. Намайг сувд шүүрдсэнийг тэр мэдэж л дээ. Үзүүлээд орхиоч гэж тэр яаж гүйсныг чи өөрөө дуулаа биз дээ. Би түүнд юу ч хэлээгүй, тэр өөрөө мэдэж, Өөр хэн нэгэн энэ тухай түүнд хэлжээ. Би түүнд өртэй байсан юм.

-Мапуи тэнэг дээ гэж Нгакура охин

нь хошуу дүрэв.

Тэр арван хоёр настай, ухаан суутал хаа билээ. Сэтгэлээ зайчуулья гэсэндээ Мапуи түүнийг шороо үмхэж унатал нь нударгалав. Тэфара Наури хоёр нулимсаа урсган, эмс өөрсдийнхөө унаган зангаар яадаг л билээ, тэр янзаараа түүнд өөд уруугүй зэм хүртээж гарав.

Хуру-Хуру эрэг дээр зогсоод өөрийнх нь танил гурав дахь далбаат онгоц аралын булангийн босгон дээр зангуугаа орхин, завь уснаа тавьж буйг харлаа. Хөлөг "Хира" нэртэй, зүгээр ч ийм нэртэй бус, эзэн нь германы еврей, сүвдны толгой баян

худалдаачин Леви, харин Хира гэдэг нь Таитигийн хулгайч, загасчдыг ивээгч бурханы нэр билээ.

-Чи сонин дуулаа биз дээ? хэмээн Хуру-Хуру данхар том толгойт, лагс бүдүүн, царай зүс хөрзгөр хүйтэн Левиг эрэг дээр хөл тавив уу. үгүй юу эг маг асуугаад: -Мапуи сувд олсон. Хикуэру байтугай бүх Паумоту, бүр ертөнцийн хаана ч тийм сувд байхгүй. Мапуи мунхаг түүнийгээ Торикид мянга дөрвөн зуун чили доллараар зарчихсан, би тэдний яриаг сэм чагнасан юм. Торики ч бас тэнэг амьтан. Чи түүнээс сувдыг нь худалдаж авч болно, хямдхан даа. Би чамд түрүүлж дуулгасан шүү,

мартавзай. Тамхи байна уу?

-Торики хаа байна?

-Ахмад Линчийнд абсент ууж байгаа. Мань хүн тэнд суусаар хэзээний бүтэн цаг болж байна.

Тийнхүү Леви Торики хоёр абсент хөнтөрсөн шиг, сүвдны үнэ хэлэлцэн, наймаа тохирох зуурт Хуру-Хуру тэднийг сэм чагнаж, үзэгдэж дуулдаагүй үнэн дээр, хорин таван мянган франкаар тохирсныг дуулжээ.

Яг энэ үед "Орохена", "Хира" хоёр арал руу бүр энүүхэнд дөхөж ирээд,

их буугаар нирхийтэл буудацгааж, бачимдан дохиолж эхэллээ. Ахмад Линч, түүний зочин байшингаас гарахдаа хоёр хөлөг сандруухан эргэж, явдал дундаа далбаануудаа хумин, шуургалах салхины түйвээнд цайвалзах усан дээгүүр тээр дор хэлтийн шунгасаар, эргээс холдон одож буйг харж амжив. Төдөлгүй онгоцнууд бараан хананы цаагуур далдарлаа.

-Шуурга намжихаар эд эргээд ирнэ. Хоёулаа эндээс зайлалгүй горьгүй нь дээ гэж Торики шавдууллаа.

-Барометр бүр унаа биз гэж ахмад Линч өгүүлэв.

Тэр бол далайд гарахаа хэдийн болиод гагцхүү Хикуэрүд багтраа өвчинтэйгээ учраа ололцон амьдарч болно гэдгийг эрт ухварласан, их сахалт буурал өвгөн билээ. Тэр байшинд орж, барометр өөд өлийн харав.

-Ээ бурхан тэнгэр минь гэхийг нь тэд дуулаад, араас нь дагдгасхийн орвоос хорин ес, хорийг зааж буй барометрын зүүг өвгөн сүр сүлдгүй гөлөрчихсөн зогсож байлаа.

Эрэг дээр ахин гарч ирээд тэд тэнгэр, далайг түгшүүр дүүрэн ширтэлхийлэе. Шуурга өнгөрсөн ч харин тэнгэр онгойсонгүй. Далбаат

хоер ч хөлөг бас тэдэнтэй цуг дахиад
нэг онгоц хамаг дарвуул юугаа
дэлгэн арал руу айсуй. Гэтэл салхи
юу юугүй эргэн хувьсхийж, далбаа
сэлт нь хумигдлаа. Тэгснээ таван
минут өнгөрөв үү яав, догшин хуй
салхи тэдний яг эсрэг талаас улаан
халз өөдөөс нь дайрахад, урьд
талынхаа далбаануудыг яажшуухан
сандчин хумиж, дараа нь бүр
хураачих нь эргээс илхэн харагдана.
Тэнгисийн дуун бүгтхэн боловч
сүрлэг догшин түрхрээд, хүчит
давалгаан эхэллээ. Цахилгаан зүрх
халирам гялбасхийн, бүрхэг
тэнгэрийг хага ярж, аянга чих
дүлийрэм тас няс буугаад явчихлаа.

Торики, Леви хоёр завь руугаа хар гүйхээрээ довтолгов. Леви сүнсээ зайлтал айсан усны үхэр аятай овгос оагос харайна. Тэнгисийн булангаас гарч явахад нь тэдний завины өөдөөс "Аораи"-гаас буулгасан завь хар хурдаараа ирж явлаа. Хитэг дээр нь Рауль сэлүүрчдийг шавдуулан зогсоно. Мөнөөх сувдны тухай бодол түүнд амар заяа үзүүлсэнгүй, тэр Мапуигийн хүслийг гүйцэлдүүлэхээр эргэн ирж буй нь энэ.

Хуру-Хуруг олж харах нь байтугай улаэн нүүрээрээ мөргөлдчихсөн агаад бороо, салхи шуурганы тийм харанхуй хуй дунд мань эр элсэн дээр харайн буужээ.

-Өнгөрсөөн -хэмээн Хуру-Хуру бархираад: -Мапуи нөгөөхийг чинь Торикид мянга дөрвөн зуун чили доллараар зарсан, тэгсэн Торики авангуутаа Левид хорин таван мянган франкаар өгчихлөө. Харин Леви түүнийгээ Францад зуун мянгаар зарна биз. Тамхи бий юу?

Рауль дотроо онгойтол сүүрс алдав. Түүний хэмаг зовиур тийнхүү оцэслэлээ. Хэдий өөрт нь олдоогүй ч тэр сувдны төлөөнөө ахиад шаналахгүй байж болох нь. Гэхдээ тэр Хуру-Хуруд итгэсэнгүй, Мапуи сувдаа мянга дөрвөн зуун чили доллараар зарсан ч байж мэднэ, гэтэл дол цохисон Леви панзач

тэрүүхний төлөө хорин таван мянган франк төлсөн гэдэг харин юу л бол. Рауль Линчээс лавлахаар шийдэн, буурал далайчны байшинд очтол, мань хүн барометрийнхээ өмнө гайхаш тасарчихсан байхтай яг таарав.

-Чи хар даа, хэдийг зааж байна? гэж ахмад түгшүүртэй асууснаа нүднийхээ шилийг арчаад, барометр өөд ахиад хараа тавилаа.

-Хорин ес, арав. Би лав ийм доогуур зааж байхыг үзээгүй гэж Рауль дуугарав.

-Чиний гайхах яах вэ! Би тавин жил

тэнгис далайгаар хөвөхдөө ийм юм үзээгүй. Дуулав уу? гэж ахмад бувтнана.

Тэд байшин доргион чичиргэх тэнгисийн түрхрээнийг чагнаархсанаа гадагш гарав. Хуй салхи номхорчээ. Эргээс бээр хэртэйд тогтуун, нам гүмд саатаж асан "Аораи" хөлөг зүүн хойд зүгээс ар араасаа сүр хүчин төгөлдөр хуйлран эрчилсээр, шүрэн эрэг өөд догшин түрэмгий сахрах өндөр өндөр давалгаанаа хэлтийн шидэгдэх ажээ. Раулийн сэлүүрчдийн нэг тэнгисийн хоолойн босго өөд зааснаа толгой сэгсэрнэ. Рауль тэр зүг харваас бөөн бөөн

цэгаан хөөс сахран
оргилон үзэгдвэй.

-Би танайд хоног төөрүүлэхээс
аргагүй нь, ахмад аа гэснээ тэрбээр
завиа эрэг дээр татаж гаргаад
өөртөө, бусад сэлүүрч нартаа толгой
хоргодох газар олохыг усан цэрэгт
тушаалаа. Барометрээ дахин
харахаар байшиндаа орсон ахмад
Линч түүнд,

-Яг хорин ес гэж дуулгав.

Тэр байшингаас сандал гаргаж бүр
суугаад тэнгисийн зүг хараа
бэлчээлээ. Үүлэн чанадаас наран
цухуйж. пүнхийсэн бүгчим болсон ч

урьдын адил сэвхийх салхигүй.
Тэнгисийн давалгаан улам
ширүүслээ.

-Хаанаасаа ийм давалгаа босдог
байна аа, ойлгохын аргагүй юм.
Өчүүхэн салхигүй... Та тэрийг хар
даа... Үгүй дээ, та ганцхан тэрийг
хараатах гэж Рауль байж ядна.

Хэдэн бээр сунасан давалгаа өчнөөн
арван мянган тонн ус бяцхан шүрэн
арал дээр нирхийтэл буулгахуйяа
газар хөдлөлтөд автсан мэт арал
чичирхийлэн доргив. Ахмад Линч
бүр мэлэрчихэв.

-Ээ бурхан минь! хэмээн дуу

алдсанаа сандлаасаа өндийгөөд
ахиад лагхийтэл суучих нь тэр.

-Салхи алга. Хэрэв салхи боссон бол
би бас ойлгохсон гэж Рауль үглэнэ.

-Сэтгэл төвдөх юун, салхи гарна
гайгүй гэж ахмад царай барайлган
өчив.

Тэд таг чиг дуугаа хураажээ. Тэдний
биеэс хөлс нь шүүдрийн сая сая
өчүүхэн ширхэг аятай бурзайсаар,
дусал болон газарт савир бууж
байна. Амьсгалах агаар ч үгүй болж,
өвгөн зоеиуртай амьсгаадна. Асар
өндөр давалгаа эрэг өөд хуйлран
наргил мододыг шавхчин

оволзсоноо, ахмад Линчийн хөл рүү хүрэн алдаад ухрав.

-Хамгийн сүүлчийн тэмдэгнээс хамаагүй өндөр байна шүү. Энд би арван нэгэн жил амьдарсан юмсан - гэж тэр хэлснээ, цагаа хараад,

-Яг гурав гэлээ.

Эр эм хоёр баахан хүүхэд, нохой дагуулчихсан эрэг дээр хүрээд ирлээ. Ахмадын байшинд орсноо тэд эргэлзсэн янзтай зогссоор, удтал тээнэгэлзсэний эцэст гарч элсэн дээр сууцгааж, хэдэн минутын дараа гэрийнхээ элдэв эд өлгийг үүрч дүүрсэн өөр нэгэн айл бас нөгөө

талаас ирж, тэдэнтэй нийлсэн агаад
удалгүй ахмад Линчийн байшинг
тойроод хэдэн зуун эр, эм улс,
хүүхэд хөгшид багшралдав. Хүүхнүүд
дундаас гартаа хөхүүл нялхаа
тэвэрсэн нэгэн бүсгүйг ахмад
дуудаж, тэдний байшин дөнгөж
саяхны давалгаанд хуу
хамуулчихсаныг мэдэв.

Ахмадын байшин арлын хамгийн
өндөр газарт хойно, тэдний баруун
зүүнтэйгүүр сүрдэм аймшигт том
том давалгаанууд нарийхан шүрэн
хүзүүвчийг даван сахарсаар
тэнгисийн булан руу уугчин тэмүүлж
авай. Эл хүзүүвч тойргоороо хориод
бээр боловч зөвхөн хаа нэг газраа

гурван зуун фут хүрэхтэй үгүйтэй
өргөн, сувд шүүрддэг цаг ид дундаа
яваа болохоор эргэн тойрны бүх
арлаас, Таитигаас хүртэл нутгийн
уугуул иргэд ийш ирцгээсэн байж.

-Энд одоо мянга хоёр зуун хүн
байна. Маргааш өглөө тэднээс хэд
нь эсэн мэнд үлдэхийг хэлэхэд хэцүү
хэмээн ахмад Линч өгүүлнэ.

-Яагаад салхи гарахгүй байгааг
ойлгохгүй юм гэж Рауль хэллээ.

-Сандрах юун хонгор минь. битгий
сандар, тун удахгүй хамаг аймшиг
эхэлнэ гайгүй.

Ахмад Линчийг хэлж дуусаагүй
байтал аймшигтай том давалгаа
арлыг тэр чигт нь нөмрөөд авлаа.
Тэнгисийн ус булангийн элсийг
гурван ямхын хэртэй нэлд нь
бүрхээд, тэдний сандал тойрон
оволзож, гараа эвхэн жигтэй том
давалгааг харж байсан хүүхдүүд
өрөвдөлтэйеэ енгинэтэл үйлцгаав.
Тахиа, муурнууд усанд тэлчилж
байснаа удсангүй үгсэж хэлэлцсэн
аятай эвтэй найртай нь аргагүй
байшингийн дээвэр өөд зүтгэлэв. Нэг
уугуул дөнгөж төрсөн гөлөгнүүдтэй
сагс барин наргил мод өөд авираад,
газраас хорин футын өндөрт сагсаа
уяж орхивоос эх жингэр нь гийнан

гаслан мод тойрон усан дундуур
шогшино.

Нар урьдын адил нүд гялбатал
гийгүүлсээр авч сэвхийх салхи
байдаггүй. Тэд "Аораи"-г зүг зүг
тийш нь чулуудах давалгааныг
ширтэлхийлэн суулаа. Сүндэрлэн
оволзох усан уулсыг юун харахтай
манатай Линч ахмад нүүрээ
гараараа таглаад байшиндаа
орчихов.

-Хорин найм, жар гэж тэр эргэж
ирэхдээ дуулдахтай үгүйтэй хэллээ.

Түүний гарт баглаа бүдүүн олс
байлаа. Тэрбээр үзүүрээс нь арван

фут урттай хэд огтлоод, нэгийг нь Раульд өгч. нөгөөг нь өөртөө үлдээгээд, "Шалавхан модонд авирцгаа" хэмээн зөвлөнгөө, үлдсэнийг нь хүүхнүүдэд тараачихав.

Зүүн хойд зүгээс хөнгөн цагаан салхи сэвхийж, нүүрийг нь илбэж буйг мэдрэнгүүт Рауль сэргээд ирлээ. "Аораи" сиймхий харж байгаад эргээс холдохоор хөдөлж буйг хараад тэр энд үлдсэндээ жигтэйхэн харамсч билээ. Далбаат хөлөг гай түйтгэрээс зайчина, харин энэ арал... Давалгаа хүзүүвч дээгүүр эрчлэн дайрч, түүнийг арай л гуд татаж унагасангүй, мань эр ч өөртөө нэг мод товлочихоод байснаа,

барометрийг гэнэт санаад байшин
руу ухасхийтэл. босгон дээр
нь ахмад Линчтэй мөргөлдчихөв.

-Хорин найм, хорь. Ох, энд чинь
чөтгөр шулмын холион бантан болох
нь! Энэ чинь юу гээч вэ хэмээн өвгөн
дуу алдав.

Агаар тэнгэр догшин хөдөлгөөнөөр
дүүрлээ. Байшин доргин
чичирхийлэх агаад хүнгэнэсэн их
түрхрээн ойртон айсуйг тэд дуулав.
Цонхны шил хяхнан доргино. Нэг
цонх тас нясхийн хага үсэрч,
өрөөгөөр нэг салхи шуугин исгэчээд,
догшин хүчтэйг нь яана, тэд арай гэж
хөл дээрээ зогсож байлаа. Хаалга

хяхнан тээгээ цууртал саваад,
хаалганы цагаан бариулын
хэлтэрхийнүүд шалаар нэг
цацагдаж, дэндүү яаруу галт хий
шахчихсан агаарын бөмбөлөг лугаа
адил өрөөний хананууд хүлхийж
цүлхийгээд явчихлаа. Тэгтэл их
бууны буудлага аятай шинэ чимээ
анир дуулдаатах нь тэнгисийн
дэлсгээний торгон нуруу
байшингийн ханыг мөргөж буй нь
тэр аж. Ахмад Линч цаг руугаа үе үе
хяламхийх. Өдрийн дөрвөн цаг. Тэр
хөх цэмбэн хүрмээ өмсөөд
хананаасаа барометрээ авч далд
халаасандаа хийсэн бөгөөд шинэ
хүчит давалгаан байшинг лүгхийтэл

бөглүүхэн түншээтэхтэл хөнгөхөн
барилга хойно суурин дээрээ хяхнан
эргэж, булангаараа арван хэм
хазайн доошоо пархийтэл суучихав.

Эхлээд Рауль гадагшаа гарав. Салхи
түүнийг шүүрэн авч, эрэг дагуулан
хөөлөө. Одоо дорно этгээдээс
хүүгүүлж байгааг тэр мэдрэв.
Үхэтхийн унаад, элсэнд наалдан
хэвтэх гэж тэр ер бусын тэнхээ
гаргасан бөгөөд ахмад Линчийг
салхи сүрэл адил хийсгэсээр, түүн
дээр чулуудчих нь тэр. "Аораи"-гийн
хоёр усан цэрэг наргилын дал
модноос үсрэн бууж, тэдэнд
туслахаар ухасхийлдэж ахуйдаа,
салхинаас халирахдаа, алхах бүртээ

газраас зууран ухаан тойнд оромгүй
бөхийн нугарч, эвхэрч авай. Ахмад
Линч юун модонд авирах манатай,
өтөл буурай хойно усан цэргүүд
хэдэн богино олс холбон түүнийг
мод руу алгуурхан өргөсөөр, ашгүй
газраас тавин фут өндөр титэмт
оройгоос нь хүлж орхив. Рауль өөр
нэг дал мод өөд олсоо чулуудаад,
эргэн тойрноо харлаа. Салхи гэж үс
босом. Ийм юм байдаг гэж түүний
зүүд тойнд ч ороогүйсэн, хүзүүвч
дээгүүр хуйларсан давалгаан
түүнийг өвдөг хүртэл нь норгоод,
тэнгисийн булангаар халив.

Нар хүүшлээд, тугалган өнгөт харуй
бүрий нөмрөв. Борооны хэдэн дусал

түүний хажуугаас үрлэн сум аятай
цохилж, нүүрэн дээгүүр нь давстай
хөөс урсаад, хацар нь өвдсөндөө
алгадуулсан мэт хорсон, нүдэнд нь
нулимс цийлэгнээд иржээ. Хэдэн
зуун хүн модонд асаад, өөр цагсан
бол Рауль энэ улсыг хараад хөх
инээд нь хүрэхсэн биз. Гэхдээ тэр
Таитид төрсөн болохоор юу хийхээ
мэднэ, мань эр бөхийгөөд модыг
гараараа бахимхан тэвэрч, хөлөө
чанга чанга жийсээр модны орой
өөд мацав. Дал модны титэм дээр
хоёр авгай, хоёр охин, нэг эр хүнтэй
тааралдав. Охидын нэг нь муураа
цээжиндээ тас тэвэрчээ.

Өөрийнхөө шовгороос тэр буурал

ахмад руу гараараа даллаваас
цаадах нь түүн рүү догь аргагүй
хариу даллаж, Рауль тэнгэрийн
барааг хараад дотор нь палхийв.
Зулай дээр энүүхэн дор тулаад ирсэн
мэт үүлс бараантах агаад саяхан
тугалган байснаа одоо бүр тас хар
болоод явчихлаа. Олон хүн модны
дор, модноос зууран бөөн
бөөнөөрөө газар суусаар, хаа ч юм
бэ залбирцгааж, хэсэг улсуудын
өмнө бүр мормоны доншууч сурталч
айлтгал үйлдэж, хөг хэмнэлтэй
намуухан, хүрэлзгэний алсын цар
цар дуун шиг хачин жигтэй чимээ
анир Раулийн сонорт хүрч, ердөө
минут хэртэй дуулдав. Гэтэл тэрхэн

эгшнээ түүнд диваажин, тэнгэр хурмастын эгшиглэнгийн тухай бодол бүүр түүрхэн сэрхийтэл бодогдоод эргэж хартал бусад модод дор ч баахан хүн бие биеэсээ зууран, олсноос чангаалдан буй нь харагдав. Тэдний царайны өнгө, тэдний уруулын нь ижилхэн хөдөлгөөнөөр цөмөөрөө залбирлын дуу дуулж буйг тэр ойлгожээ.

Салхи улам догширлоо. Тэр бүхнийг Рауль ямар ч атугай хэмжээсээр хэмжие гэхнээ эрхгүй мөхөсдөнө. Салхины тухай өнө урьдын түүний бүх төсөөллийг энэ хуй ардаа хол орхиж одсон ч, яагаад ч юм тэр салхи улам ширүүсэн байгааг

мэдэрсээр байлаа. Түүнээс
холгүйхэн мод үндсээрээ булга
татагдаж, дүүжлэгдэн байсан улс нь
газраар нэг ширвэгдээд, элсний
давчуухан зурвасаар давалгаан
эрчлээд өнгөрөхүйеэ унасан хүмүүс
нь ор мөргүй алга болчихно. Бүх
зүйл жигтэй хурдан өрнөнө. Раулийг
харж байхад тэнгисийн булангийн
цагаан хөөст уснаа хар толгой, хүрэн
цээж үзэгдсэнээ, дараагийн эгшинд
хараанаас нь арчигдан алга болно.
Модод гудайн гудайсаар унаж,
чүдэнзний мод лугаа адил цуу
үсэрнэ. Рауль салхины хүчийг
гайхаад ч баршгүй. Түүний дээр нь
амиа тээж буй дал мод бас

аймшигтай сул хий найган ганхахад,
авгай нарын нэг охиноо чанга
тэврэн орь дуу тавьж, харин нөгөөх
нь муураа гараасаа үл салгана.

Хоёр дахь хүүхдийг барьж байсан эр
Раулийн мөрөнд хүрснээ, доош
заалаа. Түүний энэ модноос зуун
алхмын тэртээд мормоны сүмийн
шовгор гонхон согтуу мэт явдал
дундаа ганхах агаад сууринаасаа
ховх татагдсан түүнийг өдгөө
давалгаа, салхи тэнгисийн булан руу
түрэн хөөж буйг Рауль олж харлаа.
Давалгааны аймшигт хүч түүнийг
дор нь шүүрч хөрвүүлээд. наргилын
бөөн дал мод руу чулуудчих нь тэр.
Модон дээрх хүмүүс болсон

наргилын самар адил ширвэгдэн
ойчиж, уугчих давалгааны дараа тэд
хөсөр ундуй сундуй хэвтээд үлдэнэ,
зарим нь хөдөлгөөнгүй, зарим нь
сарвалзан атиралдах бүлгээ. Тэд
яагаад ч юм Раульд шоргоолжийг
санагдуулах аж. Өдгөө түүнийг юу ч
айлгаж чадахгүй, тэр айж эмээсэн ч
үгүй, дараагийн давалгаан
яажшуухан хүмүүсийн энэ
үлдэгдлийг ус руу хуу арчин одохыг
айвуу тайвуу, хэрэг болгон
ажигласаар. Бүхнээс хамгийн аварга
нүсэр гурав дахь давалгаан гонхоныг
тэнгисийн булан руу чулуудаад,
хагас нь живэн хөвсөөр харанхуйд
далд орж, Ной түүнийг завин дээрээ

гаргаж авах ч юм уу, үгүй ч юм уу хэн мэдэх билээ.

Ахмад Линчийн байшинг Рауль нүдээрээ хайсаар, алга болж орхисонд нь гайхаж ядан арай гэж итгэв. Тийм ээ, тэр бүхэн дэндүү хурдан өрнөжээ. Тэсч үлдсэн моднуудаас олон хүн газарт буусныг тэр ажиглав. Гэтэл салхи улам ширүүслээ. Рауль үүнийг өөрийнхөө дал модны савалтаар багцаалдав. Тэгснээ мод урагш хойш савчиж найгахаа болиод, бараг л хөдөлгөөнгүй эгцэрч ирснээ, салхины шахалт даралт дор байдгаараа нугдайгаад, зөвхөн чичрэн доргиод эхлэх нь тэр. Гэхдээ тэр чичиргээнээс

бөөлжис нь хутгаад хариугүй
хоолойд нь нэг юм пэлбийн тулж
ирээд, тэр бүхэн хөгжмийн чичиргэн
авиа, гавай гитарын утасны
доргионыг санагдуулах агаад дал
мод ер бусын түргэн салганан
чичигнэн буй нь хамгаас аймшигтай,
хэрэв түүнийг үндсээр нь булга
татдаггүй юмаа гэхнээ тийм
даралтыг удтал тэсвэрлэлгүй
хариугүй цуу үсрэх нь.

Тээр! Нэг мод тэссэнгүй! Хэдийдээ
цуу үсэрчихсэнийг нь тэр мэдсэн ч
үгүй, гэхдээ л хугархай нь тэр байна,
голынх нь хагас. Нүдээр үзээгүй цагт
юу болж буйг төсөөлөхийн эцэсгүй.
Мододын тачигнаан хяхтнаан,

гийн аан, хүмүүсийн гаслант орь дуун
аймшигт түрхрэн, салхи, тэнгис
хоёрын нижигнэн дунд эрхгүй
живнэ. Энэ аймшигт үймээнт явдал
ид оволзож ахуйд Рауль ахмад
Линчийн байгаа зүг өөд нүд бэлчээж
байсансан. Дал мод тэг дундуураа
чимээгүйхэн хуга үсэрч, гурван усан
цэрэг, буурал ахмадын зүүгдсэн
титэм нь тэнгисийн булангийн зүг
шидэгдэхийг тэр харжээ. Тэд
унасангүй, харин сүрэл мэт агаарт
дэгдээд, мань эр хийсэн одогсдын
араас нүд салгасангүй, өнөөдүүл
эргээс зуугаад алхмын цаана усанд
палхийтэл ойчив. Тэрбээр нүд
хурцлан араас нь харж, ахмад Линч

хагацлын тэмдэг болгон түүн рүү
гараараа даллахыг олж үзжээ. Тийм
юм үзсэнээ тэр андгайлсан ч чадах
буй заа.

Рауль ингээд хүлээгээд, харзнаад
байхыг хүссэнгүй, тэрбээр уугуулын
мөрөнд хүрч, буух хэрэгтэй хэмээн
түүнд дохио зангаагаар өгүүлвэй.
Уугуул хэдий зөвшөөрсөн ч харин
авгай нар айсандаа чулуужиж
орхисон мэт огт хөдөлсөнгүй, тэр ч
нөгөөдүүлтэйгээ үлдэв. Рауль
олсоор модоо чангахан ороогоод
голоос нь зүүгдсээр газар буулаа.
Түүнийг давстай ус нөмрөөд авах нь
тэр. Тэр амьсгаагаа түгжээд, олсноос
үлгэн салган зүүгдсэн бөгөөд

давалгаан нөмрөхүйеэ, модонд
наалдан байж арай гэж ухаан сэхээ
ороод, сая олсоо бөххөн зангидав.
Тэгтэл шинэ давалгаан түүнийг юу ч
үгүй булхаад, авгай нарын нэг нь
модноос гулгаад ойчсон ч эр нь
нөгөө авгай, хоёр хүүхэд, мууртайгаа
дээр үлджээ.

Бусад мододын дор шаваарсан олон
улс аажуухан алга болсоор цөөрсөөр
буйг Рауль дээр байхын л харж
байсансан. Өдгөө түүний баруун
зүүнгүй, бүх талд нь хаа сайгүй тийм
юм болж, өөрөө хүртэл тэсч
үлдэхийн эрхэнд хамаг тэнхээ
тамираа хөвчлөн байтал дэргэдэх
хүүхнийх нь тамир алдраад ирэв

боллолтой. Давалгаа бүрийн дарэа эхлээд өөрийг нь, харин дараа нь нөгөө авгайг урсгаад явчихаагүйд тэр гайхдаг байсан буй заа. Эцсийн эцэст дахиад нэг хүчит давалгэан оволзоод өнгөрөхөд тэр орь ганцаар хоцорч, тэргүүнээ дээш өргөхүл дал модны титэм ч бас үзэгдэхгүй болжээ. Хагас нь хугарч, цуу үсэрсэн мод доргин чичирхийлнэ. Рауль тийнхүү аврагдав.

Дал модны үндэс тэсч байгаа хойно одоо салхинаас айх юмгүй, мод өөд авирч эхэлтэл бүр туйлдаж гүйцээд, арай ядан хөдөлсөөр холдохын завдгүй байтал, хэдэн том давалгаан түүнийг гүйцэн яах ийхийн завдгүй

булхан номхчилов. Тийнхүү мань эр сая өөрийгөө модноос хүлээд, юу болох нь үл мэдэгдэх аймшигт шөнийг зоригтойхон угтахаар биеэ зэхлээ.

Түнэр харанхуйд орь ганцаараа суух даанч гаслантай, ертөнцөд галав юүлээд, ганцаараа амь хэлтэрсэн мэт аймшигтай. Салхи бас л цаг цагаар улам догширсоор авай. Раулийн таамагласнаар арван нэгэн цагийн үед салхи бүр нүд бүлтрэм ширүүслээ. Тэр бол тийм гэхийн аргагүй аймшигтай, зэрлэг, хэрцгий, гасалж хуухирсан араатан, өмнөө байгаа бүхнийг нураан сүйтгэгч хар хүч, энүүхнээр шуугин өнгөрснөө

гэнэт тэр дороо эргээд ахиад
нөмрөөд ирнэ, тийнхүү эцэс төгсгөл
нь үл мэдэгдэнэ Тэр хөв хөнгөхөн,
жингүй болчихоод хаашаа ч юм бэ
өөрөө шуугин одож, бас эцэс
төгсгөлгүй хатуу юмны дундуур
түүнийг бас нэг юм хязгааргүй
хурдаар чирч яваа мэт санагдаад
явчихжээ. Салхи аль хэдийнээ орчи
хөдлөгч хий агаар бус мөнгөн ус, ус
лугаа адил мэдрэгддэг, баригддаг
болчихоод энэ хуй салхи руу гараа
оруулан, бухын гулуузны мах мэт
түүнийг хэрчим, үмхээр нь өм өм
татаж болох мэт, бас түүнээс зууран
чаргуулдаж, хад чулуунд
наалдах шиг түүн дээр элэглэн

хэвтэж болох мэт жигтэй бодол
Раулийн сэтгэлд бүүр түүр бууж
авай.

Салхи түүнийг бүр багалзуурдаад
авав. Ам хамраар нь амьсгаатай нь
хамт шунган, уушгийг нь бөмбөлөг
мэт пэмбийтэл үлээчихжээ. Тэр цаг
мөчид түүний бүх бие махбод
шороогоор пиг дүүрэн чигжээтэй
мэт санагдана. Амьсгалахын тулд тэр
дал модны холтсонд уруулаа
язартал нааж байлаа. Амсхийхийг үл
мэдэгч аймшигт хуй сүүлчийнх нь хүч
тамирыг бараад, бие сэтгэлийг нь
туйлдуулан мэнэрүүлж гүйцэв. Рауль
аль хэдийн харж, ажиглаж, бодож,
сэтгэж чадахаа болиод үхээн нь дэн

дун болжээ. "Луун сүүл гэдэг нь энэ байх нь" гэсэн ганцхан бодол тов тод үлдээд, тэр бодол нь үе үесхэн улсхийн гялалзагч өчүүхэн цог лугаа адил ой тойнд нь цуцахыг үл мэдэн зурс зурсхийнэ. Манараан дүйрээнээсээ нэг сэрэхүйеэ "Луун сүүл гэдэг нь энэ байх нь" хэмээн гэнэт бас санаад, төдөлгүй дотор нь балартав.

Арван нэгээс шөнийн гурван цаг хүртэл догшин хуй ер бусын хэрцгий, нүүр нүдгүй шуургалж, яг арван нэгэн цагийн үед Мапуи, түүний гэрийнхний амиа хоргоцоож асан мод хугараад ойчжээ. Нгакура охиноо гартаа тас зуурсан тэр

чигээрээ Мапуи тэнгисийн
булангийн уснаас самран гарч ирсэн
бөгөөд гагцхүү нутгийн уугуул л ийм
гай гамшгаас амь мэнд мултарч
чадах буй заа. Мапуигийн өөрийгөө
хүлчихсэн байсан модны саглагар
орой цагаан хөөс, долгисын
дунд галзуурсан мэт салганасаар
байлаа. Өөрийнхөө, басхүү
охиныхоо толгойг уснаас
цухуйлгахын тулд тэрбээр модны
голоос гараараа түргэн түргэн
чангааж, мөн охиноосоо ч зуурсаар,
яаж ийгээд ус залгичихалгүй тэссэн ч,
бужигнасан усан намиа, бараг
хэвтээ чиглэлээр шахуу асгарах
бороон дуслууд амьсгаа юутай нь

хамт уушгинд нь ус нэвчүүлжээ.

Тэнгисийн булангийн нөгөө эрэг хүртэл арван бээр зайтай болохоор усанд цацаж үхээгүй арван зол муутын ес нь тэнд орвонгоороо эргэлдэгч мод, элдвийн самбар, байшин, завины эвдэрхий түмэн новшин дунд няц няц цохиулан амь тавьж байлаа. Усанд хахаж цацсан, дөнгөж амь голтой тэднийг энэ чөтгөр шулмын хиртхийм тээрэм рүү чулуудан, холион бантан болгож орхиж. Харин Мапуигийн аз дайрч, хувь заяаны эрхээр тэр амь хэлтрэгсдийн тоонд багтсан агаад түүнийг элсэн дээр гаргаад хаячихсан байлаа. Бие нь нэл цусанд

будагджээ, Нгакурагийн зүүн гар хугарч, баруун гарынх нь хуруунууд бяц няц цохиулаад, дух, хацар нь ясандаа хүртэл ярагджээ. Мапуи нэг гараараа мод тэвэрч, нөгөө гартаа охиноо зууран, ёолсон шиг арайхийн сэхээ орохул тэнгисийн булангаас хуйларсан долгис түүний өвдөг, заримдаа бүр бүсэлхийгээр нь татан цохилонхон байлаа.

Үүрээр гурван цагийн үед хуй салхины догшин авир номхрох тийшээ хандав. Таван цагийн алдад жигтэйхэн салхилснаас өөр юм болсонгүй. харин зургаагийн хэрд бүр нам жим болж, нар мандлаа. Тэнгис тогтож эхэллээ. Бас л

давалгаа хаялсаар буй тэнгисийн
булангийн хөвөөнөө Мапуи эсэн
мэнд газар бараадаж чадаагүй тэр
хүмүүсийн эрэмдэг зэрэмдэг цогцсыг
олж үзэв. Тэдний дунд эхнэр, ээж
хоёр нь байгаа биз. Тэр, цогцсуудыг
ажигласаар, элсэн дээгүүр тэнүүчилж
явахдаа биеийнх нь тал уснаас
цухуйж байгаа эхнэр Тэфэрагаа
хараатахав. Мань эр газар лагхийтэл
суугаад араатан аятай гийнан
нулимсаа асгаруулсан бөгөөд балар
эртний хүмүүн өөрийнхөө уй гашууг
тийнхүү илэрхийлдэг бололтой.
Тэгтэл гэнэт авгай нь хөдлөн, ёолох
нь тэр. Мапуи түүн рүү хянамгай
харваас, тэр амьд мэнд тедийгүй

шарх шалбархай ч үгүй, зүгээр унтаж байж. Аз заяа нь түшсэн цөөхөн улсын тоонд Тэфара ийнхүү багтжээ.

Саяхнаас арал дээр суурьшсан мянга хоёр зуун хүнээс ердөө гурван зуу нь амь гарчээ. Мормон шашны доншуур сурталч, цагдаа хоёр тэдний нэрсийг бичиж авлаа.

Тэнгисийн булан хүүрээр пиг дүүрчээ. Арал даяар ганц ч байшин, ганц ч урц, чулуун дээр чулуу ч тогтож үлдсэнгүй, нэргилын бараг бүх дал мод үндсээрээ булгарч, тэсээд үлдсэн нь голоороо хугарч унаад, хамаг самар нь ганц ч үлдэлгүй газар ойчиж. Бас ундны ус гэж юу байхав, борооны ус халиад

урсчихсан гүехэн худгуудад давс
туначихжээ. Юу ч үгүй норчихсон
хэдэн шуудай гурил тэнгисийн
уснаас шүүрч авцгаав. Амь гарагсад
газраар унасан наргил самрыг зүсэн,
зүрхэнцэгийг нь ховдоглон
үмхэлцгээх аж. Тэд элсэнд нүх ухаад,
төмөр дээврийн үлдэгдэл дээгүүр нь
дэвсэж, тэр ноохой руугаа мөлхөн
орцгоож авай. Доншуур сурталч
болхидуухан нэрэгч бүрхээр
дархалсан ч, гурван зуун хүний гол
чийглэх ус яаж цэнгэгшүүлж барах
вэ. Хоёр дахь өдрийн үдэш Рауль
тэнгисийн буланд сэлэхдээ
гарилтаж, ангаж цангаж сүйд
болохгүй байгаагаа гэнэт мэдэрч,

өөрийнхөө нээлтийн тухай бүхэнд дуулгэвал төдөлгүй гурван зуун эр, эм, томчуул, хүүхэдгүй ядаж тэгэж цангаага тайлах санаатай хүзүүгээр татсан уснаа орж зогсчээ. Тэднийг тойрон өдий төдий хүүр хөвж, хөлдөр нь хүртэл бамбалзан тээглэнэ Гурав дахь өдөр нь тэд нас барагсдаа нутаглуулж, аврагч хөлгүүдийг хүлээж эхэллээ.

Гэр орныхноосоо хагацсан Наури энэ хооронд далайн хар салхины хамаг аймшгийг орь ганцаар туулжээ. Тоолохын аргагүй олон хөндүүр, хөх няц, өргөс мэтийг үл тоомсорлон нэг модон тавцангаас тас зууран байтал нь түүнийг

тавцантай нь хүзүүвч давуулан
чулуудаад, далай руу авч оджээ.
Гэтэл уул мэт аварга давалгааны
тэсвэрлэшгүй түлхэлт, цохилт,
сахраан дунд тэр самбараа
алдчихав. Юун залуу идэрмэг гэх
манатай, таяг тулдаг, жаран настай
Наури энэ арлуудын нэг дээр хүй
тасарч, тэнгис далайн хөвөөнд хамаг
амьдралаа өнгөрөөсөн билээ.
Амьсгаадаж, ус залгин, амаараа
агаар сорж ядан харанхуйд самарч
явахдаа тэрбээр мөр рүү нь
наргилын самар чамгүй хүчтэй
дэлсээтэхийг мэдэрч, яах ёстойгоо
энэхэн эгшинд товллоод, мөнөөх
самрыг шүүрч авав. Цагийн дотор

тэр дахиад долоог барьж авч чадсан бөгөөд хооронд нь холбов. Ийнхүү түүнийг усан дээр тогтоогоод байх аврах бүстэй болчихсон ч, түүндээ үхтэл цохиулах аюул үргэлж нүүрлэсээр байлаа.

Наури мах шөл арвинтай нэгэн хойно удалгүй бөөн хөх няц болов. Гэхдээ тэр ямар хуй салхи үзээгүй биш, өөрийнхөө аварга загасны бурханаас махчин араатнаас зайцуулж өгөхийг залбиран гуйв. Тэгээд салхи намжиж эхлэхийг хүлээлээ. Гэхдээ гурван цагийн үед түүнийг яаж сэгсчсэн гэж санана, юун тэр салхины сиймхийтэй манатай арайхийн амь мэнд өнгөрөв. Зургаан

цагийн алдад салхи бүр нам жим болохыг ч тэр мэдсэнгүй. Түүнийг элсэн дээр гаргаад чулуудчихад сая нэг ухаан сэхээ орсон бөгөөд давалгаа эргээд тэнгис рүү урсгачих вий гэж учиргүй бачимдан, шарх олж, цус нь асгарсан гараараа элс самардан эрэг өөд мөлхжээ.

Тэр хаа ирснээ мэдэв. Түүнийг бяцхан Такокота арал дээр гаргаад хаячихсан байлаа. Энд тэнгисийн булан үгүй, хэн ч амьдардаггүй, Хикуэругаас арван таван бээрт оршдог агаад Хикуэру тэндээс харагдах бараа үгүй ч, уг нь тэртээ өмнө зүгт байгаа гэдгийг Наури мэдэж байлаа. Түүнийг живүүлэлгүй

аварсан наргилынхаа самраар гол зогоон арав хоног аргацаав.

Шүүсийг нь ууж, зүрхэнцэгийг иднэ, гэхдээ цагийн уртад хүргэх гэсэндээ бага багаар хүртэнэ. Аврагдана гэж тэр итгэхгүй байлаа. Тэнгэр ус хоёрын савслаганд аврагч хөлгүүдийн утаа үзэгдэх авч, ямар галт онгоц хүн амьтангүй, бяцхан Такокота арлаар дайраад гаръя гэж санах вэ!

Бүр анхнаасаа хүүрнүүд түүнд амар заяа үзүүлээгүй билээ. Тэнгис тэднийг элсэн дээр ямар шаргуу гаргаж хаялнам, тэрбээр мөн тийнхүү Шаргуу бачим, тэнхээ тамираа барагдтал буцааж тэднийг

тэнгис рүү түлхэнэ. Махчин аварга загаснууд ч дор нь тэднийг цусална. Түүний тамир барагдахын цагт хүүрнүүд хүйт оргим аймшигт хэлхээгээр арлыг бүсэлж, хэдий холдох газар үгүй ч мэнь хүн тэднээс аль болох зайсхан явахыг хичээнэ.

Сүүлчийнхээ самрыг идсэн арав дахь өдрөө Наури ангаж цангасандаа харангадаж гүйцээд элсэн дээгүүр мөлхөн самрын эрэлд хатав.

"Өчнөөн хүүр хөвөөд ирж байхад самар яагаад байдаггүй билээ, гайхмаар юм амьгүй цогцосноос хавьгүй олон самар хөвж явмаарсан" гэж тэр бодсонсон. Сүүлдээ бүр цөхрөнгөө бараад

туйлдсандаа элсэн дээр тэрийн хэвтэв ээ. Одоо юундаа ч найдалтай билээ, үхлийг хүлээх үлдэж Ухаан оронгуутаа, живж үхсэн хүний хурц улаан шаргал үст толгор нүднийх нь өмнө буйг Наури бүрэг барагхан ухаарав. Долгис хүүрийг түүнд ойртуулан ширвэж хаяснаа, дараа нь ахиад цааш нь авч одов. Сүүлдээ бүтэн эргүүлэн өөд нь харуулчихуйяа, түүнд нүүр царай гэж юм ор байхгүйг Наури үзэв. Гэхдээ л улаан шаргал үс нь яагаад ч юм танил санагдаад болдоггүй. Бүтэн цаг өнгөрлөө. Шарилыг таних гэж хичээсэнгүй, үхлийг хүлээж байгаа хойно, энэ зүүд тойнд ормоор

аймаар хүүр урьд нь хэн байсан нь даанч сонингүй.

Гэхдээ цагийн дараа тэр арайхийн өндийж, шарилыг шимтэн харлаа. Хүчтэй давалгаан түүнийг шүүрч аваад багахан долгис хүрэхээргүй тийм газар аваачжээ. Тийм ээ, мань хүн эндүүрсэнгүй, Паумотугийн арлууд дээр ганц л хүн ийм улаан шаргал үстэй байсан. Энэ бол германы еврей Леви. Мапуигийн сувдыг худалдаж аваад түүнийгээ "Хира" далбаат онгоцондоо авч одсон тэр хүн. Яая гэхэв, бас нэг юм тодорхой болж. "Хира" сүйджээ. Загасчид, хулгайч нарын бурхан сувдны доншуур худалдаачнаас нүүр

буруулсан нь тэр аж.

Эмгэн мөлхсөөр хүүр рүү дөхлөө.
Цамц нь биенээс нь хуу татагдаад,
өргөн ширэн бүс нь илхэн харагдах
авай. Амьсгаагаа хураан байж Наури
бүснийх нь тээгийг мултлах гэж
оролдвоос харин ч төвөггүй юм
байж. Тэр шалавхан зайлахаар элсэн
дээгүүр бүсийг нь араасаа чирэн
буцаж мөлхлөө, Нэг жижиг халаасыг
нь, бас нэгийг, гурав дахийг нээтэл
цөм хов хоосон. Тэр хааш нь
хийчихэв? Энэ удаагийнхаа аялалаар
түүний худалдаж авсан анхны,
цорын ганц сувдыг сүүлчийн жижиг
халааснаас нь оллоо. Наури жигшим
өмхий үнэрт бүснээс холдон, хэдэн

алхам мөлхөж зайлаад, сая сувдыг
шимтэн харав. Энэ бол Мапуигийн
шүүрдэн олж, Торикийн булаан
авсан сувд. Гар дээрээ цэнэн
дэнсэлж, алган дээрээ энхрийлэн
өнхрүүлж байсан ч, сувдны сайхэн
Науриг догдлуулсангүй, харин
Мапуи, Тэфара тэр хэдийн мөрөөдөл
хүсэлдээ зүйргүй хичээнгүйлэн
барьсан тэр байшинг эмгэн
сэтгэлдээ тольдон байлаа. Сувдыг
харахул энэ байшингийн бүх юм нь,
ханан дахь найман өнцөгт цаг нь
хүртэл түүний нүднээ эрхгүй
тодроод ирнэ. Үүний төлөө
амьдралгүй яах вэ!

Тэр сиймгэр тэрлэгнээсээ өргөн гэгч

цуучин.түүгээр сувдаа бөхлөн
зангидаад хүзүүнээсээ зүүснийхээ
дараа аахилж уухилан амьсгаадсаар
эрэг даган салдархийлэв. Тэгэхдээ
наргилын самар эрэлхийлж ямар
хянамгай ажиж явсан гээч. Тун
удалгүй нэгийг, дараа нь ахиад
нэгийг олж, самраа дор нь хагалаад
хөгц амтагдсан шүүсийг нь ховх
сорж, зөөлхөн зүрхэнцэгийг цөмийг
нь идчихэв. Арай хожуухан эвдэрхий
завин дээр буучихлаа, дээр нь
сэлүүрийнх нь тээг байсангүй, гэхдээ
тэр итгэл алдарсангүй, үдэш гэхэд
тээгийг хайж олжээ. Энэ мэт олз
бүхэн сайн сайхны дохио байлаа.
Сувд түүнд аз жаргал авчирчээ. Нар

орохын өмнөхөн Наури уснаа хөвөгч
модон хайрцаг олж ирээд, эрэг дээр
чирч гаргатал, дотор нь нэг юм
түжигнээд, нээгээд үзвээс арван лааз
загасны нөөш байх нь тэр.

Завиныхаа хитэг рүү балбаж
цохилсоор, нэгийг нь онгойлгоод
ярагдсан нүхээр шүүс шимүүсийг нь
сорчихов. Дараа нь төмөр савнаас
өөдөсхөн өөдөсхөн хулд загасны мах
гаргаж идэх гэж харин хэдэн цаг
ноцолдов.

Наури дахиад найм хоног тусламж
хүлээсэнсэн. Энэ хооронд тэр
наргилын самрын ямар л сэмэрдэс
олж цуглуулнав, тэрийгээ хаман
басхүү өөрийнхөө тэрлэгний

үлдэгдэл сэлтээр нөгөө олсон тээгээ
завиндаа бэхэллээ. Завь нь энд
тэндгүй хагараад, юугаар ч шавж
бөхлөлтэй билээ, Наури ямар ч гэсэн
ус шавхаж асгах наргилын самрын
баахан яс олж тавилаа. Сэлүүр яаж
хийх вэ гэж тэр удтал бодсоор,
дараа нь төмрийн өөдсөөр үсээ
тайран. шидмэс томов. Гурван
футын Урт хөндлөвч модыг нөөшний
хайрцагны нэг самбартай мөнөөх
шидмэсээрээ холбож уялаа. Бүр
шүдээрээ мэрсээр бяцхан хоног
гаргаж бэхзлснийг яана.

Арван найм дахь хоногтоо, шөнө
дунд Наури завиа усанд тавиад
тэнгисийн дэлсгээт зурвасыг гэтлэн,

Хикуэру өөд гэртээ харих замаа
хөөлөө. Наури өтөл настай эмгэн.
Үзэж туулсан зовлон түйтгэрийнхээ
эрхээр тэр турж эцээд, гагцхүү ясыг
нь арайхийн бүрхсэн унжгар хэдэн
булчин төдийтэй үлджээ. Гурван
бярлаг сэлүүрчинд зориулсан том
завь боловч тэр өөрийнхөө хийсэн
сэлүүрээр самраад, ганцаараа
дөнгөөд байлаа. Бас ус шүүрүүлнэ
гэж тоймгүй, ямартаа л цаг
хугацааных нь гуравны нэг ус утгаж
асгахад явчих аж. Бүр гэгээ орсон
хойно ч Хикуэру бараа туруугүй,
харин Такокота тэнгэрийн хаяаны
чанад далд оржээ. Нар төөнөж,
Науригийн нүцгэн биен дээгүүр хөлс

нь сул асгарах агаад хулд загасны
хоёр нөөш үлдсэнийг
цоолоод, шимүүсийг нь өдрийн туж
соров, юун махыг нь гаргаж идэхтэй
манатай. Завийг нь баруун этгээд
рүү урсгаж хөөгөөд, өмнө зүг рүү
хөвж чадаж байгаа эсэхээ ч мэдэхгүй
хар таамгаар явлаа.

Удалгүй үдээс хойхно завин дээрээ
бүх биеэ цэхлэн зогсохуйяа, тэр сая
Хикуэруг олж үзвээ. Дал мододын
саглагар ганган титэмнүүд нь харин
алга, энд тэнд хугарсан мододын
ёрдгор голууд сэрийлдэх аж. Арлын
бараа түүний сэтгэлийг сэргээжээ.
Ийм ойрхон ирчихсэн чинээ
санаагүйсэн. Харин түүнийг далайн

урсгал баруун зүгт хөөгөөд байлаа. Завиа өмнөд этгээд рүү зүглүүлчих санаатай тэр зогсоо зайгүй сэлүүрдсээр авай. Сэлүүрийг тогтоож буй шидмэс хоногноосоо сугарч гарчихаад, Наури байранд нь буцааж оруулах гэж ноцолдох бүртээ өчнөөн цаг гарздана. Бас завины ёроолд юм л бол-ус дүүрээд ирнэ, хоёр цаг болоод Наури сэлүүрээ чулуудчихаад бүтэн цаг хутгуураар шавхсан агаад түүнийг үргэлж баруун зүгт хөөгөөд байлаа.

Нар орох үед Хикуэру түүнээс гурван бээрт, зүүн өмнө зүгт харагдаж байлаа. Тэргэл саран мандаж, найм гэхэд арал дорно зүгт гарч, хүрээд

очихноо хоёрхон бээр үлджээ.
Наури дахиад нэг цаг ухаан сэхээгүй
зүтгэсэн ч газар ойртсонгүй, урсгал
түүнийг хав барьчихаад, завь том,
сэлүүр тамтаггүйг хэлэх үү, ус утгаж
асгахад дэндүү их цаг, хүч
түйтгэрлэхийг яана. Тэгээд ч түүний
ядарч туйлдсан нь эцэсгүй, улам
улам тэнхээрэхсээр, хичнээн
тэлчилж ноцолдоод нэмэргүй, завь
баруун зүг өөд даялсаар авай.

Эмгэн, махчин аваргынхаа бурханд
залбирчихаад, завинаасаа үсрэн
самарч эхэллээ. Ус түүнийг сэргээж,
завь нь ард хоцров. Цагийн дараа
газар бүр энүүхэнд ойртоод ирлээ.
Гэтэл хамгаас аймшигтай юм

болдгоороо болов. Түүний яг эгц урд, хорин футээс холгүйхэн аварга том сэрвээ ус хага яран айсуй. Наури дальдарсангүй, түүн рүү сэлсээр атал өнөөх нь алгуурхан холдож, тэгснээ баруун тийш эргэн, түүнийг тойрон дүгрэглэж сэлэв. Гөлөгнөсөн сэрвээг хараанаасаа гаргалгүй тэр цаашаа самарлаа. Харин алга болонгуут нь уснаа юу ч болоогүй мэт хэвтчихээд, түүнийг харзнана. Араатны сэрвээ ахин үзэгдэхэд тэр хэдийнээ урд нь сэлж явлаа.

Махчин аварга загас ер яарсан янзгүй, энэ ч аргагүй, хар салхинаас хойш өлөн зэлмүүн байгаагүй нь лав. Хэрэв аварга загас ходоод нь

хов хоосон бол олз руугаа шууд ухаан зулаггүй дайрдгийг Наури мэдэх билээ. Эл араатан уртаараа арван таван фут, завьжныхаа ганцхан ярсхийх хөдөлгөөнөөр хүнийг дундуур нь өлхөн тас хазчихмаар.

Гэхдээ Наури юун аварга загастай манатай, урсгал түүнийг түвт чангаан газраас холдуулсаар хагас цаг өнгөрөхөд махчин бүр эрээ цээрээ алдав. Ямар ч аюул заналхийлээгүйг мэдчихээд тэр тойргоо улам хумин, Науригийн дэргэдүүр өнгөрөхдөө түүн рүү шуналтайяа хялайн харах ажээ. Эрт орой хэзээ боловч аварга загас зориг ороод, түүн рүү

ухасхийнэ гэдэгт эмгэн эргэлзсэнгүй.
Үүнийг хүлээлгүй үзэлцэхээр сэтгэл
шулуудаад, тэр аргаа ядан амь
дэнссэн алхам хийжээ. Өлсгөлөн, гай
түйтгэр, зовлон зүдгүүрт туйлдсан
энэ өтөл эмгэн тэнгисийн барстай
улаан халз тулчихаад, түүний
дайралтыг давж түүн рүү эхлээд
дайрахаар зоригложээ. Аятай
мөчийг харзнан, тэр хөвсөөр байлаа.
Махчин аварга загас ердөө найман
фут хүрэхтэй үгүйтэй ойрхон түүний
дэргэдүүр залхуутайяа гулбилзаад
ирэхүйеэ, Наури довтолж буй аятай
гэнэт сарвалзан урагш ухасхийжээ.
Сүүлээрээ ухаан сэхээгүй ширвэсэн
аварга загас барзгар хүйтэн

бөөрөөрөө эмгэнийг түлхэж, гарынх нь арьсыг бугуйнаас нь мөрийг нь хүртэл хуу татаад, хар эрчээрээ зайлан одлоо. Тэр сандчин нэг тойрчихоод, ашгүй нүднээс далд оров.

Элс ухан, хумирч сарайсан төмрийн өөдсөөр дээгүүр нь хучсан чийгт хар нүхэнд хэвтээ Мапуи, Тэфара хоёр хоорондоо гашуун үг чулуудалцаж авай.

-Миний үгийг дуулсан бол. сувдаа тас нуучихаад хүнд ам алдаагүй бол, одоо чамд байж л байх байсан хэмээн түмэнтээ түүнийг зэмлэдгээрээ Тэфара бас бачимдав.

-Дунг нь нээж байхад Хуру-Хуру яг миний хажууд зогсож байсан гэж би чамд мөн олон хэлсэн дээ.

-Одоо ингээд бид байшин ч үгүй болов. Рауль өнөөдөр надад юу хэлсэн гээч, хэрэв чи Торикид сувдаа зараагүй бол...

-Би зараагүй, Торики намайг луйвардсан.

-... Хэрэв зараагүй бол би чамд таван мянган франц доллар өгөхсөн гэсэн, энэ чинь арван мянган чили доллар гэсэн үг.

-Эхтэйгээ зөвлөж, тэр харин сувд

мэднэ шүү хэмээн Мапуи
тайлбарлав.

-Одоо бид сувд ч үгүй, юу ч үгүй
хэмээн Тэфара сүүрс алдлаа.

-Гэхдээ би Торикийн өрийг дарсан.
Тэгэхээр ямар ч гэсэн мянга хоёр
зууг олоо биз дээ.

-Торики үхсэн гэж авгай нь
уугчсанаа: -Тэрний далбаат
онгоцноос сураг, сэг ч алга. "Аораи",
"Хира" хоёртой хамт сүйрээ. Торики
чамд амласнаараа гурван зуун
долларын зээл мөн өгнөө. Үгүй шүү
дээ, яагаад гэвэл Торики үхсэн, чи
сувд олоогүй бол одоо ч түүнд мянга

хоёр зуугийн өртэй байх уу. Үгүй!
Яагаад гэвэл Торики талийсан,
талийдчид өр шир төлдөггүй юм.

-Леви Торикид сохор зоос өгөөгүй.
Харин Папеетэд очоод мөнгө авч
болох ам цагаан цаас түүнд өгсөн.
одоо Леви үхсэн хойно юугаа төлөх
вэ, Торики амиа алдлаа, цаас
түүнтэй хамт үрэгдээ биз, сувд
Левитэй живчихээ биз. Чиний түмэн
зөв, Тэфара. Би хайран сувдаа
үрж, түүнийхээ төлөө юу ч олж
долоосонгүй. Яая гэх вэ, одоо унтах
минь.

Гэнэтхэн тэр гараа өргөснөө
чагнаархав. Гадаа нь хэн нэгэн

арайхийн амьсгаадан буй аятай
хачин жигтэй чимээ дуулдах нь тэр.
Тэгтэл хэи нэгний гар оромжны
үүдийг хаасан чийрсийг маажлав.

-Энд хэн байна гэж Мапуи
хашгирлаа.

-Наури байнаа. Миний хүү Мапуи
хаа байгааг хэлж өгөөч хэмээн хариу
өчих нь дуулдав.

Тэфара цочин хоолойгоо
хяхтнуулснаа, нөхрийнхөө мөрнөөс
тас зуурчээ.

-Сүг сүүдэр! Сүг! Сүнс гэж тэр үгээ
арайхийн эвлүүлэв.

Айдас хүйдэснээсээ Мапуигийн царай шаргалтаад иржээ. Тэр зүрх алдан эхнэртээ наалдав.

-Сайн санаат авгай минь гэж тэр хоолойныхоо өнгийг өөрчлөх санаатай ээрч түгдрэн: -Би танай хүүг сайн мэднэ. Тэр тэнгисийн булангийн дорнод эрэгт амьдардаг гэлээ.

Чийрсний чанад сүүрс алдах дуулдана. Мапуи арай ухаан сэхээ орж, зоригжжээ.

-Сайн санаат авгай чи хаанаас ирэв гэж асуулаа.

-Тэнгисээс гэсэн уй гунигт хариу дуулдэв.

-Би бүр мэдээд байсан юм, мэдээд байсан юм гэж хойш урагш найгах зуураа Тэфара орь дуу тавилаа.

-Тэфара хэдийнээс хүний оромжинд хоног төөрүүлдэг болоо вэ гэж Наури хоолойгоо чичрүүлэн асуув.

Мапуи айдас, зэмлэл дүүрэн нүдээр эхнэр өөдөө харсан бөгөөд түүний дуу тэр хоёрыг илчилж орхив.

-Миний хүү Мапуи хэдийнээс ингээд хөгшин эхээсээ нүүр буруулж орхио вэ дээ хэмээн менөөх дуу хоолой

өгүүлнэ.

-Үгүй, үгүй, би биш... Мапуи чамаас нүүр буруулаагүй гэж тэр бархиран:

-Би Мапуи биш.

Тэр дорнод эрэгдээр байгаа гэж чамд хэлээд байна шүү.

Нгакура сэрснээ уйлчих нь тэр. Чийрс ханараад явчихлаа.

-Чи юу хийж байна? хэмээн Мапуи хоолойгоо чичрүүлэн асуулаа.

-Орж ирж байна гэж Наурийн хоолой хариу тавив.

Чийрсний булан сөхөгдөхүйеэ,
Тэфара хучлагандаа шургахаар
завдтал Мапуи түүнийг тавьсангүй.
Тэр юунаас ч юм барихгүй бол
тэсэшгүй байлаа. Хамаг бие нь
дагжин чичирч, эрүү шүд нь
тачигнатал зодолдох тэр хоёр хоёул
чийрс өөд нүдээ бүлтэртэл
ширтэлхийлэх авай. Тэрлэг ч үгүй,
хамаг бие нь усан шалхнаг болсон
Наури нүх рүү мөлхөөд ороод ирэв.
Тэд оромжны амнаас овгосхийн
холдож, толгойгоо халхлахаар
Нгакурагийн бүтээлгийг бие биеэсээ
хуу хуу таталлаа.

-Хөгшин эхийнхээ голыг норгож
болохсон доо хэмээн "сунс"

хоолойгоо хяхтнуулав.

-Уух юм өгөөд орхиоч гэж Тэфара
хоолойгоо сааралтуулан захирчээ.

-Уух юм өг гэж Мапуи охиноо
зандрав.

Тэгснээ хоёулаа Нгакураг хучлага
дороос нь ховх түлхжээ. Мапуи сүнс
ус ууж буйг нүднийхээ булангаар
харав. Тэгтэл салганасан гараа
сунган сүнс түүний гарт хүрч, гарынх
нь хүндийг мэдрэнгүүтээ түүний
өмнө буй эмгэн сүнс биш гэдэгт
Мапуи сая итгэн, нэг мэдэхийн
эхнэрээ араасаа чирэн хучлага
доороосоо өндийгөөд, Науригийн

яриаг тэд цөмөөрөө чих тавин сонсчээ. Эмгэн Левигийн тухай ярьж, Тэфарагийн алган дээр сувдаа тавихул тэр ч хадмыгаа, мах цуснаас бүтсэн хүн өмнөө буйг сая ойлгов.

-Маргааш өглөө чи сувдаа Раульд таван мянган франц доллараар зарчих гэж Тэфара хэллээ.

-Байшин яах вэ хэмээн Наури дургүйцэв.

-Тэр байшин барьж өгнө. Бүгдээрээ дөрвөн мянгад элбэг багтана гэж тэр хэлсэн, бас мянган франц доллар зээлнэ гэсэн, энэ чинь хоёр мянган чили доллар шүү дээ.

-Уртаараа дөчин фут байшин болно биз? гэж Наури асуух аж.

-Тийм ээ, дөчин фут гэж Мапуи ам дүүрэн хариуллаа.

-Голынх нь өрөөнд дүүжинтэй ханын цаг байна биз.

-Тийм ээ, бас дугариг ширээ байна.

-Тэгвэл над идэх юм өгөөч, би бүр өлбөрч хоцорч, дараа нь бүгдээрээ сайхан унтана, би туйлдахын эцэст хүрч. Харин маргааш сувдаа зэрахын урьд байшингийнхаа тухай ахиад ярилцана гайгүй. Мянган франц доллар бэлнээр авчих нь дээр биз.

Зээлээр бараа авч байснаас бэлэн
мөнгө төлчих нь хэзээний амар гэж
Наури насныхаа хэргийг бүтээсэн
мэт сэтгэг тэнүүн өгүүлвэй.